



ДЭЛХИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ

1.1. Эдийн засгийн чиг хандлага болон бодлогын асуудлууд

Тайлант оны эхний хагас жилд тохиолдсон зарим тааламжгүй үйл явдлын дараа дэлхийн эдийн засаг дахин сэргэх хандлага ажиглагдаж байна. Эдийн засгийн сэргэлт болон эдийн засгийн байдал тодорхойгүй, инфляцийн дарамт бага байгаа нөхцөлд мөнгөний бодлогоо зөөлөн хэвээр байлгах, дунд хугацааны тэнцэлд төсвийн бодлогоо чиглүүлэх шаардлагатай байна. Дэлхийн эдийн засгийн тэнцвэргүй байдал өргөжиж, өсөлт нь АНУ-аас хамаарсан хэвээр байгаа нь ихэнх оронд бүтцийн шинэтгэлийг хурдасгах, АНУ-д дунд хугацаанд төсвийн алдагдлаа хязгаарлах, зарим оронд илүү уян хатан валютын ханшийн тогтолцоонд шилжих шаардлагыг бий болгож байна.

Ирак дахь дайн богино хугацааных байснаас дэлхийн эдийн засгийн өсөлт сүүлийн хагас жилд түргэсэн 2003 онд 3.2 хувьд хүрнэ гэсэн урьдчилсан тооцоо гарч байна. Ирак дахь зөрчилдөөн хурдан дуусч байгаа болон бизнесийн ба хэрэглэгчийн итгэл ялангуяа, АНУ-д ихээр нэмэгдэн, үнэт цаасны зах зээл бэхжиж байгаа нөхцөлд ирээдүйг таамагласан үзүүлэлтүүд нааштай эргэж байгаа юм. Эдгээр үзүүлэлтүүд оны эхний хагаст нилээд сул байсан нь хоёрдугаар улиралд аж үйлдвэрийн бүтээгдэхүүн болон худалдааны өсөлт саарсан, үл хөдлөх хөрөнгийн үнийн хэт хөөрөгдөл унасны нөлөө үргэлжилсэн, мөн Ази тивд Амьсгалын цочмог халтай хам (АЦХХ) шинж өвчний сөрөг нөлөө зэргээр илэрч байлаа. Харин оны сүүлийн хагаст АНУ, Япон, Азийн зарим орнуудад эдийн засгийн идэвх, хөрөнгө оруулалт өсөх хандлага ажиглагдаж байна. Инфляцийн дарамт бага байснаар ихэнх орон макро эдийн засгийн бодлогоо зөөлрүүлсэн байна. Европ, АНУ, зарим аж үйлдвэржсэн болон хөгжиж буй орнууд хүүний хэмжээгээ бууруулсан бол АНУ болон Азийн зарим орон төсвийн бодлогоо зөөлрүүлжээ.

Санхүүгийн зах зээл дээр бага түвшинд байгаа бодлогын хүү нь тооцоолж байснаас илүү удаан үргэлжилнэ гэсэн хүлээлт, илүүдэл төлбөрийн чадвар болон мөнгөний бодлогын зөөлрөлт зэрэг нь урт хугацааны хүүг 6 дугаар сарын дундуур сүүлийн 40 жилийн хугацаанд хамгийн доод түвшинд хүргэв. Урт хугацааны хүү эргэж өссөн (ялангуяа АНУ-д) нь эдийн засаг сэргэнэ, инфляци өснө гэсэн хүлээлт нэмэгдэж байгаа, мөн засгийн газрын үнэт цаасны нийлүүлэлт ихэсч байгааг илтгэж байна. Хүүний харьцангуй бага түвшин болон хөрөнгө оруулагчид АНУ-ын их хэмжээний урсгал алдагдлаас болгоомжилсноос шалтгаалж валютын зах зээл дээр

Хүснэгт 1. Дэлхийн эдийн засгийн тойм (жилийн өөрчлөлт, хувиар)				
	2000	2001	2002	2003 *
Дэлхийн үйлдвэрлэл	4.7	2.4	3.0	3.2
Хөгжингүй орнууд	3.8	1.0	1.8	1.8
Үйлдвэрлэл хөгжсөн томоохон орнууд	3.5	0.8	1.6	1.8
Бусад хөгжингүй орнууд	5.3	1.6	2.7	1.7
Евро бүс	3.5	1.5	0.9	0.5
Шинээр аж үйлдвэржсэн Азийн улсууд	8.5	0.8	4.8	2.3
Хөгжиж буй орнууд	4.1	4.1	4.6	5
Шилжилтийн эдийн засагтай орнууд	6.6	5.1	4.2	4.9
Дэлхийн худалдааны хэмжээ (бараа, үйлчилгээ)	12.6	0.1	3.2	2.9
Импорт				
Хөгжингүй орнууд	11.8	-1.0	2.2	2.8
Хөгжиж буй орнууд	15.9	1.6	6.0	5.1
Шилжилтийн эдийн засагтай орнууд	13.4	11.9	6.3	6.6
Экспорт				
Хөгжингүй орнууд	12.0	-0.8	2.2	1.6
Хөгжиж буй орнууд	15.0	2.7	6.5	4.3
Шилжилтийн эдийн засагтай орнууд	14.7	6.0	6.3	5.8
Гол нэрийн түүхий эдийн үнэ (ам.доллараар)				
Газрын тос болон газрын тосны бүтээгдэхүүн	57.0	-14.0	2.8	14.2
Шатахууны төрлийн бус түүхий эд	1.8	-4.0	0.6	5
Хэрэглээний барааны үнэ				
Хөгжингүй орнууд	2.3	2.2	1.5	1.8
Хөгжиж буй орнууд	6.1	5.8	5.3	5.9
Шилжилтийн эдийн засагтай орнууд	20.2	16.2	11.1	9.7
Лондонгийн банк хоорондын захын хүү (6 сараар)				
Ам. долларын хадгаламж	6.6	3.7	1.9	1.3
Японы иений хадгаламж	0.3	0.2	0.1	0.1
Еврогийн хадгаламж	4.6	4.2	3.3	2.2

* Урьдчилсан тооцоо

ам. доллар 5 дугаар сарын дунд үе хүртэл үргэлжлэн суларсан бол 6 дугаар сараас бага зэрэг чангарсан байна. 2002 оны эхэнд дээд цэгтээ хүрсэн ам. долларын нэрлэсэн үйлчилж буй ханш бараг 12 хувиар суларч, евро, канад доллар болон бусад аж үйлдвэржсэн орнуудын валютууд маш ихээр чангарсан байна.

Хөгжиж буй орнуудын зах зээлийн хувьд санхүүжилтийн нөхцөл нь аж үйлдвэржсэн орнуудын хүүний түвшин бага байгаа болон гол зах зээлүүдэд (ялангуяа Бразил) хандах хандлага дээшилсэн зэргээс хамаарч 6 дугаар сард сайжирсан байна. Түүнээс хойш санхүүжилтийн зардал өссөн ч хүүний зөрүү буурсаар байна. Эдгээр орнуудын хувьд хөрөнгийн гадагшлах урсгал удааширнаас шалтгаалан цэвэр хөрөнгийн урсгал 2003 онд 110 тэрбум ам. долларт хүрэхээр байгаа нь 90-ээд оны дунд үеэс хойш хамгийн дээд түвшин юм. Хөгжиж буй орнуудын валютуудын хувьд ам. долларын ханшийн уналт бага зэрэг нөлөөлсөн ба ихэнх орны валютын нэрлэсэн үйлчилж буй ханш суларсан байна. Энэ нь урсгал болон хөрөнгийн дансны өндөр ашигтай байдаг Азийн орнуудын валютын нөөцийг ихээр нэмэгдүүлэхэд хүргэв.

Түүхий эдийн зах зээл геополитик, мөчлөгийн байдал, нийлүүлэлтийн талын шокоос ихээхэн хамаарч байв. Дайны өмнө баррель нь 34 ам. долларт хүрсэн газрын тосны үнэ 4 дүгээр сард их хэмжээгээр унасан ч Иракийн газрын тосны үйлдвэрлэл хүлээгдэж байснаас удаан сэргэж байгаа, Нигер болон Венесуэль улсуудын газрын тос олборлолтын түвшин тогтвортой эсэхээс хамаарч 8 дугаар сарын эцэст нэг баррель газрын тос эргээд өсч 30 ам. доллар болов.

Хойд Америк

Нэг жилийн сэргэлтийн дараа АНУ-ын Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий өсөлт Ирак дахь дайны явцын геополитикийн тодорхойгүй байдал өссөн, үл хөдлөх хөрөнгийн үнийн хөөрөгдөл унасны дараахь үр нөлөөнөөс шалтгаалан 2002 оны дундаас мэдэгдэхүйц саарч ирэв. Сул эрэлт болон их хэмжээний илүүдэл хүчин чадал нь инфляцийг мэдэгдэхүйц бууруулан хэрэглээний үнийн индексээр тооцсон суурь инфляци 2 хувиас доогуур байлаа. Ам. доллар ихээр суларсан нь урсгал дансны алдагдалд нөлөө үзүүлж, улмаар алдагдал их хэмжээгээр өссөн бөгөөд өнгөрсөн онтой харьцуулахад алдагдлыг санхүүгийн хөрөнгө оруулалтаар бус засгийн газрын болон корпорацуудын үнэт цаасыг борлуулах (ялангуяа, Азийн хэд хэдэн Төв банкинд) замаар санхүүжүүлсэн байна.

Ирак дахь дайн дуусгавар болсноор эдийн засаг сэргэх түлхэц болж өглөө. Хоёрдугаар улирлын ДНБ-ий гүйцэтгэл хүлээгдэж байснаас өндөр гарсан нь засгийн газрын зарлага болон хувийн хөрөнгө оруулалт, хэрэглээ, ялангуяа, автомашины борлуулалт өссөнтэй холбоотой байна. Төсвийн бодлого татварын хэмжээг бууруулах, батлан хамгаалахын зардлыг өсгөх арга хэмжээний дүнд улам зөөлөн болов. Үнэт цаасны үнэ өсч, ам. доллар 2002 оны эхэн үе дэх оргил үеэсээ их хэмжээгээр суларч, урт хугацааны хүү 6 дугаар сарын дунд үеэс нилээд нэмэгдсэн ч энэ нь хамгийн доод хэмжээндээ байна. АНУ-ын ДНБ-ийг 2003 онд 2.6 хувиар өсөхөөр таамаглаж байна.

Канад улсын ДНБ 2002 онд хүчтэй өссөн боловч тайлант оны сүүлийн саруудад өсөлт нь нилээд удаахрах хандлагатай байна. Энэ нь канад долларын хурдацтай чангаралт, сул гадаад эрэлт болон АЦХХ, үхрийн галзуу өвчнүүдийн түр зуурын нөлөөнөөс шалтгаалсан байна. Дээрх хүчин зүйлс болон суурь инфляци 1-3 хувийн зорилтот хэмжээндээ байгаа зэргээс шалтгаалан Канадын Төв банк 7, 9 дүгээр саруудад хүүний хэмжээгээ бууруулсан байна. АНУ-ын эдийн засаг сайжран, сөрөг нөлөөнүүдийн үр дагавар арилсан нөхцөлд Канад улсын эдийн засгийн өсөлт тайлант оны эцэст нэмэгдэн 1.9 хувьд хүрнэ гэсэн хүлээлттэй байна.

Баруун Европ

Евро бүс дэх эдийн засгийн өсөлт хүлээгдэж байснаас илүү удаашралтай байлаа. Бодит эдийн засаг сэргэнэ гэсэн шинж тэмдэг сулхан байгаа бөгөөд тайлант оны 2 дугаар улиралд евро бүсийн ДНБ-ий өсөлт (Герман, Франц, Итали улсуудыг

оруулаад) буурсан байна. Сүүлийн үед эдийн засаг өснө гэсэн хүлээлт нэмэгдсэн ч ажилгүйдэл өсч, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл тогтвортой өсөх шинж илрэхгүй байна. Герман улсын эдийн засаг гурван жил дараалан зогсонги байгаа нь евро бүсийн эдийн засгийн өсөлтөнд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй тус бүс нутгийн сэргэлтийг хойш нь татаж байна. Дээрх хүчин зүйлсээс шалтгаалан евро бүсийн эдийн засгийн өсөлт 2003 онд 0.5 хувь байхаар таамаглагдаж байна.

Эрэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийг харахад евро бүсийн эдийн засгийн гол хүндрэл нь сүүлийн жилүүдэд хөрөнгө оруулалтын зардал буурсантай холбоотой байна. Үүнд бизнесийн итгэл багассан, баруун, зүүн Герман нэгдсэний дараахь барилгын салбарын огцом үсрэлт үргэлжлэн буурсаар байгаа зэрэг нөлөөлжээ. Евро бүс даяар сүүлийн жилүүдэд хэрэглээ өссөн ба нэмэгдэж буй бодит орлого (инфляци буурч байгаа учраас) нь эдийн засгийн өсөлтөнд илүү их дэмжлэг үзүүлэх нь тодорхой юм. Өрхийн аж ахуйн тэнцлийн хувьд АНУ-тай харьцуулахад өрийн түвшин бага, хуримтлалын түвшин өндөр буюу харьцангуй эрүүл байгаа боловч өрхийн аж ахуйн итгэл сул байгаагаас ажилгүйдэл өссөөр байна. Мөн гадаад худалдааны нөхцөл эдийн засгийн өсөлтөнд таагүй нөлөө үзүүлжээ. Ихэнх орнуудын эрэлт сул байснаас экспорт бага хэмжээнд байж, сүүлийн хоёр жилд евро нилээд чангарсан нь ирээдүйд экспортод түшиглэсэн эдийн засгийн өсөлтийн чиглэлийг бүрхэгдүүлж байна. Энэхүү ханшийн чангаралт нь хүүний түвшинг бууруулахад хүргэжээ.


Евро бүсийн бус орнуудын хувьд Их Британийн эдийн засгийн өсөлт тайлант оны эхний хагаст хөрөнгө оруулалт, хувийн хэрэглээ болон гадаад эрэлт муудсанаас суларлаа. Сүүлийн үеийн бизнес асуулга, жижиглэнгийн худалдааны мэдээнүүд эдийн засаг сайжрах төлөвтэй байгааг илтгэж байна. Ажилгүйдлийн бага түвшин, тогтвортой орлогын өсөлт нь хөдөлмөрийн зах зээлийг тогтвортой байхад нөлөөлөв. Инфляци 2.5 хувиас дээш гарсан ч эдийн засаг сулрах хандлагатай байгаа нь Английн Төв банкыг тайлант оны 7 дугаар сард бодлогын хүүгээ 0.25 хувиар бууруулж 3.5 хувь болгоход хүргэв. Эдийн засгийн өсөлт саарах үед хэрэгжүүлсэн төсвийн бодлого нь эерэг дэмжих нөлөө үзүүлсэн нь чухал алхам боллоо. Эдгээр макро эдийн засгийн дэмжих бодлогууд болон харьцангуй таатай дотоод нөхцөл, гадаад худалдааны сайжралт зэрэг нь эдийн засгийн хүчтэй өсөлтийг дэмжих бөгөөд 2003 онд ДНБ 1.7 хувиар өсөх бололцоотой байна. 2002 онд ДНБ-ий өсөлт 1.9 хувьтай байв.

Дани, Норвеги, Швед зэрэг улсуудын дотоод эрэлт сул, ажилгүйдлийн түвшин өссөн, олон улсын нөхцөл байдал таагүй байсан нь эдийн засгийн өсөлтөнд сөргөөр нөлөөллөө. Эдгээр улсуудын Төв банк 6 дугаар сарын эхээр хүүний хэмжээгээ бууруулсан ч инфляци буурах болон эдийн засгийн идэвх сул байх тохиолдолд дахин хүүгээ бууруулах шаардлага гарч болзошгүй юм. Эдийн засгийн дэмжих бодлого болон гадаад нөхцөл сайжирснаар эдгээр улсын эдийн засаг тайлант оны 2 дугаар хагаст сэргэх хандлага ажиглагдаж байна. Швейцарь улсын хувьд худалдаа сайжирсан болон оновчтой макро эдийн засгийн бодлогын үр дүнд эдийн засаг бага зэрэг өсөх хандлагатай байна. Хэрэв эдийн засгийн өсөлт гарахгүй бол деф-


Зураг 1. Дэлхийн бодит ДНБ-ий өсөлт



Зураг 2. Дэлхийн инфляци



Зураг 3. Дэлхийн зах зээлийн богино болон урт хугацааны хүү



ляцийн эрсдэлийг бууруулахын тулд мөнгөний бодлогыг сулруулах (хүүний хэмжээ тэг руу ойр байгаа учир тоон арга хэмжээ авах магадлалтай) шаардлага гарч ирж болзошгүй юм.

Япон

Эхний улиралд ДНБ-ий өсөлт эцсийн гүйцэтгэлээр өссөн, 2 дугаар улиралд таамаглаж байснаас хавьгүй илүү гарсан нь 2003 онд тус улсын эдийн засаг 2 хувиар өсөх бололцоотой байгааг харуулж байна. Экспорт болон аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 7 дугаар сард өссөн ч жижиглэнгийн худалдаа буурч, үндэсний тооцооны бизнесийн тогтмол хөрөнгө оруулалтын мэдээ сайжирсан байхад хөрөнгө оруулалтын бараа болон барилгын материалын ачилт буурах хандлагатай байна. Мөн санхүүгийн салбарын нөхцөл байдал эдийн засгийн сэргэлтэнд тэгш бус нөлөө үзүүлсэн байна. Үнэт цаас, хувьцааны үнэ өссөн нь сайшаалтай ч, бондын орлогын түвшин оны эхэнд олон жилийн дунджаас хамгийн доод түвшиндээ хүрч, дараа нь эргээд их хэмжээгээр нэмэгдэв.

Өмнөхтэй харьцуулахад эрсдэлүүд нилээд тэнцвэржсэн ч, эдийн засагт бэхэжсэн дефляци болон бизнес, санхүү, улсын секторын тэнцэлд байнга оршиж буй сул талууд нь сөрөг нөлөө үзүүлсээр байна. Дэлхийн эдийн засгийн сэргэлт 2003, 2004 оны өсөлтөнд нөлөөлж болох боловч Японы эдийн засаг дотоод болон гадаад хүчин зүйлсийн цохилтонд хэврэг хэвээр байна. Банк болон санхүүгийн бусад байгууллагын өөрчлөн байгуулалтын ажил удаашралтай явагдаж байгаа нь хувьцаа, үнэт цаас, бондын үнэ унахад байгууллагын болон банкуудын тэнцлийг муутгаад зогсохгүй банкны зээл олголтыг багасгаж, хөрөнгө оруулалтыг бууруулах хандлагатай байна. Бусад эрсдэлд иений ханшийн чангаралт байгууллагуудын ашиг, хөрөнгө оруулалт, дефляци болон цэвэр экспортод хэрхэн нөлөөлөх, өрхийн аж ахуйн хуримтлал ямар хурдтай өсөх, өсөн нэмэгдэж буй улсын өр бодит хүүг илүү өндөр болгох зэрэг эрсдэлүүд орж байна.

Дээрх эрсдэлүүдийг даван туулахын тулд эдийн засаг дахь сул талуудыг арилгах зоригтой алхамууд шаардагдаж байна. Үүнд чанаргүй зээлийн хэмжээг багасгах тууштай арга хэмжээ авах, банкны сектор дахь өөрийн хөрөнгийн чанарт анхаарлаа хандуулах, шинээр байгуулагдсан Японы Аж үйлдвэрийг Сэргээх Корпораци (IRCJ)-ийг үр ашигтай ашиглан үйлдвэрүүдийн өөрчлөн, зохион байгуулалтыг түргэсгэх, Японы Төв банк дефляцийг арилгах шийдвэртэй арга хэмжээ авах, улсын секторын санхүүг тогтворжуулах нарийвчилсан төлөвлөгөө гаргах зэрэг багтаж байна.

Латин Америк

Урьдчилсан байдлаар Латин Америкийн ихэнх оронд эдийн засгийн өсөлт сэргэж байгаа ч бүс нутаг даяар тэгш бус байгаа бөгөөд зарим оронд улс төрийн тогтворгүй байдал сөрөг нөлөө үзүүлсээр байна. Эдийн засгийн өсөлт хэд хэдэн хү-

чин зүйлсийн нөлөөгөөр сэргэх хандлагатай байна. Үүнд, дэлхийн эдийн засгийн өсөлт болон бодит ханшийн их хэмжээний сулралтын үр дүнд экспорт өссөн, эрсдэлийн хэмжээ буурсан нь бондын зах зээлийг идэвхжүүлж, зарим тохиолдолд хоёрдогч зах зээлийн хүүний зөрүүг хамгийн доод түвшинд хүргэсэн, макро эдийн засгийн бодлогын суурь сайжирна гэсэн хүлээлт зэрэг орж байна.

Тайлант онд тус бүс нутгийн эдийн засгийг 1.1 хувиар өснө гэж мэргэжилтнүүд тооцоолжээ. Гэвч эдийн засаг сэргэх явц удаан хэвээр байна. Хамгийн гол эрсдэл нь бондын зах зээл тогтворгүй байгаад оршиж байгаа бөгөөд энэ нь эдийн засгийн өсөлт, макро эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна. Эрсдэлийн түвшин өсөх, аж үйлдвэржсэн орнуудын хүүний түвшин нэмэгдэх нь эдийн засгийн өсөлтөнд сөрөг үр дагавартай ба бүс нутаг дахь бодлогын удаашралт, долларжилтын түвшин өндөр орнуудын рейтингийг үргэлжлүүлэн бууруулах нь мөн сөргөөр нөлөөлөх магадлалтай юм. Эцэст нь, зарим орны улс төрийн байдал тогтворгүй байгаа нь эдийн засгийн сайжралт, бүтцийн өөрчлөлтийн явцыг үгүйсгэх эрсдэлийг бий болгож байна.

Аргентин улсад эдийн засгийн үйл ажиллагаа (аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, барилга) хямралын үеийн түвшнээсээ сэргэж эхэллээ. Сарын инфляци бага, худалдааны тэнцэл их хэмжээний ашигтай гарчээ. Бразил улс бодлогын хувьд итгэл олж чадсан нь бодит ханшийн чангаралт, хүүний зөрүүний багасалтаар харагдаж байна. Гадаад санхүүжилтийн өндөр шаардлага, гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсан зэргээс шалтгаалж эдийн засгийн өсөлт бага байхаар байна. Венесуэль улс 2 дугаар сард өрнөсөн ажил хаялтын дараа газрын тос олборлолтоо сэргээсэн ч эдийн засаг нь тайлант онд 17 хувь, сүүлийн хоёр жилд 26 хувиар тус тус буурахаар байна.

Азийн хөгжсиж буй орнууд

Өнгөрсөн оны эхээр Азийн бүсийн орнуудын эдийн засгийн өсөлт бага зэрэг буурсан ч тайлант онд дэлхийн хамгийн хурдан өсөлттэй бүс байхаар байна. Тайлант онд өсөлт 5.9 хувьд хүрнэ гэж тооцоолж байгаа бол 2004 онд 6.2 хувьд хүрнэ гэсэн таамаглал байна. Өсөлтийг хангах гол хүчин зүйл нь экспортоор дамжсан үйлдвэрлэлийн өсөлт юм. Дотоодын эрэлт тус бүс нутгийн хөгжилд илэрхий нөлөө үзүүлж байгаа ч дэлхийн эдийн засгийн мөчлөг тус бүсийн хөгжлийн мөчлөгийг голчлон тодорхойлж байна. Өнөөгийн байдлаар ам. долларын ханшийн сулралт нь дэлхийн эдийн засгийн эрэлтийг өөр тийш нь шилжүүлж байгаа учир эдийн засгийн өсөлтийг дотоод эрэлтийн өсөлтөөр хангах шаардлага урган гарч ирж байна. Энэхүү зорилтонд хүрэхийн тулд бүтцийн өөрчлөлтийг хурдасгах, зарим оронд ханшийн чөлөөт хэлбэрт шилжих нь илүү ашигтай байна.

Тайлант оны эхээр дотоод эрэлт их хэмжээгээр буурсан нь Иракийн дайнтай холбоотой тодорхойгүй байдал, газрын тосны үнийн өсөлт, мөн АЦХХШ өвчний

ШИГТГЭЭ 1. ДАЛД ЭДИЙН ЗАСГИЙН ХЭМЖЭЭ, ӨСӨЛТ, НӨЛӨӨ

Энэ судалгааны ажил нь дэлхий даяар нүүрлэж буй сүүдрийн (далд, албан бус, параллель) эдийн засгийн тухай ойлголт, түүний үйл ажиллагааны төрлүүд, хэмжээ, өсөлт, ажиллах хүчин, албан эдийн засагт үзүүлж буй нөлөө, түүнийг хэмжих аргачлалын талаар ойлголт өгч, зарим орны жишээн дээр товчхон өгүүлэхийн зэрэгцээ сургаж болохуйц хэд хэдэн санааг тусгасан болно. Судлаачдын үзэж байгаагаар энэ үйл ажиллагаа нь дэлхий даяар жилд триллион орчим доллараар хэмжигддэг бөгөөд татварын байцаагч болон Засгийн газрын мэдэлтнүүдийн нүдэнд өртөхгүй өнгөрдөг байна.

Далд, албан бус, параллель гэж олон янзаар нэрлэгдэх сүүдрийн эдийн засаг нь хууль бус үйл ажиллагаанаас гадна хуулиар зөвшөөрөгдсөн бараа үйлчилгээний үйл ажиллагаанаас олсон мэдээлэгдээгүй орлогуудыг (мөнгөний болон бартерийн хэлцэлүүд) агуулдаг байна.

Хүснэгт 1. Далд эдийн засгийн үйл ажиллагааны төрлүүд

Төрөл	Мөнгөний хэлцэлүүд		Мөнгөний бус хэлцэлүүд	
Хууль бус үйл ажиллагаа	- Хулгайн барааны худалдаа, - Мансууруулах бодисийн худалдаа, үйлдвэрлэл, - Биеэ үнэлэх явдал, - Мөрийтэй тоглоом, - Хилээр зөвшөөрөлгүй бараа оруулалт, - Луйвар, - Мөнгө угаалт, - Авилгал.		- Мансууруулах бодис болон хулгайн аргаар хилээр зөвшөөрөлгүй оруулсан барааны бартер, - Өөрөө хэрэглэх зорилгоор үйлдвэрлэсэн буюу тарьсан мансууруулах бодис, - Хулгай хийлт.	
	Татвараас зугтах	Татвараас зайлсхийх	Татвараас зугтах	Татвараас зайлсхийх
Хууль ёсны үйл ажиллагаа	- Өөрөө олсон мэдээлэггүй орлого, - Хууль ёсны бараа үйлчилгээний ажлаас олсон мэдээлэггүй орлого, цалин, хөлс, болон бусад хөрөнгө	- Ажилчдын хөнгөлөлт, урамшуулал, цалингаас гадуурхи нэмэгдэл орлого (мэдээлэггүй).	- Хуулиар зөвшөөрөгдсөн бараа үйлчилгээний бартер (бүртгүүлээгүй).	- Өөрөө хийсэн бүх зүйлс болон хөршийн тусламж.

*Эх үүсвэр: Липперт, Волкер "Далд эдийн засгийн хэмжээ болон нөлөө, түүний дэлхийг хамарсан байдал"

Сүүдрийн эдийн засгийн хэмжээ

Аль ч орны хувьд сүүдрийн эдийн засгийн хэмжээг тодорхойлоход их хүнд байдаг. Далд үйл ажиллагаа эрхэлдэг хүмүүс ямар нэгэн аргаар илрүүлэлтээс зугатахыг л зорих нь мэдээж. Харин бодлого баригчид болон Засгийн газрын эрх мэдэлтнүүдэд энэхүү эдийн засагт хэдэн хүн ажиллаж байгаа, хэр зэрэг тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа, ямар хэмжээтэй зэрэг олон мэдээлэлүүд хэрэгтэй болдог байна. Энэ бүхнийг урьдчилан мэдсэнээр (бүгдийг нь мэдэх боломжгүй юм) тэд эх үүсвэрээ зохистой хуваарилахад зөв шийдвэр гаргаж чадах болно. Ийм учраас засгийн газрын эдийн засагчид, статистикчид сүүдрийн эдийн засгийн хэмжээг хэр зэрэг том бэ гэдгийг ойролцоогоор тооцоолохын тулд олон зүйл хийсээр байна. Тухайлбал, сүүлийн жилүүдэд олон орны судлаачдын ажил дээр тулгуурлан сүүдрийн эдийн засгийн хэмжээг тодорхойлохдоо 84 орныг жишээ болгон авч хэд хэдэн тооцоолох аргачлалыг ашиглан сүүдрийн эдийн засгийн хэмжээг нь ойролцоогоор тогтоосон байна. Эдгээр ажлын үр дүнд сүүдрийн эдийн засаг дахь үйлдвэрлэл (нэмүү өртөг) гайхмаар том хэмжээтэй гэдэг нь тогтоогджээ.

Хүснэгт 2. ДНБ-д эзлэх сүүдрийн эдийн засгийн дундаж хэмжээ, 1988-2000

Улсуудын ангилал	*ДНБ-д эзлэх хувь, %
Хөгжиж буй орнууд	35-44
Шилжилтийн орнууд	21-30
ЭЗХАХБ-ын гишүүн орнууд (OECD)	14-16

Африк тивд 1998-99 онуудад хийсэн судалгааны тоймоос харахад Нигер ба Египт улсуудын сүүдрийн эдийн засаг хамгийн том буюу ДНБ-ий 77 ба 69 хувийг тус тус эзэлж байна. Харин Өмнөд Африкийн хувьд хамгийн бага буюу ДНБ-ий 11 хувь байна. Ази тивийн хувьд Тайландын сүүдрийн эдийн засаг хамгийн том буюу ДНБ-ий 70 хувь байхад Гонг-Конг, Сингапур улсуудын хамгийн бага буюу 14 хувь байна (1998-99). Харин Өмнөд Америкт (1998-99) Боливийн хамгийн том (67 хувь), Чили улсын хамгийн бага (19 хувь) байна.

Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан улсуудын хувьд 1998-99 онуудад хийсэн судалгаагаар Гүрж улсын сүүдрийн эдийн засгийн хэмжээ хамгийн их буюу ДНБ-ий 64 хувь, Орос улсынх 44 хувь байсан бол Узбекистан улсынх хамгийн бага буюу 9 хувь байна. Төв болон Зүүн Европын шилжилтийн орнуудаас хамгийн их нь Болгарынх (34 хувь), хамгийн бага нь Словак улсынх (11 хувь) байна.

ЭЗХАХБ-ын улсуудын хувьд (21 улс) 1999-2001 онуудад хийсэн судалгаагаар Грек болон Итали улсуудын сүүдрийн эдийн засгийн хэмжээ хамгийн их буюу ДНБ-ий 30 ба 27 хувьтай тус тус тэнцэж байна. Харин Скандинавын улсууд дунд зэрэглэлд багтаж, АНУ, Австри (тус бүр 10 хувь), Швейцарь (9 хувь) зэрэг улсуудын хамгийн бага байна.

Сүүдрийн эдийн засгийн өсөлт, ажиллах хүчин

Ихэнх шилжилтийн орнууд болон гүйцэт судлагдсан ЭЗХАХБ-ын гишүүн бүх улсуудын хувьд сүүдрийн эдийн засаг маш түргэцтэй хөгжиж байна. Харин хөгжиж буй орнуудын хувьд тоон үзүүлэлтүүдийн дутуу дулимагаас шалтгаалан чиг хандлагыг нь нарийн дүгнэн гаргах боломжгүй байна. Сүүдрийн эдийн засаг нь 1990-1998 онуудад хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүн улсуудад хамгийн ихээр хөгжсөн ба ДНБ-ий дөрөвний нэгээс гуравны нэг илүү гаруй хувь хүртэл өсч байсан байна. Харин Төв ба Зүүн Европын орнуудад бараг тогтмол буюу ДНБ-ий тавны нэг хувийг эзэлж байжээ.

ЭЗХАХБ-ын гишүүн 21 орныг тоймчилбол; Бельги, Дани, Итали, Норвеги, Испани, Швед зэрэг улсуудын хувьд сүүдрийн эдийн засаг сүүлийн 30 жилд (1970-2000) хоёр дахин өссөн буюу ДНБ-ий 10 хувиас 20 гаруй хувьд хүрчээ. Далд эдийн засгийн өсөлт нь түүний хэмжээний хувьд харьцангуй бага улсуудын хувьд ч

гарсан байна. Тухайлбал, 1970 онд сүүдрийн эдийн засаг АНУ-ын ДНБ-ий 4 хувийг эзэлж байсан бол 2000 онд 9 хувь болж өсчээ.

Сүүдрийн эдийн засгийн ажиллах хүчний зах зээлд оролцох оролцоо түүний хэмжээний адил өссөөр байна. Энэхүү ажиллах хүчний зах зээл дээр ажиллагаа эсвэл тэднийг хөлслөгчид эсвэл хоёулаа албан ёсоор зохих байгууллагад бүртгэгдэж тэмдэглэгдсэн байна уу үгүй юу гэдгийг үл тоомсорлон сүүдрийн эдийн засгийн зах зээл дээрх үйлдвэрлэлийн байдлыг барьж хянаж эрхэлдэг байна. Зарим ажилчид албан ёсны ажлын цагаар эсвэл түүний дараа сүүдрийн эдийн засагт дараагийн ажил мэргэжлээ эрхэлдэг нь ч тодорхой. Түүний зэрэгцээ зарим хүмүүс зөвхөн сүүдрийн эдийн засагт ажиллаж байгаа нь нэг талаас тэдэнд их ашиг өгдөг нөгөөтэйгүүр тэд албан эдийн засагт ажиллах эрхгүй байдагтай холбоотой юм. Сүүлийн жишээ бол хууль бус цагаачид юм.

1990 оны сүүлчээр Европын холбооны улсуудад 20 сая хүн, ЭЗХАХБ-ын гишүүн Европын орнуудад 35 сая хүн сүүдрийн эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлдэг гэсэн тоо баримт байна. Тухайлбал, 1997-98 онуудад Италид хамгийн их буюу нийт ажиллах хүчний 30-48 хувь, Испанид 12-32 хувь, Шведэд 20 хувийг сүүдрийн эдийн засгийн ажиллах хүчин бүрдүүлж байна. Ер нь хаа ч гэсэн ажилгүйчүүдийн түвшин өндөр байх тохиолдолд дээрх хувь өндөр байх магадлалтай байдаг байна.

Татварын түвшин харьцангуй доогуур, цөөн тооны албан ёсны сайн зохицуулагдсан хууль журамтай орнуудад сүүдрийн эдийн засгийн хэмжээ бага байдаг байна. Хэд хэдэн орны макроэдийн засаг болон микроэдийн засгийн тоон үзүүлэлтүүд дээр үндэслэгдсэн загваруудын судалгаанаас харахад сүүдрийн эдийн засгийн хэмжээ болон өсөлтийг удирддаг гол хүчин зүйл бол татварын ачаалал, нийгмийн хамгааллын төлбөрүүд, мөн тэдэнтэй хослон албан ёсны ажиллах хүчний зах зээлийн хязгаарлалтын өсөлт юм. Түүний зэрэгцээ албан эдийн засаг дахь цалингийн түвшин багагүй үүрэг гүйцэтгэдэг байна.

Зарим судалгаанууд хээл хахуулийн түвшний бууралт болон сүүдрийн эдийн засгийн өргөжилтийн хооронд шууд хамаарал байдгийг тогтоосон хэдий ч ерөнхийдөө бусад бүх судалгаануудаас харахад хээл хахуулийн газар авалт нь сүүдрийн эдийн засгийн хэмжээ томорсны үр дүнд үүсдэг байна.

Албан эдийн засагт үзүүлж буй нөлөөнүүд

Сүүдрийн эдийн засгийн хэмжээ дэх өөрчлөлт нь дараахь үр дагавруудыг авчрах магадлалтай. Үүнд:

- Мөнгөний үзүүлэлтүүд. Сүүдрийн эдийн засгийн хэлцэлүүд нь бэлэн мөнгөөр хийх сонирхолтой байдаг бөгөөд түүний үйл ажиллагааны өсөлтийг бэлэн мөнгөний эрэлтийг нэмэгдүүлэхтэй адилтгаж болно.
- Ажиллах хүчний зах зээлд оролцох түвшин ба ажлын цаг. Далд эдийн засагт ажиллаж буй хүмүүсийн тоо өсөхийн хэрээр албан эдийн засагт оролцох түвшин буурах хандлагатай байдаг. Дээрхтэй адил хүмүүс далд эдийн засагт олон цаг ажиллавал албан эдийн засагт ажиллах ажлын цаг багасах нь мэдээж.
- Үйлдвэрлэлийн статистик. Сүүдрийн эдийн засаг өсөхийн хэрээр бүтээгдэхүүний өгөгдлийн (ялангуяа ажиллах хүч) хэсэг нь ч гэсэн албан эдийн засгаас шилжих болно. Энэ нь албан эдийн засгийн өсөлтийн хувийг дарах магадлалтай.

Сүүдрийн эдийн засгийг хэмжих нь

Шинжээчид болон бодлого баригчид сүүдрийн эдийн засаг тооцооны аргачлалаас шалтгаалан зөрүүтэй байж болох магадлалтайг мэдэхийг зорьдог.

Тооцооны сайн аргачлалуудыг сонгож чадаагүй хэдий ч аргачлал бүрийн чадвар, үр дүн нь өөрсдийн илүү болон сул талууд, бүтээмжээ тусган харуулж чаддагаараа онцлогтой. Хүснэгт 3-т энгийн аргачлалуудыг товч дурьдлаа. Сүүдрийн эдийн засгийг тооцохдоо ихэвчлэн “бэлэн мөнгөний эрэлт” болон “далд хувьсагч”-ийн хандлагыг өргөн ашигладаг байна.

Монгол улс дахь албан бус хэвшил

Сүүдрийн эдийн засаг ямар ч нийгэмд, аль ч улсад оршин тогтдог гэж дээр өгүүлсэн билээ. Харин хэр хэмжээтэй, ямар өсөлттэй гэдгийг нь тухайн улсын хувьд тодорхойлж, албан эдийн засагтайгаа харьцуулан хослуулж ямар арга хэмжээ авахаа шийдэх нь чухал юм. Дээр өгүүлснээр Монгол улсын сүүдрийн эдийн засгийн хэмжээг ойролцоогоор тооцоолвол хөгжиж буй орнуудын жишгээр ДНБ-ий 35-44 хувь, шилжилтийн орнуудынхаар 21-30 хувь болж байна (Хүснэгт 2.). Эдгээрийн дунджаар авч үзвэл 32.5 хувь болж байна (энэ нь хамгийн энгийн арифметик аргачлал). 2002 оны нэрлэсэн ДНБ-ий хэмжээ 1094.5 сая америк доллар байсан бөгөөд үүний 32.5 хувь буюу 355.7 сая америк долларын хэмжээтэй сүүдрийн эдийн засаг манай улсад байна гэсэн тоймчилсон тооцоо гарч байна (Шилжилтийн орнуудынхаар 229.8-328.4 сая америк доллар, хөгжиж буй орнуудынхаар 383.1-481.6 сая америк долларын хооронд хэлбэлзэж байна).

Монгол улсын албан бус хэвшлийн үйл ажиллагааг судалсан хэд хэдэн ажлууд байдаг. Тухайлбал, Дж. Андерсоны “Шилжилтийн үеийн Монгол улсын албан бус хэвшлийн хэмжээ, гарал үүсэл, хэв маяг” (1998), Б. Бикалес, Ч. Хүрэлбаатар, Ш. Карин “Монгол улсын албан бус хэвшил: Санал асуулгын үр дүн болон шинжилгээ” (1999), Э. Моррис “Монгол дахь албан бус хэвшил” (2001) зэрэг олон ажлуудыг тоочиж болно. Эдгээрээс Монгол улсын албан бус хэвшлийн үйл ажиллагааны төрлүүд, хэмжээ, өсөлт, ажиллах хүчний талаархи мэдээлэл, албан эдийн засагт үзүүлж буй нөлөө, цаашид авах арга хэмжээ зэрэг олон зүйлийг мэдэж болно. Дж. Андерсоны судалгаагаар манай улсын албан бус хэвшлийн үйлдвэрлэл (нэмүү өртөг)

Хүснэгт 3. Сүүдрийн эдийн засгийг хэмжих арга замууд

Аргачлалууд	Гол онцлогууд
Шууд хандлагууд: - Түүвэрлэсэн тойм - Татварын хяналт	Сүүдрийн эдийн засгийн хэмжээг шинжилсэн (судалсан) тоон үзүүлэлтүүдээр тоймчлон тогтоох. Сүүдрийн эдийн засгийн хэмжээг татвараас нууж дарагдуулсан орлогын хэмжээг санхүүгийн шалгалтаар тогтоох.
Шууд бус хандлагууд: - Үндэсний статистикийн бүртгэл - Ажиллах хүчний статистик - Хэлцэлүүд - Бэлэн мөнгөний эрэлт - Бодит зардал (эрчим хүчний хэрэглээ)	Сүүдрийн эдийн засгийн хэмжээг үндэсний бүртгэлийн болон хувийн тоон үзүүлэлтийн орлого, зарлагын статистикийн зөрүү дээр үндэслэн тогтоох. Сүүдрийн эдийн засгийн өсөлтийг нийт ажиллах хүчний хэмжээг тогтмол гэж үзээд албан эдийн засаг дахь ажиллах хүчний бууралт дээр тулгуурлан тогтоох. Эдийн засаг дахь мөнгөний бүх хэлцэлүүдийн тоон үзүүлэлтийг ашиглан нийт нэрлэсэн ДНБ-ий хэмжээг (албан бус дээр нэмэх нь албан) тооцоолсны дараа түүнээс албан ДНБ-ий хэмжээг хасч сүүдрийн эдийн засгийн хэмжээг тогтоох. Сүүдрийн эдийн засгийн хэмжээг тогтоохдоо түүний бүх хэлцэлүүд нь бэлэн мөнгөөр явагддаг гэж үзээд түүний өсөлтийг бэлэн мөнгөний эрэлттэй холбон тайлбарлах. Сүүдрийн эдийн засгийн өсөлтийг тооцохдоо эрчим хүчний хэрэглээг эдийн засгийн нийт үйл ажиллагааны ганц шилдэг тодорхойлогч гэж үзээд түүний хэрэглээгээр тооцно. Ингэхдээ эрчим хүчний нийт хэрэглээний өсөлтийн хувиас албан ДНБ-ий өсөлтийн хувийг хасч, ялгаврыг нь сүүдрийн эдийн засгийн өсөлтөнд хамааруулна.
Загварууд: Далд хувьсагчийн хандлага	Сүүдрийн эдийн засгийн хэмжээг тооцохдоо ажиглалтаар тодорхойлогдсон, түүнд нөлөө үзүүлэхүйц хувьсагчуудыг агуулсан функц болгон авч үзнэ. Тухайлбал, татварын ачаалал, засгийн газрын зохицуулалтын дарамтууд болон сүүдрийн эдийн засгийн үйл ажиллагааны ул мөр болж үлдсэн хувьсагчууд (бэлэн мөнгө, ажлын албан цаг, ажилгүйчүүд, г.м.) болно. Энэ хандлага олон нөхцөл шалтгаан, үр дүнг хамтад нь зэрэг авч үздэгээрээ бусдаасаа илүү давуу талтай болно.

ДНБ-ий 30-38 хувьтай тэнцүү гэж дүгнэсэн нь дээрх тооцоотой ойролцоо байна. Дээрх судалгаанууд нь тоон үзүүлэлтүүдийн хүндрэлээс шалтгаалан албан болон албан бус эдийн засагт үйл ажиллагаа эрхэлж буй хүмүүсийн дунд санал асуулга явуулах, түүвэрчилсэн судалгаа хийх, ярилцлага авах зэрэг шууд аргачлалын замаар хийгдсэн байна. Цаашид эдийн засгийн тоон үзүүлэлтүүдээ улам сайжруулан, мэдээллийн суурийг бий болгож, түүнд суурилан шууд бус болон загварчлах аргачлалуудыг хослуулан хэрэглэж албан бус хэвшлийн хэмжээ, өсөлтийг тооцоолж гаргах нь бидний хувьд чухал асуудал болж байна.

Дүгнэлт

Сүүдрийн эдийн засгийн хэмжээний өсөлт нь улсын бараа үйлчилгээний чанар болон тоо хэмжээ буурч, улмаар улсын орлого багассаны үр дүнд бий болдог гэж өмнө нь дурьдаж байлаа. Гэвч ихэнх тохиолдолд пүүс компани болон иргэдэд ноогдуулж буй татварын түвшний өсөлт, улсын бараа, үйлчилгээний (засгийн газрын мэдэлд буй зам, эмнэлэг, г.м.) чанар ба зохион байгуулалт муудсантай уялдан бий болдог байна.

Нөгөө талаар сүүдрийн эдийн засагт бий болсон орлогын гуравны хоёр нь түргэн хугацаанд албан эдийн засагт зарцуулагддаг байна. Магадгүй энэ нь албан эдийн засагт тус болж түүнд нэмэлт өсөлтийг бий болгох талтай. Иймээс сүүдрийн эдийн засгийн өсөлт нь бүх зүйлд нөлөө үзүүлж чадна. Гэвч энэ нөлөө нь ихэнхдээ эерэг байна уу эсвэл эсрэг байна уу гэдгийг үнэлж дүгнэхэд их хэцүү.

Засгийн газар сүүдрийн эдийн засгийг хянахын тулд хууль тогтоол гаргаж чадна. Татварын түвшин өндөр, бага хэмжээний сүүдрийн эдийн засагтай улсын хувьд хууль журмыг сайн даган мөрдсөний үр дүнд татварын түвшинг бууруулж чадаж байна гэдгийг зарим судалгааны ажил харуулж байна. Үүнд цөөн тооны хууль журам, түүнийг тогтвортой мөрдөх болон хээл хахуулийн газар авалт бага байгаа зэрэг хүчин зүйлсүүд хослон нөлөөлсөн байна.

Сүүдрийн эдийн засгийн хэмжээ болон өсөлтийг удирдаж буй гол хүчин зүйлс нь татварын дарамт, нийгмийн хамгааллын төлбөрүүд болон улсын зохицуулах журамлах үйл ажиллагааг (хууль зүйн орчин) хэт тархаасан явдал болно. Хууль тогтоолыг сул дорой болон дур зоргоороо мөрдөх нь сүүдрийн эдийн засгийн үйл ажиллагааг өөгшүүлж өгдөг бөгөөд олон орны туршлагаас харахад авилгал болон сүүдрийн эдийн засагтай холбогдох үйл ажиллагааг хянах хуулийн дүрэм журмын чухлыг онцлон тэмдэглэсэн байна.

Эцэст нь бодлого баригч хүмүүст зориулан доорхи ашиглаж болохуйц хэдэн санааг товч өгүүлэе.

- Татварын түвшинг бууруулах нь сүүдрийн эдийн засгийг багасгах гол хүчин зүйл биш ч гэсэн түүнийг тогтворжуулах сайн талтай.
- Ахиу татварын түвшин нь татварын дундаж түвшнөөс илүү сүүдрийн эдийн засгийн хүмүүст ажлын шийдвэр гаргахад тус дөхөм болдог байна. Тухайлбал, шууд татварыг шууд бус татвараар орлуулж татварын шаардлагыг сайжруулна гэдэг нь үнэмшил багатай зүйл юм.
- Татвараас зайлсхийлтийн эсрэг олон удаагийн давтагдсан татварын санхүүгийн шалгалт хийж, өндөр торгууль ноогдуулах нь сүүдрийн эдийн засгийн хэмжээг багасгахад нөлөөлөх талтай.
- Засгийн газар сүүдрийн эдийн засгийн үйл ажиллагааг хуульчлахад онцгой ач холбогдол өгөх ёстой. Жишээлбэл, ажиллах хүчний зах зээлийг саармагжуулах.
- Зохицуулалт журамлалтыг чөлөөтэй болгох, авилгалд автах явдлыг багасгахын тулд эдийн засгийн өрсөлдөөнийг бий болгох, пүүс компаниудыг сүүдрийн эдийн засгаас албан эдийн засаг уруу шилжүүлэх тулд шинэтгэл хийх шаардлагатай.
- Засгийн газар журмынхаа тоог өсгөхөөс илүү түүнийг хамгийн бага түвшинд ч гэсэн хатуу чанга даган мөрдөхийг хуульчлах нь илүү ач холбогдолтой.

тархалттай голчлон холбоотой байв. Зохистой харьцааны журмын чангаралт, орон сууцны үнийн удаан өсөлт болон зээлийн карттай холбоотой гэмт хэрэг өссөнөөс Солонгост өрхийн аж ахуйн зээлийн өсөлт буурсан байна. Бүс нутаг доторхи худалдаа өсч байсан ч Филиппин, Солонгос зэрэг улсуудын экспорт электрон барааны салбарын уналтаас шалгаалан оны эхэнд буурч байв. Оны эхний улиралд экспорт, хөрөнгө оруулалт өссөнөөс Хятад улсын эдийн засаг жилийн 10 хувь өснө гэсэн тооцоо гарч байсан бол АЦХХШ өвчний улмаас 2 дугаар улирлаас уг өсөлт буурч эхлэв. АЦХХШ өвчин Хонгконг, Сингапурт илүү их нөлөөлж, жижиглэнгийн худалдаа болон жуулчдын тоог бууруулав.

Дээрх эдийн засгийн уналтаас сэргийлэх бодлого боловсруулагчдын гаргасан шийдвэр ихэнх тохиолдолд зохистой байлаа. Инфляцийг тогтворжуулсан нөхцөлд ихэнх орон мөнгөний бодлогоо сулруулсан ч их хэмжээний валютын нөөц хуримтлуулсаар байгаа нь ханшийг уян хатан болгох арга хэмжээ хойш тавигдсаар байгааг илтгэж байна. АЦХХШ өвчний хор хөнөөлийг арилгах үүднээс зарим оронд төсвийн урамшуулалтын бодлогыг авч хэрэгжүүлэв. Гэвч Филиппин, Энэтхэг улсуудад их хэмжээний улсын өр хуримтлагдсан, банкны салбарын байдал хүндрэлтэй байгаа зэргээс шалтгаалан төсвийн урамшуулалт бодлого хэрэгжүүлэх боломж нэн хязгаарлагдмал байна. Макро эдийн засгийн бодлогоос гадна чанаргүй зээлийн асуудлыг шийдэх (Хятад, Индонез, Филиппин, Тайланд), зээл эргэн төлөгдөх хууль тогтоомжийг чангатгах, бүтцийн өөрчлөлт хийх (Энэтхэг, Солонгос, Филиппин, Тайланд), нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагааг бэхжүүлэх, компанийн зохистой удирдлагын шинэчлэлийг цаашид үргэлжлүүлэн хийх (Солонгос), банкуудыг дахин хувьчлах (Индонез, Солонгос) зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Европын Холбоонд нэр дэвшсэн улсууд

Европын Холбоонд нэр дэвшсэн улсуудын эдийн засгийн өсөлт богино хугацаанд өсөх тааламжтай нөхцөлд байна. Тус бүс нутгийн бодит ДНБ-ий өсөлт тайлант онд 3.9 хувь байгаа бол 2004 онд 4.3 хувьд хүрэхээр байна. Ихэнх оронд эдийн засгийн өсөлт нь экспорт болон хувийн хэрэглээний өсөлтөөр хангагдав. Цаашид ДНБ-ий өсөлт экспортын өсөлтөөр хангагдахаар байгаа нь эргээд хөрөнгө оруулалтыг дэмжинэ гэсэн таамаглал төрүүлж байна. Экспорт одоохондоо хүчтэй байгаа ч Европын Холбоонд нэр дэвшсэн улсуудын эдийн засгийн өсөлт нь евро бүсийн орнуудын эдийн засгийн сэргэлтээс хүчтэй хамааралтай хэвээр байгаа бөгөөд тус бүс нутгийн ихэнх орны евро бүс дэх экспорт нь ДНБ-ий 10-35 хувийг эзэлж байна. Тус улсуудын хувьд 2002 оны 2 дугаар сараас хойш явагдаж буй еврогийн ханшийн чангаралт нь бас нэг эрсдэл юм. Учир нь зарим орон өөрийн валютыг еврод уяснаар бодит ханш нь чангарах юм. Евро бүс дэх экспортын жин нь өндөр, бодит ханш нь их хэмжээгээр чангарсан улсуудын цэвэр экспорт ДНБ-ий өсөлтөнд сөргөөр нөлөөлөв.

Европын холбоонд элссэнээр тус бүс нутгийн эдийн засгийн өсөлт дунд хугацаанд хурдсах боломжтой ч зарим эрсдэл оршсоор байна. Төсвийн тэнцэл ихэнх оронд

хүнд байгаагаас гадна хүн ам хөгшрөх, Европын холбооны байгаль орчны стандартыг хангах зэрэг гарч болзошгүй зардлыг санхүүжүүлэх шаардлага гарна. Банкны салбар эрүүл байгаа ч, хувийн секторт олгосон зээлийн хэмжээ огцом өссөн бөгөөд Европын холбоонд элссэнээр банкны өрсөлдөөн ширүүсч, хүүний зөрүүг багасгах дарамт ирж болзошгүй юм. Урсгал тэнцлийн алдагдал их, зарим оронд тогтворгүй шинжтэй болсон байна. Эцэст нь хөрөнгө гэнэт гадагшлах эрсдэл байгаа нь сүүлийн үеийн богино хугаацааны сонирхолоор хийсэн хөрөнгө оруулалтаас харагдаж байна.


Дээрх эрсдэл байгаа нөхцөлд төсвийн тэнцлийг сайжруулах, банкны салбарын хяналтыг чангатгах, өсөлтийг дэмжсэн бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Эдийн засаг тааламжтай байгаа энэ үед дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь тохиромжтой юм. Ихэнх орнууд 2004 оны дундуур Европын холбоонд элсэхээр төлөвлөж байгаа ба алсдаа еврог төлбөрийн хэрэгслээ болгох зорилго нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах бодлогын маш чухал хүчин зүйл болж байгаа юм.

Тусгаар Тогтносон Улсуудын Хамтын Нөхөрлөл (ТТУХН)


ТТУХН-ийн орнуудын эдийн засаг хүлээгдэж байснаас тэгш бус өссөн байна. 1999-2002 онуудад ДНБ-ий дундаж өсөлт 7.5 хувьд хүрсэн нь ОХУ 1998 оны санхүүгийн хямралаас гаран сэргэж эхэлсэн, газрын тосны үнэ болон эрчим хүчний экспорт өссөн, үүнтэй холбоотойгоор засгийн газрын зардал өсч, эрчим хүчний секторын хөрөнгө оруулалт өссөнөөр тайлбарлагдаж байна. Эдийн засгийн идэвх тайлант онд хүчтэй байсан нь тус бүс нутгийн эдийн засгийн өсөлтийг таамаглаж байснаас 1.4 нэгжээр илүү буюу 5.8 хувиар өсгөхөөр байна. Эдийн засаг өснө гэсэн энэхүү таамаглалд ОХУ зэрэг цэвэр эрчим хүч экспортлогч орнуудын эдийн засгийн хүчтэй өсөлт голчлон нөлөөлжээ. Зарим улсыг эс тооцвол хэрэглээний өсөлт буурснаар тус бүс нутгийн эдийн засгийн өсөлт ялимгүй удаахрах хандлагатай байна.

Тус бүс нутгийн гадаад урсгал тэнцлийн илүүдэл 2003-2004 онуудад буурах хандлагатай байгаа нь эрэлтийн хүчтэй өсөлт, газрын тосны үнийн бууралт, гадаадын шууд хөрөнгө оруулалттай холбоотой импортын эрэлт өссөн зэрэгтэй (Азербайжан, Гүрж, Казахстан) холбоотой байна. ОХУ-ын хувьд урсгал тэнцлийн илүүдэлтэй байхаар байна. Цэвэр хөрөнгийн дотогшлох урсгал зарим оронд сайжирснаар ОХУ болон Казахстан улсууд их хэмжээний валютын нөөц хуримтлуулж чадсан байна. Харин цэвэр эрчим хүч импортолдог орнууд нилээд их хэмжээний урсгал тэнцлийн алдагдалтай гарахаар байгаа нь (ядуу болон их хэмжээний өртэй Армен, Азербайжан, Гүрж, Киргиз, Молдов, Тажикстан, Узбекистан улсуудын хувьд) шийдвэрлэх чухал асуудал болоод байна. Эдгээр улсуудын хувьд төсвийн чанга бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байгаа бол зарим улсуудад гадаад өрийн асуудлаа шийдэхийн тулд олон улсын байгууллагын тусламж авах хэрэгтэй байна.

Зураг 4. Дэлхийн зах зээлийн алтны үнэ



Зураг 5. Дэлхийн зах зээлийн зэсийн үнэ



Зураг 6. Дэлхийн зах зээлийн түүхий нефтийн үнэ



Инфляци бүс нутаг даяар буурч байгаа ч бусад хөгжиж буй орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр хэвээр байна. Илүү их өөрчлөлтийг хийж байгаа улсуудад инфляци нэг оронтой тоогоор илэрхийлэгдэх болсон бол ОХУ-д өндөр хэвээр байна. Харин өөрчлөлтийг удаан хийж буй улсууд Белорус, Узбекистан дахь инфляци буурч байгаа ч өндөр хэвээр байна. ТТУХН-ийн ихэнх орнуудад эдийн засгийн мөнгөжилтийн процесс чухал асуудлуудыг гарган тавьж байна. Мөнгөжилтийн хурдыг урьдчилж харах нь хэцүү байдаг бөгөөд энэ нь бодлого боловсруулагчдыг мөнгөний эрэлтийг тааварлах, банкны салбарын эрсдэлийг (учир нь мөнгөжилтийн процесс нь зээлийн өндөр өсөлтийг дагуулдаг) удирдахад бэрхшээлтэй болгож байна. Иймд банкны салбарын зохистой харьцааны хяналт шалгалтыг цаашдаа сайжруулж, чангатгах нь чухал юм.

1.2. Дэлхийн зах зээлийн ханш, хүү

Америк долларын ханш 2002 оны 2 дугаар сард дээд цэгтээ хүрсний дараа аж үйлдвэржсэн орнуудын валютын ханш ихээр өөрчлөгдлөө. 2002 оны эхнээс 2003 оны 8 дугаар сар хүртэл ам. доллар еврогийн эсрэг 20 хувиар суларсан бол иен, фунт стерлинг, канад долларын эсрэг 10-12 хувь, австрали долларын эсрэг 20 хувиар суларсан байна. Худалдааны хувийн жингээр жигнэсэн ханшийн хөдөлгөөн хоёр талын ханшийн хөдөлгөөнөөс бага байлаа. АНУ-ын худалдааны тал орчим хувь нь хөгжиж буй орнуудтай хийгддэг бөгөөд эдгээр орнуудын долларын эсрэг ханш тогтвортой байсан болон суларснаас ам. долларын нэрлэсэн үйлчилж буй ханш 11 хувиар суларсан байна. БНХАУ болон Мексик улс Канадын дараа орох томоохон импортын нийлүүлэгч улсууд бөгөөд БНХАУ ам. долларын эсрэг тогтмол ханшийн бодлого баримталдаг бол Мексикийн песо 17 хувиар суларсан байна. Евро бүсийн орнуудын нэрлэсэн үйлчилж буй ханш евро/долларын ханштай харьцуулахад бага хэмжээгээр суларсан нь Европ доторхи худалдааны хэмжээ их, мөн Зүүн болон Төв европын орнуудтай хийх худалдаа өсч байгаатай холбоотой байна. Тухайлбал, Герман, Франц улсуудын нэрлэсэн үйлчилж буй ханш 2002 оны эхнээс 5-6 хувиар чангарсан байна.

Ихэнх бүс нутагт мөнгөний бодлогын өөрчлөлт нь ханшийн өөрчлөлтөөс мөнгөний нөхцөл байдалд бий болсон нөлөөг арилгахад чиглэгдлээ. АНУ болон Их Британид 2002 оны эхнээс мөнгөний нөхцөл байдлыг зөөлрүүлснээр хүүний түвшин бага, валют сул болов. Энэ үед евро бүсийн мөнгөний нөхцөл байдал ерөнхийдөө тогтвортой байсан ба еврогийн чангаралтаас гарах үр дүнг нөхөж, хүүний хэмжээг бууруулав. Япон улс валютын зах зээл дээр их хэмжээний интервенци хийсэн ч иений ханш чангарч хүсэж байсан мөнгөний нөхцөл байдлыг зөөлрүүлж чадсангүй.

1.3. Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ

Тайлант оны 3 дугаар сарын эхээр Ирак дахь цэргийн үйл ажиллагаа эхэлснээр газрын тосны үнэ нэг баррель нь 34 ам. доллараас 25.5 ам. доллар болтлоо буурсан байна. Дайнтай холбоотой газрын тосны нийлүүлэлтийн алдагдал Иракаар

хязгаарлагдаж бусад ОПЕК-ийн гишүүн орнууд олборлолтоо ихэсгэснээр Иракийн газрын тосны экспорт, Нигерийн 3, 4 дүгээр сард дотоодын зөрчлөөс үүссэн зарим бүтээгдэхүүний алдагдлыг нөхлөө. Венесуэль улсын газрын тос олборлолт ажил хаялтын дараа хурдан сэргэсэн ч энэхүү сэргэлт удаан хугацааны тогтвортой эсэх нь тодорхойгүй байна. Саудын Арабын үйлдвэрлэл 3-5 дугаар сард их хэмжээгээр өссөн байна. Хойд америкт хүлээж байснаас илүү хүйтэн байсан нь газрын тосны эрэлтийг хэт өсгөж, үүний дараа улирлын шинж чанартай газрын тосны хэрэглээ буурсан нь газрын тосны үнэ буурахад нөлөөлсөн байна. Гэвч аж үйлдвэрийн газрын тосны нөөц 2003 оны эхээр сүүлийн 10 жил дэх хамгийн доод түвшиндээ очсон, АНУ-ын эрчим хүч үйлдвэрлэдэг компаниудын эрэлт өссөн, ОПЕК-ийн гишүүн орнууд үйлдвэрлэлийн хэмжээгээ бууруулна гэж зарласан, Ирак дахь газрын тос олборлолт удааширсан зэргээс шалтгаалан газрын тосны үнэ 5 дугаар сараас эргээд өсч эхлэв. Түүнээс хойш газрын тосны үнэ хэлбэлзэж ирсэн бөгөөд ерөнхийдөө өсөх хандлагатай байлаа.

Тайлант оны эхний хагаст шатахууны төрлийн бус түүхий эдийн үнэ дайнтай холбоотой тодорхойгүй байдал, АЦХХ өвчин, эдийн засгийн идэвх хүлээгдэж байснаас удаан сэргэж байгаа зэргээс шалтгаалан буурлаа. Шатахууны төрлийн бус түүхий эдийн зээлжих тусгай эрх (ЗТЭ)-ээр тооцсон үнийн индекс оны эхний хагаст 3.8 хувиар буурсан байна. Харин ам. доллараар тооцсон үнийн индекс 1.6 хувиар өссөн нь ам. доллар бусад валютуудын эсрэг суларснаас шалтгаалсан байна.

Металлын үнийн хөдөлгөөн аж үйлдвэрийн салбарын үйл ажиллагаа, тэдгээрийн сэргэлтээс хамаарч хэлбэлзэж байлаа. ЗТЭ-ээр илэрхийлэгдэх металлын үнэ 2002 оны 2, 3 дугаар улирлуудад буурсан бол сүүлчийн улирал болон 2003 оны эхээр өссөн байна. Гэвч дэлхийн эдийн засгийн сэргэлт удаашрах хандлагаас шалтгаалан 2 дугаар улиралд эргээд үнэ нь буурсан байна.



МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2 МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН
ЗАСГИЙН ТОЙМ

2.1. Ерөнхий тойм

Тайлант онд Монгол улсын Засгийн газар болон Монголбанк макро эдийн засгийн тогтворжилтыг бататгах, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, улсын төсөв, санхүүг эрүүлжүүлэх, өрийн дарамтыг арилгах, экспортын чиглэлтэй хувийн хэвшлийн өсөлтийг дэмжих замаар эдийн засаг, нийгмийн салбарын шинэчлэлийг түргэтгэхэд гол анхаарлаа хандуулан ажиллалаа.

Энэ ажлын хүрээнд Монголбанкнаас хэрэгжүүлсэн мөнгө, санхүүгийн бодлогын үр дүнд санхүүгийн салбарын тогтвортой байдал бэхжиж, санхүүгийн зуучлал улам эрчимжлээ. Түүнчлэн бараа үйлчилгээний үнэ, ханш харьцангуй тогтвортой байсан нь эдийн засгийн өсөлтөнд эерэг нөлөө үзүүлсэн байна.

Өнгөрсөн онуудтай харьцуулахад манай оронд байгаль цаг агаарын харьцангуй таатай нөхцөл бүрдэж, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл сэргэлээ. Мөн аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2.0 хувиар нэмэгдэж, ДНБ-ий өсөлт урьдчилсан тооцоогоор 5.5 хувьд хүрэв. ДНБ-д аж үйлдвэрийн салбарын эзлэх хувийн жин өмнөх оныхоос 1.2 нэгжээр буурч 25.0 хувь, хөдөө аж ахуйн салбарынх 0.2 нэгжээр буурч 23.3 хувь тус тус болжээ.

Хүснэгт 2. Дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн бодит өөрчлөлт	(хувиар)							
	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003
Дотоодын нийт бүтээгдэхүүн	2.4	4.0	3.5	3.2	1.1	1.0	4.0	5.5
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	4.4	4.3	6.4	4.2	-14.9	-18.5	-10.7	4.5
Уул уурхай, олборлох үйлдвэр	6.1	5.6	4.9	3.2	6.6	9.6	-6.9	-1.2
Боловсруулах үйлдвэр	-13.8	-15.0	3.2	-2.8	-3.3	31.8	22.1	2.4
Цахилгаан, дулааны үйлдвэрлэл	0.7	0.4	3.2	4.6	0.4	3.5	3.9	1.1
Барилга	2.6	-2.7	-1.1	1.6	-14.6	10.8	18.5	12.6
Бөөний болон жижиглэн худалдаа	0.3	17.1	-3.1	1.3	26.1	9.8	13.3	9.6
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	11.2	5.8	7.4	6.1	25.2	14.9	16.2	16.5
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	42.2	-26.7	-33.0	39.9	7.0	22.4	7.3	13.5
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа	4.2	-2.4	8.4	-4.7	12.5	7.1	25.2	1.9
Боловсрол	4.0	4.1	6.8	4.6	3.2	1.3	4.9	-4.3
Эрүүл мэнд, нийгмийн халамж	4.4	3.0	1.4	3.1	-0.1	4.6	2.9	-4.7
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	0.8	6.2	5.3	0.5	57.1	10.4	49.2	1.7
Санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээ	15.6	-7.5	-16.6	7.0	30.5	27.1	1.6	9.5

Мөнгөний нийлүүлэлт (M2) 49.6 хувиар өссөн хэдий ч түүний өсөлт инфляцид бага нөлөөлж хэрэглээний барааны үнийн өсөлт жилийн 4.7 хувь болсон нь Төрөөс мөнгөний бодлогын талаар 2003 онд баримтлах үндсэн чиглэлд заасан зорилтыг хангалаа. Эдийн засгийг мөнгөжүүлэх гол үзүүлэлт болох нийт мөнгө буюу M2, ДНБ-ий харьцаа 2000 онд 25.4 хувь, 2001 онд 29.7 хувь, 2002 онд 37.9 хувь, 2003 онд 51.6 хувьд хүрлээ.


Тайлант онд Чингис хаан банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) банкны үйл ажиллагаа явуулах эрх авч, шинээр 34 ББСБ байгуулагдаж, 5 ББСБ татан буугдаж, нийт 17 банк, 88 ББСБ үйл ажиллагаа явуулж байна.

Банкуудад байршуулсан аж ахуйн нэгж, иргэдийн хадгаламж өмнөх оныхоос 66.4 хувиар өсч 363.5 тэрбум төгрөг, зээл 91.0 хувиар өсч 442.1 тэрбум төгрөг болов. Чанаргүй зээл өмнөх оныхоос 20.1 тэрбум төгрөгөөр өсч 36.7 тэрбум төгрөг болсон нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 8.3 хувьтай тэнцэж, өмнөх оныхоос 1.1 нэгжээр өсчээ. Зээлийн хүү харьцангуй өндөр байгаа ч аажмаар буурах хандлага үргэлжилж байна. Банкуудын төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оныхоос 1.9 нэгжээр буурч 31.5 хувь, валютынх 0.2 нэгжээр буурч 19.6 хувь болжээ.


Монгол оронд 1921 онд ялсан ардын хувьсгалын үр дүнд үндэсний банк, зээлийн систем үүсч хөгжих нөхцөл бүрдэж 1924 онд анхны банк болох Монголын худалдаа ба аж үйлдвэрийн банк хаалгаа нээж, харилцагчдад банкны үйлчилгээг үзүүлж эхэлснээр банк санхүүгийн системийн 80 жилийн түүх эхэлсэн билээ. 1924-1990 онуудад нэг шатлалт банкны тогтолцоо буюу ганц Улсын банкны ерөнхий хороо, түүний салбар, нэгжүүдээр банкны үйл ажиллагаа явагдаж байсан бөгөөд 1991 онд Улсын бага хурлаас Банкны тухай хууль батлан гаргаснаар хоёр шатлалт банкны тогтолцоо бүрэлдэх хууль эрх зүйн үндэс тавигдсан түүхтэй. Шинэ тогтолцоонд шилжсэний эхний жилүүдэд (1991-1996) хууль эрх зүйн орчин, хяналтын тогтолцоо сул, банкны удирдлагын чадвар дутмаг, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт муу байсан зэрэг шалтгааны улмаас банкууд дампуурч, санхүүгийн салбар хямралд орсон байлаа. Хямралыг даван туулах тууштай алхамуудыг авч хэрэгжүүлснээр 1999 оноос банкны салбарын үйл ажиллагаа сэргэж, өнөөдөр банк санхүүгийн салбар эрүүлжиж, санхүүгийн зуучлалын үүргээ амжилттай гүйцэтгэж байна. Монгол улсад банк санхүүгийн салбар үүсч хөгжсөний 80 жилийн ойг 2004 оны 6 дугаар сард тэмдэглэн өнгөрүүлэх гэж байна.

Банкны салбарт сүүлийн жилүүдэд явуулсан өмч хувьчлалын үр дүнд олон улсын банкны менежмент Монголын банкны салбарт нэвтэрч эхэллээ. Төрийн өмчийн ХААН банкиг өнгөрсөн онд Японы “Эйч Эс секюритис” (HS securities) компанид 6.8 сая ам. доллараар хувьчлав. Тус компани нь ХААН банкинд өмнө нь ажиллаж байсан АНУ-ын “Ди Эй Ай” (DAI) группын менежментийн багийн гэрээг сунган ажиллаж байгаа бөгөөд 13 сая ам. долларын хөрөнгө оруулахаар болжээ. Мөн Худалдаа хөгжил (ХХ)-ийн банк Нидерландын “Ай Эн Жи” (ING) банктай

Зураг 7. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт



Зураг 8. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт (салбаруудаар)



Зураг 9. Инфляци



менежментийн тал дээр хамтран ажиллах гэрээг 2003 онд хийж, үйл ажиллагаагаа явуулж байна.

Монголын даатгалын салбарын 90 орчим хувийг эзэлдэг Монгол даатгал компанийг өнгөрсөн онд ОХУ-ын Ангара Даатгал, Монголын Чингис хаан банкны хамтарсан “Ангара-СКВ” консорциумд 5.8 сая ам. доллараар хувьчилсан нь Монголын санхүүгийн салбарт гарсан томоохон өөрчлөлтийн нэг боллоо.

Засгийн газраас 2003 оныг “Монголд зочлох жил” болгон зарлаж, жилийн ажлын хүрээнд Монгол улсыг гадаадын улс орнуудад сурталчлах, жуулчдыг татах чиглэлээр нэлээд арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэв. Жуулчдын тоо өмнөх оныхоос 3096-аар нэмэгдсэн ч Азийн зарим оронд гарсан АЦХХ өвчний улмаас өсөлтийн хувь нь буурсан байна.

Монголд хандивлагчдын 10 дахь удаагийн зөвлөлдөх уулзалт 2003 оны 11 дүгээр сард Япон улсын Токио хотноо “Эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах стратегийг хэрэгжүүлэх нь” сэдвийн дор амжилттай зохион байгуулагдав. Уулзалтанд 16 орон, 10 гаруй хувийн хэвшил, 10 гаруй төрийн бус байгууллагын төлөөлөгчид оролцсон бөгөөд Монголд 335 сая ам. долларын хөгжлийн албан ёсны тусламж үзүүлэхээр болжээ. Манай улс сүүлийн 10 гаруй жилийн туршид 1.3 тэрбум ам. долларын буцалтгүй тусламж, 1.1 тэрбум ам. долларын хөнгөлөлттэй зээл авсан байна. Нийт ашигласан тусламжийн 50 хувийг Япон улсын, 11 хувийг АНУ-ын, 9 хувийг ХБНГУ-ын Засгийн газраас авчээ.

Тайлант онд Монгол улсын Засгийн газар хуучин социалист системийн үед Оросын Холбооны Улс (ОХУ)-аас авсан шилжих рублийн зээлийг 98 хувийн хөнгөлөлттэй нөхцөлөөр барагдуулж дуусгавар болгов.

Монгол улсын төсөвт 2003 онд 553.9 тэрбум төгрөгийн орлого хуримтлагдаж, 615.8 тэрбум төгрөгийн зардал санхүүжигдсэн нь өмнөх оныхтой харьцуулахад орлого 76.9 тэрбум төгрөгөөр, зарлага санхүүжилт 65.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Улсын Их Хурлаас (УИХ)-аас тайлант онд татварын дарамтыг багасгах зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хувь 40 байсныг 30 хувь болгон татварын хуульд өөрчлөлт оруулж, 2004 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөхөөр тогтоожээ.

Аж үйлдвэр

Тайлант онд аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 1995 оны зэрэгцүүлсэн үнээр 276.6 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оныхоос 5.5 тэрбум төгрөг буюу 2.0 хувиар өссөн нь боловсруулах аж үйлдвэрийн үйлдвэрлэл 6.7 хувь, цахилгаан, дулааны

эрчим хүч, усан хангамжийн үйлдвэрлэл 1.0 хувиар тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна. Харин уул уурхай, олборлох салбарын үйлдвэрлэл 1.0 хувиар буурчээ.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт газрын тос, шатдаг хий, бусад ашигт малтмал олборлолт, боловсруулах аж үйлдвэрийн салбарт хүнсний бүтээгдэхүүн, ундаа, тамхи, хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт, мод модон эдлэл үйлдвэрлэл, усан хангамж зэрэг дэд салбарын үйлдвэрлэл нэмэгдсэн байна. Харин металлын хүдэр олборлолт, нэхмэлийн үйлдвэрлэл, арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал, химийн бүтээгдэхүүн, мебель тавилга үйлдвэрлэл зэрэг дэд салбарын дүнгээр үйлдвэрлэл буурчээ.

Өнгөрсөн онтой харьцуулахад аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтанд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын эзлэх хувийн жин 3.4 нэгжээр өссөн бол боловсруулах аж үйлдвэрийн салбарын эзлэх хувийн жин 1.3 нэгж, цахилгаан дулааны эрчим хүч, усан хангамжийн салбарын эзлэх хувийн жин 2.1 нэгжээр тус тус буурсан байна.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэрийн 208 бүтээгдэхүүнээс цахилгаан, газрын тос, нүүрс, молибдений баяжмал, хайлуур жоншны баяжмал, метал бэлдэц, метал цувимал, зүсмэл материал, хивс, гурил, амтат ус, ундаа, талх, нарийн боов, сүү, сүүн бүтээгдэхүүн зэрэг 92 нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсөв.

Тайлант онд 2.5 тэрбум квт. цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, 5.6 сая тонн нүүрс олборлож, 6.6 сая гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оныхоос цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл 2.2 хувиар, нүүрс олборлолт 5.0 хувиар тус тус өссөн бол дулааны эрчим хүчний үйлдвэрлэл 2.1 хувиар буурсан байна.

2003 онд оны үнээр 793.2 тэрбум төгрөгийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг гадаад, дотоодын зах зээлд борлуулсан байна.

Хөдөө аж ахуй

Тайлант онд байгаль цаг агаарын харьцангуй таатай нөхцөл бүрдсэний улмаас хураасан ургац, малын тоо өмнөх оныхоос нэмэгдсэн байна.

Мал тооллогын урьдчилсан дүнгээр нийт 25.3 сая мал, үүний дотор 255.6 мянган тэмээ, 2.0 сая адуу, 1.8 сая үхэр, 10.7 сая хонь, 10.6 сая ямаа тоологдсон нь өмнөх оныхоос 1.4 сая толгойгоор буюу 5.9 хувиар өссөн байна. Малын тоо, толгойн өсөлтийг төрлөөр авч үзвэл, тэмээ 2.6 мянга, хонь 69.6 мянга, ямаа 1.5 сая толгойгоор өсч, харин адуу 3.6 мянга, үхэр 100.0 мянган толгойгоор тус тус буурсан байна.

Урьдчилсан дүнгээр нийт 15 аймаг малаа 0.8-27.2 хувиар өсгөсөн бол өнгөрсөн жилийн өвөл, хаврын байгалийн бэрхшээлд хамгийн их нэрвэгдсэн төвийн бүсийн аймгуудын малын тоо, толгой буурсан байна.

2003 онд эх малын 80.1 хувь буюу 8.4 сая эх мал төллөжээ. Өнгөрсөн оныхоос төллөлтийн хувь 12.2 нэгжээр өссөнөөс эм ямааных 20.5, ингэнийх 10.3, эм хониных 7.3, гүүнийх 5.8, үнээнийх 5.3 нэгжээр тус тус дээгүүр байна. Гарсан төлийн 93.4 хувь буюу 7.9 сая төл бойжиж байгаа нь өнгөрсөн оныхоос 1.1 саяар, төл бойжилтын хувь 5.6 нэгжээр илүү байна.

Улсын хэмжээгээр 1.3 сая том мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оныхоос 1.6 сая толгойгоор буурсан байна.

Тайлант онд 165.0 мянган тонн үр тариа, 78.7 мянган тонн төмс, 59.6 мянган тонн хүнсний ногоо хураасан нь 2002 оныхоос үр тариа 31.1 хувь буюу 39.2 мянган тонноор, төмс 51.6 хувь буюу 26.8 мянган тонноор, хүнсний ногоо 50.1 хувь буюу 19.9 мянган тонноор илүү байна.

Хураасан үр тарианы 49.2 хувь нь Сэлэнгэ аймагт, 13.0 хувь нь Булган аймагт, 12.2 хувь нь Төв аймагт, төмсний 23.5 хувь нь Төв аймагт, 18.0 хувь нь Сэлэнгэ аймагт, 9.3 хувь нь Улаанбаатар хотод, 7.2 хувь нь Ховд аймагт ноогдож байна. Хүнсний ногооны 22.9 хувийг Сэлэнгэ аймаг, 17.5 хувийг Төв аймаг, 15.9 хувийг Дархан-Уул аймаг, 8.6 хувийг Улаанбаатар хот хураан авсан байна.

Нэг га-гаас дунджаар 7.9 центнер үр тариа, 93.4 центнер төмс хураасан нь өнгөрсөн оныхоос үр тариа 2.2, төмс 37.0 центнерээр тус тус их байна.

Тайлант онд 830.8 мянган тонн өвс хадлан, 28.4 мянган тонн гар тэжээл бэлтгэсэн нь өнгөрсөн оныхоос өвс хадлан 10.2 хувь буюу 77.1 мянган тонноор, гар тэжээл 12.5 хувь буюу 3.2 мянган тонноор нэмэгдсэн байна.


Барилга

Тайлант онд барилгын компаниуд нийт 131.9 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийж гүйцэтгэсэн нь өмнөх оныхоос 38.3 хувиар өсчээ. Нийт гүйцэтгэсэн ажлын 69.9 хувийг дотоодын барилгын компаниуд, 30.1 хувийг гадаадын барилгын байгууллагууд эзэлж байна. Өнгөрсөн онтой харьцуулахад дотоодын барилгын компаниудын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 20.9 тэрбум төгрөг, гадаадын барилгын компанийнх 15.5 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Мөн цахилгаан дамжуулах шугам, орон сууц, зам, зам засвар, эмнэлэг, сургууль, худалдаа, үйлчилгээний зэрэг 42.5 тэрбум төгрөгийн үндсэн фонд бүхий барилга байгууламжийг ашиглалтанд оруулсан нь өмнөх оныхоос 2.6 дахин их байна.


Тайлант онд Их барилга төсөл хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК), Барилга корпораци хувьцаат компани (ХК)-ууд эх үүсвэрийнхээ зарим хэсгийг бондын хэлбэрээр татсан байна.

Азийн хөгжлийн банк (АХБ)-наас Монгол улсын хүн амын орон сууцны эрэлт хэрэгцээг хангахад туслах, бага болон дунд орлоготой өрхүүдэд тэдгээрийн орон


Зураг 10. Хэрэглээний барааны үнийн индекс



Зураг 11. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний өсөлт (1995 оны үнээр)



Зураг 12. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний бүтэц



сууцны төлбөрийн чадавхид нийцсэн орон сууцны зээл олгож амьдрах орчинг сайжруулах, гэр хорооллын дэд бүтэц, үйлчилгээг сайжруулах зэрэг асуудлуудыг шийдвэрлэх төслийг өнгөрсөн оноос эхлэн хэрэгжүүллээ. Уг төслийн зээлийг Голомт, Зоос, Монгол шуудан, Хадгаламжийн банкуудаар болон орон нутгийн захиргаагаар дамжуулан олгож байна.

Тээвэр холбоо

Бүх төрлийн тээврийн хэрэгслээр 17.6 сая тонн ачаа, давхардсан тоогоор 167.9 сая зорчигч тээвэрлэсэн нь өнгөрсөн оныхоос ачаа тээвэрлэлт 30.3 хувь буюу 4.1 сая тонноор, зорчигч тээвэрлэлт 58.8 хувь буюу 62.2 сая хүнээр тус тус өссөн байна.

2003 онд нийт тээвэрлэсэн ачааны 69.7 хувийг төмөр замаар, 30.3 хувийг авто тээврээр гүйцэтгэсэн бол зорчигч тээвэрлэлтийн 97.5 хувийг авто тээврийн, 2.3 хувийг төмөр замын, 0.2 хувийг агаарын тээврийн хэрэгслээр тээвэрлэжээ. Өмнөх онтой харьцуулахад авто тээврийн хэрэгслээр тээвэрлэсэн ачаа 2.8 дахин, зорчигч тээвэрлэлт 61.4 хувь, төмөр замаар тээсэн ачаа 5.6 хувиар тус тус өссөн бол агаарын тээврийн хэрэгслээр тээсэн ачаа 6.8 хувь, зорчигч тээвэрлэлт 6.5 хувь, төмөр замын зорчигч тээвэрлэлт 0.4 хувиар буурчээ.

Тайлант онд тээврийн салбараас олсон нийт орлого 192.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос 26.0 хувиар өссөн байна. Үүнээс төмөр замын тээврийн орлого хамгийн их буюу 57.1 хувь, агаарын тээврийн орлого 26.0 хувь, авто тээврийн орлого 16.9 хувийг эзэлж байна.

Авто техникийн 2003 оны үзлэг, тооллогоор 105.8 мянган авто машин тоологдсон нь өмнөх оныхоос 2.0 мянга буюу 1.9 хувиар нэмэгджээ. Нийт авто машины 74.7 хувийг амины машин эзэлж байна.

Холбоо ашиглалтын нийт орлого тайлант онд 92.4 тэрбум төгрөгт хүрсний 61.9 тэрбум буюу 67.0 хувь нь хүн амаас орсон орлого байв. Телефон цэгийн тоо өнгөрсөн оныхоос 8.8 мянга буюу 6.9 хувиар өсч 135.5 мянга, үүрэн телефон хэрэглэгчдийн тоо 62.6 мянга буюу 24.4 хувиар өсч 319.4 мянга тус тус болсон байна. Тайлант онд Мобиком, Скайтел компаниуд манай улсын бүх аймгийн төв, зарим хот суурин газарт үүрэн телефон хэрэглэх боломжийг бүрдүүлжээ.

2.2. Засгийн газрын санхүү

2003 онд төсвийн орлого 553.9 тэрбум (ДНБ-ий 40.7 хувь), төсвийн зарлага 615.8 тэрбум (ДНБ-ий 45.2 хувь) төгрөгт хүрч, төсвийн урсгал ашиг 110.4 тэрбум (ДНБ-ий 8.1 хувь) төгрөг байна. Харин төсвийн нийт алдагдал 61.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 4.5 хувь байгаа нь 2002 оныхтой харьцуулбал 0.6 нэгжээр буурсан үзүүлэлт юм. Төсвийн урсгал ашгийн дээрх үзүүлэлт нь УИХ-ын 2002 оны 80 дугаар

Хүснэгт 3. Төсвийн гүйцэтгэл		(тэрбум төгрөг)		
	2002 гүйцэтгэл	2003 төлөвлөлт	2003 гүйцэтгэл	Гүйцэтгэлийн өөрчлөлт
Нийт орлого ба тусламж	477.1	495.0	553.9	58.9
Урсгал орлого	469.8	486.8	545.3	58.4
Татварын орлого	359.2	373.7	421.0	47.3
Орлогын албан татвар	72.4	68.4	97.6	29.1
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	54.4	56.0	65.2	9.2
Өмчийн татвар	3.4	4.3	4.6	0.3
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	178.6	190.7	190.1	-0.5
Гадаад худалдааны орлого	24.6	26.6	32.6	6.0
Бусад татвар	25.8	27.6	30.8	3.2
Татварын бус орлого	110.6	113.1	124.3	11.2
Хөрөнгийн орлого	0.5	0.0	0.0	0.0
Тусламжийн орлого	6.8	8.2	8.7	0.5
Нийт зарлага ба цэвэр зээл	550.5	580.1	615.8	35.7
Урсгал зарлага	415.3	435.1	434.8	-0.3
Бараа, үйлчилгээний зардал	285.8	290.3	291.8	1.5
Цалин хөлс	105.0	117.1	116.9	-0.2
Бараа, үйлчилгээний бусад зардал	180.8	173.2	174.9	1.6
Зээлийн үйлчилгээний зардал	19.6	20.0	17.6	-2.4
Татаас ба урсгал шилжүүлэг	109.9	124.8	125.4	0.5
Татаас	8.8	9.4	9.4	-0.1
Урсгал шилжүүлэг	101.1	115.3	116.0	0.7
Хөрөнгийн зардал	68.1	64.8	90.5	25.7
Эргэж төлөгдөх цэвэр зээл	67.1	80.2	90.5	10.3
Урсгал тэнцэл	54.5	51.7	110.5	58.8
Нийт тэнцэл	-73.4	-85.1	-61.9	23.2
Алдагдлыг санхүүжүүлсэн эх үүсвэр	73.4	85.1	61.9	-23.2
Гадаад, цэвэр	81.8	99.9	-158.2	-258.1
Ашиглах төслийн зээл	80.8	91.0	106.7	15.7
Ашиглах санхүүгийн зээл	15.7	29.2	27.4	-1.8
Зээлийн үндсэн өрийн төлбөр	-14.7	-20.2	-292.3	-272.1
Дотоод, цэвэр	-8.3	-14.8	220.1	234.9

Эх үүсвэр: СЭЗЯ

тогтоолоор батлагдсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл”-д тусгагдсан төсвийн урсгал ашгийн ДНБ-д эзлэх хувийг 3.6 хувьд хүргэх зорилтыг бүрэн хангаж байна.

Төсвийн үндсэн үзүүлэлтүүд 2001 оноос эхлэн сайжрах хандлага ажиглагдаж эхэлсэн хэдий ч татварын ачаалал их, төсвийн алдагдал өндөр, түүнийг гадаадын өр зээлээр санхүүжүүлэх явдал үргэлжилсэн хэвээр байна. Тайлант онд төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд гадаадын 134.1 тэрбум төгрөгийн зээл зарцуулснаас ашиглах төслийн зээл 106.7 тэрбум, ашиглах санхүүгийн зээл 27.4 тэрбум төгрөг байв. 2003 онд нийт 292.3 тэрбум төгрөгийн гадаад зээлийн үндсэн өрийн төлбөр хийгдсэн байна.

2003 оны 6 дугаар сарын 12-ны өдөр УИХ олон улсын байгууллага, хандивлагч орноос Монгол Улын Засгийн газар зээл, тусламж авах, түүнийг ашиглах, хэрэгжүүлэх төсөл боловсруулах, батлах, зээл, тусламжийн орлогыг төвлөрүүлэх, бүртгэх, хяналт тавих зэрэгтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилт бүхий “Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай” хуулийг баталлаа. 2003 онд “Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай”, “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Мөн 2003 оны 11

ШИГТГЭЭ 2. ХАДГАЛАМЖИЙН ХҮҮНИЙ ОРЛОГЫН ТАТВАР

Хадгаламжийн хүүний орлогын татвар нь татвар ноогдолтын зарчмаар байх ёстой бөгөөд хурааж авахад хамгийн бага захиргааны зардал гаргадгаараа онцлог юм. Хадгаламжийн хүүний орлогын татвар авахдаа татварын нейтрал байх зарчмыг баримталсан татварын систем нь хамгийн зохимжтой юм. Учир нь энэ нь зах зээлийн гажуудлыг хамгийн бага байлгадаг бөгөөд үр ашгийг (effectiveness) дэмждэг. Татварын нейтрал байх зарчим нь татвар ноогдуулснаар татвар төлөгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөхөөргүй татвар ноогдуулахыг хэлж байгаа юм. Тийм ч учраас хадгалуулах шийдвэр нь өөрөөр хэлбэл хаана, хэзээ, хэдийг хадгалах вэ гэдэг шийдвэр нь бүх татвараас ангид байх ёстой юм.

Хадгаламжийн хүүний орлогод татвар ногдуулахдаа ихэнх улс барьцаат татвар (withholding tax)-ыг хэрэглэдэг. Барьцаат татвар нь татварыг эх үүсвэр (at source)-ээс нь шууд бууруулж хураахыг хэлж байгаа юм. Тухайлбал, ажил олгогч албан хаагчдын цалингаас, хүү төлөгч санхүүгийн байгууллага хүүний орлогоос шууд хасалт хийн төсөвт төвлөрүүлнэ гэсэн үг юм.

Хадгаламжийн хүүний орлогын татвар нь нийгмийн эрх ашгийн үүднээс тэгш байдалд нийцсэн татвар юм. Хэн их мөнгөн хөрөнгөтэй байна тэр хүн илүү их татвар төлнө. Зарим улсад бага хэмжээний хадгаламж эзэмшигч нарыг татвараас чөлөөлсөн байдаг. Мөн татвараас зайлсхийх явдлын эсрэг тэмцэхэд их үр дүнтэй татвар юм. Татварын хувь хэмжээ нь бага түвшинд байдгаараа давуу талтай бөгөөд эрх баригчид төлсөн татварын хэмжээгээр нь тухайн хувь хүн, байгууллагын үйл ажиллагааг тодорхойлох боломжтой болдог.

Хадгаламжийн хүүний орлогын татвар нь бас хэд хэдэн дутагдалтай. Хадгаламжийн хүүнээс бусад төрлийн орлого олж байгаа хүмүүс бага орлого татварт төлөх боломжтой байдаг. Энэ нь татварын тэгш бус байдлыг үүсгэх магадлалтай. Хоёрт, шинээр үүсч бий болж буй санхүүгийн хэрэгсэл (дериватив, хямдруулсан бонд)-д татвар ногдуулах төвөгтэй. Гуравт, гадаад хадгаламжийг татах чадвар мууддаг.

Монгол улсад хэрэгжүүлэхээр зорьж буй хадгаламжийн хүүний татвар

Монгол улсын хүн амын орлогын албан татвар, аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуульд

хадгаламжийн хүүний орлогоос 15 хувиар татвар авахаар заасан байна. Энэ заалт хэрэгжих хугацаа нь УИХ-ын тогтоолоор 2005 он хүртэл хойшилсон байна.

Татвар ноогдуулснаар хадгаламжийн хэмжээ буурна гэсэн таамаглал бий. Хүмүүс өөрийн хөрөнгөө үл хөдлөх хөрөнгөд шилжүүлэн түрээслэх маягаар ашиг олох, эсвэл татвар багатай ашиг авчрах активт хөрөнгөө шилжүүлэх магадлалтай. Иймд хадгаламжийн хүүний татвар ноогдуулснаар үл хөдлөх хөрөнгийн үнийн хиймэл хөөрөгдөл (asset price bubble) бий болж, өндөр эрсдэлтэй бизнес эрхэлдэг хадгаламж, зээлийн хоршоо руу урсах хөрөнгийн хэмжээ нэмэгдэж болох юм. Засгийн газрын бонд орлогын албан татвараас чөлөөлөгдсөн байдаг учраас иргэд, байгууллагын худалдан авах эрэлт өсөх магадлалтай. Хамгийн гол нь хадгаламж эзэмшигч нар татварт хэр мэдрэмтхий байхаас гадна өөрийн хөрөнгөө хэр үр ашигтай байршуулах шийдвэрээс хадгаламжийн хэмжээ хамаарахаар байна. Мөн эрх тэгш байдлын үүднээс Засгийн газрын бондын орлогоос ч татвар авахаар хуулинд өөрчлөлт оруулж өгвөл зохимжтой санагдаж байна.

Хүснэгт 1. Хадгаламж, хүүгийн төлбөр, татварын орлого (сая төгрөг)

Он	Улирал	Хадгаламж	Өсөлт (хувиар)	Хүүгийн төлбөр	Татварын орлого (15%-иар бодов)	Өсөлт (хувиар)
1999	IV	67,983.7		9,085.5	1,362.8	
2000	I	70,989.7		2,128.3	319.2	
	II	74,263.6		4,052.8	607.9	
	III	83,720.5		5,990.3	898.5	
	IV	92,686.2	36.3	8,388.0	1,258.2	(7.7)
2001	I	104,243.5	46.8	2,425.2	363.8	13.9
	II	114,030.0	53.5	4,989.8	748.5	23.1
	III	127,370.5	52.1	7,734.4	1,160.1	29.1
	IV	134,607.4	45.2	11,239.9	1,686.0	34.0
2002	I	152,005.6	45.8	3,656.4	548.5	50.8
	II	164,230.6	44.0	7,578.5	1,136.8	51.9
	III	195,842.4	53.8	13,406.9	2,011.0	73.3
	IV	218,359.6	62.2	19,623.9	2,943.6	74.6
2003	I	260,202.0	71.2	7,459.5	1,118.9	104.0
	II	285,187.5	73.7	16,255.7	2,438.4	114.5
	III	315,896.8	61.3	25,883.1	3,882.5	93.1
	IV	363,498.2	66.5	36,819.4	5,522.9	87.6

Нөгөө талаар, хадгаламжийн хүүний орлогод татвар ноогдуулснаар татварын байгууллага хэн хэчнээн хэмжээний хадгаламжийг аль банкинд эзэмшиж байна вэ гэдэг мэдээллийг авах боломжтой болно. Ийм ч учраас энэхүү татварыг хэрэгжүүлэх шатанд нилээн эсэргүүцэлтэй тулгарч байж болох юм.

Энэ мэдээллийг маш хязгаарлагдмал хүрээнд

ашиглах нь чухал юм. Хадгаламжийн хэмжээний мэдээлэл нь тухайн хувь хүн, байгууллагын бодит орлогыг тодорхойлоход ашигтай бөгөөд тэгш байдлын үүднээс авч үзвэл татварын эрх бүхий хүмүүст энэ мэдээлэл хэрэгтэй. Банкуудын нууц байдал (confidentiality)-д сөргөөр нөлөөлнө гэж үздэг хүмүүс байхад үүний эсрэг ч хүмүүс байна. Сөргөөр нөлөөлнө гэсэн хүмүүс банкинд итгэх итгэл буурч, улмаар хадгаламж буурч, эргээд санхүүгийн зуучлал буурна гэдэг бол нөгөө хэсэг нь банкны нууц байдал нь тийм ч зөв зүйл биш, энэ нь банкинд итгэх итгэлийг сайжруулах биш харин ч муутгадаг, хадгаламжийн хэмжээг татварын тэгш байдал, банкны нууц байдлын үнэ цэнээр өсгөж болохгүй гэж үзэж байна.

Дээрх хүснэгтээс харвал, 2000 оны эцэст хадгаламжийн хэмжээ 36.3 хувиар өссөн боловч авч болох байсан хүүний орлогын татвар нь 1999 оныхоос 7.7 хувиар буурсан байна. Энэ нь хадгаламжийн хүүний түвшин буурсантай холбоотой байхад 2002 оны 1 дүгээр улирлын эцэст хадгаламжийн өсөлт авч болох байсан татварын хүүний орлогын татварын хэмжээнээс өсөлтөөс бага болж ирэв. 2002 оны эхний улиралд хадгаламжийн өсөлт, авч болох байсан хүүний орлогын татварын өсөлт хоёрын зөрүү 5 нэгж байсан бол 2002 оны 4 дүгээр улирлын эцэст 12, 2003 оны 4 дүгээр улирлын эцэст 21 нэгж болж өсчээ. Энэ нь хадгаламж эзэмшигч нар банкинд итгэх итгэл сэргэсний үр дүнд өөрийн мөнгөн хөрөнгөө хадгаламжийн өндөр хүүтэй банкинд байршуулах болсонтой холбоотой байна. Ерөнхийдөө, банкны системд шинээр орж ирж буй хадгаламж Голомт, ХААН, Худалдаа хөгжлийн банк гэх мэт хадгаламж тогтвортой банкууд руу илүү орж байна.

Хадгаламжийн хүүний орлогод татвар ногдуулж эхэлснээр төсөвт жилдээ 5 орчим тэрбум төгрөг төвлөрөхөөр байна. Цаашдаа улс орон хөгжин, санхүүгийн зах зээл сайн хөгжсөн тохиолдолд, хадгаламжийн хэмжээ нэмэгдэж, хүүний түвшин буурах хоёр эсрэг тэсрэг хандлагын нөлөөлөлд орж болзошгүй юм. Ингэсэн тохиолдолд, татварын эрх бүхий хүмүүс гүйлгээний татвар авах асуудалд илүү анхаарал тавих нь ойлгомжтой.

дүгээр сарын 27-ны өдрийн УИХ-ын хуралдаанаар “Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тухай”, “Хүн амын орлогын албан татварын тухай”, “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” хуулиудад нэмэлт, өөрчлөлтийг оруулсан ба эдгээр нь 2004 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөгдөх юм.

Төсвийн орлого

2003 онд төсвийн нийт орлогын 98.4 (553.9 тэрбум төгрөг) хувийг урсгал орлого, 1.6 (8.7 тэрбум төгрөг) хувийг тусламжийн орлого тус тус эзэлж байна. Эдгээр үзүүлэлтүүдийг өмнөх оныхтой харьцуулбал урсгал орлогын нийт орлогод эзлэх хувь 0.2 нэгжээр өссөн бол тусламжийн орлого 0.2 нэгжээр буурчээ.

Төсвийн урсгал орлогын бүтцийг авч үзвэл нийт орлогод эзлэх татварын орлого 76.0 хувь, татварын бус орлого 24.0 хувийг тус тус эзэлж байгаа ба энэ нь 2002 оны гүйцэтгэлтэй харьцуулбал татварын орлого 1.5 нэгжээр өсч, татварын бус орлого 1.5 нэгжээр буурсан байна.

Төсвийн орлогын гүйцэтгэлийг ангилал тус бүрээр нь авч үзвэл татварын бус орлогын биелэлт 109.9, татварын орлогын гүйцэтгэл 112.7 хувьтай гарсан ба үүнээс орлогыг нь тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгчдээс хураах татварын орлого, бензиний татварын орлого, импортын пиво, дотоодын архины татварын орлого, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос бусад гол нэр төрөл дээр төсвийн орлого давж биелсэн байна.


Хүн амын орлогын албан татвар өнгөрсөн оныхоос 9.9 хувь буюу 2.6 тэрбум төгрөгөөр өссөн ба үүний дотор хувиараа аж ахуй эрхлэгчдийн татварын орлого 10.9 хувиар, орлогыг нь тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгчдээс хураах татварын орлого 17.2 хувиар, харин бусад ангиллын татварын орлого 7.2 дахин өссөн байна.

Татварын бус орлого 124.3 тэрбум төгрөг байсан ба энэ нь төлөвлөгөөнөөс 11.2 тэрбум төгрөг буюу 9.9 хувиар давж биелсэн үзүүлэлт юм. Энэ төрлийн орлогын дийлэнхийг хүүний болон торгуулийн орлого, навигаци, төсөвт байгууллагын өөрийн орлого эзэлж байна.


Улсын нэгдсэн төсвийн дүнгээр хувьцааны ноогдол ашиг 1.3 тэрбум төгрөг байсан ба энэ нь төлөвлөгөөнөөс 4.6 тэрбум төгрөгөөр (78 хувь) дутуу биелжээ.

УИХ-аас 2001 онд баталсан Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл, Засгийн газрын “Төрийн өмчийг 2002, 2003 онд хувьчлах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд өмч хувьчлалын ажлыг чиглүүлэн, уг хөтөлбөрийн дагуу 2003 онд нийт 16 аж ахуйн нэгж, 22 үл хөдлөх хөрөнгийг хувьчилан, улсын төсөвт 19.4 тэрбум төгрөгийг оруулсан нь өнгөрсөн оныхоос 3.5 тэрбум төгрөгөөр илүү байна.


Зураг 13. Төсвийн алдагдал (ДНБ-д эзлэх хувиар)



Зураг 14. Нийт орлого ба тусламж



Зураг 15. Нийт зардал ба цэвэр зээл



Төсвийн зарлага

Улсын нэгдсэн төсвийн зарлага 615.8 тэрбум төгрөг болж, төлөвлөгдсөн нийт санхүүжилт 35.7 тэрбум буюу 6.2 хувиар илүү байна. Улсын төсвийн зардлыг авч үзвэл төсвийн нийт зарлагад бараа, үйлчилгээний зардал 47.4 хувь, зээлийн үйлчилгээний зардал 2.9 хувь, татаас ба урсгал шилжүүлэг 20.4 хувь, хөрөнгийн зардал ба цэвэр зээл 29.4 хувийг тус тус эзэлж байна. 2002 оныхтой харьцуулахад төсвийн нийт зардалд эзлэх бараа үйлчилгээний зардал 4.5 нэгжээр, зээлийн үйлчилгээний зардал 0.7 нэгжээр буурч, хөрөнгийн зардал ба цэвэр зээлийн хэмжээ 4.8 нэгжээр, татаас ба урсгал шилжүүлэг 0.4 нэгжээр өссөн байна.

Зээлийн үйлчилгээний зардал төлөвлөсөн хэмжээнээс 2.3 тэрбум төгрөгөөр хэмнэгдсэн ба төсөвт байгууллагын түлш халаалтын зардал 2.6 тэрбум, гэрэл цахилгааны зардал 1.0 тэрбум, цэвэр бохир усны зардал 0.8 тэрбум, нормын хувцас, зөөлөн эдлэл авах зардал 0.4 тэрбум төгрөгөөр тус тус хэмнэгдлээ.

Хөрөнгийн зардал 90.5 тэрбум төгрөг болж төлөвлөгөөнөөс 25.7 тэрбум төгрөгөөр давж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 22.4 тэрбум төгрөгөөр илүү байна. Хөрөнгийн санхүүжилтийн энэ өсөлтийн дийлэнхийг дотоодын эх үүсвэрээр хийгдэх хөрөнгө оруулалтын өсөлт эзэлж байна.

Дотоод эх үүсвэрээр хийгдэх хөрөнгө оруулалт 2002 оныхоос 42.6 хувиар өсч 56.9 тэрбум төгрөг болсон ба үүний дотор их засвар, геологи хайгуулын санхүүжилтээс бусад үндсэн төрлүүд дээр төсвийн төлөвлөлтөөс давсан үзүүлэлттэй байна.

2.3. Төлбөрийн тэнцэл

Тайлант оны 2 дугаар хагасаас манай улсын экспортын барааны үнэ дэлхийн зах зээл дээр өссөн нь манай худалдааны тэнцэлд эерэг нөлөө үзүүлэв. Оны эхний хагаст алт болон зэсийн үнийн өсөлт дээд тал нь 10 хувийн хэлбэлзэлтэй байсан бол 2 дугаар хагаст 15-20 хувь болжээ. Оны эхэнд нэг унци алтны үнэ 343.8 ам. доллар, нэг тонн зэсийн үнэ 1554.5 ам. доллар байсан бол эхний хагаст алт 364.7, зэс 1692.0, оны сүүлийн хагаст алт 410.0, зэс 2321.0 ам. долларт тус тус хүрчээ.

Тайлант онд манай улс гадаадын 64 оронд 627.3 сая ам. долларын бараа экспортлон, 81 орноос 826.9 сая ам. долларын бараа импортолж, 99 оронтой 1454.2 сая ам. долларын худалдаа хийжээ.

Урсгал тэнцлийн алдагдал өмнөх оныхоос 6.1 хувиар буурч 98.7 сая ам. долларт хүрсэн нь ДНБ-ий 8.3 хувийг эзэлж байна.

Тайлант онд экспорт өмнөх онтой харьцуулахад 19.7 хувь, импорт 9.8 хувиар өссөн

Хүснэгт 4. Гадаад худалдааны бүтэц		(сая ам.доллар)		
	Экспорт	2002 Импорт	Экспорт	2003 Импорт
Их долоогийн бүлгийн орнууд	190.7	145.3	201.5	109.4
АНУ	140	22.9	165.7	23.4
Япон	8.4	62.9	6.3	42.8
Европын холбоо	45.2	86.2	33.1	79.3
Евро бүс	18.2	71.4	15.6	48.2
Шинээр аж үйлдвэржсэн Азийн орнууд	45	100.8	25.7	125.8
Гонконг	2.8	23.4	3.2	28.2
Сингапур	35	10.2	0.1	11.2
БНСУ	7.2	67.1	22.5	86.3
Хөгжиж байгаа орнууд	283.3	195.4	219	140.7
Ази	5.2	22.7		
БНХАУ	276.7	171.6	217.3	139.5
Алс дорнод ба Турк	1.5	22.7	1.7	1.2
Шилжилтийн эдийн засагтай орнууд	61.7	280.1	54.3	261.4
Төв ба Зүүн Европ	23.9	22.6	3.3	22.6
ОХУ	37.5	257	48	237.6
Бусад	0.3	0.5	3.1	1.2

Эх үүсвэр: Гаалийн статистик мэдээ

байна. Экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох зэсийн баяжмалын экспортын хэмжээ өмнөх оныхоос 15.3 хувиар өсч 161.7 сая ам. долларт хүрчээ.

Монголбанкнаас 14.2 тонн буюу 157.3 сая ам. долларын алтыг олон улсын банк санхүүгийн байгууллагад зарсан нь өмнөх оныхоос 33.8 хувиар өсч, экспортын орлогын 25.1 хувийг эзэлж байна. Экспортын өсөлт импортын өсөлтөөс харьцангуй өндөр байсан боловч үйлчилгээний тэнцлийг оруулж тооцсоноор гадаад худалдааны алдагдал өмнөх оныхоос 4.5 хувиар өссөн байна.

Урьдчилсан гүйцэтгэлээр тайлант онд экспортын бараа, үйлчилгээ ДНБ-ий 70.3 хувьтай тэнцэх хэмжээнд, импортолсон бараа, үйлчилгээ ДНБ-ий 91.2 хувьтай тэнцэх хэмжээнд хүрчээ. Импортын хэмжээ өндөр байгаа нь ДНБ-ий өсөлтөнд нөлөөлөх гадаадын хөрөнгө оруулалтын тоног төхөөрөмж, материал сэлбэг, дотоодод үйлдвэрлэгдэж буй бүтээгдэхүүний орцын хэмжээ өсч буйтай холбоотой юм. Нийт импортын барааны 29.9 хувийг нефтийн бүтээгдэхүүн буюу түлш, шатахуун, 21 хувийг машин, тоног төхөөрөмж, тэдгээрийн эд анги, цахилгаан хэрэгсэл, 20.5 хувийг эрдэс бүтээгдэхүүн, 10.8 хувийг авто, агаарын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги, 10.4 хувийг нэхмэл бүтээгдэхүүн, 9.2 хувийг хүнсний бүтээгдэхүүн тус тус эзэлж байна.

Үйлчилгээний тэнцэл 49.1 сая ам. долларын алдагдалтай гарсан нь өмнөх оныхоос 5.3 дахин их байна. Үйлчилгээний орлогын хэмжээ өмнөх оныхоос 12.7 хувь, зарлага буюу үйлчилгээний импорт 32.6 хувиар тус тус өсчээ.


Хүснэгт 5. Төлбөрийн тэнцэл

(сая ам. доллар)


	2002	2003 ¹				
		I	II	III	IV	Дүн
Худалдааны тэнцэл	-228.8	-37.6	-104.0	-50.7	-7.3	-199.6
Экспорт F.O.B	524.0	129.2	90.1	182.1	225.9	627.3
Үүнээс: Зэсийн баяжмал	140.2	34.8	29.1	52.5	45.3	161.7
Мөнгөжөөгүй алт	117.6	40.3	0.0	51.8	65.2	157.3
Бусад	266.1	54.2	61.0	77.8	115.4	308.3
Импорт C.I.F	-752.8	-166.9	-194.1	-232.8	-233.1	-826.9
Үүнээс: Гаальд бүртгэгдсэн	-690.7	-166.9	-194.1	-232.8	-233.1	-826.9
Үйлчилгээний тэнцэл	-9.3	-22.0	-14.9	9.3	-21.6	-49.2
Орлого	184.5	29.8	33.2	83.2	61.7	207.9
Зарлага	-193.9	-51.7	-48.1	-73.9	-83.3	-257.1
Орлого (цэвэр)	-4.5	1.2	0.1	-2.2	-10.6	-11.5
Хүүний төлбөр	-10.8	-2.0	-3.4	-2.2	-4.4	-11.9
Хувийн гуйвуулга	64.4	16.7	20.1	31.6	5.9	74.3
Урсгал дансны алдагдал						
(албан шилжүүлгийг үл оролцуулсан)	-178.3	-41.8	-98.7	-11.9	-33.5	-185.9
Албан ёсны буцалтгүй шилжүүлэг	73.2	24.0	29.9	18.9	14.4	87.2
Албан ёсны тусламж	53.0	14.4	20.4	9.4	5.1	49.4
Бусад	20.2	9.6	9.5	9.5	9.3	37.8
Урсгал дансны алдагдал	-105.1	-17.8	-68.9	7.0	-19.0	-98.7
Хөрөнгө ба санхүүгийн данс	157.4	22.8	58.1	55.0	-131.1	4.9
Шууд хөрөнгө оруулалт	77.8	15.5	42.8	39.6	33.6	131.5
Санхүүгийн хөрөнгө оруулалт	0.0	0.0	0.0	0.0	50.0	50.0
Дунд, урт хугацаат зээл	102.4	23.0	6.2	15.6	-197.0	-152.1
Үүнээс: Ашигласан	185.1	40.4	28.9	41.3	79.9	190.5
Үндсэн өрийн төлбөр	-82.7	-17.4	-22.7	-25.6	-276.9	-342.6
Засгийн газрын зээл ашиглалт	73.7	11.0	13.6	19.5	-188.7	-144.6
Үүнээс: Ашигласан	86.9	12.6	16.0	20.3	67.3	116.1
Үндсэн өрийн төлбөр	-13.2	-1.6	-2.4	-0.8	-256.0	-260.7
Аж ахуйн нэгжийн зээл ашиглалт	28.7	12.0	-7.4	-3.8	-8.3	-7.5
Үүнээс: Ашигласан	98.2	27.9	12.9	21.0	12.6	74.4
Үндсэн өрийн төлбөр	-69.5	-15.8	-20.3	-24.8	-20.9	-81.9
Богино хугацаат хөрөнгө (цэвэр)	-9.5	-7.3	-0.2	22.0	-31.0	-16.5
Арилжааны банк (цэвэр)	-8.7	-8.4	9.3	-22.2	0.3	-21.0
Худалдааны зээл, цэвэр	-14.0	-7.3	-0.2	22.0	-18.0	-3.5
Залруулга	14.1	-17.9	32.5	-37.0	19.3	-3.1
Нийт төлбөрийн тэнцэл	66.4	-12.8	21.8	25.0	-130.8	-96.8
Санхүүжилт	-66.4	12.8	-21.8	-25.0	130.8	96.8
Валютын албан нөөцийн өөрчлөлт	-65.7	12.8	-21.8	-25.0	130.8	96.8
ОУВС-гийн зээл	-4.3	-2.4	-0.9	8.9	1.3	7.1
Нийт албан нөөцийн өөрчлөлт	-61.5	15.2	-20.9	-33.9	129.5	89.8
Зээлийн өрийн үлдэгдэл	-0.7	0.0	0.0	0.0	0.0	0.0
Хугацаа хойшлуулсан өр	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Эх үүсвэрийн дутагдал	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0

¹ Урьдчилсан байдлаар


Зураг 16. Төлбөрийн тэнцэл (цэвэр дүнгээр)



Зураг 17. Урсгал дансны орлого ба зарлагын бүтэц



Зураг 18. Гадаад худалдааны тэнцэл



Мөн урсгал тэнцэлд тодорхой хувийг эзэлж буй нийт хувийн гуйвуулгын хэмжээ өмнөх оныхоос 14.8 хувиар өсч 128.3 сая ам. доллар боллоо. Гадаад орнуудаас Монгол улсад шилжүүлсэн хувийн гуйвуулгын хэмжээ сүүлийн гурван жил дараалан эрс нэмэгдэж 2003 онд ДНБ-ий 10.8 хувьтай тэнцэх хэмжээнд хүрлээ.

Тайлант онд Монгол улсад гадаад орнууд, олон улсын байгууллагаас үзүүлсэн буцалтгүй тусламжийн хэмжээ өнгөрсөн оныхоос 19.1 хувиар өсч 87.2 сая ам. доллар хүрэв.

Санхүү ба хөрөнгийн дансны тэнцэл 4.9 сая ам. долларын ашигтай гарсан ч өмнөх оныхоос 32.1 дахин буурсан байна. Тайлант онд олон улсын байгууллага, гадаад орнуудын засгийн газарт нийт 342.6 сая ам. долларын өр төлсний 250.0 сая ам. долларыг ОХУ-ын Засгийн газарт төлсөн байна. Энэ нь нийт санхүү ба хөрөнгийн данс өмнөх оныхоос буурахад нөлөөлжээ.

ШИГТГЭЭ 3. ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

1. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай

Аливаа нэг улсын хөрөнгө оруулагч өөр улсад бизнесээ өргөжүүлэх замаар аж ахуйн нэгжийн хувьцааг эзэмших бөгөөд нийт хувьцааны эзэмших хэмжээ нь хөрөнгө оруулагчид аж ахуйн нэгжийн удирдлагын хяналтыг өгч байх үед гадаадын шууд хөрөнгө оруулалт хийгдлээ гэж ойлгодог. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг санхүү (portfolio)-гийн бусад хөрөнгө оруулалтаас ялгаж байгаа гол зүйл бол удирдлагын цар хүрээ юм. Гадаадын шууд хөрөнгө оруулалт, санхүүгийн хөрөнгө оруулалтын аль аль нь тухайн улсад ашигтай байдаг.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь ихэвчлэн үндэстэн дамжсан корпораци (multinational enterprises)-ууд байдаг. Үнэн хэрэгтээ, гадаад дахь хөрөнгө оруулалт нь компаниудыг үндэстэн дамжсан болоход хүргэдэг.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь 3 хэсгээс бүрдэнэ:

- ◆ *Хувьцаа эзэмших.* Гадаадын хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжийн хувьцааг худалдаж авах,
- ◆ *Ашгаас дахин хөрөнгө оруулах (reinvested earnings).* Гадаадын хөрөнгө оруулагчид ноогдох ашгийг хуваарилалгүйгээр, эсвэл гадаадын хөрөнгө оруулагч руу шилжүүлэлгүй эргүүлж оруулсан ашиг,
- ◆ *Компани доторхи зээл эсвэл өрийн шилжүүлэг (intra-company debt transactions).* Шууд хөрөнгө оруулагч болон харьяа компанийн хооронд хийгдэх урт болон богино хугацааны зээл болон зээллэг.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хувьд урсгал (flow) болон тухайн хугацааны эцсийн байдлаархи (stock) гэсэн ойлголт байдаг. Урсгал гэдэгт гадаадын шууд хөрөнгө оруулагчаас шууд хүлээн авсан хөрөнгийн хэмжээг ойлгодог бол тухайн хугацааны эцсийн байдлаархи гэдэгт толгой компанид хамаатай хөрөнгө болон нөөц хөрөнгийн хувь хэмжээний үнэ цэнэ (value), дээр нь толгой компанитай хийх цэвэр өрийн хэмжээг нэмсэн дүн орно.

2. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын талаар хийгдсэн судалгааны тойм

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын тухай олон судалгааны ажил хийгджээ. Сүүлийн жилүүдэд гадаадын шууд хөрөнгө оруулалт болон эдийн засгийн өсөлт хоёрын хооронд эерэг хамааралтай байна гэсэн үзэл баримтлал өсч байна. Энэхүү үзэл баримтлалыг сүүлийн үеийн өсөлтийн онолд оруулж өгсөн технологи, үр ашиг ба бүтээмжийн өсөлт нь эдийн засгийн өсөлтийг дэмжинэ гэсэн нь тодруулж өгч байна. Үүний дагуу, гадаадын шууд хөрөнгө оруулалт нь эдийн засгийн өсөлтөнд аж үйлдвэржсэн орноос хөгжиж буй орнууд руу орчин үеийн технологийг шилжүүлэх замаар нөлөөлж байна.

Дээрх эерэг нөлөө (externality, spillovers) нь дотоодын аж ахуйн нэгжүүдийн бүтээмж, үр ашгийн сайжралтанд хэд хэдэн сувгаар нөлөөлж байна. Хамгийн түрүүнд эерэг нөлөө нь орон нутгийн пүүс үндэстэн дамжсан корпорацийн ашиглаж буй технологийг хуулах замаар бүтээмжийг өсгөснөөр илэрч болно. Өөр нэг нөлөө нь үндэстэн дамжсан

корпораци орон нутгийн зах зээлд орж ирснээр өрсөлдөөний дарамт өсч, орон нутгийн пүүс өөрийн эзэмшиж байгаа технологи, нөөцөө илүү үр ашигтай зарцуулах эсвэл илүү дэвшилтэт технологи хайх зайлшгүй шаардлага бий болдог. Үүн дээр нэмээд, үндэстэн дамжсан корпорацийн салбар орон нутгийн ажилчдад шинэ техник, арга барил зааж өгч, сургалт явуулснаар эерэг нөлөө үзүүлж байна. Учир нь эдгээр ажилчид нь хожим орон нутгийн компанид ажилд орох эсвэл өөрсдийн бизнесээ эхлэх зэрэг үйл ажиллагаа явуулдаг.

Эерэг нөлөөны цар хүрээг дотоодын болон гадаадын компаниудын ашиглаж буй технологийн зөрүү (technology gap)-ний хэмжээгээр тодорхойлж болно. Өөрөөр хэлбэл, дотоодын компанийн гадаадын технологийг эзэмших чадвараас хамаарна гэсэн үг. Технологийн зөрүү бага байх тусмаа эерэг нөлөө нь илүү байдаг бол зөрүү нь хэт өндөр үед эерэг нөлөөг олж харахад хүндрэлтэй байдаг.

Гадаадын хөрөнгө оруулалтанд ямар хүчин зүйлс нөлөөлж байгааг судлаачид доорх байдлаар гаргасан байна. Үүнд:

- ◆ Орон зай/тээврийн зардал: тухайн зах зээл руу экспорт хийснээр нэвтрэх нь өндөр зардалтай байвал хэвтээ хөрөнгө оруулалт экспортыг орлох учир хэвтээ хөрөнгө оруулалт өсөх магадлалтай. Гэсэн ч босоо хөрөнгө оруулалт тээвэрлэлтийн зардал өндөр үед ашиггүй тул энэ төрлийн хөрөнгө оруулалт хийх санаачилга байхгүй болно. Иймд гадаадын шууд хөрөнгө оруулалтанд тээврийн зардлын цэвэр нөлөө тодорхойгүй байна.
- ◆ Тухайн зах зээлийн хэмжээ: тухайн зах зээл том байх нь өргөжилтийн үр өгөөж, нэгж бүтээгдэхүүнд ноогдох бага тогтмол зардал зэргээс гадаадын хөрөнгө оруулалттай компани нь зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүнийхээ үнийг бууруулж чадна. Иймд хэвтээ хөрөнгө оруулалт нь зах зээлийн хэмжээтэй эерэг хамааралтай байдаг бол босоо хөрөнгө оруулалт нь зах зээлийн хэмжээтэй хамааралгүй байна. Эндээс дүгнэхэд гадаадын шууд хөрөнгө оруулалт нь зах зээлийн хэмжээтэй эерэг хамааралтай байх магадлалтай.
- ◆ Нягтрал (agglomeration)-ын нөлөө: нягтралын нөлөө илүү их хөрөнгө оруулалтыг татдаг учир босоо, хэвтээ хөрөнгө оруулалтанд хоюуланд нь эерэг нөлөөтэй. Нягтралын нөлөөг бий болгодог хүчин зүйлс гэвэл дэд бүтцийн хөгжил, аж үйлдвэржсэн байдлын түвшин ба тухайн хугацааны эцсийн байдлаархи (stock) гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ юм.
- ◆ Хүчин зүйлийн үнэ (Factor cost): Босоо хөрөнгө оруулалт нь хүчин зүйлийн үнэ бага байх тусам хүчтэй байна. Хүчин зүйлийн үнэ бага байх нь хэвтээ хөрөнгө оруулалтад мөн эерэгээр нөлөөлнө. Иймд гадаадын шууд хөрөнгө оруулалт нь хүчин зүйлийн үнэтэй эерэг хамааралтай байна.
- ◆ Төсвийн санаачлага (Fiscal incentives): төсвийн санаачлага нь аль ч төрлийн хөрөнгө оруулалтын байршлын давуу талыг өсгөх магадлалтай. Гэхдээ, босоо хөрөнгө оруулалт нь зардалд их мэдрэмтгий учраас илүү хамааралтай байхад, хэвтээ хөрөнгө оруулалт нь төсвийн санаачлагаас илүү өөр бодлого (импортын татвар өсгөх, квот г.м.)-д илүү нөлөөтэй байна.
- ◆ Бизнес/хөрөнгө оруулалтын орчин: илүү таатай бизнес/хөрөнгө оруулалтын орчин нь гадаадын хөрөнгө оруулалтыг илүү татах нь ойлгомжтой.
- ◆ Худалдааны саад/нээлттэй байдал: хэвтээ хөрөнгө оруулалт тухайн зах зээл нээлттэй болох тусам багасах магадлалтай. Босоо хөрөнгө оруулалт нь гадаад худалдаанд илүү их оролцогийн хувьд зах зээл нээлттэй болох тусам өснө.

Судлаачдын эконометрик үнэлгээний үр дүнд зах зээлийн хэмжээ нь гадаадын шууд хөрөнгө оруулалтын хамгийн хүчтэй эерэг тодорхойлогч нь болж байна. Дэд бүтцийн хөгжил, аж үйлдвэржсэн байдал, компаниудын нягтрал зэрэг нь гадаадын шууд хөрөнгө оруулалтанд эерэгээр нөлөөлж байхад улс төрийн эрсдэл, эдийн засгийн тогтворгүй байдал зэрэг нь гадаадын хөрөнгө оруулалтанд саад тотгор болдог байна. Бусад хувьсагчдын хувьд статистикийн янз бүрийн үр дүн гарсан учир дүгнэлт хийхэд хүндрэлтэй байна.

3. Монгол дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт

Монгол дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ бусад шилжилтийн эдийн засагтай орнуудтай харьцуулахад бага байна. Шилжилтийн эдийн засагтай орнууд дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын дийлэнх хувь нь өмч хувьчлалын үйл ажиллагааны үр дүнд хийгдсэн байна. Гэсэн хэдийн ч зарим улс өмч хувьчлалын өргөн хөтөлбөр хэрэгжүүлэлгүй (Азербайжан) их хэмжээний гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татаж чадсан байхад зарим улсын өмч хувьчлалын үйл явц (Унгар, Польш, ОХУ) хөрөнгийн зах зээлийн маш их хэлбэлзэлд хүргэж улмаар эдгээр гадаадын шууд хөрөнгө оруулалтыг санхүүгийн хөрөнгө оруулалт болгон бүртгэхэд хүргэсэн байна. Мөн зарим орон дотоодын хөрөнгө оруулагч нарт хандсан (Чех, Словак) хувьчлалыг явуулсан

бөгөөд энэ нь ихэвчлэн өрөөр санхүүжигдсэн нь дотоод эсвэл гадаад зээлтэй холбоотой байв.

Хувьчлалтай холбоотой шууд хөрөнгө оруулалт нь төсвийн алдагдал өндөртэй орнуудад алдагдлыг нөхөхөд зориулагдсан байна. Мөн гадаадын шууд хөрөнгө оруулалт нь өр үүсгэдэггүй урсгал учраас урсгал тэнцлийн алдагдлыг нөхөх ашигтай хувилбар юм.

Монгол улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт нь Төв болон Зүүн Европ, Балтийн улсуудаас хамаагүй доогуур, харин Тусгаар Тогтносон Улсуудын Хамтын Нөхөрлөлийн орнуудын дунджаас дээгүүр байна.

Монгол улс гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээгээрээ бусад шилжилтийн эдийн засагтай улсуудтай харьцуулахад бага боловч нэг хүнд ногдох хөрөнгө оруулалтын хэмжээгээрээ хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан зарим улсуудаас өндөр байгаа нь харагдаж байна. Нэг хүнд ногдох хөрөнгө оруулалтын хэмжээгээр ТТУХН-ийн орнуудын дундажтай ойролцоо, зүүн өмнөд Европын орнуудын дунджаас хоёр дахин бага, Төв Европ болон Балтийн орнуудын дунджаас арав гаруй дахин бага байна.

Монгол дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтанд ямар хүчин зүйлс нөлөөлж байгааг статистикийн арга хэрэглэн эконометрик үнэлгээ хийхэд шаардлагатай өгөгдөл хангалтгүй байгаа учраас нөлөөлж болох зарим хүчин зүйлсийг дурдъя. Монгол улсын импортын тариф 20¹ хувь (импортын 5, нэмэгдсэн өртгийн 15) байгаа нь хэвтээ хөрөнгө оруулалтыг татах хангалттай нөхцөлийг бүрдүүлж чадахгүй байна. Үүний оронд гадаадын пүүс, компаниуд бүтээгдэхүүнээ шууд Монголын зах зээл дээр борлуулах нь ашигтай гэж үзэж байна. Үүний нэг жишээ нь Кока-Кола компани өөрөө зах зээлд нэвтрэхийн оронд лиценз олгох нь ашигтай гэж үзсэн явдал юм. Энэ нь манай хоёр хөршид өөрийн үйлдвэртэй, худалдааны саад бага зэрэг нь нөлөөлсөн байна. Мөн хэвтээ хөрөнгө оруулалт нь зах зээлийн хэмжээ том байх үед ихэвчлэн орж ирдэг учир энэ төрлийн хөрөнгө оруулалт орж ирэх магадлал бага байна. Босоо хөрөнгө оруулалт худалдааны саад тогтвор бага үед орж ирдэг ч тээвэрлэлтийн зардал өндөр, бусад компани орж ирж амжилттай ажилласан туршлага ховор, мэргэжлийн ажилчдын хомсдол зэрэг шалтгааны улмаас бага байж болох юм. Монгол улс 1997 онд импортын татвараа тэглэсэн туршлага байгаа ба гадаадын шууд хөрөнгө оруулалт үүнд нэг их мэдрэмтгий бус байсан нь босоо хөрөнгө оруулалт өөр шалтгааны улмаас манай зах зээлд орж ирэхээс татгалзсан нь тодорхой. Мөн бусад орны хөрөнгө оруулалтын бий болгосон орчин нь Монгол улсаас илүү ашигтай байвал хөрөнгө оруулагч өөр улсад байрших нь ойлгомжтой. Хамгийн гол нь улс төрийн болон макро эдийн засгийн тогтвортой байдал гадаадын хөрөнгө оруулалтыг татахад маш чухал үүрэгтэй байна.

Монгол улсад орж ирсэн Түү Март компани (Скай худалдааны төв), Юнивком (Скайтел), Амикаль (Монгол Амикаль), Миллениум Секюритиз (Чингис Хаан), Жеральд Металз-Лугано банк консорциум (Худалдаа Хөгжлийн банк), Бороо Монголиа Майнинг корпораци (Бороо гоулд) гэх зэрэг томоохон хөрөнгө оруулагчдыг дурьдаж болно.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт мөнгөний бодлогод хэрхэн нөлөөлж болох талаар доор дурдъя. Энэ тохиолдолд тухайн улс гадаад валютын ханшийн ямар бодлого баримталж байгаагаас шалтгаалан авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь ялгагдаж байна. Тогтмол ханшийн бодлого баримталж байх үед Төв банк ханшийг тогтвортой байлгах үүднээс гадаад валютыг худалдан авах, худалдахад бэлэн байдаг. Ийм үед мөнгөний нийлүүлэлтэнд тавих хяналтаа алдах тохиолдол гардаг. Төв банк дотоодын зээлийг өсгөхөд энэ нь нийт хэрэглээг өсгөж улмаар урсгал дансны алдагдал өсч, ханшийг сулруулах бодит шаардлага гарна. Төв банк ханшийг тогтмол байлгах үүднээс гадаад валютыг зарж эхэлвэл энэ нь эргээд улсын валютын нөөцийг хорогдуулдаг. Энэ тохиолдолд мөнгөний нийлүүлэлтэнд нөлөөлөх арга бол стерилизаци (sterilization) юм. Энэ аргын гол дутагдал нь бол Төв банк их хэмжээний үнэт цаас худалдсан тохиолдолд хүүний төлбөрийн зардал их өндөр болдог явдал юм.

Хөвөх ханшийн бодлого баримталж байгаа тохиолдолд Төв банк гадаад валютын зах зээлд интервенци хийхгүй. Иймд Төв банк мөнгөний нийлүүлэлтийг хянаж, инфляцийг тодорхойлох боломжтой. Манайх шиг жижиг, нээлттэй импортоос их хамааралтай эдийн засагтай оронд валютын ханш нь мөнгөний нийлүүлэлт, инфляци хоёрын хоорондох нэг нэмэгдэл суваг болж өгдөг. Дээрх хоёр тохиолдол практик дээр ховор бөгөөд ихэнх улс ямар нэг хэмжээний интервенци хийж, валютын зохицуулалттай хөвөх ханшны бодлого баримталдаг. Ихэнх улс хөрөнгийн урсгал орж ирэхэд нэг хэсгийг нь интервенци хийн худалдан авах, нөгөө хэсгийг нь стерилизаци (sterilization) хийх замаар нөлөөг нь арилгах арга хэмжээ авдаг. Харин үлдсэн хэсэг нь нөөц мөнгөний хэмжээг өсгөж улмаар үнийн өсөлт бий болж, бодит ханш чангарахад хүргэж байна.

¹ Монгол улс Дэлхийн Худалдааны Байгууллагад элсэхдээ импортын татаварыг 20 хувиас хэтрүүлэхгүй гэсэн гэрээтэй

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх оныхоос 69.0 хувиар нэмэгдэж 131.5 сая ам. долларт хүрчээ. Монгол улсад оруулж буй хөрөнгө оруулалтын хэмжээгээр Канад, БНХАУ, БНСУ, Япон улсын хөрөнгө оруулагчид тэргүүлж, нийт хөрөнгө оруулалтын 93.2 хувийг эзэлж байна.

Нийт хөрөнгө оруулалтын 73.7 хувь нь уул уурхай, олборлох үйлдвэрт, 3.4 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, зочид буудал, зоогийн газарт, 2.3 хувь нь боловсруулах үйлдвэрт, 2.0 хувь нь харилцаа холбооны салбарт, 1.2 хувь нь барилгын салбарт тус тус хийгдсэн байна.

Тайлант онд Монгол улсын төлбөрийн тэнцэл 96.8 сая ам. долларын алдагдалтай гарсан нь өмнөх оныхоос 2.5 дахин өсчээ.

Төлбөрийн тэнцлийн алдагдлыг гадаад валютын нөөц болон зээлээр санхүүжүүлсэн байна.

2.4. Үнэ, цалин хөлс

Сүүлийн жилүүдэд макро эдийн засаг болон банк санхүүгийн салбарт нааштай өөрчлөлтүүд гарч үнэ, ханш харьцангуй тогтвортой байгаа нь бизнесийн орчинд таатай нөлөө үзүүлсээр байна.

2003 оны эцсийн байдлаар инфляцийн түвшин 4.7 хувь болж өмнөх оныхоос 3.1 нэгжээр өссөнийг хэрэглээний барааны үнийн индекст өндөр хувийн жин эзэлдэг хүнсний барааны (46.6 хувь) бүлгийн үнэ өмнөх оны мөн үеэс 7.7 хувиар нэмэгдсэнээр тайлбарлаж болно. Хүнсний барааны бүлгийн болон бусад бүлгүүдийн үнэд шатахууны үнэ өмнөх оны мөн үеэс 17.5-19.5 хувиар нэмэгдсэн нь тодорхой хэмжээгээр тусгалаа олсон бөгөөд ОХУ-ын шатахуун нийлүүлэгч компани үнээ өсгөсөн, Иракийн дайнаас үүдэлтэй дэлхийн зах зээлийн нефтийн үнийн өсөлт зэрэг нь гол сөрөг нөлөөг үзүүлэв.

Инфляцийн улирлын хэлбэлзэл 2001 оныг хүртэл хүчтэй ажиглагдаж байсан бол сүүлийн 3 жилд тогтворжих хандлагатай болж, хэрэглээний барааны үнээр илэрхийлэгдсэн инфляци 2003 оны эцэст жилийн 4.7 хувьд хүрчээ.

Хэрэглээний сагсанд өндөр хувийн жин эзэлдэг мах, махан бүтээгдэхүүний үнийн улирлын хэлбэлзэл 2002 онд харьцангуй буурч, 2000, 2001, 2003 онуудад нэмэгдсэн нь хүнсний бүтээгдэхүүний бүлгийн индексийн улирлын хэлбэлзэл өөрчлөгдөхөд нөлөөлжээ. Хүнсний барааны бусад дэд бүлгүүдийн индекс тогтвортой хэвээр байна.

Сүүлийн 4 жилийн туршид орон сууц, цахилгааны бүлгийн индексийн өөрчлөлтийн хэлбэлзэл харьцангуй нэмэгдэв. Орон сууц, цахилгаан хэрэглээний бүлгийн индексийн өөрчлөлт оны эхний хагаст харьцангуй тогтвортой, харин сүүлийн хагаст хүчтэй нэмэгдэх хандлагатай байгаа нь ажиглагдлаа.

Бусад бараа үйлчилгээний бүлгийн индексүүдийн хувьд улирлын хэлбэлзэл ажиглагдахгүй, харьцангуй тогтвортой хэвээр байна.

Хэрэглээний үнийн индексээр тооцсон инфляци 2003 оны 12 дугаар сарын эцсийн байдлаар 2000 оны эцэс (суурь үе)-ээс 14.9 хувь, оны эхнээс 4.7 хувиар өсчээ. Хэрэглээний сагсны 239 зүйлийн бараа, үйлчилгээний 15.9 хувийнх нь үнэ өсч, 15.9 хувийнх нь үнэ буурч, 68.2 хувийнх нь үнэ тогтвортой байлаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүнсний барааны бүлгээс хамгийн ихээр үнэ өссөн нь гурил, гурилан бүтээгдэхүүн 16.4 хувь, мах, махан бүтээгдэхүүн 23.4 хувь байсан бол төмс, хүнсний ногооны бүлгийн үнэ 28.7 хувь, архи, ундаа, тамхины үнэ 2.9 хувиар буурчээ. Бусад бүлгүүдийн үнийн хувьд соёл, боловсролын бараа үйлчилгээ 11.4 хувь, бусад бараа үйлчилгээ 13.6 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 4.9 хувиар нэмэгдэж орон сууц, цахилгааны үнэ 1.7 хувь, гэр ахуйн бараа 2.8 хувиар буурав. Хонь, үхрийн махны үнэ 22.8-29.2 хувь, гурилын үнэ 22.3-37.8 хувиар өсч, төмс, манжин, луувангийн үнэ 31.8-48.8 хувь, шингэн сүү, тараг 7.2-8.0 хувь, цагаан будаа 0.7 хувь, түлшний мод, нүүрс 5.8-9.8 хувиар буурчээ.

2002 онд төрийн албан хаагчдын цалинг дунджаар 20 хувиар нэмэгдүүлсэн бол 2004 оны 2 дугаар сараас дахин 25 хувиар нэмэгдүүлэхээр шийдвэрлэжээ.

Хөдөлмөрийн үнэлэмж бодитой дээшилж, хөдөлмөрийн хөлс, бүрэн болон хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ зохистой харьцаанд орлоо. Тухайлбал, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2000 онд 18000 төгрөг, 2001 онд 24750 төгрөг, 2002 онд 30000 төгрөг хүртэл нэмэгдсэн бол 2004 оны 3 дугаар сараас 40000 төгрөг болох юм. Энэ шийдвэр нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, амьжиргааны доод түвшин, нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн болон хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ, нийгмийн халамжийн тэтгэвэр зэрэг үзүүлэлтүүдийн хоорондын зохистой харьцааг тогтоох, хувийн хэвшилд ажиллагсдын цалин хөлсийг нэмэгдүүлэхэд чиглэсэн алхам болжээ.


Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагаа явуулж буй өмчийн олон хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагсдын 2003 оны 4 дүгээр улирлын сарын дундаж цалин 82.8 мянган төгрөгт хүрсэн нь 2002 оны 4 дүгээр улирлынхаас 7.3 мянган төгрөгөөр буюу 9.7 хувиар нэмэгдсэн байна.

Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагсдын сарын дундаж цалинг эдийн засгийн салбараар авч үзэхэд барилга, уул уурхайн олборлох, аж үйлдвэр, тээвэр, холбоо, агуулахын аж ахуй, санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа зэрэг салбарт ажиллагсдын дундаж цалин улсын дунджаас 7.8-40.7 мянган төгрөгөөр их байхад боловсрол, төрийн удирдлага, батлан хамгаалах, нийгмийн даатгал, нийгэм, бие хүнд үзүүлэх үйлчилгээ, хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбарт ажиллагсдын цалин улсын дунджаас 6.5-39.9 мянган төгрөгөөр доогуур байна.

Зураг 19. Хэрэглээний бараа, үйлчилгээний бүлгийн индекс, хувиар (2000.12=100)



Зураг 20. Хүнсний барааны дэд бүлгүүдийн үнийн индекс, хувиар (2000.12=100)



ШИГТГЭЭ 4. ИНФЛЯЦИЙН ТААМАГЛАЛ

1990-ээд оноос эхлэн Төв банкууд мөнгөний бодлого явуулах хэв загвараа өөрчилж, үнийн тогтвортой байдлыг бодлогын гол зорилгоо болгон, инфляцийг тодорхой түвшинд барихаар олон нийтэд зарладаг болсон байна. Энэ хэв загвараар мөнгөний бодлогоо явуулахын тулд инфляцийн таамаглал дэвшүүлдэг загвартай байх нь чухал асуудал юм. Энэ судалгааны зорилго нь Монгол улсын инфляцийн таамаглалын загвар гаргаж, түүнийг үнэлэн, ирэх оны инфляцийн ерөнхий хандлагыг харуулахад оршино.

Инфляцийг таамаглах арга замууд

Инфляцийг таамаглах олон загварууд байдаг. Жишээ нь, Филлипсийн муруйн загвар, markup загвар, индикатор загвар, мөнгөний нийлүүлэлтийн функцийн загвар, вектор авторегрессийн загвар, ARIMA загвар гэх мэт. Эдгээр загваруудаас судалгаандаа ARIMA, вектор авторегрессийг инфляцийн таамаглал дэвшүүлэхдээ ашиглалаа. Box-Jenkins-ийн ARIMA загвар нь нэг чиглэлийн загвар бөгөөд авторегресс, интеграцийн зэрэг, шаталсан дунджаас хамаардаг. Энэ загвар нь хэдийгээр энгийн боловч оновчтой сайн таамаглал хийдэг. Тиймээс ARIMA загварыг суурь болгож, бусад инфляцийн загваруудыг харьцуулдаг.

Хориод жилийн өмнө Christopher Sims (1980) шинэ макроэконометрикийн загвар вектор авторегрессийг (VAR) танилцуулсан байна. VAR n-тэгшитгэл, n-хувьсагчаас бүрдэх ба хувьсагч бүр нь өөрийнхөө хоцролттой утга болон үлдсэн n-1 хувьсагчийн одоогийн ба хоцролттой утгуудаар тайлбарлагддаг. Энэхүү энгийн загвар нь олон хувьсагчийн баялаг динамикуудыг системтэйгээр харуулдаг. VAR загварыг өгөгдлийг тайлбарлах, таамаглах, бүтцийн гаргалгаа, бодлогын шинжилгээ хийхэд ашигладаг. Гэхдээ өгөгдлийг тайлбарлах, таамаглахдаа VAR нь хүчтэй найдвартай бөгөөд эдийн засгийн бүтцийн болон бодлогын шинжилгээг сайн хийдэг эсэх нь эргэлзээтэй (J.Stock M.Watson, 2001).

Инфляцийн таамаглал хийхийн тулд хамгийн түрүүнд хугацааны цувааны бүтцийг судлах хэрэгтэй байдаг. Үүний тулд инфляци ба түүний автокорреляцийн функцийг графикаар үзүүлээ. Зураг 1-ээс харахад инфляцийн дундаж тогтвортой биш, буурсан хандлага ажиглагдаж байна. Автокорреляцийн функцийг (Зураг 2) ажиглахад автокорреляцийн утгууд хугацааны хоцролтын дагуу удаанаар буурч байгаа нь инфляцийг тогтвортой бус гэдгийг давхар баталж байна.


Зураг 1.



Зураг 2.



Зураг 3.



Нэгэнт инфляци тогтвортой бус тул (өмнөх судалгаанд ADF тестээр шалгагдсан) 1-зэргийн ялгаврыг (first order difference) авч коррелограмыг шинжиллээ.


Коррелограмын графикаас харахад 7, 12-р хугацааны хоцролт дээр автокорреляци болон хэсэгчилсэн автокорреляци нь ач холбогдолтой байна. Боломжтой хувилбаруудаас квадрат алдааны дундаж язгуур (RMSE) дээр үндэслэн дараах ARIMA загварыг сонгов.

$$\begin{aligned} \text{dlog}(\text{Inf})_t = & -0.006 + e_t - 0.953e_{t-12} \\ & (-5.53) \quad (-58.0) \end{aligned}$$


Үүнд: dlog(inf) - натурал логарифм авсан инфляцийн 1 зэргийн ялгавар, e - регрессийн алдаа, хаалтан дотор байгаа тоонууд t статистик

VAR загварын хувьсагчаар инфляцид нөлөөлж болох гол үзүүлэлтүүд буюу ханш, мөнгөний нийлүүлэлт, Төв банкны үнэт цаасны хүүг авав. Энэ загварыг бодохын тулд хувьсагч тогтвортой байх шаардлагатай. Өмнөх судалгаанд эдгээр хувьсагчийг ADF тестээр шалгаж тогтворгүй болохыг харуулсан тул энэ судалгаанд тооцоог оруулаагүй. Зарим судлаачдийн (Clements, Hendry, 1995) тогтвортой бус хувьсагчаар бодсон VAR нь, ялгавар авсан VAR, коинтеграцлагдсан VAR-аас илүү сайн таамаглал хийж байгаа нь тогтоогджээ. Иймээс энэ судалгааны зорилго нь инфляцийн таамаглал дэвшүүлэх тул хувьсагчийн 1-р зэргийн ялгаврыг авч тогтвортой болгоогүй түвшингээр авсан байна. VAR-ийн хугацааны хоцролтыг тодорхойлохдоо Akaike, Schwarz-ийн мэдээллийн шинжүүрийг ашигласан. Хугацааны хоцролт Akaike шинжүүрээр 2, Schwarz шинжүүрээр 1 гэсэн зөрүүтэй гарсан бөгөөд Akaike шинжүүрийг сонгон авч VAR-ийн хугацааны хоцролтыг 2-р авсан. VAR нь 3 хэлбэртэй байдаг: багасгасан хэлбэр (reduced), дараалсан хэлбэр, (recursive, Sims, 1980), бүтцийн хэлбэр (structural, Bernanke, Blanchard, Watson, Sims, 1986). Эхлээд VAR-ийг багасгасан хэлбэрт боддог ба энэ шатанд тооцоолсон коэффицентуудын утга ач холбогдолгүй тул энэ тооцооны үр дүнг харуулдаггүй бөгөөд системийн буруу эсэхийг тодорхойлох тестийг (misspecification) хийдэг. Харин дараагийн шатанд багасгасан хэлбэрээс дараалсан эсвэл бүтцийн хэлбэрт шилжиж импульсийн хариу функц (impulse response function) болон вариацийн задаргааг (variance decomposition) хийж үр дүнг харуулдаг. Энэ судалгаанд дараалсан буюу cholesky-ийн задаргааг ашиглан импульсийн хариу функцийг тооцооллоо.

Зураг 4.



Зураг5.



Графикаас харахад ханш болон үнэт цаасны хүү инфляцид хүчтэй нөлөөлж байхад мөнгөний нийлүүлэлтийн нөлөө харьцангуй бага бөгөөд буруу хамаарал харуулж байна.

Түүвэр доторхи 2002 оны 12 сарын инфляцийн таамаглалыг бодит утгатай харьцуулан RMSE-ийг тооцоход ARIMA загварынх 6.73, VAR загварынх 7.25 байна. Иймээс ARIMA загвар VAR -тай харьцуулахад илүү оновчтой таамаглал хийж байна. Энэ 2 загвар дээр үндэслэн 2003 оны инфляцийн ерөнхий хандлагын таамаглалыг хийлээ. Дээрх үр дүнг хүснэгтээр нарийвчлан харуулбал:

	2003											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
ARIMA	1.8	0.3	1.5	-0.4	-3.1	-2.8	-2.0	-1.8	-1.2	-1.1	-2.9	-5.0
VAR	1.1	0.1	1.7	0.3	-1.1	-0.5	1.2	4.7	6.6	6.7	5.6	4.0
Дундаж	1.4	0.2	1.6	-0.1	-2.1	-1.6	-0.4	1.5	2.7	2.8	1.4	-0.5

ARIMA, VAR загварын динамик таамаглалууд оны дунд үеэс нэлээд зөрүүтэй болж байна. Тиймээс эдгээр динамикуудыг

дундажлан ерөнхий хандлагаар инфляцийн таамаглал дэвшүүлж болно. Гэхдээ таамаглал дэвшүүлж буй хугацаа урт байхад VAR илүү найдвартай байдаг (Clements, Hendry, 1995).

Дүгнэлт

Энэ судалгаагаар 2003 оны инфляцийн хандлагын таамаглал дэвшүүлэх гэж оролдлоо. Үүний тулд цаг хугацааны ARIMA, VAR гэсэн загваруудыг ашиглалаа. VAR загвараар инфляцийн таамаглал дэвшүүлэх үед инфляцид валютын ханш, Төв банкны үнэт цаасны хүү нөлөөлж байгаа нь импульсийн хариу функцээс харагдаж байна. Тиймээс үүний түвшинг тогтвортой барихын тулд богино хугацаанд мөнгөний нийлүүлэлтээс илүү ханш, хүүнд ач холбогдол өгөхөөр дүгнэлт гарахаар байна.

ARIMA, VAR загвараар ирэх оны инфляцийг таамаглахад оны дунд үеэс нэлээд зөрүүтэй болж байна. 2003 оны эцэст инфляци ARIMA загвараар -5.0 хувь, VAR загвараар 4.0 хувь байхаар таамаглагдаж байна. Эдгээр загвар болон өмнөх жилүүдийн хандлага дээр үндэслэн тунгаан бодсоны эцэст ирэх оны инфляци жилийн 2-4 хувийн хооронд байна гэж таамаглалаа.

2.5. Ажиллах хүчний зах зээл

Монгол улсын нийт хүн ам 2003 оны эцсийн байдлаар 2504.0 мянгад хүрснээс хөдөлмөрийн насны хүн ам 1488.2 мянга, эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу ажиллах хүч 959.8 мянга, ажиллагчид 926.5 мянга болов.

Нийгмийн ядуурлыг бууруулж, эдийн засгийн өсөлтийг хангахад зах зээлийн зарчимд нийцсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлого чухал үүрэгтэй билээ.

Ажилгүйдлийн даатгалд хамрагдаагүй, удаан хугацаагаар ажилгүй байгаа нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд мэргэжил олгох болон тэднийг давтан сургалтанд хамруулж хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэхэд ихээхэн анхаарч ажилласан байна. Энэ арга хэмжээнд 2003 онд 399.4 сая төгрөг зарцуулж, 13.7 мянган хүнийг мэргэжлийн сургалтанд хамруулжээ.

Аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2003 оны жилийн эцсийн байдлаар 33.3 мянгад хүрч, өнгөрсөн оны эцсээс 8 хувь буюу 2.5 мянган хүнээр нэмэгдэв. Нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 46.5 хувь нь тодорхой ажил хөдөлмөр эрхэлж байсан бол 53.3 хувь нь аливаа нэг ажил хөдөлмөр эрхлээгүй, анх удаа ажил хайж бүртгүүлсэн хүмүүс байна. 2003 онд аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн албанд 61.9 мянган ажилгүй хүн шинээр бүртгүүлсэн байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 24.1 хувийг 16-24 насны, 33.2 хувийг 25-34 насны, 30.2 хувийг 35-44 насны, 12.5 хувийг 45-59 насны хүмүүс эзэлж байна.

Ажилгүйчүүдийн 9.3 хувь нь дээд, 9.9 хувь нь тусгай дунд, 10.9 хувь нь мэргэжлийн анхан шатны, 63.8 хувь нь бүрэн ба бүрэн бус дунд, 5.3 хувь нь бага боловсролтой, 0.8 хувь нь боловсролгүй хүмүүс байна.

Хүснэгт 6. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд							(мян. хүн)	
Үзүүлэлтүүд	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003*
Хөдөлмөрийн насны								
хүн амын тоо	1212.8	1229.6	1256.8	1279.3	1347.4	1402.8	1439.2	1488.2
Эдийн засгийн идэвхитэй хүн ам	825	828.8	842.4	853.4	847.6	872.6	901.7	959.8
Ажиллагчид	769.6	765.1	792.6	813.6	809	832.3	870.8	926.5
Бүртгэлтэй ажилгүйчүүд	55.4	63.7	49.8	39.8	38.6	40.3	30.9	33.3
Ажилгүйдлийн түвшин (хувиар)	6.7	7.7	5.9	4.7	4.6	4.6	3.4	3.5
Эх үүсвэр: ҮСГ								
* Урьдчилсан байдлаар								

Засгийн газар АХБ-ны ажлын байр нэмэгдүүлэх төслийн хүрээнд Голомт, Зоос, Эрэл, Тээвэр хөгжлийн банкаар дамжуулан 2001-2003 онд 361 аж ахуйн нэгж байгууллага, 129 иргэнд 6.2 тэрбум төгрөгийн зээл олгож, 3901 ажлын байр бий болголоо.

2003 оны эцсийн байдлаар 19 аж ахуйн нэгж БНСУ, БНЧУ, БНУУ, Япон улсуудад ажиллах хүч гаргаж нийт 2489 хүнд зуучилжээ.

Мөн тайлант онд 67 орны 7532 иргэдэд Монгол улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгосноос 65.4 хувь нь БНХАУ-ын, 17.6 хувь нь ОХУ-ын, 2.2 хувь нь БНСУ-ын, 2.1 хувь нь АНУ-ын, 2.0 хувь нь Австрали улсын, үлдэх хувийг Украин, Канад, Япон зэрэг бусад улсын иргэд тус тус эзэлж байна.

Манай улсын дэд бүтэц, тухайлбал, авто зам, эрчим хүч болон бусад салбарт хэрэгжиж байгаа хэд хэдэн төсөл, улсын хэмжээний томоохон барилга байгууламжууд, уул уурхайн салбарын үйлдвэрлэл нь улирлын чанартай, богино хугацаанд эрчимтэй явагддагаас шалтгаалан хавар, зуны улирлуудад гадаадаас орж ирэх ажиллах хүч эрс нэмэгддэг. Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлтэй ажиллаж буй гадаадын иргэдийг эдийн засгийн салбараар авч үзвэл уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарт 42.2 хувь, боловсруулах үйлдвэрийн салбарт 12.9 хувь, боловсролын салбарт 10.5 хувь, барилгын салбарт 6.9 хувь, үлдэх хувийг бусад салбарууд эзэлж байна.

3

МӨНГӨ, САНХҮҮГИЙН
САЛБАРЫН ХӨГЖИЛ

Мөнгө, санхүүгийн салбарын хувьд 2003 он иргэдийн банкинд итгэх итгэл үргэлжлэн дээшилсэн, банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний цар хүрээ өргөжиж, банкны татан төвлөрүүлсэн хөрөнгө, түүнчлэн зээлжүүлэлт нэмэгдсэн, ингэснээр эдийн засгийн өсөлтөнд хувь нэмрээ оруулсан жил болж өнгөрөв. Хэрэглээний үнийн индексээр тооцсон инфляцийн түвшин нэг оронтой тоонд шилжиж тогтворжлоо. Инфляци оны турш тогтвортой байж, тайлант оны эцэст жилийн 4.7 хувь болов. Нийт мөнгө оны эхнээс 49.6 хувиар өссөн нь ХХ-ийн банкинд байршуулсан Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр (УБҮ), Айвенхоу Майнз компанийн гадаад валютын хадгаламж огцом нэмэгдсэнтэй холбоотой бөгөөд энэ нь нэг удаагийн шинжтэй өсөлт юм.

3.1. Мөнгөний нийлүүлэлт

2003 онд эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлт оны эхнээс 49.6 хувь буюу 233.2 тэрбум төгрөгөөр өсч 703.3 тэрбум төгрөгт хүрэв. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт өмнөх онтой харьцуулахад 67.7 хувь буюу 94.1 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Энэхүү өсөлтийн дийлэнх буюу 89.2 хувийг төгрөгийн болон валютын хадгаламж (бараг мөнгө)-ийн өсөлт эзэлж байна. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөнд голлох нөлөө үзүүлж байсан банкнаас гадуурхи мөнгө болон төгрөгийн харилцах (М1)-ын нийт мөнгөний өсөлтөнд эзлэх хувь өмнөх оноос 11.9 нэгжээр буурч 10.8 хувь боллоо.

Гадаад валютын хадгаламж оны эхнээс хамгийн ихээр буюу 85.1 хувиар өссөн бол банкнаас гадуурхи мөнгө хамгийн багаар буюу 8.9 хувиар нэмэгдсэн байна. Тайлант оны 1-7 дугаар саруудад мөнгө М1-ийн жилийн өсөлт 39.4 хувиас 10.4 хувь хүртэл буурч, бараг мөнгө 58.4 хувиас 59.9 хувь хүртэл өсчээ. Харин өнгөрсөн оны 8-11

Хүснэгт 7. Мөнгө санхүүгийн салбарын гол харьцаанууд

(хувиар)

	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003
М2/ДНБ	52.4	27.6	21.9	23.7	18.6	19.9	20.4	20.5	23.8	25.4	29.7	37.9	51.6
Зээл/ДНБ	68.0	40.4	16.2	16.3	11.4	10.0	6.0	10.5	8.4	6.6	12.1	18.7	32.5
Бараг мөнгө/ДНБ	13.8	11.4	12.4	13.5	10.8	9.9	11.3	10.4	11.4	12.6	15.7	22.8	36.0
Банкнаас гадуурхи мөнгө/М2	17.1	14.1	20.5	24.4	25.1	32.5	29.3	33.7	39.6	39.0	33.0	25.7	18.7
Зээлийн үлдэгдэл (тэрбум төгрөг)	12.9	19.1	31.6	52.8	62.7	64.8	50.4	85.6	77.5	66.8	135.1	231.4	442.1

ШИГТГЭЭ 5. МОНГОЛ УЛС ДАХЬ МӨНГӨ, САНХҮҮГИЙН ТОГТОЛЦООНЫ ҮҮСЭЛ

Манай эриний өмнөх III зууны сүүлээр байгуулагдсан Хүннү нарын үеэс эхлэн Сүннү, Уйгар, Кидан гүрний үед “Зүүн үзүүрт хутган мөнгө”, “Сүхэс” (сүх), “Их Монгол улсын мөнгө”, “Өлгий мөнгө”, “Их хааны нэвтрэх эрдэнэ” нэртэй зоосон мөнгийг цутган хэрэглэж, таваар мөнгөний гүйлгээг хөгжлийн өндөр түвшинд явуулж иржээ.

Их эзэн Чингис богд 1206 онд Монголын тулгар төрийг эмхлэн байгуулаад мөнгөн зоос цутгуулан хэрэглэж, улмаар 1227 онд дэлхийд анх удаа цаасан мөнгө хэвлэн гүйлгээнд гаргаж, XIII зуунд банк байгуулж байсан түүхтэй.

Чингис хааны үе залгамжлагчид Монголын нэгдсэн гүрний үед 100 гаруй төрлийн алт, мөнгө, зэс, гууль, хүрэл зоос цутгуулж, 1236 онд Өгөөдэй хаан, 1254 онд Мөнх хаан цаасан мөнгийг дахин хэвлүүлэн гүйлгээнд гаргаж, эд баялгаа тооцоолсон бөгөөд гадаад гүрнүүдтэй худалдаа наймаа хийж байжээ.

Мөнгөн гүйлгээний энэ баялаг уламжлал эзэнт гүрний задрал, манжийн дарлалын он жилүүдэд тасалдсан ба хэдэн зууны турш улс орны аж ахуй эмх замбараагүй байдалд орсон юм. Энэ үед Монгол орны зах зээл дээр мал, арьс шир, хадаг, цай зэрэг зүйлс мөнгөний үүрэг гүйцэтгэж байсны дээр XIX, XX зууны заагт цагаан мөнгө, өмбүү, Орос, Хятад, Англи, Америкийн алт, мөнгөн зоос, цаасан тэмдэгтүүд зэрэгцэн төлбөрийн хэрэгслийн үүрэг гүйцэтгэж байжээ. Үүний уршгаар улс орны мөнгөн гүйлгээ зохицуулалтгүй болж, гадаад, дотоодын мөнгө хүүлэгчид баяжин монгол түмэн дааж давшгүй өр зээлд унасан байна. Үүний үр дүнд улсын эдийн засаг гадны хараат байдалд орсон байна.

Монгол орны зах зээлд гадаадын хөрөнгө (капитал) ихээр орж ирж байсны нөлөөгөөр гадаадын банкны салбар буюу Монголын талтай хамтарсан банкны байгууллага байгуулагдан ажиллаж байжээ. Тухайлбал, 1900 онд Өргөө, Улиастай хоёрт салбараа нээсэн Орос-Хятадын банк богино хугацаанд үйл ажиллагаа явуулсан бол 1907 онд мөн хоёр газар салбараа нээсэн хятадын Дацинь банк 1912 он хүртэл ажиллажээ. Монголын автономит Засгийн газрын хүчин чармайлтаар 1915-1919 онуудад Орос улсын Сибирийн худалдааны банкны салбар Монголын үндэсний банк нэртэйгээр ажиллаж байсан байна. Мөн Монголын Засгийн газрын хүсэлтээр 1918 оны сүүлээр нээгдсэн Хятадын Жунго банкны салбар жилийн дараа татан буугдаж Япон-Хятадын хувь нийлүүлсэн Жибинь банкны салбар үйл ажиллагаагаа эхэлсэн боловч удалгүй хаагджээ.


1921 онд Ардын хувьсгал ялсны дараа Ардын засгаас авч явуулсан эдийн засгийн анхны арга хэмжээ нь улс болон ард иргэдээс гадаадын худалдаачид, мөнгө хүүлэгчдэд төлөх өрийг хүчингүй болгох, феодалын төсөв, албан татварын системийг устгахад чиглэгджээ. Улсын түр хурал 1922 онд “Хоршоо сайжруулах банк” нээхээр шийдвэрлэсэн байна. Тухайн үеийн эдийн засгийн чадавхи дорой, мэргэжлийн ажиллах хүчин байхгүй, иймд өөрийн хүч, хөрөнгөөр банк байгуулах бололцоогүй байсан тул Монголын Засгийн газраас Зөвлөлт Холбоот Улсад хандаж туслалцаа үзүүлэх хүсэлт гаргажээ. 1923 онд Монголын Худалдаа ба аж үйлдвэрийн банкны дүрэм батлагдсан бөгөөд 1924 онд хамтарсан банк байгуулагджээ.

Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн Худалдаа ба аж үйлдвэрийн банк (Монголбанк)-ны анхны жилүүдийн үйл ажиллагааны зорилт нь хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн хөгжилд түлхэц өгөх, худалдааг өргөжүүлэх, улс орны мөнгөн гүйлгээг зохицуулах явдал байсан юм. Монголбанкны зээлийн гүйлгээнд бараа эргэлттэй холбоотой векселийн тооцоо болон вексель, бараа, үнэт металл барьцаалсан гүйлгээ зонхилж байв. Мөнгөний гүйлгээ хятад янчаан, хатуу цагаан мөнгөөр хийгдэж байсан тул түүнийг зохицуулах боломжгүй болж, банкны өмнө гадаад валют, үнэт металл, богино хугацаат вексель, түргэн борлогдох таваараар баталгаажсан монгол үндэсний валют гаргах буюу эмиссийн үйл ажиллагааг зохион байгуулах зорилт тавигдсан байна. Банк өөрийн зориулалтын гүйлгээнээс гадна үндсэн хөрөнгийнхөө 30 хувьд багтаан ашигт малтмал боловсруулах, худалдааны болон тээврийн байгууллага байгуулах концессид оролцох буюу уг концессийг хүлээн авах эрх эдэлж байв. Ингэснээр Монголын ард түмний эрх ашигт чиглэсэн үйл ажиллагааны өргөн талбар, хариуцлагатай зорилтууд Монголбанкны өмнө тавигдаж байлаа.

Зохион байгуулалтын эхэн үед Монголбанк ажлын хэлбэр, ойрын болон хэтийн зорилтыг тодорхойлж, харилцагчдыг татан зээл, тооцооны ажил гүйлгээний үндсийг тавьсан бөгөөд Хиагтад анхны салбараа нээж, хэд хэдэн гадаад банктай харилцаа тогтоосон байна. Монголбанкны энэхүү үйл ажиллагаа улс орны эдийн засгийн амьдралыг мэдэгдэхүйц идэвхжүүлжээ. 1925 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар зээлийн нийт активт эзлэх хувийн жин 52.5 хувь, касс, үнэт цаасны үлдэгдлийнх 31.6 хувь, татан төвлөрүүлсэн хөрөнгийн нийт пассивт эзлэх хувийн жин 56.8 хувь, өөрийн хөрөнгийнх 43.2 хувь тус тус байв.

Банкны үйл ажиллагааны хоёр дахь жилийн зорилт Монголд мөнгөний шинэчлэл хийх нөхцөл бүрдүүлэх явдал байлаа. Мөнгөний шинэчлэл хоёр үе шаттайгаар хэрэгжсэн юм. Эхний ээлжинд, үндэсний мөнгөн тэмдэгт төгрөг гүйлгээнд орж, мөнгөний харилцаанаас янчааныг шахан зайлуулсан, дараагийн үе шатанд, төгрөг хууль ёсны төлбөрийн хэрэгслийн үүргийг дангаар гүйцэтгэх болж, алтаар баталгаажсан байна. Засгийн газрын шийдвэрээр улс орны бүхий л аж ахуйн газар, байгууллагын тооцоо, үнэ, татвар, хураамжийг 1927 онд төгрөгөөр тооцож эхэлсэн байна.


Зураг 21. Мөнгөний үзүүлэлтүүд, 12 сарын өсөлт



Зураг 22. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн бүтэц



Зураг 23. Мөнгөний нийлүүлэлт, дотоод болон гадаад цэвэр активуудын жилийн өөрчлөлт



саруудад тэдгээрийн жилийн өсөлт харьцангуй тогтворжсон боловч оны сүүлийн сард гадаад валютын хадгаламж өмнөх сараас 24.7 хувиар нэмэгдсэн нь бараг мөнгийг огцом өсгөж, улмаар нийт мөнгө М2-ыг оны эцэст эрс нэмэгдүүлэх нэг шалтгаан болсон байна. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөнд иргэдийн төгрөгийн хадгаламж зонхилох үүрэгтэй болж байгаа хандлага харагдаж байна.

Тайлант онд мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн өөрчлөлтийн зонхилох хувь нь дотоод цэвэр активын өсөлтөөр хангагджээ. Харин гадаад цэвэр актив өмнөх оныхоос 52.2 тэрбум төгрөгөөр буурсан байна. Хэдийгээр эхний 11 сарын туршид гадаад болон дотоод цэвэр активуудын өөрчлөлт харьцангуй тогтвортой буюу жилийн өсөлт дунджаар 40 гаруй хувь байсан боловч оны сүүлийн сард дотоод цэвэр актив өмнөх сарынхаас 78.5 хувь буюу 196.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, гадаад цэвэр актив 32.0 хувь буюу 120.8 тэрбум төгрөгөөр буурчээ. Гадаад болон дотоод цэвэр активын хэмжээ сүүлийн сард огцом өөрчлөгдсөн хэдий ч тэдгээрийн өөрчлөлтүүд харилцан эсрэг чиглэлтэй байсан нь мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтөнд үзүүлэх нөлөөг багасгасан байна.

Банкны салбараас дотоод секторт олгосон цэвэр зээл оны эхнээс 57.3 хувь буюу 314.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнээс дотоод цэвэр актив 76.6 хувь буюу 285.4 тэрбум төгрөгөөр өслөө. Дотоод цэвэр зээлийн өсөлтийн 51.3 хувь нь хувийн секторт, 41.0 хувь нь засгийн газарт тус тус ноогдож байна.

Тайлант онд гадаад цэвэр актив өмнөх оныхоос 24.2 хувь буюу 64.8 сая ам. доллараар буурснаас гадаад цэвэр албан нөөц 42.9 хувь буюу 98.9 сая ам. доллараар буурав. Гадаад цэвэр албан нөөцийн өөрчлөлтөнд мөнгөжсөн алт 86.6 хувь буюу 43.1 сая ам. доллар, гадаадын банк дахь хугацаат хадгаламжийн хэмжээ 28.9 хувь буюу 46.0 сая ам. доллараар тус тус буурсан нь нөлөөлсөн байна. Харин 2003 оны 11 дүгээр сараас Чингис хаан банкны гадаад эх үүсвэр шинээр нэмэгдсэнээс бусад гадаад пассивын хэмжээ өсч, улмаар бусад гадаад актив тэр хэмжээгээр буурчээ.

Бага мөнгө М1

2003 онд банкнаас гадуурхи мөнгө болон төгрөгийн харилцахын өсөлт өмнөх оныхоос буурснаас бага мөнгөний өсөлт 6.8 нэгжээр, түүний нийт мөнгөнд эзлэх хувь 9.6 нэгжээр тус тус буурлаа. Бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслүүдийн хэрэглээ нэмэгдэхийн хирээр М1-ийн өсөлтөнд төгрөгийн харилцахын үлдэгдэл зонхилох буюу 57.4 хувийг эзлэх болсон байна.

Тайлант онд банкнаас гадуурхи мөнгө 8.9 хувь буюу 10.7 тэрбум төгрөгөөр, төгрөгийн харилцах 21.5 хувь буюу 14.4 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ. ДНБ-д зонхилох хувийг эзэлдэг хөдөө аж ахуй болон уул уурхайн салбаруудын улирлын чанартай үйлдвэрлэл өвлийн саруудад буюу оны эхний гурван сард зогсч харин 2 дугаар улиралд тэдгээрийн бэлтгэл болон үндсэн үйл ажиллагаа эхэлдэг. Үүнтэй холбоотойгоор эхний улиралд банкнаас гадуурхи мөнгөний эрэлт буурч, дараагийн

ШИГТГЭЭ 6. НИЙТ МӨНГӨ (M2)-НИЙ ДИНАМИК ЭГНЭЭГ ШИНЖЛЭХ НЬ

Төв банкны дотоодын үнийн өсөлтийг хязгаарлаж байх гол зорилтын хүрээнд зайлшгүй судалж, шаардлагатай тохиолдолд зохицуулалт хийж байх гол үзүүлэлт бол нийт мөнгө буюу M2 юм. Сүүлийн жилүүдэд нийт мөнгөний өсөлт нилээд эрчимжих хандлагатай, ялангуяа 2002 онд 42 хувь, 2003 онд 49.6 өссөн тооцоо гарч байна. Энэ судалгаагаар M2-ын динамик эгнээ дэх сүүлийн жилүүдэд гарсан өөрчлөлт болон хэлбэлзлийг тодорхойлох, түүнд мөнгөний агрегатуудын аль нь илүү хүчтэй нөлөөлж байгааг тусгахыг зорилоо. M2-ын динамик эгнээний сүүлийн 5 жилийн ерөнхий хандлага нь илэрхий өссөн бөгөөд түүнийг шугаман болон олон зэрэгт функцний аль нь илүү тодорхойлж байгааг регрессийн тэгшитгэлийн тусламжтайгаар харьцуулан үзье.


Энэ зургаас харахад мөнгөний нийлүүлэлтийн сүүлийн 5 жилийн динамик нь шугаман трендийн загварыг дагадаггүй болох нь үнэлгээний алдааны хэлбэлзлээр харагдаж байна. Мөнгөний нийлүүлэлтийг квадрат трендийн загвараар шалгаж үзэхэд $R^2=0.98$ гарсан нь хангалттай үзүүлэлт мөн боловч цааш үргэлжлүүлэн бусад загвараар шалгах шаардлага гарч байна.

Дээрх график нь экспоненциал (exponential) трендийн муруй бөгөөд алдааны хэлбэлзэл нь маш өндөр байгаа тул мөнгөний


нийлүүлэлтийг тайлбарлаж чадахгүй байна. Дараагийн шатанд авторегрессив функцээр шалгаж үзье. Зургаас харахад авторегрессив тренд нь мөнгөний нийлүүлэлтийг бүрэн хэмжээгээр загварчилж чадаж байгаа бөгөөд $R^2=99.3$, алдаа нь мөн тогтвортой байгаа нь үүнийг нотолж байна. Ийнхүү манай улсын мөнгөний нийлүүлэлт нь авторегрессив трендтэй байна.

M2 динамик эгнээний улирлын хэлбэлзлийг шинжлэх нь

Манай улсын ДНБ болон нийт зээл нь улирлын хэлбэлзэлтэй байдаг бөгөөд одоо мөнгөний нийлүүлэлтийг улирлын хэлбэлзэлтэй эсэхийг шалгая. Эконометрикийн Eviews программын Census X11 программыг ашиглан нийт мөнгөний улирлын нөлөөг шалгаж үзэхэд хэлбэлзэлтэй байгаа нь батлагдаж байна. Дараагийн шатанд нийт мөнгөний улирлын хэлбэлзлийн индексийг тооцоолон гаргасны үндсэн дээр хэлбэлзлийн графикийг байгуулж, муруйн хандлагыг шинжилнэ. M2 хувьсагдахууны динамик эгнээний сүүлийн 5 жилийн тренд нь илэрхий өссөн хандлагатай байгаа тул эгнээг статистикийн шаталсан дунджаар тэгшитгэх аргыг хэрэглэн улирлын индексийг тооцооллоо.



улирлын эхэнд хамгийн доод цэгээсээ хөдөлж, аажмаар өссөөр 3 дугаар улиралд оргил цэгтээ хүрч, улмаар аажим буурсаар 4 дүгээр улиралд улирлын нөлөөгүй утгад дөхөж очдог байна. Ийнхүү нийт мөнгөний улирлын хэлбэлзэл нь манай улсын ДНБ-ий улирлын хэлбэлзэл (Монголбанк, Судалгааны ажил 2002)-тэй ойролцоо байгаа хэдий ч ДНБ-ий оргил үе нь 2 дугаар улиралд байдаг бол мөнгөний нийлүүлэлтийнх 3 дугаар улиралд байдгаараа ялгаатай байна.



M2-ын засварласан улирлын индексүүдийг харахад нийт мөнгө нь 1 ба 4 дүгээр улиралд улирлын нөлөөгүй голлосон шаталсан дундажаасаа (100%) доогуур, 2 ба 3 дугаар улиралд түүнээс дээгүүр байдаг нь харагдаж байна. Мөнгөний нийлүүлэлтийн улирлын ерөнхий динамикийг дүрсэлбэл, 1 дүгээр

Улирлын хэлбэлзлийн засварласан утгыг (MONEYSA) нийт мөнгөний гүйцэтгэлтэй харьцуулж үзвэл улирлын хүчин зүйлсийн нөлөө төдийлөн их биш байгаа нь доорх графикаас харагдаж байна.

M2-ын динамикийг мөнгөний тоймоор тодорхойлох нь

Мөнгөний тоймын актив пассив гэдэг нь Төв банк болон банкуудын хураангуй тэнцлийн актив пассиваас бүрддэг. Түүний ач холбогдол нь банкны салбарт гарч байгаа мөнгөний болон зээлийн өөрчлөлтийг тодорхой цаг хугацаагаар, тоон үзүүлэлтээр харуулахын зэрэгцээ бодлого боловсруулагчдад тэдгээрийн өөрчлөлтийг хянаж, түүний үндсэн дээр шаардлагатай үед мөнгөний бодлогын зохицуулалтыг хийж байх боломжийг олгодогт оршино.

$$M1 = CY + DD, \quad M2 = M1 + QM \quad \text{эсвэл} \quad M2 = CY + DD + TD$$

M2 – нийт мөнгө, M1 – бага мөнгө, QM – бараг мөнгө, CY – банкнаас гадуурхи мөнгө, DD – хугацаагүй хадгаламж, TD – хугацаатай хадгаламж.

Бага мөнгө, бараг мөнгө, банкнаас гадуурхи мөнгөний сүүлийн 5 жилийн динамикийг ажиглахад бараг мөнгө буюу хугацаатай хадгаламж бусдаасаа харьцангуй огцом өсөлттэй байна. Гадаад цэвэр актив (ГЦА) болон дотоод цэвэр актив (ДЦА)-ийн нийлбэр дүн нь эдийн засаг дахь нийт мөнгөний хэмжээг бас харуулдаг. ДЦА нь дотоод цэвэр зээл (ДЦЗ) болон бусад цэвэр зүйл (БЦЗ)-ээс бүрддэг байна. Үүнийг томъёолбол,

$$M2 = ГЦА + ДЦА \quad \text{буюу} \quad M2 = ГЦА + ДЦЗ + БЦЗ.$$

Манай орны хувьд бусад цэвэр зүйлийн үзүүлэлт нь байнга сөрөг гардаг тул $M2 = ГЦА + ДЦЗ - БЦЗ$ болдог байна.

ГЦА нийт мөнгөний хамгийн их хувийг байнга эзэлж байгаагаас гадна бусад цэвэр зүйлийн жин сүүлийн 4 жилд буурах хандлагатай байна. Эдгээр үзүүлэлтүүдийн сүүлийн 5 жилийн гүйцэтгэлийг харахад дорвитой өөрчлөлт аль алиных нь хувьд ажиглагдахгүй байна. Харин ДЦА-ийн хувьд 2002 оны дундуур харьцангуй огцом өөрчлөлт (өсөлт) гарсан байна. Энэ нь 2002 оны 8 дугаар сард бусад цэвэр зүйлийн утга анх удаа эерэг гарсантай холбоотой. Бусад цэвэр зүйл 2001 оны 8-9 дүгээр саруудад огцом эерэгээр өөрчлөгдөж, 2002 оны 9, 10 дугаар саруудад огцом буурсан байна. Бусад үзүүлэлтүүдийн хувьд жигд маш багаар хэлбэлзэж байжээ. Үүнээс үзэхэд нийт мөнгөний өсөлтийг дангаараа дорвитой тодорхойлж буй үзүүлэлт ерөнхийдөө харагдахгүй байна. Тиймээс мөнгөний нийлүүлэлтийн болон гадаад, дотоод цэвэр активууд тус бүрийн тоон өгөгдлүүдийн шинжилгээ (Data analysis)-г хийж үзье. Үүний тулд мөнгөний нийлүүлэлтийг гадаад цэвэр актив, дотоод цэвэр зээл болон бусад цэвэр зүйл хамаарсан скаттер плот байгуулж, өгөгдлүүдийг абсолют утга ба өөрчлөлт гэсэн 2 утгаар авч сарын, улирлын дунджаар, улирлын эцсээр гэсэн 3 төрлөөр шинжилж үзлээ.

- Мөнгөний нийлүүлэлт, гадаад цэвэр активын өөрчлөлтийн хооронд хүчтэй хамаарал байна.
- Мөнгөний нийлүүлэлт, дотоод цэвэр зээлийн хувьд хамаарал байж болох хэдий ч зарим өгөгдлүүд доош шилжсэн плот үзүүлж байгаа нь тодорхой хугацаанд гарсан гадны нөлөөнөөс шалтгаалсан байж болзошгүй.
- Мөнгөний нийлүүлэлт, бусад цэвэр зүйлийн хувьд илт урвуу хамаарал харагдаж байна.

Өөрчлөлтөөр авсан плотоос харахад гадаад цэвэр активаас бусад нь ямар нэгэн хамаарал үзүүлэхгүй байгаа нь тодорхой байна. Ийнхүү тоон өгөгдлийн шинжилгээний үр дүнд сарын өөрчлөлтүүдээр авсан утга нь бидэнд ямар нэгэн зүйл хэлж чадахгүй байгаа тул өөрчлөлт гэсэн тооцоололтыг судалгаанаас бүрмөсөн хасаж, зөвхөн абсолют утгаар авсан шинжилгээгээр хувьсагч нарын хооронд илэрсэн хамаарлыг судлах нь зөв гэдэг дүгнэлтийг хийж болохоор байна. Мөнгөний нийлүүлэлтийн дотоод цэвэр зээлээс хамаарсан скаттер плотоос харахад ерөнхий эерэг хандлагатай хамаарал байгаагаас гадна тодорхой хугацаанд доош шилжсэн хамаарал мөн ажиглагдсаныг дээр дурдсан. Эдгээр нь 1998-1999 онууд байсан бөгөөд энэ хугацаанд мөнгөний нийлүүлэлт, дотоод цэвэр зээлд нөлөөлсөн гадны хүчтэй нөлөө байсан гэж хэлж болохоор байна. Мөнгөний нийлүүлэлтийн дотоод цэвэр зээлээс хамаарсан (улирлын эцэс дэх гүйцэтгэлээр) регрессийн тэгшитгэл бодож үзэхэд хамаарал нь маш сул буюу дараахь байдалтай байв ($R^2 = 0.28$).

$$M2_{eq_t} = 68298.87 + 1.5157 \cdot ND_{eq_t} \\ (0.9006) \quad (2.6717)$$

Тиймээс дээрх тэгшитгэлд мультипликатив Думму хувьсагч оруулан дараахь байдлаар томъёолж үнэлье.

$$M2eq_t = b_0 + b_1 * NDCEq_t + dDeq_t + u_t$$

M2eq_t - т улирлын эцэс дэх мөнгөний нийлүүлэлтийн гүйцэтгэл
NDCEq_t - т улирлын эцэс дэх дотоод цэвэр зээлийн гүйцэтгэл
Deq_t - т улирал дахь Dummy утга
Үүнд: 1998-1999 онуудын Dummy утгыг 1, 2000-2003 онуудынхыг 0 гэв.

Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
C	122020.1	23772.39	5.132847	0.0001
NDCEQ	1.567295	0.161711	9.691945	0.0000
DEQ	-151272.8	13509.06	-11.19788	0.0000
R-squared	0.930058	Mean dependent var	276053.1	
Adjusted R-squared	0.922287	S.D. dependent var	107456.4	
S.E. of regression	29955.66	Akaike info criterion	23.58439	
Sum squared resid	1.62E+10	Schwarz criterion	23.73361	
Log likelihood	-244.6361	F-statistic	119.6787	
Durbin-Watson stat	1.716841	Prob(F-statistic)	0.000000	

Dependent Variable: M2EQ

Method: Least Squares

Date: 05/14/03 Time: 22:59

Sample: 1998:1 2003:1

Included observations: 21

Дээрх тооцоололтоос харахад dummy хувьсагч оруулан тооцсон загварын үнэлгээ эрс сайжирсан нь харагдаж байна. Энэ нь юуг нотолж байна вэ гэвэл 1998-1999 онуудад Төв банкнаас явуулсан мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр дотоод цэвэр зээлээр дамжин мөнгөний нийлүүлэлт бага түвшинд байсан хэрэг бөгөөд 2000 оноос эхлэн уг хатуу бодлогыг зөөлрүүлж эхэлсний илрэл юм.


Дээрх судалгаанууд дээр үндэслэн дараахь дүгнэлтийг хийлээ. Үүнд:

- Мөнгөний нийлүүлэлтийн ерөнхий хандлага нь илэрхий өсч байгаа бөгөөд авторегрессив загвартай байна.
- Мөнгөний нийлүүлэлт нь улирлын хэлбэлзэлтэй бөгөөд хэлбэлзэл нь ДНБ-ий улирлын хэлбэлзлийн динамиктай ижил, гэхдээ оргил үе нь ДНБ-ий улирлын хэлбэлзлийн оргил үеэс 1 улирлаар хоцрогдолтой байдаг байна.
- Улирлын хүчин зүйлсийн нөлөө маш бага.
- Мөнгөний агрегатуудын шинжилгээгээр сүүлийн жилүүдийн өөрчлөлтийг Бараг мөнгөний өсөлт голчлон тодорхойлж байна. Харин мөнгөний тоймын актив пассивийн цэвэр дүнгээр авсан тоон шинжилгээгээр мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөнд гадаад цэвэр активийн өсөлт голлох нөлөөг үзүүлж байсан байна.
- 2000 оноос өмнө явуулж байсан мөнгөний хатуу бодлогын зөөлрөлт нь дотоод цэвэр зээл хувьсагчид Dummy хувьсагч оруулан тооцсон судалгаагаар нотлогдож байна.

Эх үүсвэр: www.mongolbank.mn

улиралд бэлэн мөнгөний эрэлт өсөн банкнаас гадуурхи мөнгийг нэмэгдүүлдэг. Жилийн сүүлийн хагаст бэлэн мөнгөний урсгал хөдөө аж ахуй болон уул уурхайн салбараас банкны салбар руу буцаж ордгоос бэлэн мөнгө буурдаг хандлага ажиглагдаж байна. Ийнхүү банкнаас гадуурхи мөнгөний улирлын өөрчлөлтийн хандлага харьцангуй тогтвортой байгаа бөгөөд M1 болон M2-т хүчтэй нөлөөлдөг болно. Мөн сүүлийн жилүүдэд M1-ийн нийт мөнгөнд эзлэх хувийн жингийн өөрчлөлтийг даган M2-т үзүүлж буй улирлын хэлбэлзлийн нөлөө буурах хандлага ажиглагдаж байна.

Зураг 24. Засварласан улирлын хэлбэлзлийн индексүүд



Тайлант онд бараг мөнгө 73.7 хувь буюу 208.1 тэрбум төгрөгөөр өсч, 490.5 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт мөнгөний 69.7 хувийг эзэлж байна. Сүүлийн дөрвөн жилд төгрөгийн ам. доллартай харьцах ханш харьцангуй тогтвортой байснаас иргэдийн төгрөгт итгэх итгэл нэмэгдэн, улмаар төгрөгийн хугацаат хадгаламжийн өсөлт бараг мөнгөний өсөлтөнд зонхилж байлаа. Харин 2003 оны 12 дугаар сард Эрдэнэт УБҮ болон Айвенхоу Майнз компанийн валютын харилцах дансны үлдэгдэл огцом өсч, улмаар гадаад валютын хадгаламж өмнөх сарынхаас 49.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь өмнөх 11 сарын дундаж өсөлтөөс 8.3 дахин өндөр байна. Энэ нь гадаад валютын хадгаламжийн өсөлтийн бараг мөнгөний өсөлтөнд эзлэх хэмжээг 51.0 хувь болгоход нөлөөлөв.

ШИГТГЭЭ 7. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ДИНАМИК, ЭДИЙН ЗАСГИЙН МӨНГӨЖИЛТИЙН ТУХАЙ

Мөнгөний нийлүүлэлт 1999 оноос эхлэн тогтмол өндөр хурдтай өсч ирлээ. Үүний цаана зээлийн өсөлт ч мөн өндөр хурдтай байгаа. Эдгээр нь нэгдүгээрт, мөнгөний өсөлтийн улмаас үнийн өсөлт бий болох болгоомжлол, хоёрдугаарт, мөнгөний (зээлийн) хурдтай өсөлт нь бодит эдийн засгийг потенциалгаас нь давуулан өсгөх, улмаар хүчин чадлын илүүдэл хуримтлал бий болгоход түлхэц болно гэсэн болгоомжлол гарах үндэслэл болж байна. Үүнд хариу болгож мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн энэхүү онцлогийг тайлбарлах судалгаа хийгдсэн. Үнийн огцом өсөлтгүй мөнгөний хурдтай өсөлт болох нөхцөл боломж бүрдүүлж байгаа нэг хүчин зүйл нь эдийн засгийн мөнгөжилт юм. Өөрөөр хэлбэл мөнгөний эрэлт өсч байгаа үед нийлүүлэлтийн өсөлтийн хүү, үнэд нөлөөлөх байдал нь дээрх болгоомжлол үүсэх шалтгаан болохгүй гэсэн үг юм.

Бодит мөнгөний өсөлт нь мөнгөний эрэлтийн шилжилтээс шалтгаалж байгаа бөгөөд хүчтэй инфляци, санхүүгийн зуучлагч төлбөрийн чадвар алдсны улмаас зах зээлийн субъектүүд мөнгөнөөс дайжиж байсан нь эрэлтийн шилжилтийн орон зайг бий болгосон гэж таамаглалаа. Энд 80-аад оноос бараа бүтээгдэхүүний хомсдол хэлбэрээр илэрсэн инфляци нь далд хэлбэртэй байсан гэж үзэж байгаа бөгөөд түүнийг хязгаарлах бодлогын арга хэмжээ төдийлэн амжилттай байж чадаагүйн улмаар 90-ээд оны эхээр улам хурцдан хортой үр дагавар бий болгожээ. Нуугдмал инфляци нь төвлөрсөн төлөвлөлттэй эдийн засгийн тогтолцооны үеийн үнийн хяналтын улмаас бий болж үнэ чөлөөсний дараа онцгой хүчтэй инфляцийн шалтгаан болсон. Үнэ чөлөөлөх ажил 1990-96 оны сүүл хүртэл үргэлжилсэн тул далд инфляци нилээд хугацаанд хадгалагдсаар ирсэн гэж үзэх магадлалтай. Нөгөө талаас, үнийн үсрэнгүй хурдтай өсөлтийг зогсоох бодлогын арга хэмжээ амжилт муутай байснаар үнэ чөлөөлөх явцийг удаашруулан үнийн өсөлтийн хурд өндөр байхад түлхэц болох нийгмийн бодлогын арга хэмжээнүүдийг удаа дараа авахад хүрсэн байхыг үгүйсгэхгүй.

Үнийн өсөлт багатайгаар мөнгийг хэдий хүртэл нэмэгдүүлж болох вэ гэдэг асуултын хариу олохын тулд мөнгөжилтийн тухай дэлгэрэнгүй тайлбарлах шаардлага гарсан юм. Мөнгөжилт нь албан ёсны санхүүгийн салбартай харьцдаггүй байсан (эсвэл инфляцийн улмаас харьцахаа больсон) эдийн засгийн субъектүүдийн шийдвэрт гарч байгаа эерэг өөрчлөлтөөс хамааралтай. Тиймээс төлбөр тооцоонд голлох үүрэг гүйцэтгэдэг M1 мөнгөний бодит хэмжээний өсөлт нь мөнгөжилтийг илүүтэй илэрхийлнэ.

Хүснэгт 1-д хэд хэдэн онцлог ажиглагдаж байна. 1999 он буюу мөнгөний бодит үзүүлэлтүүд өсч эхэлсэн даруйдаа мөнгөний төлбөр гүйцэтгэх чадвар өндөртэй хэсгүүд нь илүү хурдан өссөн бол цаашдаа өртөг

Хүснэгт 1. Сүүлийн үеийн санхүүгийн зах зээлийн байдлыг илтгэх түүвэр үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	1998	1999	2000	2001	2002	2003
ДНБ-ий бодит өсөлт	3.5%	3.2%	1.1%*	1%*	4%	5.5%**
Хэрэглээний үнийн индексийн өсөлтийн хувь	6.09%	10.0%	8.1%	8.0%	1.6%	4.7%
Нийт мөнгө (M2)-ний өсөлтийн хувь	-1.7%	31.6%	17.6%	27.9%	42.0%	49.6%
Бага мөнгө (M1)-ний өсөлтийн хувь	1.1%	39.0%	13.9%	21.6%	28.6%	13.4%
Банкнаас гадуурх мөнгөний өсөлтийн хувь	33.7%	39.6%	39.0%	33.0%	25.7%	18.7%
Зээлийн дундаж хүү	48.1%	44.1%	36.8%	37.4%	35.5%	31.9%
Хадгаламжийн хүүний дундаж	35.3%	39.3%	16.8%	14.3%	13.2%	14%
ХҮҮ-ээр засварласан бодит зээлийн хүү	42.2%	44.6%	29.0%	29.7%	33.8%	27.2%
Валют ханшийн сулралт	10.9%	18.9%	2.3%	0.5%	2.1%	3.8%

* IMF (2002)-т ОУВС-ын эдийн засагчдын тооцоог нийтэлсэн бөгөөд 2000, 2001 онуудын хувьд ДНБ-ний бодит өсөлтийг өмнөх жилүүдийн адилаар (зудын нөлөөг арилгалгүй) тооцож 2000 онд -1.4, 2001 онд -5.2 хувь тус тус гаргажээ. Мөн зудын нөлөөг тооцсон ч энэ үзүүлэлтээс ялгаатай байгаа юм.

** Үүлээгдэж буй гүйцэтгэлээр

хадгалах хэлбэрүүд нь илүү хурдан өсчээ. М2-ын өсөлт эрчимжиж байхад М1-ийн өсөлт суларч, банкнаас гадуурхи мөнгөний өсөлт бүр хүчтэй суларсан. Хэдийгээр мөнгөний нийлүүлэлт хүчтэй нэмэгдсэн ч үнийн өсөлт төдийлэн өндөр биш, зээл хадгаламжийн хүү яльгүй бага өөрчлөгдөжээ. Мөн бодит хүү өндөр, төгрөгийн ханш унасан хэвээр байна. Ийм учраас мөнгөний нийлүүлэлтийн өсөлт нь эрэлтийн өсөлттэй хамт явагдаж байна гэж болно. Мөнгөний эрэлтийн өсөлтийн эдийн засгийн мөнгөжилтөөр тайлбарлах үндэслэл байна. Учир нь 1995 оноос өмнө хүчтэй инфляци, банкны хямралын улмаас арилжаа хийх, хөрөнгө хураахдаа төгрөг хэрэглэх нь багасч, албан ёсны санхүүгийн үйлчилгээ хэрэглэх нь буурсан байна.

Үүний шалтгааныг (Б.Энххуяг 2002) судалгаанд банкны удирдлагын мэргэжлийн ур чадвар дутсан, зээлдэгчдийн үйлдэлд мэдээллийн ялгааны сонголтын алдаа (adverse selection of asymmetric information) даамжирсан, Монголбанкны банкны хяналтын алдаа гарсан зэргээр тайлбарласан. Мөн үүнээс гадна төгрөгийн дэвсгэртийн биет хомсдол, бэлэн бус гүйлгээний хязгаарлалт, анхны хүсэлтээрээ банкнаас мөнгөө авах боломж алдагдсан зэрэг нь санхүүгийн тогтолцооны үйл ажиллагааг хязгаарласан нэмэгдэл хүндрэлүүд болсон. Эдгээр нь иргэд, байгууллагууд мөнгөн хөрөнгөө банкинд байршуулахгүй байх сонголт хийхэд хүргэсэн бол нэгэнт татан төвлөрүүлсэн хөрөнгөө алдаж байсан банкуудын хувьд хадгаламжийн хүүний доод хязгаар зардлыг нь нэмэгдүүлж, зээлийн эрсдэлийн удирдлага бүрэлдээгүй үед мэдээллийн ялгааны үр дагавар гаарч, активын алдагдлаар санхүүгийн зуучлалын зардал өсөхөд хүрчээ. Эдгээр нь эцэстээ зарим банкуудын төлбөрийн чадварыг алдагдуулж аамжаар банкны хямрал үүсэхэд хүргэсэн.

Банкуудын төлбөрийн чадварын өсөн нэмэгдэж байсан хүндрэл, зээлдэгчид мэдээллийн ялгааг ашиглах явдал даамжирсан, өмчлөгчийн хяналтын дутагдмал байдал, санхүүгийн зуучлалын захиргаадлын дарамт зэрэг нь санхүүгийн зуучлалын бизнесийг сонирхолгүй, алдагдалтай хэлбэртэй болгожээ. Үр дагаварт нь банкинд итгэх итгэл суларч, банкууд татан төвлөрүүлсэн хөрөнгөө алдсаар, зээлийн хүүг удаан хугацаанд өндөр байлган, банкууд бага хэмжээний хөрөнгийг өндөр хүүтэй зээлдүүлэн, хугацаа өнгөрөх тутам зээлдэгчдийн зээл төлөх боломж нь алдагдан санхүүгийн зуучлал хомсдож байсан. Товчоор хэлэхэд, банкуудын хуримтлагдсан алдагдал, өөрийн хөрөнгийн дутагдал, нэр хүнд, төлбөрийн чадварын алдагдал нь инфляцийн түвшин буурсан ч эдийн засгийн мөнгөжилтийг саатуулсаар байлаа.

Өндөр инфляци, санхүүгийн зуучлалын алдагдлын бас нэг үр дагавар нь зээлийн гэрээ зэрэг санхүүгийн хэлцлүүдийн хугацаа богиноссон явдал байв. Банк инфляци, зээлдэгчийн үйлдэл зэрэг тодорхой бус байдлыг богино хугацаанд хэлцэл хийх аргаар бууруулах гэж оролдож байсан. Энэ арга төрийн өмчийн зарим нэг банк дээр ажиглагдсан онцгой тохиолдлоос бусад нөхцөлд мэдээллийн ялгааны муу сонголтын алдааг (adverse selection) залруулж байсан ч ёс зүйгүйн эрсдэлийг (moral hazard) шийдвэрлэж чадаагүй юм. Ингэж санхүүгийн хэлцлийн хугацаа богиноссон нь өндөр дүнтэй хөрөнгө оруулалт хийх боломжийг алдагдуулсан.

Банкны бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлэн, эрх зүйн орчинг шинэчилж, захиргаадлын дарамтыг арилгаснаар санхүүгийн зуучлалын бизнесийн орчинд бараг хувьсгал гарч бүтээмж нь эрчимтэй нэмэгдэж байна. Үүний үр дүнд ч банкинд итгэх итгэл сэргэн иргэд, байгууллагууд албан ёсны санхүүгийн зуучлалын хэлбэрийг илүүтэй сонгох болж эдийн засгийн мөнгөжилт богино хугацаанд саад багатай явагдаж байна. Харин хэдий болтол мөнгөний нийлүүлэлт ийнхүү хүчтэй нэмэгдсээр байх вэ гэдэг асуултанд хариулахад төвөгтэй хэвээр байгаа юм. Ийм хариултын нэг хэсэг нь мөнгөжилтийг нэг хувьсагчийн өөрчлөлтийг динамик бүрдлээр нь задлан үнэлж прогноход ашиглах арга болно. Өмнө тайлбарласнаар мөнгөжилтийн явц хангалттай болоход эхний ээлжинд төгрөгөөр төлбөр хийх хэрэгцээ хангагдаж, дараа нь төгрөгөөр хөрөнгөө хадгалах хэрэгцээ хангагдах болно. Харин мөнгөний бодлогын хүрээнд мөнгөний бодлогын нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд эхлээд төлбөрийн хэрэгслийг, дараа нь банкны пассив хөрөнгийг нэмэгдүүлдэг билээ. Тэгвэл төлбөр гүйцэтгэхэд ашиглаж буй мөнгөний өсөлт нь саарч бодит хэмжээ нь хүчтэй инфляцийн өмнөх үетэй дүйцэх хэмжээнд хүрэх нь мөнгөжилт хангалттай болсныг дохиолж болох юм. Энэ утгаараа М1 мөнгөний бодит хэмжээний өөрчлөлтийг динамик бүтцэд нь задлан загварчлах аргыг сонгож болно. Загварын хэлбэр нь:

$$\Psi_t = \alpha + \tau_t + \sum_{j=1}^k \delta_j D_{jt} + \varepsilon_t \quad (1)$$

$$\phi(L)\varepsilon_t = \theta(L)u_t \quad (2)$$

$$u_t \sim \text{wn}(0, \sigma^2)$$

гэж өгөгдсөн бөгөөд үүний $\Psi_t = M1_t/P_t$ эсвэл $\Psi_t = \ln(M1_t/P_t)$ буюу бага мөнгөний бодит хэмжээ (эсвэл түүний логарифм), τ_t нь хугацааны тренд, ε_t нь өөрийн лагтай хувьсагч болон санамсаргүй хүчин зүйлсээс хамаарсан бөгөөд алдааг загварчилсан байдал нь мөчлөг шинжийг илэрхийлж байгаа. ε_t нь сериал хамааралгүй, хугацаанд адил тархалттай санамсаргүй хэсэг юм. Загварыг үнэлээд, түүндээ тулгуурлан прогнолоход бодит М1-ийн хэмжээ 1992 оны дунд үетэй ойр байхаар тооцоологдож байна. Товчоор хэлбэл, бодит бага мөнгөний өсөлтийн хурд саарч, хэмжээ нь хамгийн хүчтэй инфляцийн өмнөх үетэй зэрэгцэж ирж байгаа нь мөнгөжилт хангалттай өндөр түвшинд хүрэхийг үзүүлж байна. Ингээд нэгэнт мөнгөжилт 2004 оны эцэс гэхэд хангалттай түвшинд хүрэх бол цаашид мөнгөний нийлүүлэлтийг үнийг өсөлтгүй нэмэгдүүлэх боломжгүй болно. Өөрөөр хэлбэл, мөнгөний аливаа агрегатын өсөлтийн хурд нэмэгдэх тутам инфляцийг нэмэгдүүлнэ. Инфляци өссөнөөр төгрөгийн худалдан авах чадвар алдагдаж хөрөнгийн урсгал гадагш шилжих болно. Улмаар мөнгөний өсөлт нь нэрлэсэн валют ханш сулрахгүй нөхцөлд бодит валют ханшийг чангаруулан эдийн засгийн өрсөлдөөн шинжид хохирол учруулан, манай орны бодит эдийн засгийг санхүүжүүлэх боломж алдагдах хүндрэл үүсэх боломжтой.

3.2. Мөнгөний зах зээл

Мөнгөний бодлогын үр дүнг инфляциар дүгнэдэг. Инфляци нь тухайн үеийн санхүүгийн зах зээлийн байдлыг даган өөрчлөгдөж байдаг учир зах зээлд дохиоллын үүргийг гүйцэтгэж байдаг. Инфляцид дараахь хүчин зүйлс нөлөөлдөг. Үүнд:

1. Санхүүгийн зах зээлийн байдал
2. Санхүүгийн зуучлагчдын үйл ажиллагаа
3. Санхүүгийн салбар дахь эрсдэлийн өөрчлөлт
4. Бодит секторын өрсөлдөх чадвар


Үүнээс эхний хоёр нь санхүүгийн зах зээлийн тухайн үеийн байдлыг харуулдаг бол дараагийн хоёр нь зах зээлийн ойрын ирээдүйн хэв шинжийг тодорхойлдог. Зах зээлийн тодорхойлогч дээрх хүчин зүйлсийг удирдан зохицуулсны үр дүнд төгрөгийн тогтвортой байдлыг хангаж, улмаар иргэдийн худалдан авах чадварыг сайжруулах нөхцөл бүрдэх болно.

Сүүлийн жилүүдэд инфляцийн түвшин тогтвортой байсан нь тааламжтай хэв шинжийг илтгэж байна. Эдийн засагт бүтээмжийг урамшуулахад тогтвортой инфляци нэн чухал үүрэгтэй байдаг. 2003 оны инфляцийн тогтворжилтыг өмнөх жилийнхтэй харьцуулахад 2003 онд хэрэглээний үнээр илэрхийлэгдэх инфляци өмнөх жилээс илүү тогтворжсон байна. Мөн дефляцигүй байгаа нь нэгэн дэвшилтэй тал болж байна. Үнийн уналт нь хэрэглээг бууруулж цаашид удаан үргэлжилбэл бараа, үйлчилгээний борлуулалтанд сөргөөр нөлөөлж улмаар хямрал өдөөдөг.

Инфляци тогтворжсоны үр дүнд үнийн өөрчлөлтийг таамаглах боломж нэмэгдэн, санхүүгийн хэлцлүүдэд үзүүлэх сөрөг нөлөө багасч байна. Санхүүгийн салбарт хөрөнгө зохистой хуваарилахад чухал нөлөө үзүүлэх банкууд нь богино хугацаанд хөрөнгө дайчлан гаргах боломж нэмэгдэж байна. Банкуудын хямрал болон банкуудын төлбөрийн чадвар удаан хугацаагаар доройтсон зэрэг нь банк хоорондын итгэлцлийг бууруулж, улмаар банк хоорондын захыг ажиллах боломжгүй болгосон байлаа. Өнөөгийн байдлаар банкны бүтцийн өөрчлөлт амжилттай хэрэгжиж, банк хоорондын захын үйл ажиллагаа идэвхжсэн билээ. Хэдийгээр бүрэн хэмжээний мөнгөний зах төлөвшиж хараахан чадаагүй ч банк хоорондын төгрөгийн, гадаад валютын зах идэвхтэй ажиллаж эхэллээ.

Хүснэгт 8. Нөөц мөнгө, M2, ХБҮИ, ханшийн өөрчлөлт												(хувиар)
	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003
Нөөц мөнгө	157.1	168.6	104.1	28.7	36.5	23.1	18.7	49.9	18.6	8.2	21.9	14.5
Нийт мөнгө (M2)	31.6	227.6	79.5	32.9	25.8	32.5	-1.7	31.6	17.6	27.9	42.0	49.6
ХБҮИ	325.5	183.0	66.3	53.1	44.6	20.5	6.0	10.0	8.1	8.0	1.6	4.7
Ханш	-	891.3	4.4	14.4	46.4	17.3	10.9	18.9	2.3	0.5	2.1	3.8


Зураг 25. Инфляци, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар



Зураг 26. Банк хоорондын зах дээр хийгдсэн төгрөгийн болон гадаад валютын арилжаа



Зураг 27. Зээлийн өрийн үлдэгдэл болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн 12 сарын өсөлт



Монголбанкнаас 2002 оны дундуур нэвтрүүлсэн репо санхүүжилтийн хэрэгсэл нь төгрөгийн захын хөгжилд ихээхэн ач холбогдолтой болсон бол банк хоорондын захаас гадаад валют авах, зарах ханшийг зарладаг болсноор гадаад валютын захын үйл ажиллагаа эрчимтэй явагдах болсон байна.

Тайлант онд банк хоорондын зах дээр дунджаар 29.0 тэрбум төгрөгийн болон 10 орчим тэрбум төгрөгтэй тэнцэх гадаад валютын хэлцэл хийгджээ. Мөн банкуудын хооронд нийт 337.9 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн бөгөөд үүний 5.9 тэрбум төгрөг нь банк хоорондын зээлээр, 205.5 тэрбум төгрөг нь репо нөхцлөөр, 78.8 тэрбум төгрөг нь ТБҮЦ-аар, 46.3 тэрбум төгрөг нь овернайт зээлээр, 1.4 тэрбум төгрөг нь засгийн газрын бондоор хийгдсэн байна. Эдгээр арилжааны нийт жигнэсэн дундаж хүү нь 10.16 хувь байв. Банк хоорондын мөнгөний захын хүү нь санхүүгийн салбарын суурь хүү болдог.

Банк хоорондын захын хөгжил нь банкууд богино хугацаанд эх үүсвэрийн илүүдлээ байршуулах бололцоог нэмэгдүүлэхийн зэрэгцээ хөрөнгө дайчлан ашиглах боломжийг олгож байна. Эх үүсвэрийн илүүдэл хөрөнгө зуучлагчдын дунд түргэн шилжих боломжтой байх нь түүнийг үр ашигтай хуваарилах үндсэн шаардлага юм. Ийм үйл ажиллагаа идэвхжих тусам богино хугацааны зээлийн зориулалттай мөнгөний бөөний үнэ хямдарч эх үүсвэрийн зардлыг бууруулах, санхүүгийн зуучлалын зардлыг багасгах боломжийг нээж өгнө. Цаашид банк хоорондын захын зохион байгуулалтыг сайжруулан мэдээллийг нээлттэй байлгах, оролцогчдын бие даасан ажиллагааг нэмэгдүүлэхэд Монголбанк санаачилгатай, шинэлэг байдлаар ажиллах шаардлага гарч байна. Монголбанк банк хооронд хийгдэх төлбөр тооцоог технологийн дэвшилтэт хэлбэрт оруулсан бөгөөд үүний үр дүнд банкууд төлбөр тооцоондоо хяналт тавих боломжтой болж, богино хугацааны эх үүсвэрээ үр ашигтай удирдах болно.

Сүүлийн жилүүдэд эдийн засгийн мөнгөжилтийг богино хугацаанд нөхөн бүрдүүлж байсан нь чухал үзүүлэлт юм. Банкуудын төлбөрийн чадвар сэргэж, мөнгөн хөрөнгө санхүүгийн салбарт эргэн төвлөрч чадсан нь санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлж, хөрөнгийн үр ашигтай хуваарилалтыг хувийн сектор давамгайлсан банкны салбараар дамжуулах болж, бодит эдийн засгийн бүтээлч хэсгийг урамшуулах зах зээлийн нөхцөл бүрдэж байна. Санхүүгийн салбар сэргэж, өрсөлдөөн нэмэгдэж байгаа учраас эдийн засгийн өсөлтийг саатуулж байсан санхүүгийн зуучлалын саад ариллаа. Цаашид эдийн засгийн өсөлтийг улам эрчимжүүлэхэд бүтээмжийн өсөлт, татварын дэмжлэг, хөрөнгийн болон хөдөлмөрийн захын хөгжил илүү чухал юм. Санхүүгийн салбарын хөгжлийг банкнаас бодит секторт олгосон зээл, банкуудад байршиж буй хөрөнгийн өсөлт харуулж байна.

Зээлийн үлдэгдэл дунджаар 81.8 хувь, татан төвлөрүүлсэн хөрөнгө 56.1 хувиар тус тус өсчээ. Эдийн засаг өндөр хурдацтай мөнгөжих үе үндсэндээ дуусах шатандаа орж байгаатай холбоотойгоор татан төвлөрүүлсэн хөрөнгийн өсөлтийн

эрч буурах магадлалтай юм. Харин зээлийн өсөлт нь банкуудын нөөц болон активын удирдлагаас хамааран тодорхой хугацаанд хадгалагдах боломжтой.

Банкинд итгэх итгэл сэргэж байгааг банкны эрсдэл даах чадварыг сайн үнэлэх болсонтой холбож авч үзэж болно. Банк болон ББСБ-ын үйл ажиллагаа нь болзошгүй эрсдэлийг өөртөө агуулж байдаг. Гэхдээ тэдгээр эрсдэлийг удирдах, эрсдэлийн улмаас алдагдал үүссэн үед түүнийг нөхөх чадварын хувьд банкны байгууллага илэрхий давуу талтай юм. Энэ мэдээллийг зөв сурталчилсны үр дүнд иргэд мөнгөн хадгаламжаа банкинд байршуулахыг илүү сонирхох боллоо. 2004 оны эхний улиралд банкуудын дүрмийн сангийн доод хэмжээ 4.0 тэрбум төгрөг байх ёстой. Энэ нь ашигтай ажиллаж буй банк бүр 4.0 орчим тэрбум төгрөгийн алдагдлыг ямар ч нөхцөлд даах чадвартай байна гэсэн үг юм. Нөгөө талаас, банкны байгууллагууд нь эрсдэлийг удирдах сайтар зохион байгуулагдсан аппарат ажиллуулж байх учиртай. Монголбанкны хяналт шалгалт ч гэсэн энэ чиглэлд илүүтэй анхаарч ажиллах болно. Банк “бүртгэлээ буруу хийсэн”, “санаатай буруу мэдээлсэн”, “мэдлэг дутмаг удирдлагатай” гэдэг тодотголоосоо салж байгаа нь ийнхүү банкинд итгэх итгэл сэргэхийн бас нэг үндэс болж байна. Үүнээс гадна Монголын банкуудын бүтээлч үйл ажиллагаа сайжирсан бөгөөд дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг ихээхэн татах боллоо. Банкны салбарын өөрийн хөрөнгийн өсөлт нь өндөр байгаа бөгөөд түүнд гадаадын хөрөнгө оруулагчдын хувийн жин ч өслөө.

Банкаар дамжин бодит эдийн засгийг санхүүжүүлэх хөрөнгө тасралтгүй нэмэгдэж эдийн засгийн мөнгөжилт богино хугацаанд хангагдаж байгаа ч зээлийн хугацаа богино, хүү өндөр хэвээр байна. 2002 оны зээлийн өрийн үлдэгдлийн 8.3 хувь нь нэг жилээс урт хугацаатай байсан бол 2003 оны эцэст энэ үзүүлэлт 22.1 хувь болсон байна. Зээлийн хүүг захиргааны аргаар бууруулах боломж байхгүй бөгөөд зээлийн хүү буураагүй тохиолдолд зээлийн хугацааг уртасгах нь зээлийн төлбөрийн дарамтыг бууруулах нэг арга болно. Нөгөө талаар, урт хугацаатай зээл нь банк ба зээлдэгч урт хугацаанд хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх тул зээл олголтын зардлыг бууруулах, барьцаа хөрөнгөөр хангах нөхцөл, бололцоог нэмэгдүүлэх сайн талтай билээ. Урт хугацаатай зээл олголтыг нэмэгдүүлэхэд орон сууцны ипотекийн зээлийг нэвтрүүлэх нь онцгой ач холбогдолтой юм. АХБ-ны төслөөр эхэлсэн энэ төрлийн шинэ бүтээгдэхүүн нь зах зээлд нэвтрээд одоогоор ихэнх банкууд өөрсдийн эх үүсвэрээр олгодог болоод байна. Цаашид банкууд бизнесийн зээлийг ялангуяа, төслийн зээлийг урт хугацаагаар олгоход суралцах бүрэн боломж бүрдээд байна.

3.3. Хөрөнгийн зах зээл

2003 онд үнэт цаасны 250 удаагийн арилжаагаар нийт 281 компанийн 8.1 сая ширхэг хувьцаа, 232.7 мянган ширхэг засгийн газрын бонд, 4 компанийн 222.3 мянган ширхэг бонд арилжаалагдаж нийт 25.4 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна. Нийт гүйлгээний үнийн дүнгийн 85.7 хувийг засгийн газрын бондын арилжаа, 10.8 хувийг компанийн бондын арилжаа, 3.5 хувийг хувьцааны арилжаа тус тус эзэлж байна.

Хүснэгт 9. Хөрөнгийн зах зээлийн арилжааны хэмжээ				(сая төгрөг)
	Арилжааны үнийн дүн		Өөрчлөлт (өсөлт, бууралт)	
	2002 онд	2003 онд	Үнийн дүнгээр	Хувиар
ЗГ-ын бонд	41,690.60	21,722.50	-19,968.10	-47.90
Компанийн бонд	2,958.00	2,988.30	30.3	1.02
Хувьцаа	13,745	895.8	-478.7	-34.80

25.1 мянган ширхэг Шинэ зуун бонд хоёрдогч зах зээл дээр арилжаалагдсанаар бондын гүйлгээний нийт дүн 250.9 сая төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд өдөрт дунджаар 32.3 мянган ширхэг хувьцаа арилжаалагдаж, 3.6 сая төгрөгийн гүйлгээ хийгдэж байсан бөгөөд тоо ширхгээр идэвхтэй арилжаалагдсан үнэт цаасанд Монгол савхи, 22 дугаар бааз, УИД, Шивээ овоо, Багануур, Агротехимпекс, Ханын материал, Билгэх баянбүрд, Бөхөг, Гонир ХК-уудын хувьцаа орж байна.

Баянгол, Улаанбаатар зочид буудал, Монгол савхи, Улбаа, Алтайн зам, Багануур, Монголын цахилгаан холбоо, Мах импекс, Шивээ овоо, Улаанбаатар ХК-уудын үнэт цаас идэвхтэй арилжаалагджээ.


2003 онд Төрийн өмчийн хороо (ТӨХ)-ны тогтоолын дагуу Алтайн зам ХК-ийн нийт хувьцааны төрийн мэдлийн хувь болох 28.6 хувь, Улбаа ХК-ийн 55.3 хувийн хувьцаа тус тус арилжаалагдлаа. Харин Говь ХК-ийн төрийн мэдлийн хувь болох 4.9 хувь, Автозам-Архангай ХК-ийн төрийн мэдлийн 12.5 хувь буюу нэг багц хувьцааны нийлүүлэлт хийгдсэн боловч арилжаалагдаагүй байна.

Топ-20 индекс 2003 онд дунджаар 768.4 нэгжид хүрсэн нь өмнөх оны дунджаас 352.9 нэгжээр буурсан байна. Энэ нь Барилга корпораци, Монгол ЭЭГ, Баянгол зочид буудал, Говь, АПУ, Тахь-ко, Таван толгой зэрэг ХК-уудын хувьцааны ханш буурсантай холбоотой юм.

2003 онд засгийн газрын бондын арилжаа 9 удаа явагдаж, 232.7 мянган ширхэг бондыг 21.7 тэрбум төгрөгөөр арилжаалсан байна. Үүнээс 5 удаагийн арилжаагаар 222.7 мянган ширхэг бондыг 21.6 тэрбум төгрөгөөр банкууд болон аж ахуйн нэгж байгууллагууд худалдан авч, 4 удаагийн арилжаагаар 10.0 мянган ширхэг бондыг 96.8 сая төгрөгөөр иргэд худалдан авчээ. Засгийн газрын хямдруулсан бондын арилжааны үнийн дүн арилжаалагдах үнийн дүнгээс 74.5 сая төгрөгийн өсөлттэй байжээ.

Тайлант онд 63 удаагийн арилжаагаар нийт 222.3 мянган ширхэг компанийн бонд арилжаалагдаж 2.7 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна. 2003 оны 4 дүгээр сард “Их барилга төсөл” ХХК нэрлэсэн үнэ нь 50000 төгрөгийн үнэ бүхий 16000 ширхэг бонд шинээр гаргасан байна.

Зураг 28. TOP-75 индекс



Зураг 29. Нийт хувьцааны зах зээлийн үнэлгээ



Тайлант онд 232.7 мянган ширхэг буюу 22.3 тэрбум төгрөгийн засгийн газрын хямдруулсан бонд, 2 тэрбум төгрөгийн 200.0 мянган ширхэг “Барилга корпорац” ХК-ийн бонд, 0.8 тэрбум төгрөгийн 16.0 мянган ширхэг “Их барилга төсөл” ХХК-ийн бондыг тус тус бүртгэжээ.

Хүснэгт 10. Компанийн бондын арилжааны мэдээ

(сая төгрөг)

Бондын төрөл	Арилжааны үнийн дүн	Эзлэх хувь
Шинэ зуун	1809.69	66.1
Нийслэл өргөө	125.7	4.6
Их барилга	1.99	0.1
Их барилга төсөл	800	29.2
Нийт дүн	2737.38	100

Хүснэгт 11. Үнэт цаасны бүртгэлд гарсан өөрчлөлт (2003.12.31-ний өдрийн байдлаар)			
	2002 он	2003 он	Өөрчлөлт
Бүртгэлтэй компанийн тоо:	403	402	-1
- Төрийн өмчийн оролцоотой	61	68	7
- Хувьчлагдсан	342	334	-8
Бүртгэлтэй хувьцааны тоо, ширхэг	657 268 298	1 224 637 137	567 368 839
- Төрийн өмчид (ширхэг)	475 076 606	988 947 572	513 870 966
- Хөрөнгө оруулагчдад (ширхэг)	182 191 692	235 689 565	53 497 873
Шинээр бүртгүүлсэн:			
- Төрийн өмчит компанийн тоо	8	12	4
- Төрийн мэдлийн хувьцааны тоо	384 906 535	569 865 749	184 959 214
Бүртгэлээс хасагдсан:			
ХК-ийн тоо	6	13	7
- Хувьцааны тоо	207 978	14 366 932	14 158 954

2003 онд бүртгэлтэй байсан 402 ХК-ийн 68 нь төрийн өмчийн оролцоотой, 334 нь бүрэн хувьчлагдсан байна. Эдгээр компанийн 1224.6 сая ширхэг хувьцаа бүртгэлтэй байгаагаас 989.0 сая ширхэг хувьцаа буюу нийт бүртгэлтэй хувьцааны 80.7 хувь нь төрийн мэдэлд байна. Хөрөнгийн биржид бүртгэлтэй төрийн өмчит ХК-ийн тоо буурсан боловч төрийн мэдлийн хувьцааны тоо ширхэг өнгөрсөн оныхоос 8.5 хувиар өссөн нь энэ онд ТӨХ-ны тогтоолын дагуу нийт 11 ХК-ийн 569.9 сая ширхэг хувьцааг нэмж бүртгэсэнтэй холбоотой юм.

Арилжааны бус гүйлгээ

Биржийн бус арилжааны хэлцлийн гүйлгээг зөвшөөрснөөс хойш 6 жилийн хугацаанд 374 ХК буюу анхны бүртгэлтэй ХК-ийн 78 хувийн нийт 9.2 сая ширхэг үнэт цаасны 1.4 тэрбум төгрөгийн гүйлгээ биржийн бус арилжааны хэлцлээр арилжаалагдсан байна. Харин 2003 онд хийгдсэн арилжааны бус гүйлгээний тоо хэмжээ үнэт цаасны тоо ширхэгээр өмнөх оныхоос 95.2 хувиар өсч, 2.2 сая ширхэг арилжаалагдсан бол үнийн дүнгээр 41.1 хувиар буурч, 137.7 сая төгрөгийн гүйлгээ хийгджээ. Дээрх судалгаанаас үзэхэд 1997 онд хувьцааны арилжааны нийт дүнгийн 0.3 хувийг арилжааны бус гүйлгээ эзэлж байсан бол 2002 онд нь 11 хувь, 2003 онд 22 хувийг тус тус эзлэх болов. 2002 онд нийт гүйлгээний 94 хувь, 2003 онд 96 хувийг багцаар хийсэн биржийн бус хэлцлийн гүйлгээ эзэлж байна.

Тайлант оны эцэст үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан нийт 25, зөвшөөрөл аваагүй 1, нийт 26 Брокер, Дилерийн компани (БДК) ажиллаж байна.

Өмч хувьчлал

Тайлант онд ТӨХ УИХ-аас 2001 онд батлагдсан Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл, Засгийн газрын “Төрийн өмчийг 2002, 2003 онд хувьчлах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд гол анхаарлаа чиглүүлж ажиллалаа.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 16 аж ахуйн нэгж, төрийн өмчийн 22 үл хөдлөх хөрөнгийг 2003 онд хувьчилав.

2003 онд хувьчлагдсан хөрөнгүүд нь доорхи салбарт хамрах аж ахуйн нэгж, үл хөдлөх хөрөнгүүд байв. Үүнд:

- Банк санхүүгийн салбар
- Уул уурхай
- Эрчим хүч
- Авто зам
- Хүнс
- Нийгмийн салбар
- Бусад

Банк, даатгалын салбараас 2003 онд “ХААН” банк, “Монгол даатгал” ХХК-ийг олон улсын уралдаант шалгаруулалтаар, “Түшиг даатгал” ХХК-ийг уралдаант шалгаруулалтын аргаар тус тус хувьчилав.

Уур уурхайн салбараас “Шарын гол” ХК-ийн төрийн эзэмшлийн 80 хувийг уралдаант шалгаруулалтаар, “Ган” төрийн өмчит ХК (ТӨХК)-ийг хаалттай дуудлагын худалдаагаар хувьчиллаа.

Эрчим хүчний салбараас “Дархан, Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийг уралдаант шалгаруулалтын аргаар, “Налайхын дулааны станц” ТӨХК-ийг менежментийн гэрээгээр, “Багануурын Дулааны Цахилгаан Станц” ТӨХК-ийг уралдаант шалгаруулалтын аргаар тус тус хувьчилсан байна.

Автозамын салбараас Завхан аймаг дахь “Завхан-Улбаа” ХК-ийн төрийн эзэмшлийн хувийг Монголын хөрөнгийн биржээр, Ховд аймаг дахь “Алтайн зам” ТӨХК-ийн төрийн эзэмшлийн хувийг нийтийн дуудлагын худалдаагаар, мөн салбарын харъяа үл хөдлөх хөрөнгүүдийг нийтийн дуудлагын худалдаагаар хувьчилав.

Хүнсний салбараас “Хүнс трейд” ТӨХК-ийг нийтийн дуудлагын худалдаагаар, “Меркури” хүнсний захыг түрээсийн давуу эрхээр хувьчиллаа.

Нийгмийн салбараас “Эмийн үйлдвэр” ТӨХК, “Монэмзим” ТӨХК-ийг уралдаант шалгаруулалтын аргаар, “Монголэмимпекс” ТӨХК-ийн 49 хувийг нийтийн дуудлагын худалдаагаар, Хүмүүнлэгийн ухааны их сургууль, Улаанбаатарын их сургуулийг менежментийн үр дүнг харгалзан хувьчилсан байна.

Төрийн өмчийн хороо 2003 онд өмч хувьчлалын ажлын дүнгээр улсын төсөвт 19.4 тэрбум төгрөг оруулав.

4

БАНК, САНХҮҮГИЙН
САЛБАРЫН ХӨГЖИЛ4 БАНК САНХҮҮГИЙН
САЛБАРЫН ХӨГЖИЛ

Улсын хэмжээгээр 2003 онд 17 банк, 88 ББСБ-ууд үйл ажиллагаа явуулж, бүх аймаг хотуудын нутаг дэвсгэрт нийт 635 салбар нэгж (92 салбар, 523 тооцооны төв, 20 хадгаламжийн касс)-ээр дамжуулан харилцагчдад банкны үйлчилгээ үзүүлж байна. Аймаг сумдад 15 банкны харьяа 478 салбар нэгжээр үйлчилгээ үзүүлж байгаа нь өмнөх оныхоос 20-оор нэмэгдэн нийт салбар нэгжийн 75.3 хувийг эзэлж байна.

Өмнөх оны байдлаар Монголбанкнаас зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулж байсан 16 банкнаас төрийн өмчит 2, төрийн өмчийн оролцоотой 2, хувийн 12 (үүнээс гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай банк 1) банк байсан бол тайлант онд ХААН банкыг хувьчлан гадаадын хөрөнгө оруулалттай Чингис хаан ББСБ-д банк байгуулах зөвшөөрөл олгосноор төрийн өмчит 1, төрийн өмчийн оролцоотой 2, хувийн 14 банк үйл ажиллагаа явуулж байна. 2002 оны байдлаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой банкуудад банкны салбар дахь нийт иргэд байгууллагын хадгаламжийн үлдэгдлийн 28 хувь, харилцахын үлдэгдлийн 10 хувь

Хүснэг 12. Банкуудын салбар, нэгж

(2003 оны эцсийн байдлаар)

		Улаанбаатар хот		Хөдөө орон нутаг		Нийт	
		Салбар	Өөрчлөлт	Салбар	Өөрчлөлт	Салбар	Өөрчлөлт*
		нэгжийн тоо		нэгжийн тоо		нэгжийн тоо	
1	Хөдөө аж ахуй	31	20	343	3	374	23
2	Худалдаа хөгжил	8	0	10	0	18	0
3	Хадгаламж	31	-1	9	0	40	-1
4	Голомт	9	-1	2	0	11	-1
5	Шуудан	6	-3	67	5	73	2
6	Эрэл	3	0	1	0	4	0
7	Улаанбаатар хотын банк	14	-2	2	0	16	-2
8	Капитал	6	1	3	2	9	3
9	Тээвэр хөгжлийн банк	3	0	0	0	3	0
10	Кредит	6	2	2	1	8	3
11	Зоос	8	4	9	3	17	7
12	Анод	13	6	5	2	18	8
13	Интер	2	0	2	1	4	1
14	Капитрон	5	2	1	1	6	3
15	ХАС	10	3	22	2	32	5
16	Менатеп	1	0	0	0	1	0
17	Чингис хаан	1	1	0	0	1	1
	Бүгд	157	32	478	20	635	52

* Өмнөх оны эцсээс өөрчлөгдсөн тоо


нь төвлөрч байсан бол төрийн өмчийн оролцоотой банкыг хувьчлан шинээр хувийн хэвшлийн нэг банк үүсгэн байгуулах зөвшөөрөл олгосон зэрэгтэй холбогдон банкны салбар дахь төрийн өмчийн оролцоо тогтмол буурч байна.

Зүүн Өмнөд Азийн болон бусад зарим улс орнуудад АЦХХШ өвчин гарсан нь манай аялал жуулчлалын салбарт гарах хүлээгдэж буй өсөлтийг бууруулсан сөрөг нөлөөлөл ихтэй байсан ч аж үйлдвэрлэлийн салбар өмнөх жилүүдийн нэгэн адил өсч, газар тариалан сэргэснээр ДНБ-ий өсөлт төлөвлөж байсан хэмжээнээс илүү гарсан байна. Нөгөө талаас энэ нь банк, санхүүгийн салбарын үйл ажиллагааг өргөжүүлэхэд давхар түлхэц болж өгсөн гэж үзэж болохоор байна. Уг салбар дахь банк болон ББСБ-ын актив өмнөх онуудынхаас илүү хурдацтай өслөө. Тухайлбал, банкны салбарын нийт актив өмнөх оныхоос 67.5 хувь, харилцах 59.0 хувь, хадгаламжийн дүн 66.5 хувь, өөрийн хөрөнгө 80.1 хувиар тус тус өссөн байна.

Иргэд байгууллагын эдийн засгийн үйл ажиллагаа өргөжин тэлэхийн хирээр тэдгээрт санхүүгийн олон талт үйлчилгээ хэрэгцээтэй болж байгаа нь сүүлийн жилүүдэд ажиглагдаж байгаа бөгөөд банкууд олон төрлийн үйлчилгээ үзүүлэн тэдгээрийн шимтгэл хураамжаар орлого олох талд түлхүү анхааран ажиллаж байна. Банкууд сүүлийн жилүүдэд бэлэн бус төлбөр тооцооны гол хэлбэрийн нэг болох төлбөрийн картуудыг гаргаж эхэлсэн бөгөөд тайлант онд банкуудын нийт карт эзэмшигчдийн тоо өмнөх оныхоос 33671-ээр нэмэгдэж 55074 болсон байна. Үүнээс гадна Капитрон, Голомт банкууд интернет банкны үйл ажиллагааг анх удаа нэвтрүүлсэн бөгөөд бусад банкуудын хувьд телефон банкны үйлчилгээг нэвтрүүлж байгаа нь харилцагчдын цаг хугацааг хэмнэх, санхүүгийн үйлчилгээг ойртуулахад чухал арга хэмжээ болж байна. 2002 онд банкууд шинэ нэр төрлийн үйлчилгээ нэвтрүүлж байсан бол тайлант онд эдгээр үйлчилгээний хэлбэр, чанараар өрсөлдөх байдал ажиглагдаж байна. Энэ нь банкны харилцагчдын хувьд ашигтай ч эдгээр үйл ажиллагаатай холбоотойгоор банкинд гадаад болон дотоод хүчин зүйлсээс шалтгаалсан үйл ажиллагааны эрсдэл гарч болзошгүй тул орчин үеийн техник тоног төхөөрөмж, программ хангамж ашиглах, боловсронгуй болгох тал дээр банкууд анхааран ажиллах шаардлагатай юм.

Төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэл нь банкны салбарын хямралын жилүүд (1996-1999)-эд санхүүгийн салбарын өрсөлдөөнийг дэмжихээсээ илүү санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бий болгох, банкны салбарын бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлэн хийх асуудалд үндсэндээ чиглэгдэж байв. Эдгээр үйл ажиллагааны үр дүнд банкны салбар тогтворжих хандлагатай болж байгаагийн зэрэгцээ санхүүгийн салбарын үр ашиг, эрсдэлийг даах чадварыг дээшлүүлэх, жижиг харилцагчдад санхүүгийн үйлчилгээг ойртуулахад өрсөлдөөн бий болгох нь чухал асуудлуудын нэг болсон тул банкнаас гадна санхүүгийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн үйл ажиллагааг нэмэгдүүлэх шаардлагатай болсон юм. Иймээс Төрөөс баримтлах мөнгөний бодлогын үндсэн чиглэлд ББСБ-ын үйл ажиллагааг дэмжих, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр тодорхой бодлого барьж


Зураг 30. Мөнгөний нийлүүлэлт, банкнаас гадуурхи мөнгийг ДНБ-д харьцуулсан хувиар



Зураг 31. Чанаргүй зээл



Зураг 32. Өөрийн хөрөнгө болон активын өгөөж



ШИГТГЭЭ 8. САНХҮҮГИЙН ЗУУЧЛАЛ


Санхүүгийн зуучлал гэдэг нь мөнгөний илүүдэл нөөцтэй хэсгээс дутагдалтай байгаа хэсэг рүү мөнгийг аль болохоор түргэн шуурхай, өртөг багатай шилжүүлэх үйлчилгээ юм. Энэхүү үйлчилгээг үзүүлж байгаа байгууллага болон хүмүүсийг санхүүгийн зуучлагч хэмээдэг бөгөөд банк, банк бус санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулалтын компани, хадгаламж зээлийн хоршоо, даатгалын компани зэрэг нь санхүүгийн зуучлалын үүрэг гүйцэтгэдэг ба манай улсын хувьд 1990 онд хоёр шатлалт банкны систем үүссэнээр санхүүгийн зуучлал жинхэнэ утгаараа хөгжиж эхэлсэн гэж хэлж болно.

Хөгжлийн эхэн үед эдийн засгийн бүтцийн өөрчлөлтөөс үүдсэн таагүй байдал, тодруулбал, хэт өндөр инфляци, санхүүгийн салбар дахь хууль эрх зүйн сул орчин, зээлийн бодлогын учир дутагдалтай байдал, шинэ системийн талаархи банкны ажилтнуудын мэдлэг, дадлага дорой зэргээс үүдэн санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа доголдож, санхүүгийн салбарын хямралд хүргэсэн ба энэхүү хямрал нь яван явсаар дээд цэгтээ хүрч, 1998-1999 онд банк санхүүгийн салбарыг эрүүлжүүлэх бодлогуудыг хэрэгжүүлж эхэлсэн байна. Зарим банкуудын хувьд менежментийн урамшуулал буюу ашгаас хамаарсан урамшууллын хуваарилалт байгаагүйгээс банкны ажилтнууд өөрсдөө санхүүгийн давхар “зуучлагч” нар болж, тухайн банкны хувьд хохиролтой үйл ажиллагааг явуулсан нь хямралын бас нэгэн шалтгаан болсон юм.


Энэ мэт тоочвол энэхүү хямралын цаад шалтгаан нь олон боловч, уг шалтгаануудыг нэгтгэж тодорхойлбол зарим банкууд нь банк нь санхүүгийн зуучлагчийн давуу байдлыг гаргаж, мэргэжлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж чадаагүй гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл, зээлдэгчийн талаархи мэдээллийг сайтар цуглуулж дүн шинжилгээ хийгээгүй, зээлийн зарцуулалт дээр тодорхой хяналтыг тавьж ажиллаагүй, мэргэжлийн түвшинд хөрөнгө оруулалтын эрсдэлүүдийг тооцож тархаан байршуулаагүйгээс үүдэн их хэмжээний зээл чанаргүй зээлийн өгнээнд шилжиж, эцэст нь ийм эмгэнэлтэй үр дүнд хүрсэн билээ.

Санхүүгийн салбарын зуучлалын үндсэн үзүүлэлтүүдийг дараахь графикуудаар харуулъя.

Зураг 1. Зээлийн өрийн үлдэгдэл, хадгаламж, нийт мөнгийг ДНБ-д харьцуулсан харьцаа



Зураг 2. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь



Эдгээр зурагуудаас харахад, 2000 оны эхний хагасаас санхүүгийн зуучлалын үзүүлэлтүүд сайжрах хандлагатай болж эхэлсэн байна. Үүнийг дараахь хүчин зүйлээр тайлбарлая. Хямралын шалтгаан, үүнд хүргэх болсон алдаан дээрээ суралцаж шинэ системд ажиллах тодорхой хэмжээний дадлагатай болсоос гадна банкууд зээлийн зохистой бодлого баримталж ажиллаж байгаа, Монголбанкнаас банкуудад тавих хяналт шалгалтыг чангатгасан зэрэг нь банкуудын зээл олголт, чанаргүй зээлийн үзүүлэлт сайжрах үндсэн шалтгаан болж өгсөн юм. Мөн 1999 оноос банк, санхүүгийн салбар харьцангуй тогтворжиж, иргэдийн банкинд итгэх итгэл аажмаар нэмэгдэж, ингэснээр банкуудын хөрөнгө татан төвлөрүүлэлт сайжирч эхэлсэн байна.

Иргэдийн орлого харьцангуй бага, ихэнх тохиолдолд хэрэглээгээ л дөнгөж хангахуйц байгаа өнөөгийн нөхцөлд төлбөр тооцоо гүйцэтгэхэд хялбар гэдэг утгаараа мөнгөө бэлнээр хадгалах сонирхол их байж болно. Сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байгаа бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох картын хэрэглээг дэлгэрүүлэх нь иргэдийн гар дээр эргэлдэж байгаа бэлэн мөнгөний хэмжээг багасгах нэг арга зам юм. Гэвч өнөөгийн нөхцөлд уг бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслийг хэрэглэхэд өртөг харьцангуй өндөр, иргэдийн бодит орлого бага, картын хэрэглээний системийн хөгжил сул (банк хоорондын, банк болон үйлчилгээний байгууллагуудын хоорондын нэгдмэл сүлжээ бүрэн гүйцэд бий болж чадаагүй) зэрэг хүндрэлтэй талууд байна.

Банкнаас гадна бас нэгэн чухал санхүүгийн зуучлалын байгууллага нь хөрөнгийн бирж юм. Харамсалтай нь манай улсын хувьд хөрөнгийн биржийн үйл ажиллагаа маш идэвхгүй, бараг үхмэл гэж хэлж болохоор байдалд байгаа ба иргэд ч хөрөнгийн бирж гэж нэрнээс цааш тодорхой ойлголт байдаггүй нь удаа дараагийн санал асуулга дээрээс харагдаж байсан билээ. Хэрэв хөрөнгийн бирж жинхэнэ утгаараа идэвхтэй үйл ажиллагаа явуулах хэмжээнд хүрч чадах юм бол компаниудын хувьд шаардлагатай байгаа санхүүжилтээ зөвхөн банкны зээлээр хязгаарлах бус харин өрийн бичиг эсвэл хувьцаа олгох замаар олж авах боломж нээгдэх юм. Үүнтэй зэрэгцээд санхүүгийн салбар дахь хүүний хэмжээ буураад зогсохгүй, үүний хөгжилд бодит хувь нэмэр болох санхүүгийн мэргэжлийн байгууллагууд үүсч, хөгжих нь гарцаагүй. Өөр нэгэн асуудал гэвэл томоохон хөрөнгө оруулалт шаардлагатай салбаруудын хувьд бид ихэвчлэн гадаадын зээл, төсөл, хөрөнгө оруулалтанд найдах хэрэгтэй болдог. Магадгүй, иймэрхүү том хэмжээний санхүүжилтийг ганц банк бие даан хийнэ гэдэг нь тухайн банкны хувьд хэтэрхий эрсдэлтэй, ахадсан хэрэг байж болох юм. Тэгвэл энэ тохиолдолд хэд хэдэн банк хамтарч эрсдэлийн зөв тоцоололд үндэслэн санхүүжилтийг хийж болох юм.

ажилласны дүнд 1999 онд 1 ББСБ Монголбанкнаас үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авч байсан бол сүүлийн 4 жилд 97 банк бус санхүүгийн байгууллага байгуулагдан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан бөгөөд үүнээс 34 байгууллага нь тайлант онд зөвшөөрөл авсан байна. Нэг талаас, санхүүгийн салбарт өрсөлдөөнийг бий болгон, зуучлалын хүрээг өргөтгөх шаардлага нөгөө талаас, иргэд байгууллагын дунд банкны зарим үйл ажиллагаа эрхлэн явуулах сонирхол их байгаа нь өнгөрсөн хэдэн жилд байгуулагдсан ББСБ-ын тооноос харагдаж байна. ББСБ байгуулагдаж байх эхэн үед тэдгээрт тусгайлан зохицуулсан хууль байгаагүй бөгөөд зөвхөн банкны тухай хуулийн дагуу Монголбанкнаас баталсан холбогдох журмуудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байсан юм. Иймд Монголбанкнаас ББСБ-ын тухай хуулийн төсөл боловсруулахад идэвхтэй оролцон ажиллаж, тайлант онд уг хууль батлагдан гарав. Энэ нь ББСБ цаашид хөгжих үндэс суурийн эхлэл болж байгаа бөгөөд үүнтэй холбогдуулан Монголбанкнаас холбогдох журам, заавруудыг шинэчлэн батлан гаргалаа.

Банкуудын активын өсөлт тайлант онд өмнөх онуудынхаас харьцангуй их байсан бөгөөд санхүүгийн салбарын зуучлалыг тодорхойлогч гол үзүүлэлт болох мөнгөний нийлүүлэлт ба ДНБ-ий харьцаа 2001 оны үзүүлэлтээс 21.9 нэгжээр, 2002 оныхоос 13.7 нэгжээр өсч 51.6 хувьд хүрсэн байна.

4.1. Банкны салбар

Тайлант онд банкны салбарын нийт активын хэмжээ 67.5 хувь буюу 333.1 тэрбум төгрөгөөр өсч ДНБ-ий 60.6 хувийг эзэлж байна. Активын дүн огцом өсөлттэй байгаа нь нийт хадгаламжийн үлдэгдэл 66.5 хувь буюу 145.1 тэрбум төгрөгөөр (үүнээс иргэдийн хадгаламж 141.6 тэрбум төгрөгөөр), нийт харилцахын үлдэгдэл 59.0 хувь буюу 77.3 тэрбум төгрөгөөр, гадаадын банкнаас татсан эх үүсвэр 3.1 дахин буюу 34.9 тэрбум төгрөгөөр, өөрийн хөрөнгө 80.1 хувь буюу 49.1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байв.

Банкны салбарын нийт активын 51.8 хувийг цэвэр зээлийн өрийн үлдэгдэл, 19.0 хувийг гадаад актив, 9.3 хувийг Төв банкны үнэт цаас (ТБҮЦ), 8.4 хувийг банкны нөөц, 5.7 хувийг засгийн газраас авах авлага тус тус эзэлж байгаа нь өмнөх оны

Хүснэгт 13. Банк санхүүгийн системийн үзүүлэлтүүд								(хувиар)
	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003
1 М2/ДНБ	19.9	20.4	20.5	23.8	25.4	29.7	37.9	51.6
2 Зээл/ДНБ	10.0	6.0	10.5	8.4	6.6	12.1	18.7	32.5
4 Өөрийн хөрөнгө/ДНБ	-2.1	2.0	0.9	2.2	3.1	4.2	5.0	8.1
6 Нийт актив/ДНБ	21.3	23.6	22.0	19.7	22.1	29.8	39.7	60.6
7 Банкнаас гадуурхи мөнгө/ДНБ	6.5	6.0	6.9	9.4	10.0	9.8	9.7	9.7
8 Хадгаламж/ДНБ	13.4	14.4	13.6	13.7	15.5	19.9	28.2	42.0

ШИГТГЭЭ 9. ЗЭЭЛЖҮҮЛЭЛТ

Ашгийн төлөө санхүүгийн зуучлагчийн үүргийг гүйцэтгэдэг байгууллагын хувьд банк нь аж ахуйн нэгж, иргэдээс хөрөнгө татан төвлөрүүлж, түүнийгээ зөв зохистой байршуулан ашиг олдог. Өөрөөр хэлбэл, банк нь зээлийн хүүний орлого болон татан төвлөрүүлсэн хөрөнгөнд төлөх хүүний зардлын зөрүүнээс ашиг олдог.

Монгол улсад 1921 онд Ардын хувьсгал ялснаар үндэсний банк, зээлийн систем үүсч хөгжих суурийг тавьсан билээ. Ийнхүү 1924 онд Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн Монголын худалдаа ба аж үйлдвэрийн банк байгуулагдаж албан газруудын нэр дээр данс нээх, тэдний хөрөнгийг төвлөрүүлэн хадгалах, төрөл бүрийн тооцоо, гуйвуулга, гүйлгээ хийх, гадаад дотоодын аж ахуйн газар, байгууллага, иргэдэд зээл олгох зэрэг үйл ажиллагаа явуулж байв. Түүнээс хойш 70 гаруй жилийн хугацаанд зээл олгох үйл ажиллагааг Сайд нарын зөвлөлийн тогтоолын дагуу зөвхөн ганц Улсын банк (Монголбанк) хөтлөн явуулж байлаа. Харин банкны хоёр шатлалт тогтолцоо (Төв банк ба банкууд) үүсч хөгжсөн 1991 оноос эхлэн банкууд зах зээлийн харилцааны зүй тогтлын дагуу нийгэм эдийн засгийн салбаруудын зээлжүүлэлтийг явуулж байна.

Монгол улсад банк санхүүгийн систем үүсч хөгжсөний 80 жилийн ойг тохиолдуулан санхүүгийн зуучлалын гол хэлбэр болох зээлжүүлэлтийн хөгжлийг түүхэн үечлэлээр авч үзье.

1. 1924-1991

Манай орны хувьд хөдөө аж ахуй (газар тариалан, мал аж ахуй)-н салбар ДНБ-д хувийн жингээрээ дээгүүрт ордог бөгөөд зээлжүүлэлтийн нэг томоохон салбарт зүй ёсоор тооцогддог. Монгол улсад анхны банк болох Монголын худалдаа ба аж үйлдвэрийн банк (Улсын банк) үүсгэн байгуулагдсан 1924 оноос эхлэн энэ салбарыг түлхүү анхаарч, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийг хөгжүүлэх, худалдааг өргөжүүлэх, үндэсний зээлийн тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээ авч байв. 1933 он хүртэл Улсын банкны зээлийн бодлого тодорхой чиглэлээ олоогүй, зээл олгоход баримтлах үндсэн зарчмууд тогтоогүйгээс банкны зээлжүүлэлт гол төлөв худалдаа бэлтгэлийн ажиллагааг санхүүжүүлэх, хувийн худалдааг голлосон зах зээлийн барааны хангамж, үнийн хөдөлгөөнийг зохицуулахад чиглэгдэж байв. Тухайн үед шинээр байгуулагдаж байсан хамтын аж ахуйтнууд (нэгдэл, сангийн аж ахуй)-ыг өргөнөөр зээлжүүлж байсны улмаас зээлийн зориулалт, эргэн төлөлт (хугацаа), баталгаа гэх мэт зээлийн үйл ажиллагааны зарчмууд хэрэгжихгүй байлаа. Түүний зэрэгцээ аж ахуйн байгууллагууд банкаар дамжуулахгүйгээр бие биедээ шууд зээл өгөх явдал газар авч байв. Эдгээр байдалд дүгнэлт хийж БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1933 оны 2 дугаар тогтоолоор зээл олгох, байгууллагуудын хоорондын тооцоог хийх, мөнгөн гүйлгээг зохицуулан зохион байгуулах ажлыг зөвхөн Улсын банк хариуцан гүйцэтгэж байхаар шийдвэрлэж, банкны зээлийн үндсэн зарчмуудыг батлан тогтоож өгсөн юм. Улсын банкны зээлжүүлэлт 1933 онд 1930 онтой харьцуулахад худалдааны салбарт 5 дахин, тээврийн салбарт 15.5 дахин, хөдөө аж ахуйн салбарт 18.5 дахин өссөн байна. Мөн мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэн зохицуулах банкны үйл ажиллагааны дүнд банкинд хуримтлагдсан хөрөнгө өсөн нэмэгдэж, улс ардын аж ахуйн зээлжүүлэлтийг өсгөж жижиг үйлдвэрлэгчдэд зээл олгох боломжийг нэмэгдүүлжээ. 1934 оны дунд үеийг 1932 оны эхэн үетэй харьцуулбал жижиг худалдаачид, гар урчуудад олгосон зээл 30 дахин, хувийн аж ахуйтанд олгосон зээл 8 дахин өссөн байна. 1940 онд хуралдсан 8 дугаар Их хурлаас улсын эдийн засгийн хөгжлийг цаашид эрчимжүүлэх зорилт тавьж энэ ажлын хүрээнд зээл тооцооны журамд өөрчлөлт оруулсан байна. Ийнхүү 1948-1952 онуудад банкаас олгосон зээл 40 шахам хувиар өсч, 1952 оны эцсийн байдлаар богино хугацааны зээлжүүлэлт 360.1 сая төгрөг, урт хугацааны зээлжүүлэлт 10.9 сая төгрөгт хүрчээ.

Хүснэгт 1. Нийт зээл, активын хэмжээ (10 жилийн дунджаар) (сая төгрөгөөр)

Он	Нийт зээл	Нийт актив	Нийт активт зээлийн эзлэх хувийн жин %
1924-1934	22,580.1	43,361.5	52.1
1935-1944	117,153.7	229,239.9	51.1
1945-1954	251,661.1	454,297.3	55.4
1955-1964	1,162,588.0	2,417,009.6	48.1
1965-1974	2,016,261.5	17,641,364.7	11.4
1975-1984	4,872,048.0	48,539,116.5	10.0
1985-1990	7,825,533.7	93,642,587.3	8.4

Засгийн газрын 1956 оны "Улс ардын аж ахуйн цаашдын хөгжилд Улсын банкны үүргийг дээшлүүлэх тухай" тогтоолоор зээлийн болон байгууллагын дансанд төлөх хүүний хэмжээг тогтоож, банкны хяналтын үүргийг улам өндөржүүлсэн байна. 1963 онд банкны хяналтыг хүч-

тэй болгох тухай Засгийн газрын шийдвэр гарч үйлдвэр, аж ахуйн газруудыг үндсэн ажиллагаа, ашгийнх нь чанарын үзүүлэлтээр ангилан зээлжүүлэх, урамшуулал үзүүлэх буюу торгууль ноогдуулах болсон байна. Харин 1971 онд аж ахуйн салбаруудыг удирдлага, төлөвлөлтийн шинэ тогтолцоонд шилжүүлэхтэй уялдуулан банкны үйлчилгээ, хяналтыг зохицуулах ажил хийгдэж, удирдлага, төлөвлөлтийн шинэ тогтолцоогоор ажиллаж байгаа газруудыг эргэлтээр зээлжүүлэх журам тогтоосон байна. 1980 оны сүүлчээр зээлийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх,

үр дүнгийн норматив үзүүлэлтийг үндэслэн мөнгөний гүйлгээг зохицуулах арга хэмжээ авч, банкны салбаруудыг томоохон сумдуудад шинээр байгуулж, 1990 онд банкны ажилд орчин үеийн тооцоолох техник, тоног төхөөрөмж нэвтрүүлжээ. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг дахь зээлжүүлэлтийн үйл явцыг Монгол улсад банк санхүүгийн салбар үүссэн 1924 оноос 1990 он хүртэлх хугацаагаар 10 жилийн дунджаар тоймлон авч үзэхэд зээлийн нийт активт эзлэх хувийн жин 1924-1933 онд хамгийн их буюу 52.1 хувь байсан бөгөөд энэ нь хувьсгалын дараах сэргээн босголтын үйл ажиллагаатай холбоотой юм. Зээлийн нийт активт эзлэх хувийн жин 1934-1963 онуудад 50 орчим хувийг, 1963-1990 онуудад буурч 10 хүртэлх хувийг эзлэх болсон байна.

2. 1991-1999

1991 онд Улсын бага хурлаас Банкны тухай хуулийг батлан гаргаснаар банкны 2 шатлалт тогтолцоо бүрэлдэн хөгжих хууль эрх зүйн үндэс тавигдсан билээ. Ийнхүү банкны 2 шатлалт тогтолцооны үүсэл, хөгжил нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих шилжилтийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг, бодитой алхам болж ирсэн юм. Шилжилтийн эхний он жилүүдэд шинэхэн зохион байгуулагдсан банкуудын зүгээс үйл ажиллагаагаа явуулах арга туршлага, дотоод зохион байгуулалт тааруу байснаас гадна зээл олголтын журам заавар болон хууль зүйн орчин маш муу байсан нь зээл эргэн төлөгдөхгүйд хүргэж, улмаар банкуудыг санхүүгийн хямралд оруулж эхэлсэн юм. Түүнчлэн төрийн зүгээс банкуудын үйл ажиллагааг зах зээлийн зарчмаар зохицуулах эрх зүйн зохицуулалт сул байснаас төр томоохон банкууд дахь өмчийн төлөөллөөрөө дамжуулан зээлийн шийдвэрт нь зарим талаар нөлөөлөх, төлбөрийн чадварыг доройтуулахад түлхэц болж өгсөн билээ. Банкуудын санхүү төлбөрийн чадварын хүндрэлийн үндэс нь зээлийн үйл ажиллагаатай холбоотой байсан бөгөөд зээлдэгчийн талаар мэдээлэл хомс, тэдгээрийн үйл ажиллагааг тодорхойлох асуудал хүндрэлтэй байснаас банкуудын зээлийн багцын чанар муудсан юм. Хямралын анхны шинж тэмдэг нь 1994 онд Монгол Хоршоо, Сэлэнгэ банкуудыг Ард, ХОТШ банкинд нэгтгэснээр илэрсэн юм. Ийнхүү судалгаа шинжилгээгүй олгогдсон зээлийн гинжин хэлхээ үргэлжилсээр 1999 оны эцсээр Сэргээн Босголт банкны чанаргүй зээл, нийт зээлийн харьцаа 100 хувьд, мөн үед ХОТШ банкны тус үзүүлэлт 96.4 хувь болсон төдийгүй энэ үзүүлэлт нь 1996 онд Ард, Даатгал банкуудыг, 1999 онд ХОТШ, Сэргээн босголт банкуудыг тус тус дампуурахад хүргэсэн байна.

3. 2000-2003

Банкны салбар 1996-1999 онуудын хямралыг давж, хууль эрх зүйн орчноо тодорхой хэмжээгээр бүрдүүлсэн, Монголбанкны хяналт шалгалт явуулах эрх хэмжээ нэмэгдсэн, банкны нягтлан бодох бүртгэл шинэчлэгдсэн, боловсон хүчнийг сургасан, хяналтын бусад механизмууд, дотоод хяналт бий болсон зэрэг нь банкны үйл ажиллагаа сэргэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Ийнхүү банкуудын үйл ажиллагаа 2000 оноос сайжрах хандлагатай болохын хирээр банкинд итгэх итгэл нэмэгдэж, банкууд дахь харилцах, хадгаламж өсч, тэр хэмжээгээр зээл олголт нэмэгдсэн байна. 2001 оноос банкнаас авсан зээл заавал эргэж төлөгдөх нөхцөлийг бүрдүүлэх, эрх зүйн орчинг боловсронгуй болгох үүднээс Иргэний хуульд зээл болон зээлийн барьцааг зохицуулсан хууль эрх зүйн зарчмын өөрчлөлтүүдийг тусгаж өгсөн бөгөөд энэ нь зээлийн эрсдэлийг бууруулахад нааштай нөлөө үзүүлсэн юм. Мөн Монголбанк банкуудын зээлийн эрсдэлийг бууруулахад туслах, чанаргүй зээлтэй зээлдэгчдэд нэмж зээл олгох явдлыг зогсоох үүднээс Зээлийн мэдээллийн сан (1996 онд байгуулсан)-гийн үйл ажиллагааг хэвийн явуулах, хурдасгах үйл ажиллагааг донор орнуудын тусламжтайгаар хийж гүйцэтгэсэн нь банкинд өртэй, хэтэрсэн зээлтэй аливаа албадлагын хэмжээ авагдаж байсан зээлдэгчдэд шинээр нэмж зээл олгодог явдал эрс багассан байна. Ийнхүү Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн цогц арга хэмжээ, банкуудын өөрсдийн дотоод менежментийн үр дүнд банкуудын зээлжүүлэлт сайжирсан байна. Тухайлбал, 2003 оны эцэст зээлжүүлэлтийн хэмжээ 442.1 тэрбум төгрөгт хүрсэн нь 2000 оны мөн үеэс 7 дахин, 2001 оны эцсээс 3.5 дахин, харин 2002 оны дүнгээс 1.9 дахин тус тус өссөн байна. Сүүлийн 4 жилийн байдлаар үйлдвэрлэлийн болон үйлдвэрлэлийн бус салбарын зээлжүүлэлт жилд дунджаар хоёр дахин өссөн үзүүлэлттэй байв. 2003 оны эцсийн байдлаар нийт зээлжүүлэлтийн 43.7 хувь нь үйлдвэрлэлийн салбарт, 56.3 хувь нь үйлдвэрлэлийн бус салбарт хийгдсэн байна.

2003 оны эцсийн байдлаар үйлдвэрлэлийн бус салбарын зээлжүүлэлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 90.9 хувиар, үйлдвэрлэлийн салбарын зээлжүүлэлт 62.2 хувиар тус тус өссөн байна. Үйлдвэрлэлийн болон үйлдвэрлэлийн бус салбарын зээлжүүлэлтийн өсөлт 2001 оны эцсийн байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад хамгийн өндөр байсан бөгөөд үйлдвэрлэлийн салбарын зээлжүүлэлтийн өсөлт 127.7 хувь, үйлдвэрлэлийн бус салбарын зээлжүүлэлтийн өсөлт 99.9 хувь байсан байна.

Сүүлийн жилүүдэд банкнаас гадуурхи бэлэн мөнгөний хэмжээ буурч, эх үүсвэр банк, санхүүгийн байгууллагад хуримтлагдан эргээд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад хөрөнгө оруулалт болж байгаа нь санхүүгийн зуучлал гүнзгийрч байгааг илтгэж байна. Банкуудын хөрөнгө оруулалт нь ерөнхийдөө үйлдвэрлэлийн бус салбарт чиглэгдэж байгаа бөгөөд цаашид үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэхэд гол анхаарлаа хандуулах хэрэгтэй байгаа нь тоон үзүүлэлтүүдээс тодорхой байна. Өөрөөр хэлбэл, банкууд хүүгээ бууруулах, хугацаагаа уртасгах зэрэг арга хэмжээ авч, ингэснээрээ урт хугацааны зээлжүүлэлтийг, ялангуяа үйлдвэрлэлийн салбаруудыг бүрэн хүчин чадлаар хөгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох шаардлагатай байна.

байдалтай харьцуулахад цэвэр зээлийн өрийн үлдэгдлийн нийт активт эзлэх хувийн жин 6.6 нэгжээр, гадаад активын нийт активт эзлэх хувийн жин 4.7 нэгжээр тус тус өсч бусад хөрөнгийн нийт активт эзлэх хувийн жин буурсан байна. Харин актив тус бүрийн өөрчлөлтийн хувьд банкны нөөц 27.4 хувь, бусад банк дахь харилцах, хадгаламж, ТБҮЦ-ны нийт үлдэгдэл 37.1 хувь, цэвэр зээлийн өрийн үлдэгдэл 80.9 хувь, бусад үнэт цаас 90.7 хувь, үндсэн хөрөнгө 38.8 хувь, өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө 60.1 хувь, бусад актив 30.1 хувиар тус тус өслөө.

Тайлант онд салбарын нийт пассивын дүн 65.8 хувь буюу 284 тэрбум төгрөгөөр нэмэгдсэний 51.1 хувийг нийт хадгаламжийн, 27.2 хувийг нийт харилцахын, 12.3 хувийг гадаад банкуудаас татсан эх үүсвэрийн өсөлт тус тус эзэлж байна. Банкны салбарын пассивын бүтцийг өмнөх оныхтой харьцуулахад нийт пассивын дүнд эзлэх харилцах, үүнд засгийн газрын харилцах, хадгаламжийн дүн буурч, иргэд байгууллагын хадгаламж, гадаадын банкнаас татсан эх үүсвэр, бусад пассивын дүн өсч, нийт пассивын 50.8 хувь нь хадгаламж, 29.1 хувь нь харилцах, 7.2 хувь нь дотоод болон гадаадын банкуудаас татсан эх үүсвэр, 3.8 хувь нь бусад пассиваас бүрдэж байна.

Банкуудын үйл ажиллагаанаас харахад тайлант онд харилцах, хадгаламж хэлбэрээр татан төвлөрүүлсэн хөрөнгийн дийлэнх хэсгийг зээлд байршуулж байгаа нь өмнөх жилүүдийн үйл ажиллагааны чиг хандлагатай ижил байна. Гол ялгаатай тал нь зээлдэгчдийг бүлэглэн авч үзэх, зээлийн нэр төрөл, хэлбэрийг олшруулах хандлагатай байгаад оршиж байна. Үүнтэй зэрэгцэн банкууд шинээр үйлчилгээ болон санхүүгийн бүтээгдэхүүн гаргаж байгаа нь нэг талаас, уг үйл ажиллагаанаас орлого олох зорилготой, нөгөө талаас үйлчилгээгээрээ харилцагчдыг татах, улмаар эх үүсвэрээ нэмэгдүүлэх чиглэлтэй байна.

Хүснэгт 14. Зээлийн тайлан салбараар (тэрбум төгрөг)				2003.12.31
	Эхний үлдэгдэл	Олгосон	Төлсөн	Эцсийн үлдэгдэл
Зээлийн нийт дүн	281.9	714.7	560.0	441.2
Үйлдвэрлэлийн зориулалтаар	147.0	214.2	171.0	194.9
ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт	13.8	24.5	16.7	24.2
Цахилгаан хий үйлдвэрлэл, усан хангамж	3.6	14.0	8.2	9.4
Барилга	14.3	44.6	27.6	31.3
Уул уурхай, олборлох үйлдвэрлэл	35.6	47.9	46.9	37.5
Боловсруулах үйлдвэр	79.7	83.2	71.6	92.5
Үйлдвэрлэлийн бус зориулалтаар	134.9	500.5	389.0	246.3
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар	80.7	307.2	236.6	150.4
Аялал, жуулчлал, зочид буудал, зоогийн газар	7.2	5.7	5.8	7.2
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	6.5	19.3	12.4	13.6
Үйл хөдлөх хөрөнгө, түрээсийн бизнесийн үйл ажиллагаа	3.0	9.3	5.2	7.6
Эрүүл мэнд, боловсрол	1.3	2.9	2.2	2.1
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	4.0	5.2	4.9	4.4
Бусад	32.2	150.9	121.9	61.0

Хүснэгт 15. Зээл, чанаргүй зээл, хадгаламж, банкнаас гадуурхи мөнгө (тэрбум төгрөг)

	1997	1998	1999	2000	2001	2002	2003
1 Нийт зээлийн өрийн үлдэгдэл	50.4	85.6	77.5	66.8	135.1	231.4	442.1
Өсөлт*	-22.3	70.0	-9.5	-13.9	102.3	71.4	91.0
2 Чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл	14.5	32.6	42.1	15.9	10.9	16.6	36.7
Өсөлт*	-56.1	125.8	29.0	-62.2	-31.6	52.4	121.6
3 Нийт хадгаламж	58.5	59.3	70.0	92.7	134.6	218.4	363.5
Өсөлт*	27.3	1.4	18.0	32.5	45.2	62.2	66.5
4 Банкнаас гадуурх мөнгө	49.8	56.4	87.3	100.9	109.2	120.8	131.5
Өсөлт*	19.3	13.4	54.6	15.6	8.2	10.6	8.9

* хувиар

Өмнөх оныхоос банкуудын нийт орлого 58.4 хувь, нийт зардал 70.0 хувиар тус тус өсч, татварын өмнөх нийт ашгийн хэмжээ 15.1 хувиар нэмэгдсэн байна. Үүнд банкуудын зээлийн хүүний орлого 65.5 хувиар нэмэгдсэн ч хүүний зардал 96.6 хувиар нэмэгдсэн, болзошгүй эрсдлийн зардал өссөн, бусад төрлийн зардал бусад төрлийн орлогоос их хэмжээгээр нэмэгдсэн зэрэг нөлөөлжээ. Сүүлийн 2 жилийн хугацаанд банкуудын зарласан зээлийн хүүний жигнэсэн дундаж болон бодит гарсан орлогоор тооцсон дундаж хүүний хэмжээ буурч байгаа боловч эх үүсвэрт зарласан хүүний түвшин буурахгүй байгаа нь банкууд эх үүсвэр татан төвлөрүүлэн зах зээлд тодорхой байр суурь эзлэх сонирхолтой байгааг харуулж байна. Эдгээр байдлаас шалтгаалан банкны салбарын активын өгөөжийн үзүүлэлт 2002 оныхоос 1.2 нэгжээр буурч 3.1 хувь болов.

Хүснэгт 16. Орлого, зардал (тэрбум төгрөг)

	2001 он		2002 он		2003 он		2003		2003	
							2001		2002	
	дүн	хувь*	дүн	хувь*	дүн	хувь*	дүн	хувь**	дүн	хувь**
Нийт орлого	52.1	100	84.6	100	134	100.0	81.9	157.2	49.4	58.4
Үүнээс:										
Хүүний орлого	35	67.1	57.9	68.4	95.8	71.5	60.8	173.7	37.9	65.5
Арилжааны орлого	5.1	9.8	12.3	14.5	4.3	3.2	-0.8	-15.7	-8	-65
Ханшийн тэгшитгэлийн орлого	2.5	4.8	4.1	4.9	19.8	14.8	17.3	692	15.7	382.9
Шимтгэлийн орлого	5.2	10.0	7.3	8.6	10.2	7.6	5	96.2	2.9	39.7
Бусад орлого	4.3	8.3	3.0	3.5	3.9	2.9	-0.4	-9.3	0.9	30.0
Нийт зарлага	36.1	69.2	66.7	78.9	113.4	84.7	77.3	214.1	46.7	70.0
Үүнээс:										
Хүүний зардал	13.4	25.7	24.2	28.7	47.7	35.6	34.3	256	23.5	97.1
Болзошгүй эрсдэлийн зардал	2.3	4.4	5.9	7	10.1	7.5	7.8	339.1	4.2	71.2
Арилжааны зардал	3.7	7.1	11.4	13.5	2.3	1.7	-1.4	-37.8	-9.1	-79.8
Ханшийн тэгшитгэлийн зардал	2.5	4.9	3.8	4.5	18.7	14.0	16.2	648	14.9	392.1
Боловсон хүчний зардал	5.9	11.3	9.5	11.2	14.7	11.0	8.8	149.2	5.2	54.7
Элэгдлийн зардал	1.2	2.3	1.9	2.2	3.2	2.4	2	166.7	1.3	68.4
Бусад зардал	7	13.5	9.9	11.8	16.8	12.5	9.8	140	6.9	69.7
Татварын өмнөх цэвэр ашиг	16	30.8	17.8	21.1	20.5	15.3	4.5	28.1	2.7	15.2
Татварын зардал	6.2	11.8	6.8	8.1	6.7	5.0	0.5	8.1	-0.1	-1.5
Цэвэр ашиг	9.9	18.9	11	13	13.8	10.3	3.9	39.4	2.8	25.5

* нийт орлогод эзлэх хувь

** өөрчлөлтийн хувь

4.2. Банк бус санхүүгийн байгууллагууд (ББСБ)

Санхүүгийн зуучлалыг өргөжүүлэх, цаашид санхүүгийн байгууллагаас хөрөнгө оруулалтын буюу урт хугацааны зээл олгох үндсэн нөхцөлийг бий болгох, санхүүгийн салбар дахь хүүний түвшинг бууруулах үүднээс санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг банкнаас бусад санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг нэмэгдүүлэх шаардлага гарч байна. Монголбанкнаас ББСБ-ын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр зарим ажлууд хийж гүйцэтгэсний үр дүнд сүүлийн 2 жилийн хугацаанд ББСБ-ын тоо 76-аар нэмэгдэж 97-д хүрснээс тайлант онд 88 ББСБ үйл ажиллагаа явуулж байна.

Иргэд байгууллагын сул чөлөөтэй хөрөнгийг санхүүгийн зуучлалын үйл ажиллагаанд татан оролцуулах үүднээс Монголбанкны Ерөнхийлөгчийн 2002 оны 211 тоот тушаалаар ББСБ-ын дүрмийн сангийн доод хэмжээг хот болон хөдөө, орон нутагт ялгаатайгаар дахин шинэчлэн тогтоов. Үүнд, Улаанбаатар хотод 30.0 сая төгрөг байсныг өөрчлөн 100.0 сая төгрөг байхаар, Дархан, Эрдэнэт хотуудад дүрмийн сангийн доод хэмжээ 10.0 сая, харин хөдөө орон нутагт дүрмийн сангийн доод хэмжээг 1.0 сая төгрөг хэвээр байхаар тогтоов. Энэхүү тогтоолын дагуу ББСБ-ууд дүрмийн сангаа нэмэгдүүлэхийн зэрэгцээ шинээр байгуулагдаж байгаа нь ББСБ-ын нийт актив болон зээлийн өрийн үлдэгдэл өсөхөд нөлөөлөв. Тайлант онд 34 ХХК-д Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг шинээр олгосон ба эдгээрээс 3 ББСБ-ууд хөдөө орон нутагт шинээр байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна. Түүнчлэн гадаадын хөрөнгө оруулалттай 3 ББСБ банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авчээ. Тайлант онд 5 ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгов.


ШИГТГЭЭ 10. ХАДГАЛАМЖ

Санхүүгийн зах зээл ба санхүүгийн зуучлагчид нь зээлдэгч болон зээлдүүлэгчдийг холбох гол үүрэг гүйцэтгэдэг билээ. Энэхүү үйл ажиллагаа нь эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжихэд чухал ач холбогдолтой юм.


Ардын хувьсгал 1921 онд ялалт байгуулснаар үндэсний банк, зээлийн систем үүсч хөгжих нөхцөл бүрдсэн бөгөөд Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн Худалдаа ба аж үйлдвэрийн банк (Монголбанк) 1924 онд үйл ажиллагаагаа эхэлсэн байна. Монголбанк байгуулагдсан цагаасаа эхлэн аж ахуйн нэгжүүдийн данс нээх, тэдний хөрөнгийг төвлөрүүлэн хадгалах, төрөл бүрийн тооцоо гүйлгээ хийх, зээл олгох зэрэг ажлыг гүйцэтгэж байжээ. Банкны үйл ажиллагааны хоёр дахь жилийн гол зорилт бол мөнгөний шинэчлэл хийх нөхцөл бүрдүүлэх явдал байсан бөгөөд үүнийг хэрэгжүүлэхийн тулд өөрийн болон татан төвлөрүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн байна. 1925 онд Худалдаа ба аж үйлдвэрийн банкны өөрийн хөрөнгө бараг хоёр дахин, татан төвлөрүүлсэн хөрөнгө дөрөв дахин өсчээ. 1925 оны эхэнд татан төвлөрүүлсэн хөрөнгийн үлдэгдэлд монгол байгууллагуудын эзлэх хувийн жин 10.1 хувь байсан бол оны эцэст 61.2 хувь болжээ. Улсын эдийн засгийн хөгжлийг цаашид эрчимжүүлэх зорилгоор 1940 онд хөрөнгө оруулалтын санхүүжилтийг Монголбанкинд төвлөрүүлэн хянаж гүйцэтгэхээр болсон байна. 1954 онд Монголбанк нь Улсын банк болон өөрчлөгдөн зохион байгуулагджээ. Харилцах, хадгаламжийн хэлбэрээр байршуулсан хөрөнгө 1927-1930 онд дунджаар 2.3 сая төгрөг байсан бол 1931-1940 онд 28.6 сая төгрөг, 1941-1950 онд 44.1 сая төгрөг, 1951-1960 онд 139.5 сая төгрөг, 1961-1970 онд 523.4 сая төгрөг, 1971-1980 онд 1.1 тэрбум төгрөг, 1981-1990 онд 3 орчим тэрбум төгрөг болж өссөн байна. Монгол улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд 1991 онд шилжсэний дараа санхүүгийн зуучлалын хөгжлийг илэрхийлэх нэг үзүүлэлт болох хадгаламжийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийн жин 1999 оноос

эхлэн эрчимтэй өсч эхэлжээ. Тухайлбал, харилцах хадгаламжийн ДНБ-д эзлэх хувийн жин 2000 онд 15.5 хувь байсан бол 2003 онд 42 орчим хувьд хүрчээ.

Зураг 1. Харилцах, хадгаламж



Зураг 2. Богино хугацаатай хадгаламжийн жилийн хүү (тухайн оны эцсийн байдлаар)




Санхүүжилтийн эх үүсвэр нэмэгдэж, улс ардын аж ахуйн бүтээгдэхүүн, үйлчилгээний эргэлтэнд шаардагдах мөнгөн хөрөнгө өсч, улмаар эдийн засгийн өсөлтийг хангах боломжтой болсон байна.

Хүүг бодит түвшинд эерэгээр байлгах, иргэдийн хадгаламжийг үнэгүйдлээс хамгаалах зорилгоор 1992 оноос 1996 он хүртэл хадгаламжийн хүүний доод хэмжээг Монголбанкнаас тогтоож ирсэн болно. Сүүлийн хэдэн жилд банкуудын зарласан хугацаатай хадгаламжийн жилийн хүү буурч байгаа нь цаашид зээлийн хүүг бууруулж санхүүжилтийг эрчимжүүлэх боломжийг нэмэгдүүлж байгаа болно.


Банкны салбарыг эрүүлжүүлэн бэхжүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангах талаар Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд сүүлийн гурван жилд банкуудын татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ эрс өссөн байна. 2003 онд харилцах, хадгаламжийн хэмжээ 222.5 тэрбум төгрөг буюу 63.7 хувиар өсч 571.8 тэрбум төгрөгт хүрчээ. Үүнд гадаадаас ирсэн хувийн гуйвуулгын өсөлт ч нөлөөлсөн болно. Сүүлийн жилүүдэд гадаадад ажиллаж буй манай иргэдийн тоо нэмэгдэж байгаа бөгөөд энэ хэрээр хувийн гуйвуулга ч өсч байна. 2003 онд цэвэр хувийн гуйвуулга 9.9 сая ам.доллар буюу 15.4 хувиар өсч 74.3 сая ам.доллар болжээ.

2003 оны байдлаар банкуудад байршуулсан нийт хадгаламжийн 21.3 хувийг хугацаагүй, 78.7 хувийг хугацаатай хадгаламж тус тус эзэлж байна. Нийт хугацаагүй хадгаламжинд төгрөг ба валютаар байршуулсан хугацаагүй хадгаламжийн хувийн жин 50 орчим хувь буюу ижил тэнцүү байхад төгрөгийн хугацаатай хадгаламж нийт хугацаатай хадгаламжийн 70.3 хувь, валютын хугацаатай хадгаламж 29.7 хувийг тус тус эзэлж байна. Төгрөгийн хугацаатай хадгаламж нийт хадгаламжийн ихэнх хэсэг буюу 55.3 хувийг бүрдүүлжээ. Энэхүү үзүүлэлтүүд нь банкны байгууллага болон үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгт үзүүлж буй итгэл нэмэгдсэний хэмжүүр болж байна.

Зураг 3. Хадгаламжийн бүтэц (2003)



Зураг 4. Иргэдийн хадгаламжийн өөрчлөлт



Нийт хадгаламжийг байршуулагчийнх нь өмчийн хэлбэрээр авч үзвэл, өнгөрсөн онд улсын байгууллагын хадгаламж нийт хадгаламжийн 1.6 хувь, хувийн хэвшлийнх 2.4 хувь, иргэдийнх 95.9 хувь, бусад байгууллагынх 0.1 хувийг тус тус эзэлжээ. Улсын байгууллагын хадгаламжийн жилийн өсөлт 23.9 хувь, хувийн хэвшлийнх 73.4 хувь байжээ. Харин нийт хадгаламжийн дийлэнх хувийг эзэлж буй иргэдийн хадгаламж 141.6 тэрбум төгрөг буюу 68.4 хувиар өссөн байна. Өнгөрсөн оны байдлаар иргэдийн нийт хадгаламж 348.6 тэрбум төгрөг болсноос төгрөгийн хадгаламж 65.4 хувь, валютын хадгаламж 34.6 хувийг тус тус эзэлж байна.

Банкуудын татан төвлөрүүлсэн хөрөнгө нэмэгдсэн нь санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлж хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломжийг олгож байгаа бөгөөд нөгөө талаар олон түмний банкны салбарт итгэх итгэл өссөнийг харуулж байна.

2003 оны эцсийн улирлын нэгтгэлд нийт 88 ББСБ хамрагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад үйл ажиллагаа явуулж буй ББСБ-уудын тоо 22-оор буюу 33.3 хувиар нэмэгдэв.

Тайлант онд үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-уудын нийт хувь нийлүүлэгчдийн тоо 210, нийт ажиллагсдын тоо 285-д хүрчээ. Мөн 2003 онд нийт 3.4 мянган зээлдэгчдэд зээлийн үйлчилгээ үзүүлсэн байна.

Гадаадын хөрөнгө оруулалттай 6 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа ба тэдгээрийн дүрмийн сангийн хэмжээ 2.4 тэрбум төгрөг байгаа нь ББСБ-уудын нийт дүрмийн сангийн 20.0 хувийг эзэлж байна.

ББСБ-уудын ихэнх нь зээлийн үйл ажиллагаа эрхэлж, цөөн тооны байгууллагууд нь мөнгөн гуйвуулга, санхүүгийн түрээс факторинг зэрэг үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан байна.

ББСБ-ууд үйл ажиллагаагаа өргөжүүлэх үүднээс гадаадын байгууллага иргэдтэй хамтран ажиллаж байна. Монголбанк манай улсад хэрэгжүүлж байгаа олон улсын санхүүгийн болон бусад байгууллагуудаас хэрэгжүүлэх төсөлд олгох эх үүсвэрийг дамжуулан зээлдүүлэх үйл ажиллагаанд ББСБ-ыг оролцуулах талаар анхааран ажиллаж байна.

Хөдөө орон нутагт бичил санхүүгийн үйлчилгээг иргэдэд хүргэх зорилгоор Дэлхийн банкны бичил санхүүгийн хөгжлийн сангаас (Өрхийн амьжиргааг дэмжих хөтөлбөр) Ситисан, Баттөгрөг, АВТС, Капмон, Кредит Монгол зэрэг ББСБ-уудад нийт 150.0 сая төгрөгийн зээлийг олгосон байна. Мөн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ажлын байр нэмэгдүүлэх төслийн хүрээнд Дэвж сан, Мөнх арилжаа, Мон арвис сан зэрэг ББСБ-уудад нийт 120.0 сая төгрөгийн зээлийг олгожээ.

Тайлант онд хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо 3-аар нэмэгдэж 9-д хүрсэн нь нийт үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын 10.2 хувийг эзэлж байна. Байршлын хувьд авч үзвэл, Дархан-Уул аймагт 3, Завхан аймагт 2, Архангай аймагт 2, Төв, Сэлэнгэ, Дорнод аймгуудад тус бүр 1 ББСБ үйл ажиллагаа явуулж байна.

ББСБ-уудын салбар, төлөөлөгчийн газар Баянхонгор, Сүхбаатар, Өмнөговь, Дархан-Уул, Өвөрхангай зэрэг аймгуудад шинээр байгуулагдсан ба нийт салбар, нэгжийн тоо 10-д хүрээд байна.

ББСБ-уудын нийт актив өмнөх оны мөн үеэс 51.7 хувь буюу 6.4 тэрбум төгрөгөөр өсч 18.9 тэрбум төгрөг болсон нь нийт банкны салбарын 2.3 хувийг эзэлж байна.

Нийт эх үүсвэр нэмэгдсэнээр мөнгөн хөрөнгийн дүн бага зэрэг өссөн ч нийт активт эзлэх хувийн жин 9.1 нэгжээр буурч 24.0 хувь болов. Харин зээлийн өрийн үлдэгдэл

Хүснэгт 17. Банк бус санхүүгийн байгууллагуудын үзүүлэлтүүд (Тэрбум төгрөг)				
	2000	2001	2002*	2003
Зээлийн өрийн үлдэгдэл	1.5	13.2	6.3	11.8
Нийт актив	3.0	23.4	12.5	18.9
Нийт пассив	1.4	3.1	3.9	5.2
Өөрийн хөрөнгө	1.6	20.3	8.6	13.7
* 2002 оны үзүүлэлтийг Чингисхаан ББСБ-ын үзүүлэлтийг хасч тооцов.				

5.4 тэрбум төгрөгөөр өсч 11.5 тэрбум төгрөг болсон нь нийт активын 60.7 хувийг эзэлж өмнөх оныхоос 11.4 нэгжээр өссөн байна.

Нийт авлага өмнөх оныхоос 0.3 тэрбум, үндсэн хөрөнгө 0.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн ч эдгээрийн өсөлтийн хурдац нь нийт активын өсөлтийн хурдацаас бага байгаагаас шалтгаалж нийт авлагын нийт активт эзлэх хувийн жин 1 нэгжээр буурч 6.5 хувь, үндсэн хөрөнгийн нийт активт эзлэх хувийн жин 2.1 нэгжээр буурч 7.7 хувь тус тус болжээ. Харин урьдчилж төлсөн тооцоо, материал, бага үнэтэй, түргэн элэгдэх зүйл болон урьдчилж төлсөн татварын дүнгийн механик өсөлттэй холбоотойгоор бусад актив 93.1 сая төгрөгөөр өсч 114.0 сая төгрөг болсон нь нийт активын 0.6 хувийг эзэлж байна.

Хүүний орлого авчирдаг актив тайлант онд нийт активын 60.7 хувь болж өссөн нь ББСБ-ууд активаа зохистой байршуулсан, зээлийн идэвхтэй бодлого баримталж буйг харуулж байна. Цаашид ББСБ-ууд шинээр үүсгэн байгуулагдах, эх үүсвэрүүд нэмэгдэх чиг хандлагатай тул зээлийн өрийн үлдэгдэл ч өсөх хандлагатай байна.

Тайлант онд нийт эх үүсвэр өмнөх оны мөн үеэс 51.7 хувиар өсч 18.9 тэрбум төгрөгт хүрсэн нь ББСБ-уудын дүрмийн сан нэмэгдсэн, тухайн үеийн ашиг өмнөх оны

Хүснэгт 18. ББСБ-ын зээлийн багцын чанар (сая төгрөг)				
Үзүүлэлт	2002.12.31*		2003.12.31	
	Дүн	Нийт активт эзлэх хувь	Дүн	Нийт активт эзлэх хувь
Зээл (цэврээр)	6140.4	49.3	11470.6	60.7
Нийт зээл	6340.1	50.9	11830.6	62.6
Хэвийн зээл	5790.1	46.5	10907.3	57.7
Чанаргүй зээл	419.7	3.4	773.0	4.1
Хугацаа хэтэрсэн зээл	119.6	1.0	282.2	1.5
Хэвийн бус зээл	102.1	0.8	216.9	1.1
Эргэлзээтэй зээл	170.0	1.4	182.2	1.0
Муу зээл	28.0	0.2	91.6	0.5
Санхүүгийн түрээсийн тооцоогоор авлага	130.3	1.0	150.3	0.8
(ЗТУБАХС)	-199.8	-1.6	-360.0	-1.9
* 2002 оны үзүүлэлтийг Чингисхаан ББСБ-ын үзүүлэлтийг хасч тооцов.				

мөн үеэс 86.2 хувиар өссөн зэргээс шалтгаалж ББСБ-ын өөрийн хөрөнгө 60.2 хувь буюу 5.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн, түүнчлэн ББСБ-ын бусдаас татан төвлөрүүлсэн санхүүгийн эх үүсвэр 52.6 хувь буюу 0.9 тэрбум төгрөгөөр өссөн зэрэгтэй тус тус холбоотой байна.

Өөрийн хөрөнгийн өсөлтийн хурдац нийт эх үүсвэрийн өсөлтийн хурдацаас их байсан тул өөрийн хөрөнгийн нийт эх үүсвэрт эзлэх хувийн жин 3.8 нэгжээр өсч 72.6 хувь болов. Харин санхүүгийн эх үүсвэр 1.0 тэрбум төгрөгөөр өсч 2.9 тэрбум төгрөг, бусад пассив 0.3 тэрбум төгрөгөөр өсч 2.3 тэрбум төгрөг тус тус болсон боловч нийт пассивын өсөлт нь нийт эх үүсвэрийн өсөлтийн хурдацаас бага байсантай холбоотойгоор бусад пассивын нийт эх үүсвэрт эзлэх хувийн жин 3.8 нэгжээр буурч 27.4 хувь болов.

ББСБ-ууд 2003 онд 1.1 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оныхоос 86.2 хувь буюу 0.5 орчим тэрбум төгрөгөөр өссөн байна.

Ашгийн өсөлтийг нэг талаас, ББСБ-уудын тоо нэмэгдсэн, мөн үйл ажиллагаа нь жигдэрч, зээлийн идэвхтэй бодлого баримтлан ажиллаж байгаа, нөгөө талаас бусдаас татан төвлөрүүлсэн санхүүгийн эх үүсвэрийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 52.6 хувиар нэмэгдэж 2.9 тэрбум төгрөгт хүрснээр санхүүгийн зуучлалын хүрээгээ тэлж байгаа зэргээр тайлбарлаж болно. ББСБ-уудын хуримтлуулсан ашгийн хэмжээ 107.6 сая төгрөг байна.

ББСБ-уудын нийт орлого тайлант онд өмнөх оны мөн үеэс 90.5 хувиар буюу 1.9 тэрбум төгрөгөөр өсч 4.1 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт эх үүсвэр өмнөх оны мөн үеэс 51.7 хувиар нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Нийт орлогыг бүтцээр нь авч үзвэл, 80.2 хувь буюу 3.3 тэрбум төгрөг нь хэвийн ба хугацаа хэтэрсэн зээлийн хүүний орлого, 2.0 хувь буюу 82.2 сая төгрөг нь санхүүгийн түрээсийн орлого, 5.8 хувь буюу 239.1 сая төгрөг нь гадаад валютын арилжааны орлого, 5.7 хувь буюу 234.2 сая төгрөг нь гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого, үлдэх хувийг бусад орлого эзэлж байна.

Харин өмнөх оны мөн үеэс үйл ажиллагааны цар хүрээ нэмэгдсэнтэй холбоотойгоор тайлант оны эцэст зардал зүйл тус бүрээр өсч нийт зардал 2.9 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 91.9 хувь буюу 1.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийт зардлын өсөлтийг авч үзвэл, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 1.9 тэрбум төгрөгөөс 2.9 тэрбум төгрөгт хүрсэн ба тэдгээрийн хүүний зардалд нийт 679.8 сая төгрөг зарцуулсан нь нийт зардлын 23.0 хувийг эзэлж байна. Бусдаас татан төвлөрүүлсэн санхүүгийн эх үүсвэр, үйл ажиллагаа, үйлчилгээний төрөл, цар хүрээ өргөжихийн хирээр цаашид ч уг зардал нэмэгдэх хандлагатай байна.

**ШИГТГЭЭ 11. БАНК БА БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН
ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААР ХИЙСЭН СУДАЛГАА**

Аливаа улсын эдийн засгийн хөгжлийн нэгэн тулгуур хүчин зүйл бол санхүүгийн зуучлал юм. Санхүүгийн зуучлагч байгууллагуудын оролцоотойгоор хөрөнгийн илүүдэлтэй байгаа салбараас хомсдолтой байгаа салбар руу хөрөнгө шилжиж, ингэснээр эдийн засагт шаардлагатай байгаа хөрөнгө оруулалтыг хийх боломжийг бүрдүүлнэ. Энэхүү судалгааны ажлын гол зорилго нь санхүүгийн зуучлалын гол байгууллагууд болох банк, ялангуяа хөгжөөд удаагүй байгаа ББСБ-ын сүүлийн 2 жилийн үндсэн үзүүлэлт болох зээл, өөрийн хөрөнгө, орлого, зарлага, ашиг (алдагдал) зэргийг харьцуулан дүгнэлт хийхэд оршино. Энэхүү судалгаанд 2001 оны 1 дүгээр улирлын¹, мөн оны 4 дүгээр улирлын болон 2002 оны 4 дүгээр улирлын банкны болон ББСБ-ын үзүүлэлтүүдийг авч ашиглав.

Хүснэгт 1. Банкны үндсэн үзүүлэлтүүд

	2001 оны 1дүгээр улиралд	2001 оны эцэст	Өсөлт (%)	2002 оны эцэст	Өсөлт (%)
Нийт актив	243.9	332.7	36.4	493.0	48.2
Нийт зээл	80.4	135.1	67.9	231.5	71.3
Чанаргүй зээл	15.7	10.9	-30.8	16.6	52.4
Өөрийн хөрөнгө	27.8	47.2	70.4	61.3	29.9
Орлого	9.6	52.1	445.7	84.6	62.2
Зарлага	6.6	42.3	539.9	73.6	74.0
Ашиг/алдагдал	2.9	9.9	234.5	11.0	11.5

1999 оны банкны хямралаас хойш банкны салбарын үзүүлэлтүүд харьцангуй тогтворжиж, сайжрах төлөвдөө орж, санхүүгийн чадварын хувьд сул, өндөр эрсдэлтэй хэмээн тооцогддог байсан ХААН бан-

кинд 2000 оноос менежментийн шинэчлэлийг хийснээр уг банкны үзүүлэлтүүд сайжирч, хөдөө орон нутаг дахь зээлжүүлэлт нэмэгдэж, санхүүгийн үйлчилгээ, зуучлалыг гүнзгийрүүлэх эхлэлийг тавьсан.

2001 оны эхний улирлаас оны эцэс хүртэл орлого 4.5 дахин (42.6 тэрбум төг), зарлага 5.4 (35.7 тэрбум төг) дахин өсч, цэвэр ашиг 2.3 дахин (6.9 тэрбум төг) өсч 9.9 тэрбум төгрөгт хүрчээ. Үүнийг нарийвчлан авч үзвэл, энэ хугацаанд банкны орлогын ихэнх хувийг бүрдүүлдэг хүүний орлого 6.6 тэрбум төгрөгөөс 35.0 тэрбумд хүрсэн буюу 5.2 дахин, хүүний зардал 2.8 тэрбумаас 13.4 тэрбумд буюу 4.9 дахин өсчээ. Өөрөөр хэлбэл, энэ хугацаанд банкуудын эх үүсвэрийн татан төвлөрүүлэлт сайжирч, зээл олголт ихсэж, санхүүгийн зуучлал улам бүр гүнзгийрсэн гэсэн үг юм.

2001 оны эцэст банкны салбарын нийт зээлийн хэмжээ 135.1 тэрбум байсан нь нийт активын 40.6 хувь, ДНБ-ий 12.1 хувьтай тэнцүү, 2002 онд 231.5 тэрбум төгрөг буюу нийт активын 46.9 хувь, ДНБ-ий 18.8 хувьтай тэнцүү байлаа. Чанаргүй зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувийг авч үзвэл, энэ нь 2001 оны эхний улиралд 19.5 хувь, уг оны эцэст 8 хувь, 2002 онд 7.1 хувь болж буурсан байна.

Банкны ашигт ажиллагааг хэмжих хэмжигдэхүүн нь татварын дараах ашгийг нийт активын хэмжээнд харьцуулж тооцдог нийт активын өгөөж (ROA) ба энэ нь банк активаа хэр ашигтай байршуулж байгааг тодорхойлдог үзүүлэлт юм. Ерөнхийдөө, энэ нь 1 хувиас дээш байхад банкны үйл ажиллагааг ашигтай байна гэж шинжээчид үнэлдэг. 2001 оны эхний улирлын байдлаар энэхүү харьцаа нь 1.21 хувь, мөн оны эцэст 3.0 хувь, харин 2002 оны эцсийн байдлаар 2.2 хувь байв. Өөр нэгэн хэмжигдэхүүн нь өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) ба үүнийг тооцохдоо татварын дараах ашгаа өөрийн хөрөнгөдөө харьцуулдаг. Энэхүү үзүүлэлт нь уг банкны хувьцаа эзэмшигчид өөрийн оруулсан хөрөнгө оруулалтандаа хэр ашиг олж байгааг илэрхийлдэг бөгөөд банкны салбарын хувьд уг үзүүлэлт нь 2001 оны эхний улирлын байдлаар 10.6 хувь, 2001 оны эцэст 20.9 хувь, харин 2002 оны эцэст 17.9 хувьтай байлаа.

"ББСБ-ын үйл ажиллагааны тухай хууль"-д зааснаар зээл, факторинг, санхүүгийн түрээс зэрэг 10 банк бус санхүүгийн үйл ажиллагааг ББСБ нь эрхэлж болно хэмээн тодорхойлсон ч зээлээс бусад үйл ажиллагаа нь харьцангуй түгээмэл бус, эрхлэх туршлага бага зэргээс шалтгаалан зөвшөөрөл авсан ББСБ-ын дийлэнх нь зөвхөн зээлийн үйлчилгээ үзүүлдэг бөгөөд энэ нь жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, макро эдийн засгийн гол үзүүлэлт болох ядуурал, ажилгүйдлийг бууруулахад чухал үүрэгтэй юм.

¹ Энд Чингисхаан ББСБ үйл ажиллагаагаа эхэлсэнээр ББСБ-ын системд гарсан өөрчлөлтүүдийг тодорхой гаргахын тулд 2001 оны 1 дүгээр улирлын үзүүлэлтүүдийг оруулан тооцов.

2001 оны эхний улирлын байдлаар ББСБ-аас олгосон зээлийн хэмжээ 1.8 тэрбум төгрөг, мөн оны эцсийн байдлаар 13.2 тэрбум төгрөг байсан бол 2002 оны эцэст энэ нь 2.7 дахин өсөж 36.0 тэрбум төгрөгт хүрчээ. 2001 оны 1 дүгээр улиралд ББСБ-уудын нийт активын хэмжээ 5.2 тэрбум төгрөг, 2001 оны эцэст 23.4 тэрбум, 2002 онд 44.1 тэрбумд хүрсэн байна. Энэ хугацаанд чанаргүй зээлийн хэмжээ 0.03 тэрбум төгрөгөөс 0.4 тэрбумд хүрсэн, нийт зээлийн багцад эзлэх хувь нь 2001 оны 1 улирлын сүүлчээс оны эцэс хүртэл 1.7 хувиас 0.3 хувь болж буурсан боловч уг үзүүлэлт нь 2002 оны эцэс гэхэд дахин 1.2 хувь болж өсчээ. Эхний үеийн бууралт нь 2001 онд олгосон зээлийн хэмжээ огцом өссөнтэй, харин дараагийн үеийн өсөлт нь ББСБ-ууд байгуулагдсан эхний үедээ олгосон зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь болсонтой, үүнтэй уялдан гарч байгаа асуудлуудаас үүдсэн байж болох талтай. ББСБ-аас олгосон нийт зээлийн хэмжээг ДНБ-д харьцуулан авч үзвэл энэ нь 2001 оны эцсийн байдлаар 1.2 хувь, харин 2002 оны эцэст 2.9 хувьтай байв.

Хүснэгт 2. ББСБ-ын үндсэн үзүүлэлтүүд

(тэрбум төг.)

	2001 оны 1дүгээр улиралд	2001 оны эцэст	Өсөлт (%)	2002 оны эцэст	Өсөлт (%)
Нийт актив	5.2	23.4	350.4	44.1	88.5
Нийт зээл	1.8	13.2	623.6	36.0	173.1
Чанаргүй зээл	0.0	0.0	15.2	0.4	1005.3
Өөрийн хөрөнгө	1.9	20.3	985.2	25.7	27.1
Орлого	0.55	1.2	121.6	4.4	263.6
Зарлага	0.61	1.1	81.1	3.2	192.0
Ашиг/алдагдал	-0.1	0.1	296.6	1.2	944.8

ББСБ-уудын өөрийн хөрөнгийн нийт хэмжээ 2001 оны эхний улирлын байдлаар 1.9 тэрбум, оны эцэст 20.3 тэрбум төгрөг, 2002 онд 25.7 тэрбум төгрөг болж 2002 онд 26.6 хувиар өсчээ. 2001 оны эхний улиралд

0.06 тэрбум төгрөгийн алдагдалтай байсан бол уг оны эцэс гэхэд ашиг нь 0.1 тэрбум төгрөг, 2002 оны эцсийн байдлаар ашиг нь 12 дахин өсч, 1.2 тэрбум болсон байна. Мөн хугацаанд орлого 0.55 тэрбум төгрөгөөс 4.4 тэрбум, зарлага 0.61 тэрбумаас 3.2 тэрбум болж тус тус өсчээ.

2002 оны байдлаар үйл ажиллагаа явуулж буй ББСБ-уудаас хамгийн том нь болох Чингисхаан ББСБ нь 2001 оны 4 дүгээр улиралд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд энэ нь ББСБ-ын өсөлтийн гол хүчин зүйл болсон юм. Энэхүү ББСБ-ын нийт системийн үндсэн үзүүлэлтэд эзлэх хувь өндөр учир тус салбарын илүү бодит өсөлтийг авч үзэхийн тулд Чингисхаан ББСБ-ын үзүүлэлтүүдийг оролцуулалгүй тооцож доор хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 3.

(тэрбум төг.)

	2001 оны 1дүгээр улиралд	2001 оны эцэст	Өсөлт (%)	2002 оны эцэст	Өсөлт (%)
Нийт актив	5.2	8.4	62.5	12.5	47.6
Нийт зээл	1.8	3.1	70.2	6.3	104.3
Чанаргүй зээл	0.0	0.0	15.2	0.4	1005.3
Өөрийн хөрөнгө	1.9	6.1	229.2	8.6	39.5
Орлого	0.55	0.9	69.2	2.2	131.2
Зарлага	0.61	0.8	33.9	1.5	88.5
Ашиг/алдагдал	-0.1	0.1	294.9	0.6	434.8

Энэ хүснэгтээс харахад чанаргүй зээлийн хэмжээ 2001 оноос 2002 онд 10 дахин өсч, 0.4 тэрбум төгрөгт хүрсэн нь анхаарал татаж байна. 2001 оны байдлаар чанаргүй зээлийн 50.8 хувь нь хугацаа хэтэрсэн зээл,

49.2 хувь нь хэвийн бус зээл байсан бол 2002 онд үүний 28.5 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 24.3 нь хэвийн бус зээл, 40.5 хувь нь эргэлзээтэй зээл, 6.7 хувь нь муу зээл байна. Энэ нь дээр дурьдсанчлан байгуулагдсан эхний үед олгосон зээлийн эргэн төлөлтийн хугацаа болж байгаагаас үүдсэн байж болох бөгөөд иймд эрсдэлээ тооцон, зээлийн зөв бодлого явуулахад анхаарах хэрэгтэй болов уу.

ББСБ-ыг хөдөөд байгуулах асуудлыг дэмжих бодлогын хүрээнд шинээр байгуулагдаж байгаа ББСБ-ын дүрмийн санг байршлаас шалтгаалан ялгаатай тогтоосон хэдий ч хөдөөд үйл ажиллагаагаа явуулж байгаа ББСБ-ын тоо чамлалттай байна. 2002 оны 2 дугаар сард хот, хөдөөгийн зээлдэгчдийн дунд явуулсан санал асуулгын² дүнгээс харахад судалгаанд оролцогчдын ердөө 6.6 хувь нь зээлийн эх үүсвэрээ ББСБ-аас авдаг гэсэн байхад 10.2 хувь нь танил тал, найз нөхөд, хувь хүнээс зээл авдаг гэж хариулсан байгаа нь ББСБ цаашид өргөжин тэлж, санхүүгийн зуучлалаа улам бүр гүнзгийрүүлэх боломжтойг илтгэж байна. 2002 оны

² Н. Амар, Г. Ариунхишиг. "Банкны зээлдэгчдийн дунд явуулсан санал асуулга, судалгааны ажлын дүн"

эцсийн байдлаар ББСБ-ын ашигт ажиллагааг тодорхойлох активын өгөөж (ROA) нь 3 хувь ба өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) нь 5 хувьтай байна.

Хүснэгт 4. ББСБ-ын үндсэн үзүүлэлтүүдийг банкуудын адилтгах үзүүлэлтэд харьцуулсан байдал (хувиар)

	2001 оны 1дүгээр улиралд	2001 оны эцэст	Өсөлт (нэгж)	2002 оны эцэст	Өсөлт (нэгж)
Нийт актив	2.1	7.0	4.9	8.9	1.9
Нийт зээл	2.3	9.8	7.5	15.6	5.8
Цэвэр зээл	2.6	10.2	7.6	16.0	5.8
Чанаргүй зээл	0.2	0.4	0.1	2.5	2.2
Өөрийн хөрөнгө	6.7	42.9	36.2	42.0	-0.9
Орлого	5.8	2.3	-3.4	5.3	2.9
Зарлага	9.2	2.6	-6.6	4.4	1.8
Ашиг/алдагдал	-	1.2	-	11.0	9.9

ББСБ-аас олгосон зээл нь 2001 оны эхний улирлын байдлаар банкуудын олгосон зээлийн 2.3 хувь байсан ба үүнээс хойш тогтмол өсөж 2001 оны эцэст 9.8 хувь, 2002 оны эцэст 15.6 хувь болжээ. Зээлжүүлэлтэд ББСБ-ын оруулах хувь

нэмэр нэмэгдэхийн хирээр зээлийн бодлогоо оновчтой явуулж, эрсдэлээ зөв тооцох зайлшгүй шаардлагатай. Харин өөрийн хөрөнгийн огцом өсөлтийг мөн л Чингисхаан ББСБ-ын үйл ажиллагаа явуулж эхэлсэнтэй холбон тайлбарлаж болно. 2001 оны эцсийн байдлаар харуулсан орлого ба зарлагын харьцаа 2001 оны эхний улирлаас буурсан нь банкууд дахь хадгаламж ба олгосон зээлийн хэмжээ эрс ихэссэнтэй холбоотой.

Дээрх хэсгүүдээс харахад сүүлийн жилүүдэд банкууд болон ББСБ-ын үйл ажиллагаа сайжирч, санхүүгийн зуучлал гүнзгийрч байгаа нь харагдаж байна. Хэдийгээр ББСБ үйл ажиллагаа эрхлээд удаагүй, ердөө 3 жил гаруйхан болж байгаа ч жижиг, дунд бизнес эрхлэгчдийг зээлээр хангахад оруулах хувь нэмэр нь жилээс жилд нэмэгдсээр байна. Гэвч орон нутагт үйл ажиллагааг явуулж буй ББСБ-уудын тоо хэт цөөн, ББСБ-ын болон уг байгууллагын үйл ажиллагааны талаар мэдээлэл хомс зэргээс иргэд, жижиг болон дунд бизнес эрхлэгчид зээлийн хэрэгцээгээ танил тал, найз нөхдөөсөө зээлэх замаар хангаж байгааг анхаарах хэрэгтэй байна. Мөн үйл ажиллагаа явуулах эрх авсан ББСБ-уудын ихэнх нь зээл олгох үйлчилгээ үзүүлж байгаа ба тэдгээрийн олгосон зээлийн хэмжээ ихсэж санхүүгийн секторт эзлэх байр суурь өргөжихийн хэрээр тэдний эрсдэл тодорхой хэмжээгээр нэмэгдэж байгаа билээ. Иймд ББСБ-д тавих хяналт шалгалтаа зөвхөн улирал тутам тайлан тэнцэл авсанаар хязгаарлалгүйгээр, зээлийн эрсдэлээ зөв тооцож, зээлийн зөв бодлого баримталж, үйл ажиллагаагаа хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр үнэн зөв цацаж байгаа эсэхэд анхаарч, энэ чиглэлд тавих хяналт шалгалтаа чангатгах хэрэгтэй байна.

Монгол банкнаас ББСБ-ын дүрмийн санг тогтоохдоо хот суурин газарт 100.0 сая, хөдөөд 1.0 сая төгрөг гэж тогтоосон, шинээр 2002 оны 12 дугаар сард "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай" хууль батлагдсан, ББСБ-д банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, цуцлах, хяналт тавих журмыг шинэчлэн боловсруулсан зэрэг хүчин зүйлс нь ББСБ-ын үйл ажиллагаа явуулах хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлж, дээр дурьдсан хүндрэлүүдийг арилгаж, санхүүгийн зуучлалд оруулах хувь нэмрийг улам бүр нэмэгдүүлэхэд түлхэц болно гэж дүгнэж байна.

Эх үүсвэр: www.mongolbank.mn

Болзошгүй эрсдэлийн нийт зардал (зээлийн, авлагын болон өмчлөх бусад үндсэн хөрөнгийн) 240.5 сая төгрөг буюу нийт зардлын 8.0 орчим хувийг, боловсон хүчний холбогдолтой зардал 491.9 сая төгрөг буюу 16.6 хувийг, үйл ажиллагааны бусад зардал 1031.3 сая төгрөг буюу 34.9 хувийг, татварын зардал 241.5 сая төгрөг буюу 8.2 хувийг тус тус эзэлж байна.

Мөнгөн хөрөнгө нийт активын 24.0 хувийг эзэлж байгаа нь ББСБ-уудын ашгийн түвшинд тодорхой хэмжээгээр сөргөөр нөлөөлж байгаа бөгөөд сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд (Монголбанкны үнэт цаас г.м) байршуулах боломжийг судлах хэрэгтэй байна.

Цаашид ББСБ-уудын нягтлан бодох бүртгэлийг сайжруулах, программ хангамжийн асуудлыг цогц хэлбэрээр шийдэх, Монголбанкнаас баталж гаргасан заавар журмуудаар эдийн засагч, нягтлан бодогч нарт зориулсан сургалт семинарыг жилд хоёроос доошгүй удаа тогтмол зохион байгуулж, боловсон хүчний чадварыг дээшлүүлэх шаардлагатай байгааг анхаарах нь зүйтэй байна.



ТӨВ БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Ы
АГАА

МОНГОЛБАНКНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Тайлант онд Монголбанк макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалж, үнэ ханшийн тогтворжилтыг бататган, санхүүгийн салбарт хийх бүтцийн өөрчлөлтийг үргэлжлүүлэх замаар тус салбарын сэргэлтийг гүнзгийрүүлэх, гадаад валютын нөөцийг зөв зохистой байршуулах, өсөлтийг хангахад анхаарч ажиллав.

5.1. Мөнгөний бодлого

Нөөц мөнгө

Тайлант онд нөөц мөнгө оны эхнээс 14.5 хувь буюу 25.5 тэрбум төгрөгөөр өсч 200.8 тэрбум төгрөгт хүрчээ. Нөөц мөнгөний өөрчлөлтийг бүтцээр нь авч үзвэл банкнаас гадуурхи мөнгөний өсөлт 42.0 хувь, банкуудын нөөцийн өсөлт 58.0 хувийг тус тус эзэлж байна. Банкнаас гадуурхи мөнгөний нөөц мөнгөнд эзлэх хувийн жин 1996 оноос хойш буюу сүүлийн найман жилийн туршид байнга буурч тайлант онд 65.5 хувьд хүрчээ. Банкнаас гадуурхи мөнгөний өсөлт буурахын хирээр банкуудын нөөцийн өсөлт нэмэгдэж, тайлант оны эцсээр нөөц мөнгөний 34.5

ШИГТГЭЭ 12. МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХЭРЭГСЛҮҮДИЙН ХӨГЖИЛ

Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд Монголбанкны үндсэн зорилт нь “төгрөгийн тогтвортой байдлыг хангах” гээд, зорилтод хүрэх үүднээс явуулах үйл ажиллагааны чиглэлийн нэг цөм бол “мөнгөний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх” гэж заажээ. Цааш нь бодлого хэрэгжүүлэх хэрэгслүүдийг тогтоож өгсөн байна. Ийнхүү хуулийн хүрээнд тодорхойлогдсон мөнгөний бодлогын хэрэгслүүд нь заавал байлгах нөөцийн хувь, хэмжээг тогтоох; банкинд олгох зээлийн хэмжээг тогтоох; Монголбанкны зээл, үнэт цаасны хүү болон хямдруулалтын хувиар дамжуулж хүүний нэгдсэн бодлого явуулах; нээлттэй захын үйл ажиллагаа явуулах; банкнаас олгох зээлийн үлдэгдэлд хязгаарлалт хийх зэрэг болно. Монголбанк төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэгч байгууллага болохын хувьд тухайн жилд хэрэгжүүлэхээр батлан гаргасан Төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн дагуу бодлого хэрэгжүүлэхдээ эдгээр хэрэгслүүдээс бие даасан сонголт хийдэг. Хуульчлан баталсан хэрэгслүүд нь жил бүр бүгд нэгэн зэрэг хэрэглэгдэхгүй бөгөөд тэдгээрийг зорилгод нийцтэй байдлаар хослуулан хэрэглэх, хослолын нийлэмж нь нийтдээ үр өгөөжтэй байх зэрэг нь мэргэжлийн хүрээнд хийгдэх ажил болно.

Чухам ямар хэрэгслийг хэзээ илүүтэй хэрэглэх талаар нэгдсэн жор байдаггүй ч бодлогын хэрэгслүүдийн зохимжтой хослолыг олох талаар санал нэгдсэн үзэл байж болно. Хуульчлан тогтоосон бодлогын хэрэгслүүд нь Монголбанкны явуулах үйл ажиллагааны хүрээг тогтоох тал дээр илүү анхаарсан байхад тухайн жилийн төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлд тусгагдсан зорилтыг хангахад зориулагдсан бодлогын арга хэмжээ нь зах зээлийн тухайн нөхцөл байдлаас шалтгаалан тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл, бодлогын хэрэгслүүд нь бүгд нэг чиглэлд үйлчилдэггүй учраас мөн түүнчлэн бүгд сайн муу аль аль талын үр дагавартай байдаг тул ямар хэрэгсэл хэрэглэхийг урьдчилан таамаглах боломж хязгаарлагдмал юм. Ерөнхийдөө, мөнгөний бодлогын хэрэгслүүдийг шууд, шууд бус гэсэн хоёр бүлэгт хуваадаг. Шууд хэрэгслүүд нь захиргааны арга хэмжээнд тулгуурласан норматив шинжтэй байхад шууд бус хэрэгсэл нь зах зээлийн механизмыг бодлогын зорилгод чиглүүлэн өдөөх хэлбэртэй. Шууд хэрэгслүүд нь санамсаргүй муу үр дагавар их үлдээдэг бол шууд бус нь урт хугацаанд санаа зоволтгүй хэрэглэж болдог сайн талтай. Заавал байлгах нөөц тогтоон хяналт тавьж, биелүүлээгүй бол шийтгэл хүлээлгэх; банкинд Монголбанкнаас олгох эсвэл банкны иргэд, аж ахуйн нэгжид олгох зээлд дээд хэмжээ тогтоох; аливаа төрлийн хүүний түвшинг хязгаарлах зэрэг нь шууд хэрэгслийн жишээ. Банк хоорондын зах дээр зарагдах үнэт цаас Монголбанкнаас эрхлэн гаргах, банкны зарим активыг худалдаж авах, эргүүлэн зарах зэрэг нээлттэй захын үйл ажиллагаа гэж нэрлэгдэх хэрэгслүүд нь зах зээлийн механизмд тулгуурлан хийгдэх учраас шууд бус хэрэгсэл болно.

Шууд хэрэгслүүдийн сайн тал нь богино хугацаанд хүчтэй нөлөөлөх чадвартай. Гэхдээ ийнхүү богино хугацаанд захиргааны арга хэмжээнд тулгуурлан хүчтэй нөлөөлж байгаа нь өөрөө бусад бүх муу үр дагаврын үндэс болно. Шууд хэрэгслүүдийг хэрэглэх явцад санхүүгийн зуучлагчийн ашигт ажиллагаанд саад хийдэг учраас 1) санхүүгийн зуучлалын өртөг өсөх, 2) банк хоорондын зах, цаашилбал мөнгөний захын бүтцийг эвдэн эцэстээ ашигтай ажиллагааг захиргааны аргаар хуваарилах болдог. Эдгээр муу үр дагавар даамжирвал

зах зээлийн зохион байгуулалтыг гажуудуулан бодлого хэрэгжүүлэгч нь бодлогын зорилгодоо бус харин ашгийн төлөө үйлчлэх орон зай бий болгоно. Үүнтэй харьцуулахад шууд бус хэрэгсэл нь хавьгүй сайн үр дагавартай. Гэхдээ шууд бус хэрэгслийн сул тал нь санхүүгийн дэд бүтцээс хэтэрхий хамааралтай, бодлогын үр дагавар тодорхой бус байдаг явдал юм. Ямартай ч шууд хэрэгсэл нь муу үр дагавартай болох нь тодорхой учраас бололцоо байвал шууд бус хэрэгслийг түлхүү хэрэглэх нь зохистой.

Шууд бус хэрэгслүүд нь банкуудын ашигт ажиллагаанд нөлөөлдөг учраас банкууд Монголбанкны тавьж буй нөхцөлийг тооцоолоод өөрийн ажиллагааг зохицуулж мөнгөн нөөцөө удирдана. Монголбанк банк хоорондын захын хамгийн хүчтэй оролцогч тул эдгээр хэрэгслүүдээрээ дамжуулан банк хоорондын захын хэмжээ, үнэд нөлөөлөх чадвартай бөгөөд эдгээр нөлөөлөл нь төрийн мөнгөний бодлогын зорилтыг хангахад чиглэгдсэн байх нь чухал юм. Гэхдээ шууд бус хэрэгслүүдийн үр дагавар нь банк хоорондын захын дэд бүтэц, түүний зохицуулалт зэргээс шалтгаалан тодорхой хугацааны дараа эдийн засагт нөлөөлнө. Өөрөөр хэлбэл, шууд бус хэрэгслийг хэрэглэх боломж нь банк, санхүүгийн системийн хөгжил; түүний эрх зүйн зохицуулалт; бодлого хэрэгжүүлэгчийн эрмэлзэл, бодлогын сонголт; нийгмийн сэтгэл зүй, ёс заншил зэргээс хамааран тодорхойлогдоно.

Өндөр хөгжилтэй санхүүгийн системийн үед шууд хэрэгслийг банк эсвэл санхүүгийн, эсвэл банк санхүүгийн хямрал болсон нөхцөлд хэрэглэх нь маш сайн үр дүн өгч байгааг сүүлийн жилийн хямралууд, ялангуяа 2001 оны Аргентины хямрал харуулсан.

Манай улсад эдийн засгийн зах зээлийн тогтолцоонд нийцсэн банкны систем үүсч эхэлж байсан жилүүдэд шууд хэрэгслүүдийг хэрэглэдэг байсан. 1995 он хүртэл заавал байлгах нөөцийн зохицуулалт хийх, банкуудаас аж ахуйн нэгжид олгох зээлийн хэмжээнд хязгаарлалт хийх нь бодлогын голлох хэрэгсэлд тооцогдож байсан бол 1997 хүртэл зээлийн хязгаар, банкуудын хадгаламжид төлөх хүүний доод хязгаар голлох үүрэгтэй болжээ. Эдгээр онуудад дээрх хязгаарлалтын зорилготой зөрчилдсөн шинжтэй зээлийн бодлого Монголбанкнаас баримталж байсан юм. Дээрх хязгаарлалтууд мөнгөний нийлүүлэлтийг огцом нэмэгдүүлэхээс сэргийлэх бодлогын сонирхолд чиглэгдэж байсан бол Монголбанкнаас банкуудад, заримдаа аж ахуйн нэгжүүдэд олгож байсан зээлүүд нь өмнөх зорилтоос эсрэг чиглэлд ажиллаж байв. Энэ бол бодлогын зорилт хоёрдмол шинжтэй болоход бодлогын хэрэгслүүдийн үзүүлэх нөлөөний сонгодог жишээ юм. 1997 оноос зээлийн бодлогыг эргэн харж шууд бус хэрэгслүүдийг түлхүү хэрэглэх зорилт дэвшүүлснээр банкуудын олгох зээлийн хязгаар, банкуудын хадгаламжийн хүүний доод түвшингийн зохицуулалт хэрэглэгдэхээ больж 1993 онд нэвтрүүлсэн Төв банкны үнэт цаасны хэмжээ голлох үүрэгтэй болсон. Банк өөрийн балансын бүтцээс хамаараад Төв банкны үнэт цаасны хүү өөрчлөгдсөн тохиолдолд шинээр олгох зээлийн хүүгээ өөрчлөх ёстой. Гэхдээ одоогоор Төв банкны үнэт цаасны олдоц илүү нөлөөтэй байгаа болно. Өөрөөр хэлбэл, Төв банкны үнэт цаас мэтийн төлбөр гүйцэтгэх чадвартай актив бага байгаа нөхцөлд илүүдэл нөөцийн хэмжээ өсч зээл нэмэгдүүлэх шаардлага их болж байна.

Нөгөө талаас, Монголбанкны зарж/авч байгаа гадаад валют, худалдан авч байгаа алтны хэмжээ нь дээрхи бодлогын хэрэгслүүдийн хажуугаар хүчтэй нөлөө үзүүлэгч болсоор байгаа юм. Монголбанкны эдгээр үйлдэл нь бодлогын хэрэгслүүдтэй нэгэн зорилгод нэгдэж чадах болоогүй байна. Алт худалдаж авах нь аливаа Төв банкны гүйцэтгэх ёстой уламжлалт үйлчилгээ биш бөгөөд манай орны хэрэглэж ирсэн онцлогтой холбоотой ажиллагаа. Одоогоор Монголбанк алт худалдаж авсан, гадаад валют авсны үр дүнг Төв банкны үнэт цаасаар дамжуулан арилгаж чадаж байгаа боловч цаашдаа энэ ажил нь тийм тогтвортой арга байх боломжгүй болж байгаа. Төв банкны үнэт цаасны хэмжээ ихээхэн хуримтлагдаж байгаатай үүнийг холбож үзэж байна. Нэг үгээр хэлэхэд, мөнгөний бодлогын хэрэгслүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, бодлогын хэрэгслүүдийн зохистой нэгдмэл хослолыг олох асуудлууд өмнөх жилүүдийн адил хурцаар тавигдсаар байгаа юм. Одоогийн Монголбанкны хэрэглэж буй хэрэгслүүдэд Төв банкны үнэт цаасны арилжаа, нээлттэй захын ажиллагаа, ялангуяа репо хэлцлүүд голлох үүрэг гүйцэтгэж байгаа. Харин алт, гадаад валют авах асуудал нь бодлогын зорилгын дор нэгдэж чадаагүй байгаа бөгөөд валютын ханш, алтны үйлдвэрлэлийн хуримтлалыг эдийн засгийн өсөлтөд ашиглах зорилгыг мөнгөний бодлогын зорилтоор хязгаарлах нийгмийн сэтгэл зүйн хөрс бүрэн бүрдээгүй, аль аль талын сонирхлыг хангасан бодлогын шийдлийн хувилбарууд тогтоогүй гэхэд болохоор байгаа юм.

Эцэст нь мөнгөний бодлогын хэрэгслүүд нь аливаа Төв банкны биеэ даасан байдлыг илтгэх хамгийн чухал цэг бөгөөд мөнгөний бодлогын зорилт ч бодлогын хэрэгслүүдтэй харьцуулахад биеэ даасан байх шаардлагын хувьд төдийлөн өндөр биш юм. Мөнгөний бодлого нь нийгэм эдийн засгийн хөгжлийг тогтвортой урт хугацаанд хангахад шаардлагатай цорын ганц макро бодлогын хувилбар биш харин ч төрийн сангийн бодлого, нийгмийн бодлогын хамт цогц болж байх учир макро эдийн засгийн бусад зорилттой нийцтэй байх нь зүйтэй. Өнөөгийн макро эдийн засгийг судалдаг онолчид, дэлхийн бусад орнуудын туршлагаас харахад мөнгөний бодлогыг бас нэг чухал үр дагавар байнгын анхаарлын төвд байсаар байна. Энэ нь мөнгөний бодлогыг буруу хэрэглэснээр эсвэл түүний шаардлагуудыг үл тоомсорлон бодлогын хэрэгслүүдийг макро эдийн засгийн бусад зорилтын шаардлагад захируулснаар мөнгө өөрөө нийгмийг тогтворгүйжүүлэгч онцгой хэрэгсэл болон хувирч асар их хөнөөлтэй хямралыг өдөөдөг асуудал юм. 90-ээд оны Албанийн, 2001 оны Аргентиний хямрал үүний жишээ. Харин Азийн, Оросын, Бразилийн хямралууд нь гадаадын хөрөнгө оруулалтыг бодлогогүй хэтэрхий урамшуулсантай холбоотой.

хувийг банкуудын нөөц эзэлж байв. Нөөц мөнгөний өсөлт өмнөх оныхоос 7.4 нэгжээр буурч 14.5 хувьд хүрчээ.

Сүүлийн найман жилийн үзүүлэлтээс харахад банкнаас гадуурхи мөнгөний улирлын хэлбэлзлийг даган нөөц мөнгө жилийн эхний гурван сард дундаж түвшнээсээ 6.0-10.7 хувиар доогуур, 4 дүгээр сард дундаж түвшнийхээ орчимд, 5-9 дүгээр саруудад дунджаасаа 3.5-8.3 хувиар өсч, оны сүүлийн гурван сард дунджийнхаа орчимд хэлбэлзэж байв. Банкнаас гадуурхи мөнгөний өсөлт буурахын хирээр нөөц мөнгөний улирлын хэлбэлзлийн далайц М1 болон М2-ын адилаар буурах хандлага ажиглагдаж байна. Харин банкуудын нөөцийн улирлын хэлбэлзлийн хандлага тогтворгүй байна.

Тайлант онд Монголбанк нийт 160.8 тэрбум төгрөгийн алт болон гадаад валют (цэвэр дүнгээр) худалдан авчээ. Мөнгөний нийлүүлэлтийн энэхүү өсөлтийг саармагжуулах үүднээс Монголбанк оны туршид сард дунджаар 44.8 тэрбум төгрөгийн ТБҮЦ банкуудад байршуулж байв. Монголбанк нөөц мөнгөний хөдөлгөөнийг оновчтой зохицуулах үүднээс банкны салбарын илүүдэл нөөцийн хэмжээг богино хугацаанд төлөвлөх ажлыг гүйцэтгэж эхэллээ. Цаашид нөөцийн богино хугацааны төлөвлөлтийг амжилттай хэрэгжүүлж, өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэхүйц болгон жигдрүүлэхэд шаардлагатай мэдээллийг зохих эх үүсвэрүүдээс тухай бүр хугацаа алдалгүй авах тогтвортой мэдээллийн сувгийг бий болгох шаардлагатай байна. Тухайлбал, Санхүү, эдийн засгийн яам (СЭЗЯ)-наас төсвийн дансны хүлээгдэж буй орлого, зарлагын мэдээг тогтмол богино хугацаанд хүлээн авах, Монголбанкны газар, хэлтсүүдийн хооронд мэдээлэл солилцох ажлыг тогтмолжуулах зэрэг нь чухал ач холбогдолтой юм.


Төв банкны үнэт цаас

Монголбанк нь эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлт, нөөц мөнгөний хэмжээг зохих түвшинд байлгах зорилгоор өөрийн үнэт цаасыг гаргаж, үнэт цаасны арилжааг дараахь хэлбэрээр явуулдаг. Үүнд:

Анхдагч захын үйл ажиллагаа

Монголбанк нь 2003 онд нийт 100 удаа ТБҮЦ-ны арилжаа явуулж 958.9 тэрбум төгрөгийн үнэт цаас борлуулав. Үүний 56.1 хувь буюу 537.5 тэрбум төгрөгийг 7 хоногийн хугацаатай, 22.5 хувь буюу 216.1 тэрбум төгрөгийг 14 хоногийн хугацаатай, 11.3 хувь буюу 108.1 тэрбум төгрөгийг 28 хоногийн хугацаатай, 6.8 хувь буюу 65 тэрбум төгрөгийг 91 хоногийн хугацаатай, үлдэх 3.4 хувь буюу 32.1 тэрбум төгрөгийг 1 болон 2 хоногийн хугацаатай үнэт цаасны тусгай арилжаагаар борлууллаа.


Зураг 33. Засварласан улирлын хэлбэлзлийн индексүүд



Зураг 34. Мөнгөний үржүүлэгч



Зураг 35. Заавал байлгах нөөцийн хүрэлцээ



ШИГТГЭЭ 13. МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТИЙН ЗАГВАР

Судалгааны ажлын зорилго нь нөөц мөнгөний өөрчлөлт мөнгөний агрегатуудад хэрхэн нөлөөлдгийг загварчлах, улмаар мөнгөний бодлогын хэрэгслүүдийн мөнгөний үзүүлэлтүүдэд нөлөөлөх нөлөөллийг тодорхойлох явдал юм.

Банкуудын татан төвлөрүүлсэн хөрөнгө тэдгээрийн өөрийн хөрөнгөөс хавьгүй хурдтай өсч байвал зохистой харьцааны шалгуурын дагуу банкууд мөнгөний үржүүлэгчийн хэмжээнээс бага хэмжээгээр зээлээ нэмэгдүүлнэ. Гадаад валютын эрсдэлийн харьцаа ч үүнтэй ижил төрлийн нөлөөг үзүүлдэг. Хэрэв мөнгөний үржүүлэгчийг мөнгөний нийлүүлэлт, нөөц мөнгөний харьцаа гэвэл тэр нь бодлогын хэрэгслүүдийн өөрчлөлт, мөнгөний эрэлт, санхүүгийн зах зээл, хүлээлтээс хамааран өөрчлөгддөг. Үнэндээ эдгээр гадаад орчны өөрчлөлтүүдийг үржүүлэгчийн хуваарь, хүртвэр дэх хувьсагчид ялгаатай тусгаж авдаг. Нөгөөтэйгүүр, мөнгөний бодлогын хэрэгслүүд болон бусад шалтгаанаар нөөц мөнгө өөрчлөгдөхөд мөнгөний агрегатуудад харилцан адилгүй нөлөө үзүүлдэг тул үржүүлэгчийн өөрчлөлтөөр үүнийг салган харах боломжгүй юм. Иймд нөөц мөнгөний өсөлт мөнгөний агрегатуудад хэрхэн тархаж байгааг загварчилснаар үржүүлэгчийг шууд загварчилсантай адил үр дүнд хүрч болох юм.

Нөөц мөнгө нь банкнаас гадуурхи мөнгө, банкуудын нөөцийн нийлбэр бөгөөд Төв банкны хураангуйлсан тэнцлийн гадаад, дотоод цэвэр активтай тэнцэнэ. Нөөц мөнгөний хэмжээ нь Монголбанк (МБ)-ны банк хоорондын зах дээр шууд хийж буй хэлцлүүдийн дүнд эсвэл Засгийн газар (ЗГ)-ын дансны өөрчлөлт, олон улсын гэрээний нөхцлөөс шалтгаалан өөрчлөгдөж болно. Шууд хэлцлүүдийн хэмжээг Монголбанк бүрэн удирдах бололцоотой бол Засгийн газрын дансны өөрчлөлт, олон улсын санхүүгийн байгууллагуудаас авсан зээл зэргээс хамааран гарч буй өөрчлөлтийг удирдах боломж хязгаарлагдмал юм.

Нөөц мөнгөний хэмжээг Монголбанк удирдаж болох ч түүний бүтэц нь банкууд, бизнесийн салбар, иргэд (нийтэд нь банкны харилцагчид)-ийн сонирхлоос хамаардаг. Мөнгөн хөрөнгөө бэлэн мөнгөөр байлгах уу эсвэл банкинд байршуулах уу гэдгийг банкны бус сектор, харин хэдий хэмжээний бэлэн бус нөөц байлгахыг банкууд шийдвэрлэнэ. Нөөц мөнгө өөрчлөгдөхөд банк хоорондын захын хүү болон зах зээлийн бусад нөхцөл өөрчлөгдөнө. Банк нь дотоод эсвэл гадаад цэвэр активаа нэмэгдүүлэх хоёр төрлийн байнгын дарамтанд ажилладаг. Энэ нь i) нөөц мөнгөний өсөлтөөр төв банк мөнгөний захын хэмжээг тэлэх, ii) татан төвлөрүүлсэн хөрөнгө нэмэгдэж банкны нөөц нэмэгдэх зэрэг болно. Нөөц мөнгө нэмэгдсэнээс шалтгаалан банкууд харилцагчидтайгаа валютын арилжаа хийх (гадаад цэвэр активаа өсгөх), зээл олгох (дотоод цэвэр активаа өсгөх) эрмэлзэлтэй болно. Хэрэв зээл олгохгүй эсвэл банкны системийн дотоод, гадаад цэвэр активын харьцаа өөрчлөгдөхгүй бол нөөц мөнгөний өсөлт нь банкуудын илүүдэл нөөцийг нэмэгдүүлнэ. Зээл олгосон бол мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ. Банкуудын шийдвэр эхний ээлжид хөрөнгийн багцын зохицуулалт, дараа нь харилцагчдын эрэлтэд нийцсэн зээлийн өөрчлөлт байна.

Төрийн сангийн нэгдсэн данс (ТСНД)-д орлого ороход мөнгөний хэмжээ буурч, ТСНД-аас төлбөр хийгдсэн үед өснө. ТСНД-ны өөрчлөлтийг мөнгөний нийлүүлэлтэд нөлөөлөх, нөлөөлөхгүй гэсэн хоёр хэсэгт хуваагаад нөлөөлөх хэсэгт тохирох хувьсагчийг тодорхойлж CG нэрээр загварт оруулсан. Нөгөө талаас ЗГ нь гадаад төлбөр гүйцэтгэх зэрэг шаардлагаар МБ-тай гадаад валютын арилжаанд орж болох бөгөөд энэ нь мөнгөний нийлүүлэлтэд нөлөөлж болохыг мөн орууллаа.

Харилцагчдын эзэмших хөрөнгийн бүтцийн шийдвэр нь тэдний орлогын өсөлт, хөрөнгийн багцад төлөгдөж буй хүү, үүнтэй жиших бусад орлогын өөрчлөлтөөс хамаарна. МБ алт олборлогдсоос алт худалдан авснаар, эсвэл банкууд зээл олгосноор харилцагчдын эзэмшиж буй мөнгөн хөрөнгө нэмэгдэнэ. Эхнийх нь нөөц мөнгөний өсөлтөөр шууд нэмэгдэж буй мөнгөний нийлүүлэлт. Дараагийнх нь шууд бус замаар (мөнгөний үржүүлэгчээр) мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлж байгаа хэлбэр юм.

Монголбанкнаас үүсгэсэн мөнгө нь төв банк дахь банкуудын дансдыг нэмэгдүүлэн илүүдэл нөөцийг өсгөөд банкны системээс бодит секторт олгосон зээлийн өрийн үлдэгдлийг нэмэгдүүлнэ. Тэгвэл нөөц мөнгөний өсөлт нь илүүдэл нөөц, банкнаас гадуурхи мөнгө, банкууд дахь харилцах дансдын үлдэгдлийг нэмэгдүүлнэ. Алт худалдан авснаар нөөц мөнгө нэмэгдэх нь шууд банкууд дахь харилцах дансдын үлдэгдлийг нэмэгдүүлдэг бол бусад тохиолдолд зээлийн өсөлт гол үүрэг гүйцэтгэнэ.

Өмнө дурдсан мөнгө банкны систем руу орох-гарах мөнгөний урсгалыг илэрхийлэх тэгшитгэлийг тодорхойлж, 1997/12-2003/12 саруудын мэдээллийг ашиглан загварыг үнэлэн дор үзүүлэв.

$$\begin{aligned} rr_t &= 0.30(dd_{t-1} + td_{t-1}) + 0.00002T^2 + 0.17D1 + 0.62rr_{t-1} \\ re_t &= 4.08 + 0.25cbb - 0.68cbbre_t + 0.71l_{t-1} - 4.41(s_t - s_{t-6}) - 0.05fx_t + 0.01au_t - \\ &- 7.44D3 + 0.09re_{t-1} + 0.13re_{t-5} + 0.51ar_t \\ fr_t &= -0.04(cbb_{t-1} - libor_{t-1}) + 4.65? s_{t+1} - 1.60D3 + 0.91fd_t - 0.12fr_{t-1} + 0.23q3 + 0.31D9 - \\ &- 0.36D10 + 0.82ar_t \\ td_t &= 1.76 + 0.005T + 0.1dd_{t-1} - 0.08cr_t - 0.01DEPR_{t-1} + 0.31? s_{t+1} + 0.44td_{t-1} + 0.39td_{t-6} - 0.75ar_t \\ fd_t &= -0.11t + 0.0002T^2 + 0.13cr_{t-2} + 0.80s_t + 0.50fd_{t-1} - 0.12fd_{t-6} \\ cr_t &= 0.03cbbre_t - 0.002T - 0.01DEPR_t - 0.07dd_{t-1} + 0.86m0_t + 0.01lq_t + 0.01fx_t + 0.02Q4 + \\ &+ 0.05Q2 + 0.04Q3 + 0.08D6 - 0.09D8 + 0.18cr_{t-1} \\ dd_t &= 1.11 + 0.15cbb_{t-1} + 0.22l_t + 0.003? au_t + 0.03re_t - 0.01lq_t + 0.5dd_{t-1} \\ l_t &= 0.05y_{t-5} - 0.006loanr_t + 0.97l_{t-1} - 0.08D2 - 0.24D7 + 0.28ar_{t-2} \end{aligned}$$

энд: rr_t -заавал байлгах нөөцийн хэмжээ, dd_t -банкуудын төгрөгийн харилцах дансны үлдэгдэл, td_t -банкуудын төгрөгийн хугацаатай хадгаламжийн үлдэгдэл, re_t -банкуудын илүүдэл нөөц, cbb_t -ТБҮЦ, $cbbre_t$ -ТБҮЦ-ны жигнэсэн дундаж хүү, l_t -зээлийн өрийн үлдэгдэл, s_t -төгрөгийн ам.доллартай харьцах спот ханш, fx_t -МБ-аас гадаад валютын зах дээр хийсэн цэвэр интервенцийн хэмжээ, au_t -МБ-ны алт олборлогч аж ахуйн нэгжүүдээс төгрөгөөр худалдаж авсан алтны үнийн дүн, fr_t -МБ дахь банкуудын валютын харилцах болон хадгаламж, $libor_t$ -Лондонгийн банк хоорондын захын хүү, fd_t -банкуудын гадаад валютын нөөц, cr_t -банкнаас гадуурхи мөнгө, $DEPR_t$ -банкуудын хугацаатай хадгаламжийн хүүгийн энгийн дундаж, $m0_t$ -нөөц мөнгө, lq_t -МБ-аас гаргаж буй мөнгө, y_t -тооцоолсон бодит сарын ДНБ, $loanr_t$ -банкуудын тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү, Q_t -улирлын дамми хувьсагч, D_t -улирлын бус дамми хувьсагчид.

Системийн үнэлгээнээс ТБҮЦ-ны хүү болон хэмжээ банкуудын илүүдэл нөөцөд харилцан эсрэг тэсрэг сулавтар нөлөөллийг үзүүлдэг бол төгрөгийн ам.доллартай харьцах ханшны сүүлийн 6-н сарын өөрчлөлт банкуудын илүүдэл нөөцийн удирдлагад хамгийн хүчтэй нөлөө үзүүлдэг нь харагдаж байна. Банкуудын МБ дахь валютын харилцах болон хадгаламжинд валют хуримтлуулах шийдвэрт богино хугацааны буюу ирэх сарын төгрөгийн ам.доллартай харьцах ханшны хүлээлт хамгийн нөлөөтэй байдаг байна. Төгрөгийн болон валютын хадгаламжинд тухайн сарын төгрөгийн ам.доллартай харьцах ханш хамгийн их сөрөг болон эерэг нөлөө үзүүлдэг болохыг үнэлгээний үр дүнгээс харж болно.

Харин МБ-ны гадаад валютын арилжаа болон МБ-аас худалдан авсан алтны хэмжээгээр нөөц мөнгийг нэмэгдүүлж, үржүүлэгчээр дамжин мөнгөний нийлүүлэлтэд нөлөөлдгийг загварын үнэлгээ харууллаа. Монголбанкны худалдаж авсан цэвэр гадаад валютын дүнгээр банкнаас гадуурхи мөнгө болон илүүдэл нөөцийг нэмэгдүүлэн, улмаар нөөц мөнгө, мөнгөний нийлүүлэлтийг өсгөдөг. Харин алт худалдан авсны үр дагаварт мөнгөний үзүүлэлтүүдэд гарах нөлөө ийм үр дүнтэй илэрч байгаа нь томоохон алт олборлогчид ирээдүйн орлогоо зээл, урьдчилгаа зэргээр явагдаж буй үйлдвэрлэлийг санхүүжүүлэхэд зарцуулдгаас хамаарч байж болох юм.

Нөөц мөнгийг удирдахад ТБҮЦ-ны хэмжээ хангалттай үр дүн өгөхгүй гэж дүгнэлээ. Энэ нь дараахь хэдэн шалтгаантай байж болох юм. Банкны бүтцийн өөрчлөлтийн эхний жилүүдэд банкуудын активын бүтцийг сайжруулах үүднээс илүүдэл нөөцийн хэмжээнд бараг тулал нь ТБҮЦ худалддаг байсан практик нөлөөлжээ. Нөгөөтэйгүүр гадаад валют, алт худалдан авах хэмжээ үнэт цаастай харьцуулахад их тул ТБҮЦ-ын дорвитой нөлөөлөх боломжийг хааж байна. Эцэст нь банкны бүтцийн өөрчлөлтийн дүнд банкуудын татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ эрс өсч, активт илүүдэл хөрөнгийн хэмжээ хуримтлагдан ТБҮЦ-ны өөрчлөлтийн нөлөөг дамжуулах хүчийг сулруулж байна.

Банкуудын нөөцийн хэмжээ валют ханш, хүүний өөрчлөлтийг илүү мэдэрч байна. Үүнд долларжилт өөрийн хувь нэмрийг оруулсан байж болно. Өөрөөр хэлбэл, Төв банкнаас мөнгөний нийлүүлэлтийг илүү бүтээлчээр удирдахад гадаад валютыг гүйлгээнд хэрэглэх хэмжээг багасгахад чиглэгдсэн ажил хийх шаардлагатай болохыг илэрхийлж байна.

Мөн мөнгөний бодлогын үр нөлөөг таамаглах бололцоог нэмэгдүүлэхэд мөнгөний захын хөгжлийг түргэтгэх нь том хувь нэмэр оруулах юм. Мөнгөний захын хөгжил нь хөрөнгийн уян хатан, зохистой байршилтыг түргэтгэн, эдийн засагт нэмэгдэж буй мөнгийг илүү үр ашигтайгаар бодит үйлдвэрлэлд зарцуулах боломжийг нэмэгдүүлдэг.

Эцэст нь тэмдэглэхэд манай улсын эдийн засаг тогтворжиж, санхүүгийн зуучлал гүнзгийрэн, банкуудын үйл ажиллагаа тогтмолжихийн хирээр манай бодит болон мөнгө, санхүүгийн үзүүлэлтүүдийн бүтцийн өөрчлөлтийн нөлөөнүүд багасан загварын үнэлгээг цаашид сайжруулах нь дамжиггүй билээ. Иймд энэхүү загварыг үргэлжлүүлэн тооцоолж, Монголын эдийн засгийн мөнгөний талыг загварчлах ажлыг улам бүр сайжруулах нь зүйтэй юм.

Тайлант оны 12 дугаар сарын эцэст Монголбанкнаас худалдсан үнэт цаасны хэмжээ өмнөх сарынхаас 1.4 дахин, өмнөх оны мөн үеэс 1.2 дахин нэмэгдэж 76.0 тэрбум төгрөг болжээ.

Тайлант оны туршид банкууд өдөрт дунджаар 42.4 тэрбум төгрөгийн ТБҮЦ-ны үлдэгдэлтэй байлаа. Нийт ТБҮЦ-ны өдрийн дундаж үлдэгдлийн 84 гаруй хувийг ХХ, Хадгаламж, Голомт, Монгол шуудан, ХААН, Интер банкууд эзэмшиж байсан бол үлдэх 16 орчим хувь нь бусад банкуудад ноогдож байна.

ТБҮЦ-ны жигнэсэн дундаж хүү оны эцсийн байдлаар 11.5 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үеийн дундаж хэмжээнээс 1.5 нэгжээр дээгүүр байна. Тайлант онд ТБҮЦ-ны хүүнд нийт 4.6 тэрбум төгрөг төлсөн байна.

Хоёрдогч захын үйл ажиллагаа

2003 оны туршид ТБҮЦ-ны хоёрдогч зах дээр нийт 275 удаа арилжаа явагдаж 284.2 тэрбум төгрөгийн ТБҮЦ-ыг банкууд хоорондоо худалдах болон худалдаж авах, мөн репо нөхцөлөөр худалдах болон худалдаж авах арилжаа хийжээ. Үүний 27.7 хувь буюу 78.7 тэрбум төгрөг нь ТБҮЦ-ны хоёрдогч захын арилжаа байгаа бол 72.3 хувь буюу 205.5 тэрбум төгрөг нь репо нөхцөлтэй арилжаа байлаа.

ХХ, Хадгаламж, ХААН, Монгол шуудан, Голомт банкууд банк хоорондын зах дээр худалдсан болон худалдаж авсан ТБҮЦ-ны нийт хэмжээний 84 гаруй хувийг эзэлж байгаа бол бусад банкуудад 16 орчим хувь ноогдож байна.


ХААН, ХХ, Хадгаламж, Монгол шуудан, Голомт банкууд репо хэлцлээр ТБҮЦ худалдсан, худалдаж авсан нийт үнийн дүнгийн 84 орчим хувийг эзэлж байгаа бол Анод, Интер, Капитрон, Зоос, Улаанбаатар хотын, Капитал, Хас, Кредит зэрэг банкууд 16 гаруй хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл, эдгээр банкууд өөрийн илүүдэл нөөцийг үр ашигтай хэлбэрт байршуулах буюу түр зуурын эх үүсвэрийн дутагдлаа нөхөх зорилготой арилжааг шуурхай хийж иржээ.

Мөн банкууд банк хоорондын зах дээр 12.8 тэрбум төгрөгийн ТБҮЦ-ыг барьцаалан 7 удаа нийт 9.2 сая ам. долларын хадгаламжийн гэрээ хийсэн байна.


Заавал байлгах нөөцийн талаар

Банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дээшлүүлэх, харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Монголбанк нь банкуудад бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн тодорхой хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг заавал байлгах нөөцөд төвлөрүүлэх шаардлага тавин өдөр бүр хангалтыг нь хянан ажиллаж байна.


Зураг 36. Банкуудын репо хэлцлээр худалдсан болон худалдан авсан ТБҮЦ



Зураг 37. Хоёрдогч зах дээр худалдсан болон худалдан авсан ТБҮЦ



Зураг 38. Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү



ШИГТГЭЭ 14. БАНК ХООРОНДЫН ЗАХЫН ИЛҮҮДЭЛ НӨӨЦ

2000 оны сүүлээс эхлэн 2003 оны эхэн хүртэл банкны системийн хэмжээгээр илүүдэл нөөцийн хуримтлал өсөн нэмэгдэж байсан нь зөвхөн бодлого боловсруулагчид болон судлаачид төдийгүй зарим гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг зүй ёсоор татаж байсан юм.

Тодорхойгүй байдлыг арилгах боломжит бусад хөрөнгийн хэлбэр байхгүй тохиолдолд илүүдэл нөөцийн хуримтлал нь зайлшгүй шаардлагатай болдог. Өөрөөр хэлбэл, банкууд төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа хангах эсвэл хүүний түвшин үнэт цаасны брокерын шимтгэлээс бага тул алдагдалтай үйл ажиллагаа явуулж байгаагаас илүүдэл нөөцийг хуримтлуулах эрмэлзэлтэй байж болно. Энэ нь нөгөө талаас хадгаламж эзэмшигчдэд банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлэх дохио болдог.

Харин хадгаламж, зээлийн өөрчлөлтийн тодорхойгүй байдал болон бусад гадаад хүчин зүйлсийг тодорхой хэмжээнд хянасны дараа бэлэн байгаа илүүдэл нөөцийг зорилтод түвшинд хүргэхэд гарах дотоод зардал харьцангуй өндөр байгаагаас илүүдэл нөөцийн хүсээгүй хуримтлал бий болдог гэжээ.

Дээрх хоёр тайлбар нь зөвхөн банкуудын илүүдэл нөөцийн удирдлагын эсрэг, тэсрэг хандлагыг харуулаад зогсохгүй, мөнгөний бодлого тэдгээрээс хамааран эсрэг, тэсрэг нөлөө үзүүлэхийг харуулдаг байна. Өнөөгийн мөнгөний бодлогын стандарт процессоор хэрэв илүүдэл нөөцийн хуримтлалыг банкууд хүссэн бол мөнгөний тэлэх бодлого нь мөнгөний нийлүүлэлтэд хүчтэй нөлөөлж нэмэгдүүлдэг. Харин илүүдэл нөөцийн хуримтлалыг хүсээгүй бол мөнгөний тэлэх бодлого нь мөнгөний нийлүүлэлтэд сулавтар нөлөө үзүүлэх бөгөөд нөөц мөнгийг хүчтэй нэмэгдүүлэн улмаар мөнгөний үржүүлэгчийг бууруулдаг байна.

Судалгааны ажлын зорилго нь илүүдэл нөөцийн хуримтлалын шалтгаан болон энэ нь мөнгөний бодлогод хэрхэн нөлөөлж буйг тодруулахыг энэхүү судалгааны ажлын хүрээнд тавьсан болно. Илүүдэл нөөц ашиглагдахгүй хөрөнгө хэлбэрээр байна уу эсвэл ашиглах боломжгүй хөрөнгө хэлбэрээр байршиж байна уу гэдгийг тодорхойлохдоо Lindley et al нарын ашигласан динамик оптимизацийн загварыг ашигласан.

Богино хугацаанд бэлэн байгаа илүүдэл нөөцийн зорилтод түвшинг тодорхойлохдоо банкууд дараахь квадрат алдангийн функцийг хүлээгдэж буй утгыг хамгийн бага байлгадаг гэж үзье.

$$C = \min \left[E_i \sum_{t=0}^{\infty} d^t \left[w_0 (ER_t - ER_t^*)^2 + w_1 (ER_t - ER_{t-1})^2 \right] \right] U,$$

Энд: ER_t - банкуудын бэлэн байгаа илүүдэл нөөц, ER_t^* - банкуудын зорилтод илүүдэл нөөц, d - хямдруулалтын хувь, $0 < d < 1$, w_0 , w_1 - жингийн хувь, U_t - банкуудын мэдээллийн багц. Жин w_0 болон w_1 нь харгалзан илүүдэл нөөцийг зорилтод түвшинд хангах эсвэл илүүдэл нөөцийг орлого олох хөрөнгөд хөрвүүлэх хоёр төрлийн зардлын нөлөөний хэмжээг илэрхийлэх бөгөөд эдгээр жингийн харьцаа нь дээрх хоёр төрлийн зардлын аль нь илүү чухал болохыг харуулна.

Банкуудын илүүдэл нөөцийн 1994-2002 оны динамикаас харахад дараалсан банкны секторын бүтцийн өөрчлөлтүүд болон банкны системийн хэмжээнд нөлөөтэй байсан томоохон банкуудын хямралаас ихээхэн хамаарч байв. Харин сүүлийн хэдэн жилүүдэд банк, санхүүгийн секторын үйл ажиллагаа тогтворжиж, банкуудын бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ нэмэгдэх хирээр илүүдэл нөөцийн хэмжээ тогтвортой өсөх хандлагатай байв. Бодит эдийн засгийн үйлдвэрлэл болон мөнгөний нийлүүлэлтийн адилаар банкуудын илүүдэл нөөц улирлын хэлбэлзэлтэй бөгөөд энэхүү улирлын хэлбэлзлийн хандлага нь хугацааны туршид өөрчлөгдөхөөс гадна аливаа гэнэтийн шокийн нөлөөгөөр хүчтэй өөрчлөгддөг байна.

Үнэлгээний үр дүнгээс харахад илүүдэл нөөцийн түвшинд мөнгөний бодлогын үзүүлэлтүүд, татан төвлөрүүлсэн хөрөнгө, тэдгээрийн шок хувьсагчид (Мөнгө M2-ын шок хувьсагчийг оруулахгүйгээр) нөлөөлдөг байна. Харин ТБҮЦ-ны хүү илүүдэл нөөцийг өөрчлөх нөхцөл болдоггүйг загварын үнэлгээний үр дүн харууллаа. Загварын үнэлгээний үр дүн 2001 оноос илүүдэл нөөцийн хуримтлал нэмэгдэхэд банкуудын хөрөнгийн дотоод зохицуулалтын зардал өндөр байгаа нь нөлөөлж буйг харууллаа. Илүүдэл нөөцийн зорилтод түвшнээсээ өөрчлөгдөх зардал сүүлийн жилүүдэд хүүний түвшин буурч байгаагаас шалтгаалан харьцангуй буурсан байж болох талтай билээ. Харин нөгөө талаас банкуудын татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ эрчимтэй нэмэгдэх хирээр банкуудын санхүүгийн чадавхи сайжирч, зах зээлийн өрсөлдөөн улам бүр нэмэгдэж илүүдэл нөөцөө өөр орлого олохуйц хөрөнгө рүү шилжүүлэх хөрөнгийн зохицуулалтын зардлыг нэмэгдүүлжээ. Иймд хөрөнгийн зохицуулалтын зардал нэмэгдэх хирээр банкууд өсөн нэмэгдэж буй татан төвлөрүүлсэн хөрөнгийнхөө хэмжээгээр илүүдэл нөөцөө орлого олох хөрөнгөд шилжүүлж чадахгүй байснаас илүүдэл нөөц үр ашиггүй бупер хөрөнгө хэлбэрээр хуримтлагдахад хүрч байв. Өөрөөр хэлбэл, хэдийгээр зээлийн хэмжээ нэмэгдэж байгаа ч гэсэн банкуудын татан төвлөрүүлсэн хөрөнгийн өсөлтөөс бага буюу татан төвлөрүүлсэн хөрөнгийн банкны салбар руу орох урсгал түүнийг буцаагаад эдийн засагт орлого олох хөрөнгө рүү шилжүүлэх банкны чадавхаас давсан байсан гэж хэлж болох юм.

2003 онд заавал байлгах нөөцийн шаардлагыг хангаж ажиллаагүй банкуудад 20.2 сая төгрөгийн торгууль ноогдуулсан байна. Тайлант онд банкууд жилийн туршид заавал байлгах нөөцөө хангаж ажилласан бөгөөд Монголбанк дахь харилцах дансандаа өдөр бүр дунджаар 24.6 тэрбум төгрөг байлгахаас 34.0 тэрбум төгрөг байршуулж байжээ. Банкны салбарын хэмжээнд өдөр бүр дунджаар 9.4 тэрбум төгрөгийн илүүдэл нөөцтэй байсан байна.

Заавал байлгах нөөцийн хэмжээ 2003 онд өмнөх оны дундажтай харьцуулахад 28.5 хувь, банкуудын нөөц 15.6 хувиар тус тус нэмэгдэн, илүүдэл нөөц 18 хувиар буурчээ. Заавал байлгах нөөцийн хэмжээ нэмэгдсэн нь банкуудын татан төвлөрүүлсэн хөрөнгө өссөнтэй холбоотой юм. Харин илүүдэл нөөцийн хэмжээ буурсан нь банкуудын нөөцийн удирдлага сайжирч байгааг илтгэж байна.

2003 онд банкуудын заавал байлгах нөөцийн хэмжээ 14 хувь байсан бөгөөд энэ нь харьцангуй өндөр тул 2004 оноос заавал байлгах нөөцийн хэмжээг 12 хувь болгохоор төлөвлөж байна. Заавал байлгах нөөцийн хэмжээг бууруулснаар чөлөөлөгдөх хөрөнгө нь зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх юм.

Засгийн газрын цэвэр зээл

2003 оны эцэст Монголбанк болон банкуудын нэгдсэн дүнгээр засгийн газраас авах авлага 211.1 тэрбум төгрөг, засгийн газрын хадгаламж 114.4 тэрбум төгрөгт хүрч, цэвэр зээлийн хэмжээ 96.7 тэрбум төгрөг болсон нь өнгөрсөн оны эцсээс 129.1 тэрбум төгрөгөөр илүү байна.

Монголбанк болон банкуудын засгийн газраас авах авлага өнгөрсөн оныхтой харьцуулахад эрс өссөн нь засгийн газрын цэвэр зээл нэмэгдэхэд нөлөөлжээ.

Засгийн газраас авах авлагын талаар

Засгийн газраас авах авлага Монголбанк болон банкуудын тэнцлийн нэгдсэн дүнгээр 2003 оны эцэст 211.1 тэрбум төгрөг байгаа бөгөөд өнгөрсөн оныхоос 180.4 тэрбум төгрөг буюу 6.9 дахин нэмэгдсэн байна.

Хүснэгт 19. Засгийн газрын цэвэр зээл	(сая төгрөг)		
	2002.12.31	2003.12.31	Өсөлт
Засгийн газраас авах авлага	30,742.6	211,121.0	180,378.4
Засгийн газрын хадгаламж	63,181.9	114,433.7	51,251.8
Үүнээс: а/ Улсын төсвийн	60,284.2	110,568.2	50,283.3
б/ Орон нутгийн төсвийн	2,526.5	3,747.0	1,220.5
в/ Төсөвт байгууллагын төсвийн гадуурхи	344.0	100.5	(243.5)
г/ БӨБА-ны харилцах данс	27.2	18.0	(8.5)
Засгийн газрын цэвэр зээл	-32,439.3	96,687.30	129,126.6

Засгийн газраас авах нийт авлагын 164.2 тэрбум төгрөг буюу 77.7 хувийг Монголбанкны авлага, үлдэх 46.9 тэрбум төгрөг буюу 22.3 хувийг банкуудын авлага эзэлж байна.

Бүтцээр нь авч үзвэл, 160.2 тэрбум төгрөг буюу 75.9 хувь нь Монголбанкнаас авсан зээл, 20.5 тэрбум төгрөг буюу 9.7 хувь нь Хадгаламж банк, Монголбанк болон ХХ-ийн банкинд байршиж буй банкны бүтцийн өөрчлөлтийн энгийн өрийн бичиг, 30.3 тэрбум төгрөг буюу 14.4 хувь нь банкуудын худалдан авсан богино болон дунд хугацааны бонд байна. Мөн 44.0 сая төгрөг буюу 0.02 хувь нь банкуудаас улсын төсөвт урьдчилж төлсөн татвар, 74.4 сая төгрөг буюу 0.04 хувь нь банкуудын Засгийн газрын үнэт цаасны хүүний авлага байна.

Засгийн газраас гаргасан банкны бүтцийн өөрчлөлтийн энгийн өрийн бичиг

2003 оны эцсийн байдлаар Засгийн газраас гаргасан банкны бүтцийн өөрчлөлтийн энгийн өрийн бичгийн хэмжээ нийт 20.5 тэрбум төгрөг байгаагийн 16.1 тэрбум төгрөг буюу 78.5 хувь нь Хадгаламжийн банкинд, 4.0 тэрбум төгрөг буюу 19.5 хувь нь Монголбанкинд, 399.6 сая төгрөг буюу 1.9 хувь нь ХХ-ийн банкинд байршиж байна. Тайлант онд СЭЗЯ 4.7 тэрбум төгрөгийн өрийн бичгийн төлбөрийг барагдуулав.

Гэрээний дагуу 2003 онд Монголбанк 6.0 тэрбум төгрөгийн засгийн газрын өрийн бичгийг Хадгаламжийн банкнаас худалдан авав. Үүнээс 2.0 тэрбум төгрөг төлөгдөн жилийн эцэст 4.0 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарлаа. Уг өрийн бичигт 2003 онд СЭЗЯ 521.4 сая төгрөгийн хүү төлсөн байна. Засгийн газрын өрийн бичгийг Монголбанк худалдаж авахад мөнгөний нийлүүлэлт огцом нэмэгдэх, үнэ өсөх зэрэг сөрөг үр дагаврууд өмнө нь ажиглагдаж байлаа. Хэдийгээр энэхүү үр дагаврууд багассан ч Засгийн газар авсан зээлийнхээ хүүг өөрөө тогтоох зэрэг санхүүгийн хэлцлийн зарчимтай харшилсан зүйл хадгалагдсан хэвээр байна. Тухайлбал, банкны бүтцийн өөрчлөлтийн өрийн бичгийн хүүний хувь хэмжээг Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 168 тоот тушаалаар тогтоосон бөгөөд энэ тушаал өнөөг хүртэл хүчинтэй хэвээр байна.

Засгийн газрын хадгаламжийн талаар

Засгийн газрын хадгаламж 2003 оны эцэст 114.4 тэрбум төгрөг байгаа нь өнгөрсөн оны эцсийнхээс 81.1 хувь буюу 51.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийт хадгаламжийн 96.6 хувь буюу 110.6 тэрбум төгрөгийг улсын төсвийн, 3.2 хувь буюу 3.7 тэрбум төгрөгийг орон нутгийн төсвийн, 0.1 хувь буюу 100.5 сая төгрөгийг төсөвт байгууллагын төсвийн гадуурхи хөрөнгө эзэлж байгаа бөгөөд 91.7 тэрбум төгрөг буюу 80.2 хувь нь Монголбанкинд, 22.7 тэрбум төгрөг буюу 19.8 хувь нь банкуудад байршиж байна.

ШИГТГЭЭ 15. ТӨВ БАНКНЫ ҮНЭТ ЦААС, ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ ӨӨРЧЛӨЛТ, ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ ХҮҮНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН СУДАЛГАА

Аливаа санхүүгийн зах зээлийн хөгжилд Засгийн газрын үнэт цаас онцгой байр суурь эзэлдэг бөгөөд түүнийг хамгийн эрсдэл багатай өрийн хэрэгсэл гэдгийг зах зээл өндөр хөгжсөн орнууд нийтээр хүлээн зөвшөөрсөн байдаг. Манай орны хувьд Засгийн газрын үнэт цаас нь одоогоор зах зээлд ялангуяа мөнгөний хоёрдогч зах зээлд идэвхтэй арилжаалагддаг өрийн хэрэгсэл болох болоогүй байгаа хэдий ч сүүлийн 3 жилд түүний арилжааны хэмжээ өмнөх жилүүдийг бодоход харьцангуй нэмэгдэж тогтмолжин, төрөл зүйл нь ч олширсон байна.

Засгийн газрын үнэт цаас, Төв банкны үнэт цаасыг харьцуулах нь*Зориулалтын ялгаа*

Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ) болон Төв банкны үнэт цаас (ТБҮЦ) нь хоёулаа санхүүгийн зах зээлийн хэрэгсэл боловч эцсийн зорилго нь ялгаатай байдаг. Засгийн газрын хувьд төсвийн бодлогыг хэрэгжүүлэх, Засгийн газрын өрийг удирдах буюу төсвийн орлогын улирлын чанартай дутагдлыг нөхөх зорилгоор үнэт цаас гаргадаг бол Төв банкны хувьд дотоодын үнийн өсөлт буюу инфляцийг хязгаарлах, арилжааны банкуудын Төв банк дахь харилцахын үлдэгдлийг зохицуулах зорилгоор гаргагдсаар шалтгаалан тэдгээрийн макро эдийн засагт үзүүлэх нөлөө өөр өөр байх тул зарим тохиолдолд тус тусын бодлогын хэрэгжилтэнд зөрчил үүсдэг. Тухайлбал, ЗГҮЦ гаргаснаар мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлдэг бол ТБҮЦ гаргаснаар нөөц мөнгийг бууруулна.

Зах зээлийн ялгаа

ТБҮЦ худалдан авагчид нь зөвхөн банкууд байдаг бол ЗГҮЦ худалдан авагчид нь хууль, эрх зүйн хувьд Төв банк болон банкууд, Монгол улсын иргэд, төсөвт байгууллагаас бусад аж ахуйн нэгж, байгууллагууд, гадаадын иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд байж болдог. Ийнхүү оролцож болох этгээдийн хэлбэрээрээ ЗГҮЦ-ны зах зээл нь ТБҮЦ-ныхыг бодвол илүү өргөн хүрээтэй боловч Монгол улсын өнөөгийн нөхцөлд түүний гол худалдан авагчид нь банкууд байна. 2000-2001 онд нийт арилжаалагдсан ЗГҮЦ-ны 97 хувийг банкууд худалдан авсан бол 2002 онд энэ хэмжээ 91 хувь байв.

Хүүний ялгаа

ЗГҮЦ, ТБҮЦ-ууд нь хоёулаа хямдруулсан хэлбэрээр арилжаалагддаг тул хямдруулалтын хувь хэмжээтэй бөгөөд ЗГҮЦ-ны хямдруулалтын хувь хэмжээг ТБҮЦ-ны хүү, инфляцийн түвшинтэй уялдуулан тогтоодог боловч төсөвт аль болох бага дарамт учруулах талаас нь бас бодолцдог байна. Тиймээс хүүний түвшингээрээ ерөнхийдөө ойролцоо байх нь ойлгомжтой юм. Харин худалдан авагчдын хувьд ЗГҮЦ-ны хүүний орлогыг албан татвараас чөлөөлдгөөрөө ТБҮЦ-наас ялгагдах онцлогтой.

Үнэт цаасны төрлийн ялгаа

Монголбанк 7, 14, 28, 91 хоногийн хугацаатай үнэт цаас гаргадаг бол Засгийн газрынх ихэвчлэн 30, 60, 90, 120 хоногийн зарим тохиолдолд 150 болон 1-2 жилийн хугацаатай байна.

Техник процедурын ялгаа

Харьцуулж буй 2 үнэт цаасны арилжаа явуулах техник процедурын гол ялгаа нь Төв банк өөрийн дотоод сүлжээгээ ашиглан, арилжаа явуулахаас 1 хоногийн өмнө банкуудад мэдэгдсэний үндсэн дээр өөрөө арилжаагаа удирдаж явуулдаг бол ЗГ арилжаагаа 7 хоногийн өмнөөс нийтэд зарласны үндсэн дээр Хөрөнгийн биржээр дамжуулан нээлттэй (худалдан авагчид өөрсдөө биеэр оролцох) болон хаалттай (биржийн гишүүн брокер, дилерээр дамжуулах) хэлбэрээр явуулдаг байна.

Адил, төстэй талууд

- Санхүүгийн хэрэгслүүд,
- Хямдруулсан хэлбэртэй,
- Арилжаа нь үнэ хаялцуулах журмаар явагддаг,
- Худалдан авагчдын дийлэнх хувь нь банкууд,
- Улирлын хэлбэлзэлтэй (ЗГҮЦ 4 дүгээр улиралд гардаггүй харин төлөгддөг, ТБҮЦ жилийн турш арилжаалагддаг боловч оны дундуур буурч, 1, 4 дүгээр улиралд өсдөг).

ЗГҮЦ, ТБҮЦ-ны зах зээлийн байдал

ЗГҮЦ, ТБҮЦ тус бүрийн 2002 онд хийсэн арилжааны талаархи ерөнхий мэдээллийг доорх хүснэгтэнд нэгтгэж харуулав.

	Үзүүлэлт	ТБҮЦ 2002 онд	ЗГҮЦ 2002 онд
1	Арилжааны тоо	98	20
2	Гаргасан хэмжээ	1000 тэрбум	53.8 тэрбум
3	Борлогдсон хэмжээ	833.3 тэрбум	51.3 тэрбум
4	Хүүний хувь хэмжээ (жилийн дундаж)	11.08%	11.33%

2002 оны анхдагч зах дээр явуулсан арилжаанд оролцогчдын худалдан авсан байдлыг үнэт цаас тус бүрээр харуулъя. Гэхдээ ТБҮЦ-ны хувьд банкууд хугацаа нь

дуусмагц буцаах, тэр дор нь дахин шинээр худалдаж авах гэх мэтээр жилийн турш үргэлжлэн арилжаанд оролцож байсан тул тэдгээрийн эзэмшиж байсан үнэт цаасны жилийн дундаж хэмжээг авлаа. Харин ЗГҮЦ-ны арилжаа цөөн байсан тул худалдан авсан нийт хэмжээг гаргах боломжтой бөгөөд худалдан авагч тус бүрээр гаргав.

Хүснэгтээс харахад хамгийн том худалдан авагчид аль алиных нь хувьд Худалдаа хөгжлийн, ХААН, Хадгаламжийн банкууд байна. Хоёрдогч зах зээлийн хувьд ТБҮЦ-ных хамаагүй том бөгөөд 2002 онд л гэхэд нийт 94 удаагийн арилжаагаар 86.2 тэрбум төгрөгийн ТБҮЦ-ыг банкууд хоорондоо худалдаж байсан байна. ЗГҮЦ-ны хувьд хоёрдогч зах зээлийн арилжаа жилд зөвхөн 1-2 удаа л хийгддэг байна.

Худалдан авагчид	ТБҮЦ		ЗГҮЦ	
	Эзэмшиж байсан ТБҮЦ-ны жилийн дундаж үлдэгд. (тэрбум)	Нийт борлуулалтанд эзлэх хувийн жин (%)	2002 онд худалдан авсан нийт хэмжээ (тэрбум төг)	Нийт борлуулалтанд эзлэх хувийн жин (%)
Банкны сектор:				
ХХБ	13.1	36.9	15.05	30
ХААН	9.0	25.3	11.32	22.5
Хадгаламж	3.0	8.4	11.55	22.9
Голомт	3.9	11.0	1.20	2.4
Анод	1.0	2.8	3.70	7.3
Монгол шуудан	0.9	2.5	-	-
Зоос	0.5	1.4	-	-
Тээвэр хөгжил	0.3	0.8	-	-
Улаанбаатар	1.3	3.6	-	-
Интер	1.3	3.6	-	-
Капитрон	0.7	2.0	-	-
Хас	0.1	0.3	-	-
Эрэл	0.3	0.8	-	-
Шинэчлэл	0.2	0.6	-	-
Монголбанк	-	-	4.0	7.9
Хөрөнгийн бирж	-	-	0.8	1.5
Иргэд, байгууллагууд	-	-	2.22	4.4

ЗГҮЦ-ны хүүнд нөлөөлөгч хүчин зүйлсийн эмпирик судалгаа

ТБҮЦ, ЗГҮЦ нь зорилгын хувьд зарчмын эрс ялгаатай боловч гол худалдан авагчид нь банкууд байгаа (нийт борлогдож буй ЗГҮЦ-ны 90-ээс дээш хувь нь банкуудад ноогддог) тул ТБҮЦ, ЗГҮЦ-ны үзүүлэлтүүдийн хооронд хамаарал байх нь зайлшгүй.

Онолын үндэслэл.

ТБҮЦ-ны хүү нь мөнгөний зах дээрх хамгийн идэвхтэй хүү тул ЗГ хүүгээ тогтоохдоо зах зээлийн хүүтэй уялдуулахыг оролдоно. ЗГ-ын гаргаж байгаа үнэт цаасны хэмжээ нь ТБҮЦ-ны хэмжээтэй харьцуулбал маш бага учир хүү нь өндөр байна. ЗГҮЦ-ны гол худалдан авагчид нь банкууд тул банкны системийн чөлөөт нөөцийн хэмжээнээс хамаарна. Банкууд илүүдэл нөөц ихтэй үед ЗГҮЦ авах эрэлт ихсэх учир түүний хүү буурна. Харин илүүдэл нөөцийн хэмжээ бага байвал ЗГҮЦ-ны хүү өснө. ЗГҮЦ-ны хүүд нөлөөлж болох дээрх хүчин зүйлсүүдийг загварт оруулан дараахь байдлаар тодорхойлов.

$$TBR_t = C(0) + C(1) * CBRR_t + C(2) * ExRs_t$$

Үүнд: TBR_t - t сар дахь ЗГҮЦ-ны хүү, $CBRR_t$ - t сар дахь ТБҮЦ-ны хүү, $ExRs_t$ - t сарын эцэс дэх банкуудын илүүдэл нөөцийн хэмжээ.

1. Онол дээр үндэслэн $C(1) > 0$ буюу ЗГҮЦ-ны хүүний өөрчлөлт нь ТБҮЦ-ны хүүгийн өөрчлөлттэй эерэг хамааралтай,
2. $C(2) < 0$ буюу ЗГҮЦ-ны хүүний өөрчлөлт нь банкуудын илүүдэл нөөцийн өөрчлөлттэй сөрөг хамааралтай байх ёстой.

Тоон өгөгдлийн хамрах хугацаа нь 2000 оны 1 дүгээр сараас 2002 оны 12 дугаар сар байна. Зарим сард ЗГ-ын үнэт цаасны арилжаа явагдаагүй учир тухайн сард TBR_t байхгүй байгаа нь шугаман регрессийн сонгодог загварын үндсэн зарчмууд зөрчигдөхөд хүргэж байна. Иймд өгөгдөл байхгүй сарын бүх өгөгдлийг загварын үнэлгээнд оруулаагүй бөгөөд ингэсэн тохиолдолд үнэлэгдсэн коэффициентүүд нь хамаарлыг харуулж болохыг William H. Greene "Econometric analysis" Second Edition-д тайлбарласан байдаг. Манай тохиолдолд ЗГҮЦ-ны хүүний (TBR) өгөгдлүүд зарим сард дутуу байгаа тул бусад хувьсагчдын өгөгдлүүдээс TBR хувьсагчийн хувьд дутаж буй тухайн сарын өгөгдлүүдийг хасаж регресс бодуулан холбогдох коэффициентүүдийг олов. Үүний дараа тэдгээр коэффициентүүдийг ашиглан дутуу байгаа өгөгдлүүдийг тооцож олсны үндсэн дээр бүрэн өгөгдөлтэйгээр дахин регресс бодуулан шалгаж үзэхэд үр дүн нь хасаж бодуулсан регрессээс муу гарлаа. Тиймээс ignorable case-ийг сонгож авсан болно. Загварыг Eviews програм дээр хамгийн бага квадратын аргаар бодуулахад дараахь үр дүн гарч байна.

$$TBR_t = 11.32 + 0.39 \cdot CBBR_t - 0.36 \cdot EXRS_t$$

(4.2688) (1.9951) (-3.3340)

Dependent Variable: TBR

Method: Least Squares

Date: 01/08/03 Time: 22:39

Sample: 2000:01 2002:03

Included observations: 27

Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
C	11.32030	2.651825	4.268871	0.0003
CBBR	0.390529	0.195739	1.995153	0.0575
EXRS	-0.356521	0.106933	-3.334056	0.0028
R-squared	0.487021	Mean dependent var	13.19000	
Adjusted R-squared	0.444273	S.D. dependent var	2.820600	
S.E. of regression	2.102675	Akaike info criterion	4.428737	
Sum squared resid	106.1098	Schwarz criterion	4.572719	
Log likelihood	-56.78795	F-statistic	11.39278	
Durbin-Watson stat	1.771245	Prob(F-statistic)	0.000332	

Иймд автокорреляци байхгүй байна.

Breusch-Godfrey Serial Correlation LM Test:

F-statistic	0.674956	Probability	0.519412
Obs*R-squared	1.560932	Probability	0.458192

TBR-ийн хувьд ADF статистик нь критикал утгаасаа бага байгаа учир Unit root-ийн тэг гипотезийг үгүйсгэж байна.

ADF Test Statistic	-2.679581	1% Critical Value*	-3.7667
		5% Critical Value	-3.0038
		10% Critical Value	-2.6417
*MacKinnon critical values for rejection of hypothesis of a unit root.			
ADF Test Statistic	-1.478007	1% Critical Value*	-3.7343
		5% Critical Value	-2.9907
		10% Critical Value	-2.6348
*MacKinnon critical values for rejection of hypothesis of a unit root.			
ADF Test Statistic	-0.625990	1% Critical Value*	-3.7343
		5% Critical Value	-2.9907
		10% Critical Value	-2.6348

*MacKinnon critical values for rejection of hypothesis of a unit root.

Дүгнэлт

1. CBBR хувьсагчийг үнэлсэн үнэлгээ болох 0.39 коэффициент нь онолын хувьд үнэн буюу ТБҮЦ-ны хүү нь ЗГҮЦ-ны хүүтэй эерэг хамааралтайг баталж байгаагийн зэрэгцээ t-шинжүүрээрээ хувьсагчдын хооронд сул хамаарал байгааг үзүүлж байна. (Банкуудын чөлөөт нөөц нэг тэрбум төгрөгөөр нэмэгдвэл ЗГҮЦ-ны хүү 0.36 нэгжээр буурна.)
2. Банкуудын чөлөөт нөөцийн хэмжээг үнэлсэн үнэлгээ -0.36 нь уг хувьсагч ЗГҮЦ-ны хүүтэй урвуу хамааралтайг үзүүлэхээс гадна t-шинжүүрээрээ статистикийн хувьд найдвартайг харуулж байна. (ТБҮЦ-ны хүү нэг нэгжээр өсвөл ЗГҮЦ-ны хүү 0.39 нэгж пунктээр мөн өснө гэсэн үг юм.)

2003 онд Монголбанк Төрийн сангийн нэгдсэн дансанд нийт 1.9 тэрбум төгрөгийн хүү төллөө. Засгийн газар 2003 онд 3 удаа, нийт 38.2 тэрбум төгрөгийн хадгаламжийг гэрээний үндсэн дээр Монголбанкинд байршуулсан бөгөөд эдгээр хадгаламжинд Монголбанк 0.8 тэрбум төгрөгийн хүү төлжээ. Монголбанк Засгийн газрын хадгаламжинд хүү төлөх нь оновчтой хэрэгсэл биш юм. Гэвч Төрийн сангийн нэгдсэн дансыг нэвтрүүлэх эхний шатанд уг дансанд хөрөнгө байршуулах алдагдсан боломжийн өртгийг нөхөх үүднээс авсан арга хэмжээнийх нь хувьд бид үүнийг хүлээн зөвшөөрч байна. Цаашид засгийн газрын бондыг их хэмжээгээр гаргах шаардлагагүй болж хөрөнгө хэмнэгдэхийн хирээр дээрх зуршил аажмаар арилах болно.

Засгийн газрын бонд

Засгийн газар 2003 онд богино хугацааны хямдруулсан, богино хугацааны энгийн, ам. долларын богино хугацааны энгийн гэсэн 3 ангиллаар нийт 113.1 тэрбум төгрөгийн бондын арилжаа явуулж, оны эцэст 89.8 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

2003 онд өмнөх онтой харьцуулахад Засгийн газрын арилжаалсан бондын хэмжээ 63.0 тэрбум төгрөг буюу 2.2 дахин, үлдэгдэл нь 83.7 тэрбум төгрөг буюу 14.7 дахин тус тус нэмэгджээ. Бондын арилжааны үлдэгдэл ийнхүү нэмэгдсэн нь 12 дугаар сард 75.0 сая ам. долларын энгийн бонд гаргасантай холбоотой юм.

2003 онд арилжаалагдсан нийт бондын 53.8 тэрбум төгрөг буюу 47.6 хувийг банкууд худалдаж авсны дотор ихэнх хэсгийг ХХ, ХААН, Хадгаламжийн болон Анод банкууд, 58.4 тэрбум төгрөг (50.0 сая ам.доллар) буюу 51.6 хувийг Айвенхоу Майнз компани тус тус худалдан авчээ.


Тайлант онд Засгийн газраас шинээр гаргасан болон оны эцэст үлдэгдэлтэй гарсан бондуудаас ам. долларын бондууд жилийн 3.0-5.3 хувийн хүүтэй арилжаалагдсан бөгөөд энэ нь хүүний хамгийн бага түвшин байлаа. Богино хугацааны хямдруулсан бонд 2.2-14.2 хувь, дунд хугацааны тусгай зориулалтын бонд 14.0 хувь, богино хугацааны энгийн бонд 14.0 хувь, дунд хугацааны хямдруулсан бонд 10.8-15.8 хувийн хүүтэй арилжаалагджээ.

2003 онд засгийн газрын дунд болон богино хугацааны энгийн бондын жигнэсэн дундаж хүү засгийн газрын бусад бондынхаас нэлээд өндөр, гэхдээ ТБҮЦ-ныхаас арай доогуур түвшинд байна (Зураг 29).

Төв банкны санхүүжилт

Банкуудын богино хугацааны нөөцийн дутагдал, санхүү, төлбөрийн чадварын доголдол гарч, банк хоорондын захаас эх үүсвэр олоогүй тохиолдолд Монголбанк нь эцсийн зээлдүүлэгчийн хувьд ТБҮЦ хямдруулан худалдаж авах хямдруулалтын санхүүжилт, тохиролцсон хугацааны эцэст банк өмнө нь худалдсан байсан ТБҮЦ-

Зураг 39. Жигнэсэн дундаж хүү



- 1 ЗГ-ын богино хугацааны хямдруулсан бонд
- 2 ЗГ-ын богино хугацааны энгийн бонд
- 3 ЗГ-ын богино хугацааны ам.долларын энгийн бонд
- 4 ЗГ-ын дунд хугацааны тусгай зориулалтын (замын) бонд
- 5 ЗГ-ын дунд хугацааны хямдруулсан бонд
- 6 Төв банкны үнэт цаас

аа урьдчилж тохирсон үнээр буцаан худалдаж авах репо санхүүжилт, эсвэл овернайт зээл олгох зэрэг хэлбэрээр банкуудыг дахин санхүүжүүлдэг.

2003 онд Монголбанк эдийн засаг, санхүүгийн салбарын өнөөгийн болон ирээдүйн хөгжлийн чиг хандлага, мөнгөний бодлого, төлбөр тооцооны систем, банкуудын төлбөрийн чадвартай уялдуулан банкуудыг санхүүжүүлэх журмыг шинэчлэн боловсрууллаа. Энэхүү журмын дагуу Монголбанк 2003 онд банкуудад нийт 108.5 тэрбум төгрөгийн санхүүжилт хийснээс 29 удаагийн хэлцлээр нийт 64.2 тэрбум төгрөгийн овернайт зээл, 10 удаагийн хэлцлээр 34.3 тэрбум төгрөгийн репо санхүүжилт, 10.0 тэрбум төгрөгийн хямдруулалтын санхүүжилт тус тус олгожээ.

Дамжуулан олгосон зээлийн талаар

Олон улсын санхүүгийн байгууллагуудаас Монголбанкаар дамжуулан дараахь 3 төрлийн төслийг амжилттай хэрэгжүүлж байна. Үүнд, Монгол улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу экспортын чиглэлийн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, санхүүгийн секторыг дэмжих зорилго бүхий 5.1 сая еврогийн төслийн хүрээнд өссөн дүнгээр нийт 7.4 тэрбум төгрөгтэй тэнцэх эх үүсвэрийг ХХ, Монгол Шуудан банкуудаар дамжуулан дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг секторт олгоод байна. Үүнээс 2003 онд 3.4 тэрбум төгрөгтэй тэнцэх зээлийг олголоо. 2003 оноос эхлэн банкуудын буцаан төлсөн зээлээр эргэлтийн сан бүрдүүлж хуримтлуулан, 2.1 тэрбум төгрөгтэй тэнцэх зээлийг энэхүү

эргэлтийн сангаас дахин зээлдүүлээд байна. Төслийн 1 дүгээр хөтөлбөр дуусч байгаатай холбогдуулан 2 дугаар хөтөлбөрийн холбогдох гэрээнүүдийг СЭЗЯ, банкуудтай байгууллаа. Энэхүү 2 дугаар хөтөлбөрийн хүрээнд эхний эх үүсвэр шилжин ирснээс 438.1 сая төгрөгийн зээлийг олголоо.

АХБ-ны Хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх хөтөлбөрийн төслийн үйл ажиллагаа 2002 оноос эхлэн амжилттай хэрэгжиж байна. Уг хөтөлбөрийн хүрээнд нийт 4.4 сая ам. долларын зээлийг оролцогч банкуудаар дамжуулан хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх зорилгоор олгож байна. Зээлийн үйл ажиллагаа 2002 оны 4 дүгээр улирлаас ихээхэн эрчимжиж байгаа бөгөөд уг төслийн хүрээнд өссөн дүнгээр нийт 3.1 тэрбум төгрөгийн зээлийг Монголбанкнаас төсөлд оролцогч Зоос, Монгол шуудан, ХАС банкуудад олгоод байна. Үүнээс 2003 онд 1.9 тэрбум төгрөгтэй тэнцэх зээлийг олголоо. 2003 оноос эхлэн банкуудын буцааж төлсөн төслийн зээлээр эргэлтийн сан бүрдүүлж хуримтлуулан, 0.7 тэрбум төгрөгтэй тэнцэх зээлийг төслийн зориулалтаар дахин олгоод байна.

АХБ-ны “Ажлын байр нэмэгдүүлэх 1290-МОН” төсөлд Голомт, Зоос, Эрэл, Тээвэр хөгжлийн банкууд оролцож байгаа бөгөөд Монголбанкнаас эдгээр банкуудад байршуулсан ажлын байр нэмэгдүүлэх тусгай хугацаат хадгаламжийн үлдэгдэл 2003 оны жилийн эцсийн байдлаар 2.7 тэрбум төгрөг болсон байна. Үүнээс Голомт банкинд 1.1 тэрбум, Зоос банкинд 1.0 тэрбум, Эрэл банкинд 0.5 тэрбум, Тээвэр хөгжлийн банкинд 0.1 тэрбум төгрөгийг тус тус байршуулжээ.

2003 онд зориулалтын дагуу нийт 785.0 сая төгрөгийн хадгаламжийг Эрэл, Голомт болон Зоос банкуудад шинээр байршуулж, 501.9 сая төгрөгийг Эрэл, Тээвэр хөгжлийн банкуудаас буцаан татлаа.

Мөн Голомт банкинд 1.0 тэрбум, Зоос банкинд 1.0 тэрбум төгрөгийн хадгаламжийн хугацааг тус бүр 18 сараар сунгав.


Зоос банк 2001 оны 5 дугаар сараас, Эрэл банк 2001 оны 6 дугаар сараас, Голомт банк 2001 оны 7 дугаар сараас, Тээвэр хөгжлийн банк 2001 оны 11 дүгээр сараас тус тус уг эх үүсвэрийг ашиглаж эхэлсэн байна. Энэ хугацаанд Голомт банк 1186, Эрэл банк 933, Зоос банк 786, Тээвэр хөгжлийн банк 293, нийт 3198 ажлын байрыг шинээр бий болгожээ.

5.2. Валютын бодлого, нөөцийн удирдлага


Гадаад валютын нөөцийн удирдлага

Тайлант онд улсын гадаад валютын нөөцийг үр ашигтай байршуулан, түүний төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангахад анхаарч ажиллав. Оны эцэст улсын гадаад валютын цэвэр албан нөөц 129.0 сая ам. долларт хүрсэн нь импортын 8.1 долоо хоногийн хэрэгцээг хангахаар байна.


Зураг 40. Гадаад цэвэр албан нөөц



Зураг 41. Төгрөгийн ам. доллартай харьцах ханш



Зураг 42. Төгрөгийн бодит ба нэрлэсэн үйлчилж буй ханшийн хөдөлгөөн



Дотоодын алт олборлогч 122 аж ахуйн нэгжээс бохир жингээр 11.1 тонн, цэвэр жинд шилжүүлснээр 9.8 тонн алт худалдан авч 132.2 тэрбум төгрөг төлсөн нь өмнөх оны мөн үеэс 12.9 тэрбум төгрөгөөр илүү байна. Нийт 13 удаагийн ачилтаар 9.8 тонн цэвэршүүлсэн алтыг улсын нөөцөд хүлээн авчээ. Манай улсын гол экспортын барааны нэг болох алтны үнэ олон жилийн дунджаас өндөр түвшинд гарч улсын нөөцийн бүтэц дэх хувийн жин нь өсөхөд таатай нөлөөг үзүүлсэн байна.

Эрсдэл харьцангуй багатай, хүүний өндөр ашиг олох үнэт цаас, хүүний түвшин өндөртэй шинэ валютыг нөөцөд авах боломжуудыг эрэлхийлж тодорхой үр дүнд хүрлээ. Тайлант онд гадаадын харилцагч банк, санхүүгийн байгууллагуудад улсын валютын нөөцийг хадгаламж, үнэт цаасанд байршуулан жилийн эцэст 5.0 сая ам. долларын хүүний орлого, валютын зах дээрх арилжаанаас 3.3 сая ам. долларын, алтны арилжаанаас 1.8 сая ам. долларын ашиг оллоо.

Нөөцийн удирдлагын ажлын хүрээнд олон улсын санхүүгийн зах зээлийн хүүний түвшин буурч байсан нөхцөлд олж болох хүүний орлогыг дээшлүүлэх, харилцагчдын эрсдэлийг бууруулах зорилгоор гадаадын шинэ түншүүдтэй хэлцэл, арилжааны ерөнхий гэрээг байгуулж, санхүүгийн шинэ хэрэгсэл нэвтрүүлэхэд санаачилга гаргаж ажиллалаа.

Улсын валютын нөөцийн үр ашгийн өгөөж жилийн 4.4 хувьд хүрсэн нь Лондонгийн банк хоорондын захын дундаж хүүнээс 3.0 нэгжээр өндөр түвшинд байна.

Валютын ханшийн бодлого

Төрөөс 2003 онд баримтлах үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу Төв банкны зүгээс ханшийн чөлөөт тогтолцоог бэхжүүлэх, валютын ханшийг тогтвортой байлгах зорилтыг тавьж ажиллав.

Төгрөгийн ам. доллартай харьцах Монголбанкны ханшийг тогтоохдоо зах зээлийн эрэлт нийлүүлэлтэнд үндэслэн бодитой тогтоож 2003 оны 1 дүгээр сараас эхлэн ханшийг өдөр бүр олон нийтэд зарлаж ирлээ.

Тайлант оны эцэст төгрөгийн ам. доллартай харьцах ханш, гадаад худалдааны тэнцэл, гадаад зах зээл дээрх ам. долларын ханшийн сулралт, дотоод дахь мөнгөний нийлүүлэлт зэрэгтэй уялдан нэрлэсэн ханшийн уналт жилийн 3.8 хувьтай байлаа. Тайлант оны эхний 11 сарын байдлаар бодит ханшийн чангаралт 12.9 хүрсэн нь эдийн засаг дахь мөнгө, гадаад зах зээл дэх үнийн өсөлт, бусад харьцах валютуудын огцом өөрчлөлтүүдтэй харьцуулбал харьцангуй тогтвортой түвшинд байв.

Банк хоорондын валютын захын үйл ажиллагааг цаашид хөгжүүлэх, үр дүнтэй болгох талаар банкуудын саналыг авч, цаашид валютын захын арилжааг боловсронгуй болгох зорилт тавин ажиллаж байна.

Төлбөрийн тэнцлийн статистик үзүүлэлтүүдийн хамрах хүрээг өргөжүүлж, үндэслэлийг сайжруулах зорилгоор уг статистикийн гол бүрэлдэхүүн хэсэг болсон үйлчилгээний статистик үзүүлэлтийг сайжруулах зорилт тавин ажиллав. Үүний үр дүнд төлбөрийн тэнцлийн тодорхой бус үзүүлэлтүүдийн зөрүүг багасган аялал жуулчлал, эмнэлгийн үйлчилгээ, гуйвуулгын хэмжээг бодитой тогтоох чиглэлээр ажиллаж тодорхой үр дүнд хүрлээ. Тухайлбал, Лондонд ажиллаж амьдарч байгаа иргэдийн хувийн гуйвуулгын судалгааг хийсэн нь үр дүнтэй ажил боллоо.

Банкуудаар дамжин хийгдэж буй гадаад гүйлгээний мэдээг нэгтгэн гаргах ажлыг тогтмолжуулсан бөгөөд одоогийн байдлаар 16 банкнаас уг мэдээллийг сар бүр тогтмол авч байна. Гаалийн Ерөнхий газар (ГЕГ), Үндэсний статистикийн газар (ҮСГ)-тай тохиролцсоны дагуу тайлант оны 10 дугаар сараас эхлэн алтны экспорт, импортын мэдээг сар бүрийн гадаад худалдааны статистикийн мэдээнд тусгах болов.

5.3. Банк болон банк бус санхүүгийн байгууллагын хяналт шалгалт

Манай улсын санхүүгийн салбарыг бүрдүүлж байгаа гол байгууллагууд нь банк болон ББСБ-ууд болж байгаа бөгөөд Монголбанкнаас санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах үндсэн зорилгын хүрээнд эдгээр байгууллагуудад холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавин ажиллав.

Тайлант онд санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудын тоо нэмэгдэж үйл ажиллагаа нь харьцангуй идэвхжиж ирлээ. Тухайлбал, ББСБ-ууд олноор байгуулагдаж байгаа бөгөөд эдгээр байгууллагуудын зарим үйл ажиллагаа ялангуяа, зээлийн үйл ажиллагаа эрчимтэй явагдах боллоо. Тайлант онд ББСБ-ын тухай хууль батлагдан гарсан нь уг байгууллагад хяналт тавих үйл ажиллагааны эрх зүйн орчинг бүрдүүллээ.

Банкуудын үйл ажиллагааны хүрээ өргөжихийн хирээр тэдгээрт тавих хяналтын үйл ажиллагааг улам боловсронгуй болгох асуудал зайлшгүй тулгарч, банкууд өөрсдөө үйл ажиллагааныхаа эрсдэлийг тооцоолж, цаашдынхаа чиг хандлагыг тодорхойлох асуудал зүй ёсоор тавигдаж байна.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2003 онд баримтлах үндсэн чиглэл нь өмнөх онуудтай харьцуулахад дараахь онцлогуудтай байв. Энэ нь санхүүгийн салбарт бий болсон тогтвортой байдал, нааштай бусад хандлагуудыг хадгалах, цаашид улам бэхжүүлэн хөгжүүлэх, банкуудын үйл ажиллагааг олон улсын жишигт нийцсэн зарчмаар явагдах нөхцлийг бүрдүүлэх, үйл ажиллагааг нь нийтэд ил тод, нээлттэй болгох, хяналт шалгалтын үйл ажиллагааг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн арга, аргачлалуудаар явуулахад чиглэгдсэн арга хэмжээ авах, банкуудаас гаргаж байгаа санхүүгийн шинэ нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг хөхүүлэн дэмжих зэрэг болно.

Банк болон ББСБ-уудад хяналт шалгалт хийж байгаа өнөөгийн тогтолцоо нь олон улсын банк санхүүгийн байгууллагуудад тавигддаг хяналтын нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн, үр ашигтай бүтцээр явагдаж байгаа бөгөөд цаашид боловсронгуй болгох зорилгоор Монголбанкнаас тухайн нөхцөл байдалд тохируулан зарим тодорхой өөрчлөлтүүдийг хийж ирлээ.

Банкуудад хийгдэж байгаа хяналт шалгалтын талаар

Тайлант онд газар дээрх шалгалтын хүрээнд батлагдсан хуваарийн дагуу банк болон ББСБ-уудын санхүү, төлбөрийн чадварын байдал, үйл ажиллагаанд Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан шалгалтын удирдамжийн хүрээнд 15 банк, 1 ББСБ-д иж бүрэн шалгалтыг хугацаанд нь хийж гүйцэтгэн, шалгалтын дүнг Монголбанкны Захирлуудын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулан, түүний биелэлтэнд нь хяналт тавьж ажиллалаа. Мөн олон улсын санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудаас банкуудаар дамжуулан жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа төслийн зээлийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтын байдалд дээрх төслүүдийг хэрэгжүүлж байгаа 10 банкинд газар дээрх шалгалт хийж, үр дүнг УИХ-д тайлагналаа.

Банкинд зайнаас хяналт тавих үйл ажиллагаагаар банкнаас ирүүлсэн мэдээлэл, тэдгээрийн динамик үзүүлэлт болон ашигт ажиллагаа, активын чанарыг илэрхийлэх үзүүлэлтүүдэд үндэслэн санхүү төлбөрийн чадварын байдалд дүгнэлт өгч, санхүү төлбөрийн чадварын хүндрэлд орсон банкуудад холбогдох хууль тогтоомжийн дагуу цаг алдалгүй арга хэмжээ авч ажиллалаа.

Хяналт шалгалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар авсан арга хэмжээ

Хяналт шалгалтын газар нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах үндсэн зорилтын хүрээнд банк болон ББСБ-уудад газар дээр болон зайнаас хяналт шалгалт хийн, холбогдох журам заавруудыг шинэчлэн боловсронгуй болгохын зэрэгцээ тэдгээрийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцсэн, зохистой түвшинд хүргэхийн тулд тодорхой чиглэлүүдээр зөвлөмж, аргачлалуудыг гарган хүргүүлээ. Үүнээс гадна олон улсын санхүүгийн байгууллага болон хандивлагч орнуудаас манай орны эдийн засгийн өсөлтийг хангах, нийгмийн шинж чанартай орон сууц, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах чиглэлээр олгож байгаа хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг банк болон ББСБ-аар дамжуулан хэрэгжүүлэхэд төрийн холбогдох бусад байгууллагуудтай хамтран ажиллаж, шаардлагатай мэдээ мэдээллээр ханган, төсөл хэрэгжүүлэгч нэгжийн бүрэлдэхүүнд орж ажиллаж байна.

Банкны салбарын хямралын үеэс хойшхи жилүүдэд зарим банкуудын тэнцлийн хөрөнгийн хэмжээ болон үйл ажиллагааны цар хүрээ бага, гаргаж байгаа санхүүгийн бүтээгдэхүүний нэр төрөл цөөн тоотой байсан нь банкны гүйцэтгэх удирдлага өдөр тутмын дийлэнх үйл ажиллагааг дангаараа удирдан явуулах

боломжийг олгож байсан. Гэвч сүүлийн жилүүдэд ялангуяа, тайлант онд энэ байдал өөрчлөгдөн банкуудын активын хэмжээ эрс нэмэгдсэн, шинээр олон төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн гаргах болсон нь банкуудын гүйцэтгэх удирдлага банкны үйл ажиллагааны бүх хүрээг дагнан удирдан явуулах нь үр өгөөжгүй болж, ингэснээр банкны бүтэц зохион байгуулалт, эрх мэдэл, үүрэг, хариуцлагыг оновчтой хуваарилан зохион байгуулах асуудал гарч ирсний дүнд зарим банкууд зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийг хийж байна. АХБ-ны тусламжтайгаар банкны бүтэц, зохион байгуулалт, хяналтын системийн үр ашгийг сайжруулан, ил тод байдлыг нэмэгдүүлэх, олон нийтийн банкинд итгэх итгэлийг улам гүнзгийрүүлэх зорилгоор “Банкны байгууллагуудад зохистой удирдлагын зарчмуудыг хэрэгжүүлэх аргачлал”-ыг боловсруулан банкуудад хүргүүлээд байна.

Банкуудын гол зорилго нь ашиг олоход чиглэгдэж байдаг бөгөөд энэхүү зорилгоо хэрэгжүүлэхийн тулд үйл ажиллагаандаа учирч болзошгүй эрсдэлээ тооцоолон удирдах нь зах зээл өндөр хөгжсөн орнуудын банк санхүүгийн байгууллагад хийгддэг зайлшгүй үйл ажиллагаануудын нэг байдаг. Манай банкуудын хувьд байгуулагдсан үеэсээ эхлэн эрхлэн явуулж байсан банкны үйл ажиллагааны нэр төрөл бага буюу зөвхөн хадгаламж, харилцахаар хөрөнгө татан төвлөрүүлэн түүнийгээ зээлд байршуулах, төлбөр тооцоо хийх зэрэг үйл ажиллагаанаас орлого олдог байсан нь сүүлийн үеийн банк санхүүгийн байгууллагад ашиглагддаг боловсронгуй техник, тоног төхөөрөмж ашиглах шаардлагыг бий болгодоггүй байлаа. Энэ байдал сүүлийн жилүүдэд эрс өөрчлөгдөж, мэдээлэл холбооны орчин үеийн техник, тоног төхөөрөмж ашиглах болов. Санхүүгийн салбар дахь өрсөлдөөн нэмэгдсэнээр санхүүгийн бүтээгдэхүүний үнийн болон зах зээлийн эрсдэлд өртөх байдал эрс нэмэгдэж байна. Иймээс эрсдэлээ тодорхойлж үнэлдэг уламжлалт аргаас илүү олон улсад хөгжсөн эрсдэл тооцоолох арга, аргачлал, программ хангамжийг ашиглах хэрэгцээ урган гарч байна. Банкуудын энэхүү асуудлыг шийдвэрлэх, цаашдаа бий болох нөхцөл байдалд бэлтгэл болох үүднээс “Зах зээлийн эрсдэл тооцоолох аргачлал”-ыг боловсруулан банкуудад хүргүүлээ.

Тайлант онд томоохон банкууд Австралийн Эф Эн Эс (FNS) компанийн бүртгэлийн программ хангамжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж байгаа нь амжилттай хэрэгжиж байна. Мөн зарим банкууд дотоодын компаниудын хийсэн бүртгэлийн программ хангамжийг ашиглаж байгаа нь үр дүнтэй болж байгаа бөгөөд бүтээгдэхүүний ангилал нэмэгдсэнтэй холбоотойгоор банкууд бүртгэлийн программ хангамжаа шинэчлэх, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн гаргах асуудлууд зайлшгүй гарч ирж байна. Үүнтэй холбоотойгоор Монголбанкинд банкуудаас авдаг тайлан мэдээний маягт, дансны дугаарлалтыг шинэчлэх шаардлага гарч байна. Банкууд Монголбанкнаас гаргасан бүртгэлийн журмын дагуу санхүүгийн бүртгэлээ явуулдаг байсан бөгөөд энэ нь дээрх шалтгааны улмаас банкуудаас ирсэн мэдээлэлд нарийвчилсан судалгаа шинжилгээ хийх хэрэгцээ болон банкуудын үйл ажиллагаандаа нэвтрүүлж байгаа программ хангамж зэрэгтэй нийцэхгүй болсон байна. Иймд тайлант онд банкууд Олон улсын бүртгэлийн стандарт, зарчмуудын дагуу санхүүгийн бүртгэлээ хийж, харин Монгол-

банкнаас баталсан маягтын дагуу тайлан мэдээгээ гаргаж байхаар өөрчиллөө. Ингэхдээ хуучин дансны төлөвлөгөөг илүү нарийвчилсан бөгөөд энэ нь банкуудын үйл ажиллагаанд нарийвчилсан судалгаа шинжилгээ хийхэд гарч байсан хүндрэлтэй асуудлуудыг тодорхой хэмжээгээр шийдвэрлэсэн байна.

ББСБ-ын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн үндэс нь ББСБ-ын тухай хууль батлагдсанаар бий болж “ББСБ-ын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцон, үнэлэлт дүгнэлт өгөх журам”, “ББСБ-ын зөвшөөрөл олгох, цуцлах журам”-уудыг шинэчлэн, “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа, санхүүгийн байдалд газар дээр нь шалгаж үнэлгээ, дүгнэлт өгөх журам”, “Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих аргачлал”-уудыг шинээр боловсруулан гаргалаа.

Сүүлийн жилүүдэд зарим хөгжиж байгаа орнуудын банк санхүүгийн хууль эрх зүйн зохицуулалтын байдал бусад орнуудтай харьцуулахад сул, хяналтын систем муу хөгжсөнөөс олон улсын шинж чанартай гэмт хэрэг болох хүний болон хар тамхины наймаа, зэвсгийн худалдаа зэргээс олсон хөрөнгөө тухайн оронд байршуулан угаах үйл ажиллагаа ажиглагдах боллоо. Хэдийгээр манай улсад энэ төрлийн үйл ажиллагаа албан ёсоор бүртгэгдээгүй байгаа ч банк санхүүгийн салбар тогтворжих, нөгөө талаас уг салбарын үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль эрх зүйн орчин бусад хөгжилтэй орнуудтай харьцуулахад дөнгөж хөгжиж байгаа буюу сул зэргээс хамааран гэмт үйлдлээс олсон мөнгөө угаах сонирхол бий болж болзошгүй юм. Мөнгө угаах үйлдлийн гол зорилго нь хууль бус үйл ажиллагаанаас олсон хөрөнгийг хууль ёсны шинж чанартай болгон тухайн этгээдэд буцаан олгох үйл ажиллагаа байдаг тул санхүүгийн салбар харьцангуй тогтвортой хөгжиж буй газраар дамжуулан энэ зорилгоо гүйцэлдүүлэхийг хичээдэг. Тухайн улс орны эдийн засаг, санхүүгийн тогтолцоонд мөнгө угаах үйл ажиллагаа нэвтэрснээр санхүүгийн салбарын тогтвортой байдлыг алдагдуулах, улс оронд авилгалыг хөхүүлэн дэмжих, ингэснээр нийгэмд бий болж байгаа ёс зүйг сулруулах нөлөөлөл үзүүлдэг нь нэгэнт нотлогдсон билээ. Иймд Монголбанкнаас “Мөнгө угаах үйл ажиллагааны эсрэг тэмцэхэд банк санхүүгийн байгууллагын анхаарах асуудлын тухай зөвлөмж”-ийг Мөнгө угаах үйл ажиллагаатай тэмцэх олон улсын зөвлөл (FATF)-өөс 1990 онд гаргаж 1996 онд шинэчлэн боловсруулсан материалуудад үндэслэн боловсруулсан бөгөөд үүнд мөнгө угаах үйл ажиллагааны хууль эрх зүйн байдал, түүний эсрэг авч явуулах албадлагын арга хэмжээнүүд, санхүүгийн систем болон түүний зохицуулалт, олон улсын хамтын ажиллагааны талаар тусгасан болно. Үүний зэрэгцээ мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх асуудлаар олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж, холбогдох хуулийн төслийг бэлтгээд байна.


Өөрийн хөрөнгийн үзүүлэлт

Тайлант оны эцсийн байдлаар банкны салбарын хэмжээгээр нийт өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 20.4 хувь


байгаа нь өмнөх оныхоос 0.4 нэгжээр өссөн бөгөөд Монголбанкнаас тогтоосон доод хэмжээнээс 10.4 нэгжээр их байна.

Монголбанк банкуудын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг нь өргөжүүлэх үүднээс 2001 оны 9 дүгээр сард үйл ажиллагаа явуулж байсан банкуудад дүрмийн сангийн доод хэмжээгээ 2004 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор 4 тэрбум төгрөгт хүргэх, үүнтэй холбогдуулан дүрмийн сангаа нэмэгдүүлэх ажлыг тогтоосон хугацаа хүлээлгүйгээр цаг алдалгүй авч ажиллахыг үүрэг болгосны дагуу банкууд өнгөрсөн 2 жилийн хугацаанд дүрмийн сангаа тогтвортой нэмэгдүүлсээр байна. Банкуудын өөрийн хөрөнгө дүрмийн сангаа нэмэгдүүлэх байдлаар өсөхийн зэрэгцээ банкны ашгийн хэмжээгээр нэмэгдэж 2003 онд харьцангуй их хэмжээгээр буюу 49.1 тэрбум төгрөгөөр өсөв. Гэвч банкуудын

Зураг 43. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт



Зураг 44. Өөрийн хөрөнгийн зохистой харьцаа



эрсдэлээр жигнэсэн нийт активын хэмжээ өссөн нь өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт өмнөх оныхтой харьцуулахад өөрчлөлт бага байх гол шалтгаан болж байна. Энэ байдал нь сүүлийн жилүүдэд банкууд зээлийн үйл ажиллагаагаа цөөн тооны найдвартай зээлдэгчдэд төвлөрүүлэх, эрсдэл багатай гэж тооцогдох Төв банк болон засгийн газрын үнэт цаасанд хөрөнгөө байршуулах хандлага нь өөрчлөгдөж, аль болох харилцагчдыг татах, ингэснээр зах зээлд тодорхой байр суурь эзлэх зорилгоор эх үүсвэрээ хүүний орлого өндөртэй актив хөрөнгөд байршуулж байгаатай холбоотой байна. Тайлант оны эцсийн байдлаар өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг бүх банкууд хангаж ажиллалаа.

ББСБ-уудын нийт өөрийн хөрөнгө 2003 оны эцэст 13.7 тэрбум төгрөг болсон нь өмнөх оны мөн үеэс 60.2 хувь буюу 5.2 тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэ нь 26 ББСБ шинээр үүсгэн байгуулагдсан, хоёрдогч өглөг болон ашгийн динамик өсөлт зэрэгтэй холбоотой байна.

Мөн 100 хувийн эрсдэлээр жигнэгдэх актив болох зээл болон бусад активын дүнгийн өсөлтөөс шалтгаалан эрсдэлээр жигнэсэн нийт активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 79.4 хувь буюу 6.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 14.4 тэрбум төгрөг болсон байна.

Үүний үр дүнд өөрийн хөрөнгийн өсөлтийн хурдац, эрсдэлээр жигнэсэн активын өсөлтийн хурдацаас харьцангуй бага байгаагаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт өмнөх оны мөн үеэс 10.7 нэгжээр буурч 92.6 хувь болжээ.

Нийт зээлийн өсөлтийн хэмжээ улиралд дунджаар 5.0 орчим хувь байв. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг ихэнх ББСБ-ууд хангаж ажиллажээ.

Хөрвөх чадварын үзүүлэлт

Банкуудын хөрвөх чадварын байдалд Монголбанкнаас гаргасан холбогдох журмуудын дагуу банкуудын заавал байлгах нөөцийн хувь хэмжээ болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт (ТТГЧ)-ийг үнэлэн хяналт тавьж байна. Сүүлийн 2 жилийн байдлаар банкуудын татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ өмнөх онуудынхаас хурдацтайгаар өсч байгаа ч ТТГЧ-ын үзүүлэлт тогтвортой өндөр түвшинд байна. Уг үзүүлэлт өмнөх оны эцсээс 4.5 нэгжээр буурсан боловч 41.1 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон ТТГЧ-ын үзүүлэлтийн доод хэмжээнээс 23.1 нэгжээр их байлаа. Энэ нь банкууд зээлд хөрөнгөө байршуулж, зээлийн хяналтаа сайжруулснаар ашигт ажиллагаагаа нэмэгдүүлэх хандлагатай байгаа ч хүүний орлого харьцангуй өндөр санхүүгийн түрээс, хөрөнгө оруулалтын үнэт цаас зэрэг активт хөрөнгөө байршуулах боломж бага байгаатай холбоотой юм. Энэ нь санхүүгийн түрээс, бусад адилтгах төрлийн үйл ажиллагаа болон санхүүгийн зах зээлийн хөгжил манай оронд сул байгаагаас шалтгаалж байна. Мөн төгрөгийн хувьд салбарын хэмжээгээр ТТГЧ-ын үзүүлэлт 34.5 хувь, валютын

хувьд өндөр буюу 54.1 хувь байгаа нь банкууд валютын эсрэг төгрөгийн уламжлагдсан санхүүгийн хэрэгслээр хийх арилжаа хөгжөөгүйгээс валютын эрсдэлийг удирдах боломж бага байгаатай холбоотой юм.

ББСБ-ууд дүрмийн сангаа бэлэн мөнгө оруулах замаар болон бусдаас санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэх замаар нэмэгдүүлсэн (бусдаас татан төвлөрүүлсэн санхүүгийн эх үүсвэр өмнөх оны мөн үеэс 48.6 хувиар өссөн), харин түргэн борлогдох активын дүн өмнөх оны мөн үетэй харьцуулахад тогтвортой түвшинд байгаа зэрэгтэй холбогдон ТТГЧ-ын шалгуур үзүүлэлт 51.1 нэгжээр буурч 87.5 хувь болсон байна. Уг үзүүлэлтийг ББСБ-ын нэгтгэлийн хувьд хангаж ажилласан байна.

Түргэн борлогдох активын бүтцийг судлахад 80.0 хувь буюу 3.6 тэрбум төгрөг нь мөнгөн хөрөнгө, үлдэх 0.9 тэрбум төгрөг нь банк болон бусад санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах дансны үлдэгдэл байсан бол бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн 48.1 хувь буюу 2.5 тэрбум төгрөг нь банк болон бусад санхүүгийн байгууллагаас авсан зээл, 44.2 хувь буюу 2.3 тэрбум төгрөг нь бусад пассив, 7.2 хувь нь зарим эх үүсвэрийн данс тус тус байв.

Зээлийн үйл ажиллагаа ба зээлийн багцын чанар

Банкны салбарын хэмжээгээр зээлийн өрийн үлдэгдэл бусад актив хөрөнгөөс хамгийн өндөр хувиар буюу 91.0 хувиар өссөн нь өмнөх жилийн үзүүлэлтээс 19.7 нэгжээр их байгаа бөгөөд жилийн эцсийн байдлаар зээлийн өрийн үлдэгдэл 442.1 тэрбум төгрөг болов. Гэвч чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 2.2 дахин буюу 20.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 36.7 тэрбум төгрөг болсон нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 8.3 хувийг эзэлж өнгөрсөн оны эцсээс 1.1 нэгжээр өссөн байна.

Тайлант онд банкуудын зээлийн өрийн үлдэгдлийн өсөлт татан төвлөрүүлсэн хөрөнгийн өсөлтөөс их байгаа нь бусад актив хөрөнгийг бууруулан өндөр орлоготой активт хөрөнгөө байршуулж байгаатай холбоотой байна. Зээлийн хүүг бодит олсон хүүний орлогоор тооцоолоход тайлант онд 25.6 хувь байгаа нь банкуудын зарласан төгрөгийн жигнэсэн дундаж хүүнээс 5.9 нэгжээр бага болж энэ нь өмнөх оны байдлаас 0.4 нэгжээр бага байна. Банкуудын зарласан хүүнээс бодитоор орж байгаа зээлийн хүүний орлого нь өмнөх оны мөн үеэс их болсон нь хүүний төлөлт сайжирсныг илэрхийлж байгаа ч тайлант онд чанаргүй зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувийн жин өсөв. Энэ нь нэг талаас, аж ахуйн нэгж байгууллагуудын зээлийн эрсдэл өмнөх оныхоос нэмэгдсэнийг харуулах боловч нөгөө талаас, банкууд зээлд хөрөнгөө их хэмжээтэйгээр байршуулж байгаагаас зээлд тавих хяналтын үйл ажиллагаа сулрах, зээлдэгчдийн үйл ажиллагаанд зөвхөн барьцаа хөрөнгийн хэмжээ, түүний чанарыг голчлон харгалзан үнэлгээ өгч, зээлдэгчийн үйл ажиллагаанд бодитоор үнэлэлт дүгнэлт өгөх асуудал хангалтгүй байгаатай холбоотой гэж үзэж болно. Иймд банкууд зээл олгох үйл ажиллагааг чанаржуулах шаардлагатай байгаа ч зээлдэгчдийн эрсдэлийг бууруулах үүднээс

тэдгээрийн санхүүгийн тайлан мэдээг үнэн зөв бодитой гаргах, аудитын байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зэрэг арга хэмжээ авах зайлшгүй шаардлага гарч байна.

Зээлийн эрсдэлийг бууруулах гол асуудал нь зээлдэгчид, тэдгээрийн мөнгөн хөрөнгийн урсгалын талаархи бодитой мэдээлэлд үндэслэсэн судалгаа шинжилгээ байдаг. Монголбанкнаас зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд Дэлхийн банкны техник туслалцааны дагуу тус сангийн программ хангамж болон техник, тоног төхөөрөмжийг боловсронгуй болгон зээлдэгчдийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг оруулах ажлыг хийж байна.

Зээлийн эрсдэлийг олон улсын банк санхүүгийн байгууллагууд нь нэлээд боловсронгуй аргачлалаар тооцоолж байгаа бөгөөд манай нөхцөлд зээлдэгчийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгдөг буюу зэрэглэл тогтоох үйл ажиллагаа явуулдаг байгууллага байхгүй, ямар нэг байдлаар зэрэглэл тогтооход тухайн компанийн үйл ажиллагааны байдлыг илэрхийлэх санхүүгийн тайлан мэдээний чанар хангалтгүй буюу олон улсын бүртгэлийн стандартад бүрэн нийцээгүй, хувьцаа буюу үнэт цаас нь хөрөнгийн биржээр арилжаалагддаггүй, нөгөө талаас хөрөнгийн биржийн үйл ажиллагаа хангалттай хэмжээнд явагдахгүй байгаа зэрэг шалтгаанаас болж бусад харьцангуй хөгжилтэй орнуудад хэрэглэгддэг аргачлалыг хэрэглэх боломжгүй байна.

Тайлант онд ББСБ-ын зээлийн багцын үзүүлэлтүүдийг өмнөх оныхтой болон өмнөх улиралтай харьцуулан үзэхэд дараахь байдалтай байна. Үүнд:

ББСБ-уудын олгосон зээлийн цэвэр өрийн үлдэгдэл тайлант онд нийт эх үүсвэр нэмэгдсэнтэй холбоотойгоор өмнөх оны мөн үеэс 86.8 хувиар буюу 5.3 тэрбум төгрөгөөр өсч 11.5 тэрбум төгрөг болсон нь нийт активын 60.7 хувьтай тэнцүү байна.

Харин нийт зээлийн үлдэгдлийн өсөлтийн хурдац, чанаргүй зээлийн үлдэгдлийн өсөлтийн хурдацаас бага байгаагаас чанаргүй зээлийн нийт активт эзлэх хувийн жин өссөн үзүүлэлттэй, харин нийт зээлийн багцын хувьд харьцангуй тогтвортой буюу 6.6 хувь орчим байна.

Чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл болон түүний өсөлтийн хурдац харьцангуй бага байгаа нь нэгдүгээрт, болзошгүй эрсдэлийн зардлыг татвараас чөлөөлөх холбогдох хуулийн заалт байхгүйгээс ББСБ-ууд зээлийн ангиллыг журмын дагуу хийж зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сан (ЗТУБАХС)-г байгуулах сонирхолгүй, хоёрдугаарт, нийт олгосон зээлийн эрсдэлийг дийлэнх ББСБ-ууд зөвхөн өөрийн хөрөнгөөр дааж байгаа зэрэгтэй холбоотой юм. Иймд зээлийн ангиллыг зохих журмын дагуу хийсэн тохиолдолд нийт олгосон зээлийн өрийн үлдэгдлийн ангилалд өөрчлөлт орж, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл өсөх магадлалтай юм.

Тайлант оны эцэст ББСБ-ууд ЗТУБАХС-г Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүү, эдийн засгийн сайдын хамтарсан 2000 оны 614/125 тоот тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам”-ын дагуу 361.6 сая төгрөгөөр байгуулахаас 360.0 сая төгрөгөөр буюу 1.6 сая төгрөгөөр дутуу байгуулсан байна.

Гадаад валютын эрсдэлийн үзүүлэлт

Тайлант оны эцэст ББСБ-ын нэгтгэлийн хувьд гадаад валютын позици нэгж болон нийт валютаар 20.6 хувь байгаа нь Монголбанкны Ерөнхийлөгчийн 2000 оны 247 тоот тушаалаар батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцох журам”-д заасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангахгүй байна.

Үүний шалтгаан нь дүрмийн сан, бусдаас татан төвлөрүүлсэн санхүүгийн эх үүсвэрийг ихэвчлэн төгрөгөөр бүрдүүлж байгаа, мөн ханшийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор ББСБ-ууд гадаад валютаар эзэл олгох сонирхол давамгайлдаг зэргээс шалтгаалан зохистой харьцааны уг шалгуур үзүүлэлтийг дийлэнх ББСБ-ууд хангаж ажиллаж чаддаггүй байна. Гадаад валютаар олгосон зээлийн өрийн үлдэгдэл ББСБ-уудын нийт зээлийн багцын 22.5 хувийг эзэлж байна.

Иймд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2003 оны 637 тоот тушаалаар батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-д уг үзүүлэлтийг нийт валютын хувьд 40 хувь байхаар шинэчлэн тогтоов.

ББСБ-уудын санхүү, төлбөрийн чадварын гол гол үзүүлэлтүүдэд нааштай өөрчлөлтүүд гарч байгаа хэдий ч тэдгээрийн санхүүгийн зуучлалд гүйцэтгэж байгаа үүрэг хязгаарлагдмал хэвээр байна.

Зах зээлийн эрсдэл

Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд олон улсын банк санхүүгийн байгууллагууд өөрсдийн боловсруулсан аргад үндэслэн эрсдэл тооцоолох, эрсдэлийг удирдах хандлагатай болж байна. Манай орны хувьд эрсдэл тодорхойлон үнэлэхдээ уламжлалт аргуудыг ашиглаж байгаа бөгөөд санхүүгийн зах зээлд банкууд болон төрийн байгууллагууд, томоохон компаниуд санхүүгийн хэрэгсэл гаргахын хирээр энэхүү уламжлалт аргуудаар эрсдэлийг бодитой тодорхойлох боломж бага болж байна. Дээрх байдлаас болон банкуудын актив хөрөнгийн хэмжээ нэмэгдэн хадгаламж, зээлийн хүүг хугацаа, зориулалтаар нь олон төрлийн байдлаар тогтоох болсон нь ирээдүйн тодорхой хугацаанд тодорхой итгэх магадлалтайгаар мөнгөн дүнгээр эрсдэлээ илэрхийлэн тооцоолох сүүлийн үеийн аргачлалыг хэрэглэхийг шаардаж байна. Ингэснээр уламжлалт аргаар эрсдэл үнэлэхэд ажилтнуудын субъектив

байдлаар гаргасан дүгнэлтээс үүсэх алдааг багасган аливаа шийдвэрийг илүү үр дүнтэй гаргах нөхцөл бололцоо бүрдэх юм. Үүнтэй холбогдуулан Монголбанкнаас зах зээлийн эрсдэл тооцоолох аргачлал болон уг эрсдэлийг удирдахад баримталж ажиллах зарчмуудыг боловсруулан гаргалаа.

Монголбанк нь банкуудын гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс хүлээж болзошгүй эрсдэлийг бууруулах үүднээс гадаад валютын нээлттэй позицид тогтоосон хязгаарлалтаар банкуудад хяналт тавин ажиллаж байна. Тайлант онд төгрөгийн гол валютуудтай харьцах ханш харьцангуй тогтвортой байсан боловч банкуудын гадаад валютын нээлттэй позици урт¹ байж, өмнөх оныхоос 7.4 дахин өсч 40.2 тэрбум төгрөгт хүрэв. Гэвч өөрийн хөрөнгө харьцангуй их хэмжээгээр өссөнөөс хязгаарлалтын үзүүлэлтийн өсөлтийг сааруулан, уг үзүүлэлт 27.6 нэгжээр нэмэгдэн 36.5 хувьд хүрсэн нь байвал зохих хэмжээнээс 3.5 нэгжээр бага байна.

Банкны хувьчлал

Сүүлийн жилүүдэд санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бүрдүүлэх үүднээс санхүүгийн салбарын бүтцийн өөрчлөлтийн хүрээнд төрийн өмчийн оролцоотой болон төрийн өмчит томоохон банкуудыг хувьчлах ажил үргэлжлэн, ХААН банк тайлант онд амжилттай хувьчлагдлаа. Банкууд дахь төрийн мэдлийн хувьцааг гадаадын хөрөнгө оруулагч нарт хувьчилснаар зөвхөн банкны салбар хөгжих нөхцөлийг бүрдүүлээд зогсохгүй санхүүгийн тогтвортой байдал улам батжих, нөгөө талаас гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаагаараа чухал ач холбогдолтой болж байна. Одоогийн байдлаар Капитал банк дахь төрийн мэдлийн хувьцааг хувьчлахаар зарлаад байна.

Үндсэндээ төрийн мэдэлд Хадгаламжийн банк үлдэж байгаа бөгөөд банк санхүүгийн байгууллагын хувьчлалын хүрээнд цаашид тус банк дахь засгийн газрын бүтцийн өөрчлөлтийн өрийн бичгийг мөнгөжүүлэх, улмаар үйл ажиллагааг нь сайжруулан гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад хувьчлах бэлтгэл ажил хийгдэж байна.


5.4. Бүртгэл тооцоо, мэдээллийн технологи

Нягтлан бодох бүртгэл


Монголбанк өнгөрсөн онуудад системийн хэмжээний нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, бүртгэлийн сахилгыг сайжруулах талаар анхаарч ажиллаж ирлээ. Үүний дагуу 1996 оноос хоёр тогтолцоот банкны системд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, үндсэн зарчмуудад

¹ Гадаад валютаар илэрхийлэгдсэн тэнцлийн актив хөрөнгө болон түүнтэй адилтган тооцох тэнцлийн гадуурхи үүргийн нийт дүнгээс гадаад валютаар илэрхийлэгдсэн тэнцлийн пассив хөрөнгө болон түүнтэй адилтган тооцох тэнцлийн гадуурхи үүргийн нийт дүнг хасахад гарах дүн нь эерэг байвал нээлттэй урт позицитай, сөрөг байвал нээлттэй богино позицитай гэнэ.


Зураг 45. Банк хоорондын төлбөр тооцоо



Зураг 46. Банк хоорондын төлбөр тооцоо, ДНБ



Зураг 47. Зохион байгуулагдсан сургалт



нийцүүлсэн заавар журмуудыг гаргасан юм. 1997-98 онуудад Төв банк нь өөрийн нягтлан бодох бүртгэлийн системийг иж бүрнээр шинэчилсэн ба 1998 оноос АХБ-ны санхүүжилтээр нягтлан бодох бүртгэлийн компьютерийн системийг суурилуулах ажлыг эхлэн 2003 онд бүрэн дууслаа. Ингэснээр Монголбанк болон банкууд нь олон улсын жишигт нийцсэн бүртгэлтэй болсны зэрэгцээ түүнийг хөтлөх иж бүрэн программ хангамжтай болсон юм.

Төв банкнаас 2003 онд өөрийн нягтлан бодох бүртгэлийн тэнцлийн актив талд бүртгэлтэй байсан чанаргүй активын хэмжээг 50.2 хувиар бууруулж, тэр хэмжээгээр банкны орлогыг нэмэгдүүллээ.

Тайлант онд банк хоорондын тооцоогоор дамжин өнгөрөх гүйлгээ нь тооны болон дүнгийн хувьд эрс өслөө. Гүйлгээний тоо болон дүн нь өмнөх онтой харьцуулахад 2001 онд 19.4 ба 52.1 хувиар, 2002 онд 43.7 ба 45.0 хувиар, тайлант онд 83.1 ба 49.0 хувиар тус тус өсчээ.

Гүйлгээний тоо болон дүнгийн энэхүү өсөлт нь нэг талаас, Төрийн нэгдсэн сангийн үйл ажиллагаа жигдэрч Улаанбаатар хот төдийгүй орон нутагт идэвхтэй үйл ажиллагаа явуулах болсноос, нөгөө талаас, иргэд болон аж ахуйн нэгжүүдийн банкинд итгэх итгэл сайжирч бэлэн бус төлбөр тооцоогоо зөвхөн банкаар дамжуулан гүйцэтгэх болсонтой холбоотой юм.

2003 онд банк хоорондын тооцоогоор дамжин өнгөрсөн гүйлгээний тоо болон дүн өсөхийн хирээр ДНБ-ий эргэлт (банк хоорондын тооцоонд оролцож буй нийт төлбөрийн дүнг ДНБ-д харьцуулсан харьцаа) хурдаслаа. Энэхүү үзүүлэлт нь 2000 онд 1.2 байсан бол 2001 онд 1.7, 2002 онд 2.2, 2003 онд 3.0 хүрчээ.

Мэдээллийн технологи

Мэдээллийн технологийн асар хурдацтай хөгжлийг даган банкны салбарын техник технологи, программ хангамж нь орчин үеийн шаардлагын дагуу шинэчлэгдэн сайжирч байна. Жилийн эцсийн байдлаар Монголбанкны төв аппаратад Олон улсын төлбөр тооцооны, банк болон салбар хоорондын төлбөр тооцооны, Төв банкны нягтлан бодох бүртгэл тооцооны, дотоодын зэрэг тус тусдаа дөрвөн төрлийн сүлжээнд хоёр зуу гаруй хэрэглэгч холбогдон ажиллаж байна. Цаашид, Монголбанк нь банк хоорондын сүлжээг бодит цагийн горимд шилжүүлэх зорилттойгоор ажиллаж байгаа бөгөөд энэхүү ажлын эхний алхам болгон 2000 онд тус сүлжээг цахим горимд шилжүүлсэн билээ.

Тайлант онд Монголбанк нь АХБ-ны тусламжтайгаар банкны ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх төслийг амжилттай хэрэгжүүлж дуусгалаа. Уг төслийн хүрээнд ХААН, ХХ, Эрэл, Монгол шуудан, Хадгаламжийн банкуудад олон улсын стандартад нийцсэн, банкны иж бүрэн программ хангамжийг суурилууллаа. Үүний

зэрэгцээ, тус программ хангамжийн тусламжтайгаар банкны үйлчилгээ нь бодит цагийн горимд орон зайнаас хамааралгүйгээр явагдах зарчмын өөрчлөлт гарлаа.

Монголын ихэнх банкууд дотоодын программ хангамж боловсруулагч компаниуд болон банкны мэдээллийн технологийн ажилтнуудын боловсруулсан системийг ашигладаг бөгөөд эдгээр нь бодлогын олон горимд ажиллах, төвлөрсөн өгөдлийн сан, сүлжээг удирдах, өгөгдлийн сангаас асуулга авах, тайлангууд гаргах, нууцлал болон хэрэглэгчид таатай, уян хатан байдлаараа хангалтгүй байлаа. Төслийн хүрээнд мэдээллийн технологийн иж бүрэн шийдлийг нэвтрүүлснээр банкууд орчин үеийн банкны шинэ үйлчилгээг нэвтрүүлэх, харилцагчдад шуурхай үйлчилгээ үзүүлэх, мэдээллийн нууцлалыг хамгаалах өргөн боломжтой болж байгаа юм. Түүнчлэн, банкны төвүүд салбаруудтайгаа бодит цагийн горим бүхий сүлжээгээр холбогдох болсон нь харилцагчдад өөрийн бизнесийг банкны аль ч салбараас явуулах боломжийг олгох болсон бөгөөд зөвхөн өөрийн салбараас гэсэн хязгаарлалтгүй болж байгаа юм.

АХБ-ны санхүүжилтээр 2000-2003 онд хэрэгжсэн уг төсөл нь Монгол улсын банк санхүүгийн системд бодит цагийн горимд ажиллах программ хангамжийг Монгол улсын 5 банкинд анх удаа амжилттай хэрэгжүүлсэн, бодит цагийн горимыг нэвтрүүлэхийн тулд орчин үеийн мэдээллийн технологийн ололт болох сансрын холбооны Ви Эс Эй Ти (VSAT) системийг анх удаа ашигласан, банкны системийн үйлчилгээнд анх удаа теллер (teller)-ийн горимыг нэвтрүүлсэн, банкны хэмжээнд анх удаа реляц төрлийн Оракл Р Ди Би Эм Эс (Oracle RDBMS) өгөгдлийн санг удирдах системд суурилсан иж бүрэн шийдлийг суурилуулсан, Монгол улсын банк санхүүгийн салбарт анх удаа банкны иж бүрэн программ хангамжийг нэвтрүүлсэн, программ хангамжийн шийдлийн зэрэгцээ анх удаа техникийн болон харилцаа холбооны асуудлыг давхар шийдсэн зэрэг ололт бүхий ажил боллоо.

Тайлант оны эцсийн байдлаар ХААН банкны нийт 47 нэгж, үүнээс орон нутаг дахь 28 салбар, ХХ-ийн банкны 17 салбар нэгжүүд, үүнээс 5 аймаг дахь 6 салбар нэгж, Эрэл банк нь Улаанбаатар хот болон Дархан-уул аймаг дахь салбартайгаа тус системийн бодит цагийн горимд ажиллаж байна. Түүнчлэн Монгол шуудан банк нь Улаанбаатар хот дахь өөрийн 8 салбартайгаа тус системийг ашиглан онлайн горимд харилцагчдын гүйлгээг түргэн шуурхай гүйцэтгэж байна. Энэхүү төслийн сүүлчийн шатанд Хадгаламжийн банк тус системийг нэвтрүүлэх ажлыг эхлэн, өөрийн төв болон Улаанбаатар хот дахь салбарууддаа суурилуулж байна. Банкууд дээрх системээс гадна өөрсдийн нөөц бололцоог ашиглан ижил төстэй системүүдийг суурилуулж байна. Анод, Хас банкууд Орос, Энэтхэг зэрэг улсуудтай мэдээллийн технологийн салбарт хамтран ажиллаж өөрсдийн нягтлан бодох бүртгэлийг шинэ системд шилжүүлсний зэрэгцээ, Голомт банк өөрийн орны мэдээллийн технологийн чиглэлийн хувийн компаниудын нэг болох И Си Эм (ЕСМ) компанийн боловсруулсан программ хангамжаар бүрэн шинэчиллээ. Голомт банк тус системийн тусламжтайгаар Улаанбаатар хот дахь 6 дугаар тооцооны төвтэйгээ бодит цагийн горимд ажилладаг боллоо.

2003 онд Хадгаламж, Зоос банкууд олон улсын бэлэн бус төлбөрийн картыг ашиглах эрхтэй болсноор ихэнх банкууд энэ үйлчилгээг гүйцэтгэх боллоо. Гэвч банкуудын нэвтрүүлж буй системүүд нь нэгдсэн нэг стандартгүй, хууль эрх зүйн зохицуулалтгүй хийгдэж байгаа тул энэ байдлыг арилгах зорилгоор Монголбанкнаас, Монгол улсын төлбөр тооцооны системийг шинэчлэх төслийг эхлүүлээд байна. Тус төсөл нь Монгол улсад бэлэн бус төлбөр тооцооны шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх буюу банк хоорондын төлбөрийн картын үндэсний сүлжээг бий болгох, Төв банкны нягтлан бодох бүртгэл дэх банк хоорондын тооцооны харилцагчдын гүйлгээг нэг бүрчлэн гүйцэтгээд өдрийн эцэст хаадаг байсан “холимог” системийг салган бага дүнтэй гүйлгээний банк хоорондын нет-систем болон их дүнтэй гүйлгээний бодит горимын гросс (gross)-системийг байгуулах, банк санхүүгийн нэгдсэн сүлжээг бий болгох зэрэг зорилготой юм.

Ийнхүү дээрх төслийн хүрээнд Монгол улсад нэгдсэн нэг стандартаар бэлэн бус бүх төрлийн төлбөр тооцоог гүйцэтгэж эхлэх ба банк санхүүгийн компьютерийн нэгдсэн сүлжээг байгуулж бодит цагийн горимд ажиллах банк хоорондын төвийг байгуулахаар зорьж байна.

Тайлант онд банк хоорондын тооцооны түр болон харилцах дансдын хуулгыг цаасан хэлбэрээр, ажлын дараа өдөрт зөөдөг байсныг бүрэн программчилж, тухайн өдөрт багтаан компьютерийн сүлжээг ашиглан файлаар дамжуулдаг болсон нь Төв банк болон банкуудад шинэлэг зүйл байлаа. Түүнчлэн, Төв банк болон орон нутаг дахь салбаруудын хэмжээнд гараар хөтлөдөг байсан материалын картуудыг 2002 онд халсны адилаар үндсэн хөрөнгийн гурван мянга гаруй картыг халж программын аргаар хөтлөх боллоо.

5.5. Бусад үйл ажиллагаа

Удирдлага зохион байгуулалт

Монголбанкны боловсон хүчний бодлого нь санхүү банкны салбарыг тогтворжуулах, банкны бүтцийн өөрчлөлтийг өргөжүүлэн гүнзгийрүүлэх бодлогын чанартай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхэд өндөр боловсрол, мэргэжил эзэмшсэн ажилтнуудыг ажиллуулахад чиглэгдлээ.

Тайлант онд Монголбанк нь удирдлага, 6 газар, 11 хэлтэс, 9 алба, 1 тусгай тасаг, 1 төслийн нэгж, Монголбанкны орон нутаг дахь 19 салбар, 1 төлөөлөгчийн газар гэсэн нэгжүүдэд нийт 310-аад төрийн албан хаагчтай үйл ажиллагаагаа явууллаа.

ББСБ-уудын тоо нэмэгдсэн, ББСБ-ын тухай хууль батлагдан гарсан зэрэгтэй холбоотойгоор холбогдох заавар журмуудыг шинэчлэх, зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан материалыг хянан шийдвэрлэх зэрэг нэлээд ажил нэмэгдсэнтэй холбоотойгоор Хяналт шалгалтын газарт ББСБ-уудын үйл ажиллагааг хариуцсан

хэлтэс байгуулагдлаа. Ингэснээр Хяналт шалгалтын газар нь 4 хэлтсийн зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус банкны нийт ажиллагсдын 66.5 хувь нь төрийн захиргааны албан хаагч, 34.8 хувь нь төрийн үйлчилгээний албан хаагч, 48 хувь нь эмэгтэйчүүд, 52 хувь эрэгтэйчүүд байгаа бөгөөд 46 хувь нь 21-35 насны, 28.8 хувь нь 36-45 насны, 20.4 хувь нь 46-54 насны, 5 хувь нь 55-аас дээш насны ажилтнууд байна.

Албан хаагчдын мэдлэг боловсролыг цаг үеийн шаардлагад нийцүүлэх асуудлын хүрээнд тэдний мэргэжил, ажлын дадлага туршлагыг дээшлүүлэх, нарийн мэргэшил эзэмшүүлэх зорилгоор гадаадын банк, Дэлхийн банк, Олон улсын валютын сан (ОУВС)-гийн институт, Монголбанкны дэргэдэх Банкны сургалтын төв зэргээс зохион байгуулж буй сургалтанд албан хаагчдыг жилд дунджаар 1-2 удаа хамруулдаг. Энэ талаар 1996 оноос эхлэн “Сургалтын хөтөлбөр” боловсруулахдаа газрын захирлуудын саналыг голчлон тусгаж тухайн жилд сургалтанд хамрагдах ажиллагсдын тоо, мэргэжлийн сэдвийг урьдчилан тодорхойлон ажиллаж ирлээ.

Одоогийн байдлаар АНУ, Япон, Австрали, Их Британи, Монгол улсуудад докторын зэргийг 2 (гадаадад хамгаалсан 1, дотоодод хамгаалсан 1), магистрын зэргийг 40 (гадаадад 31, дотоодод 9) ажилтан хамгаалаад байна.

2003-2005 оны хичээлийн жилд Монголбанкны нэр дээр ОХУ, Австрали, АНУ, Япон улс болон эх орондоо докторын сургалтанд 3, магистрын сургалтанд гадаадад 11, дотоодод 9 ажилтан тус тус суралцаж байна.

Монголбанк ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхэд нийгмийн баталгааг (орон сууц, унааны хөнгөлөлт, эрүүл мэнд, соёл олон нийтийн арга хэмжээ) түлхүү анхаарч ирлээ.

Дотоод аудит

Монголбанк нь дотоод аудитын үйл ажиллагааны хүрээнд Дотоод аудитын 2002-2006 оны хөтөлбөр, 2003 оны төлөвлөгөөний дагуу Монголбанкны газар, хэлтэс, орон нутаг дахь салбар нэгжүүдэд төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулж буй эсэхэд хяналт тавьж, эрсдэлийг бууруулах, учирч болзошгүй аливаа эрсдэл, алдагдлаас хамгаалах, зөрчил дутагдлыг илрүүлэн тогтоох, холбогдох арга хэмжээ авах, санал, зөвлөмж болон үүрэг, даалгавар өгөх зэргээр ажиллалаа.

Тайлант онд аудитыг Монголбанкны 5 газар, хэлтэс, орон нутаг дахь салбар, төлөөлөгчийн газрыг бүрэн хамруулан эрсдэл ихтэй, эрсдэл бий болж болзошгүй талбарт голлон чиглүүлж ээлжит, гэнэтийн, хэсэгчилсэн болон мэдээлэл, санал,

гомдлын мөрөөр нийт 47 удаа хийж, илэрсэн зөрчил дутагдалд холбогдох арга хэмжээг цаг тухайд нь авч, хэрэгжилтэнд нь хяналт тавьж ирлээ.

Мөн дотоод аудитын үйл ажиллагааг хагас жил тутам нэгтгэн дүгнэж, Захирлуудын зөвлөлийн гишүүдэд тайлагнаж, аудитын үр дүнгээр холбогдох арга хэмжээ авч ажиллав.

Тайлант онд дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулах, боловсронгуй болгон олон улсын стандартад нийцүүлэх зорилгоор ОУВС-гийн зөвлөмжийн дагуу Монголбанкны үйл ажиллагааны үе шат бүрт бий болсон буюу учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх, хэмжих, үнэлэх, хянах, удирдах замаар түүнийг бууруулах, арилгахад чиглэгдсэн бүтэцтэй дотоод хяналтын системийг бий болгох, мөрдүүлэхэд баримтлах заавар, журмыг боловсруулав. Тухайлбал, “Дотоод аудитын газрын дүрэм”, аудит хийх явцад мөрдөж буй хянан шалгагчдын гарын авлагыг шинэчлэн, аудитын горим, Дотоод аудитын газрын бүтэц, зохион байгуулалтыг тусгасан заавар, журмын төслийг шинээр тус тус боловсрууллаа.

Цаашид Монголбанкны дотоод аудитын бодлого, зарчим, хөтөлбөр, төлөвлөлтийг боловсронгуй болгох, үйл ажиллагаандаа мөрдөх, дээр заасан эрх зүйн актуудыг шинэчлэх, боловсон хүчний мэдлэг боловсролыг дээшлүүлэх зэрэг ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Энэ онд УИХ-аас Монголбанкны Хяналтын зөвлөлийг баталсан нь тус банкны дотоод аудитын үйл ажиллагааг боловсронгуй болгож, Монголбанкны үйл ажиллагаанд үнэн зөв, бодитой дүгнэлтийг цаг тухайд нь оновчтой өгч байх арга хэмжээ болов.

Тайлант онд Дотоод аудитын газар Монголбанкны 2002 оны санхүүгийн тайланг баталгаажуулах болон ОУВС-гийн хүсэлтээр гадаад нөөцийг удирдах үйл ажиллагаанд тусгай аудитыг “Эрнст энд Янг Монгол Аудит” компаниар, Монголбанкны нийгмийн хөгжлийн сан, гадаадын банкинд байршуулсан активууд, гадаад валютын нөөцийн үр ашгийн талаархи шалгалтыг Үндэсний аудитын газраар хийлгэх ажлыг тус тус зохион байгуулж, тухайн газруудаас Монголбанкинд өгсөн зөвлөмжийн биелэлтийг гаргаж, холбогдох арга хэмжээ авч ажиллав.

Бэлэн мөнгөний хангалт

2003 онд Монголбанкнаас мөнгөн тэмдэгттэй холбоотой дараахь үйл ажиллагааг эрхлэн явуулав. Үүнд:

5000-тын дэвсгэртийг шинээр Германы Гийзеке Дэврийнт пүүст захиалж хийлгэн 2003 оны 3 дугаар сараас гүйлгээнд гаргав.

Монголбанкны үндсэн зорилтыг Төв банкны тухай хуулинд Үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангах гэж тодорхойлсон. Бусад зорилтуудад санхүүгийн системийг хянах, тогтвортой эдийн засгийн хөгжлийг хангах, мөнгө зээлийн нөхцлийг сайжруулах зэрэг олон нийтийн эрх ашигт нийцсэн зүйлүүд ордог. Төв банкны хуулиар Монголбанк ашиг олох зорилгыг тавьдаггүй боловч улсын валютын нөөцийг удирдах, банкуудад зээл олгох явцдаа ихээхэн хэмжээний ашигтай ажилладаг. Доорхи хүснэгтэд Монголбанкны ашгийг сүүлийн арван жилийн байдлаар үзүүлэв.

Хүснэгт 1. Монголбанкны ашиг 1993-2002 онд

Он	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002
Ашиг (тэрбум төг)	1.5	0.2	0.7	0.3	0.4	16.4	1.7	4.2	13.9	21.8
Төг/ам\$ Ханш (хугацааны эцэст)	396	414	473	693	813	902	1072	1097	1102	1125
Ашиг (сая ам \$)	3.8	0.6	1.4	0.4	0.4	18.1	1.5	3.8	12.6	19.4

Хүснэгтээс харахад, Монголбанкны жил бүрийн ашиг харилцан адилгүй, огцом хэлбэлзэлтэй явсаар иржээ. Ашгийн хэмжээ ийнхүү хэлбэлзэх нь

ямар хүчин зүйлсээр тодорхойлогддог вэ?

Монголбанкны орлого, зарлагын бүтцийг харахад нийт дүнгээрээ гадаад валютын болон алт үнэт металлын арилжааны орлого, зарлага голлодог. Өөрөөр хэлбэл, Монголбанкны орлого, зарлагын дийлэнх хэсгийг хүүний бус орлого, зарлага эзэлж байна. Энэ нь Монголын Төв банкны үйл ажиллагааны онцлог бөгөөд Монгол улсын алтны зах зээл төв банкныхаа үйл ажиллагаатай 1990-д оны эхэн үеэс нягт холбоотой явж ирсэнтэй холбоотой.

Монголбанк улсын гадаад валютын нөөцийг удирдан аривуулах ажиллагааг хэрэгжүүлдэг. Монголбанкны нийт орлогод гадаад валютын орлогын эзлэх хувийн жин үлэмж хэсгийг нь эзэлдэг. Тэгвэл валютын арилжааны цар хүрээг нэмэгдүүлэх гол хүчин зүйл нь алтны арилжааны цэвэр орлогын өсөлт юм. Жилийн дүнгээр тооцсон Монголбанкны алтны арилжааны цэвэр орлого алтны үнэ хоёрын хооронд төдийлөн өндөр хамаарал ажиглагддаггүй.

Манай улсын хувьд жилээс жилд алт олборлолтын хэмжээ өсөн нэмэгдсээр байгаа нь алтны арилжааны орлогыг алтны үнээс хамааралгүй өсгөсөөр байгаатай холбоотой юм. Сүүлийн жилүүдэд алт олборлолтын хэмжээ нэмэгдэхийн хирээр улсын валютын цэвэр албан нөөц нэмэгдэж улмаар энэ нь валютаар арилжаа хийх эх үүсвэрийг нэмэгдүүлэх бололцоо олгож байна.

Төв банкны ашгийн бас нэгэн эх үүсвэр нь банкуудад олгодог дахин санхүүжилтийн болон Засгийн газарт олгох зээлийн хүүний орлого байдаг. Банкуудад болон Засгийн газарт олгох зээлийн хэмжээ нь Төв банкны бодлогын хэрэгслийн хувьд тухайн жилийнхээ мөнгөний бодлогын зорилтоос шууд хамаардаг.

Банкуудад болон Засгийн газарт олгосон зээлийн хүүний орлого сүүлийн жилүүдэд эрс буурсан. Хүүний орлого ийнхүү буурсан нь банкны системн үйл ажиллагаа тогтворжиж, иргэдийн хадгаламж өсөж улмаар банкуудын илүүдэл нөөцийн хэмжээ нэмэгдснээр Монголбанкнаас банкуудад, Засгийн газарт олгох зээлийн хэмжээ буурсантай шууд холбоотой.

Монголбанкны хүүний төрлийн зардлын хөдөлгөөн нь үндсэндээ ТБҮЦ-ны хүүний зардлын хэмжээгээр тодорхойлогддог бөгөөд энэ мөнгөний бодлогын шууд зардал буюу манай санхүүгийн системн суурь хүү юм. ТБҮЦ-ны хүү буурахын хирээр Монголбанкны зээлийн хүү буурсаар байна.

Банкуудад олгох дахин санхүүжилт, Засгийн газарт олгох зээл зэрэг орлого авчрах активууд, мөн гол зарлагыг гаргаж байгаа ТБҮЦ-ны хүү зэрэг нь бүгд шууд бус бодлогын хэрэгслүүд юм. Өөрөөр хэлбэл, Монголбанкны мөнгөний бодлого голчлон ашигт ажиллагааны хувьд мөнгөн алдагдлыг бий болгодог шууд бус арга хэрэгслүүдээр явагддаг бөгөөд ойрын жилүүдэд ч энэ хандлага үргэлжлэх болно.

Монголбанкны бусад үйл ажиллагааны ашгийг орлого зарлагын тайлангийн бусад орлого зарлага бүрдүүлдэг. Бусад орлого гэсэн бүлэг нь өөртөө шимтгэлийн орлого, үндсэн хөрөнгийн түрээсийн орлого, хүү торгуулийн орлого гэх мэт бусад орлогуудыг хамруулдаг. Бусад зардлын бүлэгт нөөцийн, ажиллагсадын, үйл

ажиллагааны, элэгдлийн гэх мэт бусад зардлууд ордог. Эдгээр зардлууд нь Төв банкны зардлын 5-15 хувийг эзэлдэг тул хөдөлгөөн нь ашигт ажиллагаанд төдийлөн хүчтэй нөлөөлдөггүй.

Нийт банкны салбарын ашигт ажиллагааны түвшин санхүүгийн зах зээл дээр өрсөлдөөн нэмэгдэхийн хэрээр улам бүр буурч байна. Тухайлбал, 2002 оны эцсийн байдлаар банкуудын нийт активын өгөөжийн үзүүлэлтийг татварын өмнөх ашгаар нь тооцоход өмнөх жилээсээ 1.6 нэгжээр буурч 4.3 хувь болжээ. Харин Монголбанкны хувьд нийт активын өгөөж мэдэгдэхүйц хэмжээгээр байнга өссөн үзүүлэлттэй гарчээ.

Монголбанкны ашигт ажиллагааны коэффициентийг 1999-2002 хугацаанд нийт активын өгөөж, өөрийн хөрөнгийн өгөөжийн үзүүлэлтээр тооцсоныг доорхи хүснэгтэд харуулав.

Хүснэгт 2. Монголбанкны ашигт ажиллагааны үзүүлэлт

Үзүүлэлт	1999	2000	2001	2002
Активын өгөөж(хувиар)	0.7	3.1	3.6	4.8
Өөрийн хөрөн- гийн өгөөж (хувиар)	4.0	17.0	34.0	65.0

Нийт салбарын ашигт ажиллагааны үзүүлэлт буурч буй сүүлийн жилүүдэд Монголбанкны ашигт ажиллагаа тогтвортой байсаар байна. Тухайлбал, банкуудын хувьд, активынх нь чанар өмнөх жилүүдээсээ сайжирч, харьцангуй өндөр орлого оруулдаг актив болох

зээлийн өрийн үлдэгдэл эрс нэмэгдсэн. Гэвч зээлийн хүү харьцангуйгаар буурсан, зардал өндөртэй хадгаламж, харилцах өссөнөөс шалтгаалан ашигт ажиллагааны үзүүлэлт нь буурч байна. Монголбанк ашигт ажиллагааны хувьд салбарын нийтлэг чиг хандлагад хамрагдахгүй байгаа нь Төв банкны ашгийн бүтцийн онцлогоос шалтгаалж байна.

Эх үүсвэр: www.mongolbank.mn

500, 1000-тын дэвсгэртийг мөн пүүст дахин нэмж хэвлүүлэн, татан авч 2003 оны 11 дугаар сараас гүйлгээнд гаргав.

Гүйлгээн дэх дэвсгэртийн чанар амархан мууддаг учир дээрх шинээр нэмж хийлгэсэн дэвсгэртүүдийг хир, бохирдолтоос хамгаалах тусгай бодисоор бэхжүүлж, хэд хэдэн нууцлалын онцлог, хийцийг нэмж оруулав.

50, 100-тын дэвсгэртийн нөөц багассан тул 2003 оны 12 дугаар сард нэмж хэвлүүлэх гэрээг тендерийн үндсэн дээр Германы пүүстэй байгуулсан бөгөөд 2004 оны хоёрдугаар улиралд багтааж татан авах төлөвлөгөөтэй байна.

Түүнчлэн, аймаг орон нутгийг салбар банкуудаараа дамжуулж бэлэн мөнгө буюу хэрэгцээт дэвсгэртүүдээр хангах, муудсан мөнгийг татаж устгах, давтан тоолж, хянах ажиллагааг тогтмол явуулж ирлээ.

Тайлант онд Монголбанк 106 тэрбум төгрөгийн муудсан мөнгийг гүйлгээнээс татан авч устгасан бөгөөд 124 тэрбум төгрөгийн шинэ дэвсгэртийг гүйлгээнд гаргасан байна.

Тайлант онд зоосон төгрөгийн эргэлт нэлээн удаан (гүйлгээнд гаргасан хэмжээ бага) байсан бөгөөд энэ нь зоосыг хэрэглэх орчин бүрдэж амжаагүйтэй холбоотой юм.

Жижиг болон дунд дэвсгэртийн хувь хэмжээ бага байгаа нь гүйлгээнд банкнаас гадуур том хэмжээний төлбөр тооцоо явагдсан хэвээр байгаатай холбоотой юм.

Түүнчлэн, 2003 онд Монголбанкны мөнгөн тэмдэгтийг тоолох, ялгах, устгах ажиллагааг сайжруулах, түргэсгэх, түүний аюулгүй байдлыг хангах зорилгоор Германаас мөнгө тоологч, ялгагч BPS 200, мөнгө цоологч BC40 зэрэг машинуудыг авч суурилуулан ажиллуулж байна.

Монголбанкны дэргэдэх Сургалтын төв

Банкны сургалтын төв (БСТ) нь 2003 онд сургалт, семинарыг төлөвлөгөөний дагуу тогтмол явуулж ирсэн ба сургалт семинарыг чанартай зохион байгуулахад гол анхаарлаа хандуулан ажиллалаа. Нийт дотоод, гадаадын сургалт, семинар болон бусад үйл ажиллагаанд давхардсан тоогоор нийт 1768 хүн хамрагдан оролцлоо. Энэ нь банкны салбарт ажиллагсдын 31 хувь юм. БСТ нь энэ онд 41 сэдэв бүхий 45 удаагийн дотоод, гадаадын сургалт, семинарыг зохион байгуулахаар төлөвлөснөөс тайлант онд 40 сэдвээр 54 удаагийн сургалт, семинар зохион байгуулаад байна. Эдгээр сургалт, семинарт нийт 1449 хүн хамрагдсан нь 2002 онтой харьцуулахад 1.8 дахин их байна. Ингэж сургалт, семинарт оролцогсдын тоо эрс нэмэгдсэн нь Монголбанк болон банкууд, мөн зарим ББСБ тус сургалтын төвийн үйл ажиллагааг байнга дэмжин туслалцаа үзүүлэн, сургалт, семинарт өөрсдийн ажиллагсдыг идэвхтэй оролцуулж байгаатай холбоотой юм.

Дотоод сургалтын талаар

БСТ нь банкуудын ажилтнуудын эрэлт хэрэгцээ, шаардлагыг хангахуйц сургалт семинарыг зохион байгуулж явуулахын тулд оны эхэнд банкуудаас санал авч 2003 оны сургалтын төлөвлөгөөг хамтран боловсруулж, уг төлөвлөгөөний дагуу сургалт семинарыг зохион байгуулж явуулсны үр дүнд банкуудаас сургалтанд хамрагдах идэвх сайн байгаа ба энэ онд 36 сэдэв бүхий 48 удаагийн сургалт семинарыг дотооддоо зохион байгуулж, нийт 1361 хүнийг хамруулаад байна.

Тайлант онд БСТ нь өөрийн гишүүн байгууллагуудаас ирүүлсэн 56 санал хүсэлтийг хүлээн авч цаг хугацаанд нь шуурхай барагдуулж ажилласан ба зарим банкуудын хүсэлтийн дагуу төлөвлөгөөнөөс гадуурхи сургалтуудыг зохион байгуулснаас гадна, сургалтын танхим, программ хангамж, тоног төхөөрөмж зэргээр хангаж ажиллав.

Банкны ажилтнуудын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор банк санхүүгийн англи хэлний дамжааг 2 удаа зохион байгуулсан ба нийт 32 хүн дээрх дамжаанд хамрагдсан байна.

Мөн Эрэл банкны хүсэлтийн дагуу англи хэлний дамжааг тус банк дээр ажлын бус цагаар зохион байгуулсан ба энэ дамжаанд 11 хүн хамрагдав. Англи хэлний дамжаанд хамрагдсан нийт 43 хүнээс хичээлийн программыг хангаж шалгалтанд тэнцсэн 31 хүнд сертификат олгов.

Тайлант онд “Банкны ажилтны бизнесийн харилцааны болон үйлчилгээний соёл” сэдэвт сургалтыг 10 банк болон ББСБ дээр зохион байгууллаа. БСТ нь анх удаа өөрийн санаачилгаар, банк санхүүгийн нягтлан бодогчоор цаашдаа өөрийн банкинд ажиллахыг хүссэн, мөн нягтлан бодогч мэргэжлийг эзэмшихийг хүссэн банкуудад ажиллаж байгаа мэргэжлийн бус хүмүүст зориулан нягтлан бодох бүртгэлийн дамжааг зохион байгуулж хичээллүүлээ. Энэхүү дамжаанд 16 хүн хамрагдан оролцсноос 13 хүн шалгалтанд тэнцэж сертификат гардаж авав.

БСТ-өөс 2003 оны 9 дүгээр сарын 22-25-ны өдрүүдэд банк санхүүгийн байгууллагуудын төвлөрсөн байдлыг харгалзан үзэж, Дархан, Эрдэнэт хотуудад үйл ажиллагаагаа явуулж буй банкны салбаруудын ажилтнуудад зориулж, “Бичил зээлийн үйл ажиллагаа, бичил зээл” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Энэ нь тус төвөөс хөдөө орон нутагт бие даан зохион байгуулсан анхны сургалт бөгөөд энэхүү сургалтанд нийт 48 хүн хамрагдснаас Дархан хотоос 12 банкны 25, Эрдэнэт хотоос 10 банкны, 1 ББСБ-ын нийт 23 хүн тус тус хамрагдлаа.

Сургалтын төв нь 2004 онд банкны систем үүсч хөгжсөний 80 жилийн ойг угтаж хөдөө орон нутагт бүсчилсэн хэлбэрээр сургалт, семинарыг банкуудтай хамтран зохион байгуулахаар төлөвлөж байна.

2003 онд 6 удаагийн гадаад сургалт, семинарыг Швед, Люксембург, Англи, Тайвань зэрэг орнуудад Эс Ай Ди Эй (SIDA), Европын сэргээн босголт, хөгжлийн банк (EBRD) болон Азийн бүтээмжийн байгууллагын тусламж санхүүжилтээр зохион байгуулан 89 хүнийг хамрууллаа. Ялангуяа, Монголбанкны Англи дахь төлөөлөгчийн газар, EBRD-тай хамтран зохион байгуулсан банкны удирдлагуудад зориулсан сургалт семинар, уулзалт, ярилцлагууд нь маш үр дүнтэй ажил боллоо. Швед улсад зохион байгуулагдсан 3 удаагийн сургалтанд 30 хүн оролцох байснаас БСТ-ийн хүсэлтийн дагуу 5 хүнийг нэмж дээрх сургалтуудад хамруулав.

Тус сургалтын төвийн санхүүгийн үйл ажиллагаа, чадавхи 2003 онд урьд онуудынхаас эрс сайжирсан юм. Банкууд сургалтын гишүүнчлэлийн татварыг хугацаандаа төлж байгаа нь манай сургалтын төвийн үйл ажиллагааг дэмжиж байгаагийн нэг илрэл бөгөөд энэ нь сургалт, семинар хэвийн явагдах гол нөхцөл болж байна. Тайлант оны нийт орлого 48.4 сая, зарлага 31.3 сая төгрөг байна. Нийт орлогын 31.5 сая төгрөг нь Монголбанк, банкууд болон ББСБ-ын гишүүнчлэлийн татвар, 16.9 сая төгрөг нь тус төвийн идэвхтэй үйл ажиллагааны үр дүнд олсон орлого байна.

Тайлант онд БСТ нь банкуудыг сурталчлах, банкны ажилтнуудын мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадварыг ард түмэнд таниулах, ажилтнуудын хооронд ажлын арга туршлага, мэдээллийг харилцан солилцуулах, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, банкны ажилтнуудын идэвх, ажлын чадавхийг дээшлүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулж явууллаа.

Ардын хувьсгал ялсны дараахь он жилүүдэд Монголын Засгийн газар тухайн үеийн эдийн засгийн чадавхи, мэргэжилтэй ажиллах хүчний хангамжаас шалтгаалан бие даан банк байгуулах боломжгүй байсан учраас Зөвлөлт Холбоот Улсад хүсэлт тавьсны үндсэн дээр 1924 оны 6 дугаар сарын 2-нд Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн Худалдаа ба аж үйлдвэрийн банк байгуулагдаж үйл ажиллагаагаа эхэлж байсан түүхтэй. Байгуулагдсан цагаасаа Монголбанк нь гадаадын банк, санхүүгийн байгууллагуудтай харилцаа тогтоож хамтын ажиллагаагаа өргөжүүлэн тэлэхэд ихээхэн анхаарч ирсэн билээ. Ийнхүү гадаад үйл ажиллагаа жилээс жилд идэвхжиж 1955 онд гадаадын 3 банктай, 1960 онд 17 банктай, 1974 онд дэлхийн 20 гаруй орны 50 орчим банктай шууд харилцаатай ажиллаж байв. 1963 оны 10 дугаар сард Болгар, Унгар, Зүүн Герман, Польш, Румын, Орос, Чехословак болон Монгол улсын Засгийн газар өөрсдийн орнуудад хийгдэж байсан гадаад худалдаанд олон талт тооцооны систем нэвтрүүлэх тухай, мөн Эдийн засгийн хамтын ажиллагааны олон улсын банк (ЭЗХАОУБ) байгуулах тухай хэлэлцээрт гарын үсэг зурсанаар олон талын тооцооны системийг бий болгосон юм. Мөн Эдийн засгийн хамтын туслалцааны зөвлөл (ЭЗХТЗ)-ийн гишүүн орнууд Олон улсын хөрөнгө оруулалтын банк байгуулсан бөгөөд БНМАУ-ын Улсын банк нь эдгээр байгууллагуудын бүрэн эрхт гишүүний хувьд банкны үйл ажиллагаанд бусад гишүүн орны адил тэгш эрхтэйгээр оролцож, тогтоосон журмын дагуу өөрийн орны гадаад төлбөр тооцоог явуулахын зэрэгцээгээр тус улсын эдийн засгийг түргэн хурдацтай хөгжүүлэхэд зориулан зээл авч байсан юм.

Монгол Улс 1991 оноос зах зээлийн харилцаанд шилжиж олон улсын банк, санхүүгийн бусад байгууллагуудтай хамтран ажиллах, үйл ажиллагааны хүрээг өргөтгөх замаар өндөр хөгжилтэй улс орнуудын туршлагаас судлах, тэдгээрийн дэмжлэг туслалцааг авахад ихээхэн анхаарч ажилласан юм. Энэ зорилгоор Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг байгууллагад 1991 онд гишүүнээр элсэж хамтын ажиллагаа идэвхтэй явуулж байна.

Олон улсын валютын сан

Олон улсын валютын сан (ОУВС)-гийн туслалцаатай Монгол Улс шилжилтийн үеийн бэрхшээлийг даван туулах, эдийн засгийн шинэ харилцааны хууль зүйн үндэслэлийг бий болгох, макро түвшин дэх тулгамдсан зорилтуудыг шийдвэрлэх талаар шат дараалсан арга хэмжээг хамтран хэрэгжүүлж ирсэн билээ.

1991 оноос “Стэнд бай” хөтөлбөрийг хэрэгжүүлснээр донор орнуудын зээл тусламжийг ашиглах нөхцөлийг бүрдүүлж уг хөтөлбөрийн хүрээнд хадгаламжийн хүүг нэмэгдүүлэх, заавал байлгах нөөц тооцох хувь хэмжээг өндөржүүлэх, банкуудад зээлийн лимит тогтоох замаар мөнгөний хатуу бодлого явуулж, татварын системийг өөрчлөх замаар төсвийн бодлогыг чангатгасан нь тэр үеийн өндөр хурдцаар өсч байсан инфляцийг сааруулж эдийн засаг тогтворжих хандлагатай болсон байна.

1993 оноос дараагийн шат болох Бүтцийн өөрчлөлтийг дэмжих (ESAF) хөтөлбөрийг хэрэгжүүлэн гадаад ба дотоод эдийн засгийн тэнцвэргүй байдлыг арилгаж, эдийн засгийн өсөлтийг ханган, зах зээлийн эдийн засагт шилжин орох үйл явцыг улам гүнзгийрүүлэн хөгжүүлэх нөхцөлийг бүрэлдүүлж эхэлсэн байна. Хамгийн сүүлийн ESAF хөтөлбөрийг 1999 оны 6 дугаар сард баталсан бөгөөд энэхүү ядуурлын эсрэг хөтөлбөр нь Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах (PRGF) хөтөлбөрөөр солигдсон юм. Уг хөтөлбөр нь анх 2001 оны 9 дүгээр сарын 27-нд Ядуурлыг бууруулах үндэсний стратегийн баримт бичгийн дагуу батлагдан хэрэгжилт дээр Монгол улс, ОУВС өнөөг хүртэл хамтран ажиллаж байна.

Дэлхийн банк

Дэлхийн банкинд гишүүнээр элссэнээс хойшхи хугацаанд тус байгууллага нь манай орны нийгэм, эдийн засгийн хөгжлийг судалж үзээд нэг хүнд ногдох ДНБ-ий үзүүлэлтийг үндэслэн хөгжиж буй ядуу орнуудын А зэрэглэлд оруулж Олон улсын хөгжлийн ассоциац (ОУХА)-аас хөнгөлөлттэй зээл авах боломжийг бүрдүүлж өгсөн юм. ОУХА-ийн зээлийн нөхцөл нь 35-40 жилийн хугацаатай, эхний 10 жилд үндсэн өрийн хөтөлбөрөөс чөлөөлөгдөх, авсан зээлээс жилдээ 0.75 хувийн үйлчилгээний хураамж төлөхөөр нөхцөлтэй байв. Дэлхийн

банкны зээлийн хөрөнгөөр Тогтвортой амьжиргаа, санхүүгийн чадавхийг хөгжүүлэх болон Хувийн хэвшлийг хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлж байна.

Өрхийн тогтвортой амьжиргаа төсөл нь 2002 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд төслийн зээлийг дамжуулан олгох санхүүгийн байгууллагаар Зоос, Улаанбаатар хотын банк, Хадгаламж, Интер, Монгол Шуудан, ХААН, Сити сан, АБТС, Баттөгрөг, Капмон, Кредит Монгол зэрэг банк болон банк бус санхүүгийн байгууллага шалгарсан юм. Эдгээр санхүүгийн байгууллагын төв орон нутаг дахь салбар нэгжээр 2003 оны жилийн эцсийн байдлаар нийт 1855.2 сая төгрөгийн зээлийг 1652 зээлдэгчдэд жилд дунджаар 30.18 (сарын 2.51 хувь) хувийн хүүтэйгээр олгоод байна. Уг төслийн зээлийн 92.4 хувийг орон нутгуудад олгосноос сум болон сумаас алслагдсан нутагт оршин суугчид 37.6 хувийг эзэлж байна. Зээлийг худалдаа, үйлчилгээ, хөдөө аж ахуйн болон хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, сургалтын төлбөр, хувийн болон ахуйн хэрэглээний зориулалтаар олгожээ.

Дэлхийн банкны Санхүүгийн чадавхийг хөгжүүлэх төсөл Монгол улсын Засгийн газар, Олон улсын Хөгжлийн Ассоциацийн 2002 оны 9 дүгээр сард байгуулагдсан гэрээгээр зохицуулагдаж байгаа бөгөөд санхүүгийн салбарын чадавхийг дээшлүүлэх, банкуудын эрсдэлийн удирдлагыг сайжруулах, төлбөрийн системийг боловсронгуй болгох зэрэг үндсэн зорилготой болно. Төслийн хүрээнд төлбөрийн системийг шинэчлэх, бэлэн бус төлбөр тооцооны арга хэрэгслийг нэвтрүүлэх, санхүүгийн байгууллага, харилцагчид, карт эзэмшигчдэд үйлчлэх клирингийн төв байгуулах, түүний техник программ хангамжийг суурилуулах, холбогдох журам заавар, эрх зүйн орчинг бүрдүүлэх, банкны салбарын санхүүгийн нэгдсэн сүлжээ байгуулах ажлыг эхлүүлсэн болно.

Азийн хөгжлийн банк

Монгол улс Азийн хөгжлийн банк (АХБ)-д 1991 онд гишүүнээр элссэнээс хойш тус банкнаас үзүүлэх зээл тусламж, техник туслалцаа жилээс жилд нэмэгдэж байлаа. АХБ нь манай улсын эдийн засгийн бүх салбарт тусламж үзүүлж буй томоохон хандивлагчдын нэг юм.

1999 оныг хүртэл Монголбанкны Ерөнхийлөгч АХБ дахь Монголыг хариуцсан захирагчийн хувьд АХБ-ны зээл тусламжийн асуудлыг хариуцах, АХБ-наас Монголд явуулж буй үйл ажиллагааг зохицуулах ажлыг хийж гүйцэтгэж байсан юм. АХБ Монгол улсад явуулах үйл ажиллагааны анхны дунд хугацааны (1994-1999) стратеги нь Монгол улсыг төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоонд шилжих үйл явцыг түргэтгэхэд чиглэгдэж байсан. 1999 оны 11 дүгээр сард АХБ-наас Монголд явуулах үйл ажиллагааны дунд хугацааны (2000-2005) Ядуурлыг бууруулах стратегийн төслийг боловсруулсан. Энэхүү стратегийн онцлог нь эдийн засгийн өсөлтийг хангах, ядуурлыг бууруулахад хувийн секторын үүрэг оролцоог дээшлүүлэх чиглэлийг баримталж, засаглалыг сайжруулах механизмыг бий болгоход АХБ-ны санхүүжилт чиглэгдэж байсан. Энэхүү санхүүжилтийн хүрээнд АХБ-наас Засаглалын шинэтгэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 25 сая ам. долларын хөнгөлөлттэй зээл олгохоор болсон юм. Уг хөтөлбөрийн зорилго нь Төсвийн байгууллагын санхүүжилтийн удирдлагын үр ашигтай тогтолцоо, хариуцлагын бодит тогтолцоо, ил тод мэдээллийг хүргэх системийг бий болгох замаар Монгол улсад төрийн захиргаа, удирдлагын шинэ тогтолцоонд шилжих үйл явцыг дэмжихэд оршиж байсан болно.

Монгол Улс АХБ-тай "Ядуурлыг бууруулах түншлэлийн гэрээ"-г 2000 онд байгуулснаар уг гэрээг байгуулсан хоёр дахь орон болсон юм.

АХБ-ны зээлээр манай улсад хэрэгжүүлж байсан бүх төслүүд AAA зэрэглэлтэй буюу маш амжилттай хэрэгжиж байгаа гэсэн үнэлгээтэй байсан юм. Мөн АХБ-наас орон сууц, хөдөө орон нутгийн санхүүжилтийн төсөл болон ажлын байр нэмэгдүүлэх төслүүдийг хэрэгжүүлж байна. Орон сууцны санхүүжилт төсөл нь АХБ-ны Захирлуудын зөвлөлөөр 2001 оны 10 дугаар сард зөвшөөрөгдөж, УИХ-ын 2002 оны 4 дүгээр сарын тогтоолоор батлагджээ. Төслийн хүрээнд шинээр орон сууц барих, худалдан авах, засвар хийх үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор Голомт, Зоос, Хадгаламж, Монгол Шуудан бакуудаар дамжуулан зээл олгож байна.

Хөдөө орон нутгийн санхүүжилт төсөл нь АХБ-ны Захирлуудын зөвлөлийн 2001 оны 10 дугаар сард зөвшөөрөгдөж, УИХ-ын 2003 оны 4 дүгээр сард батлагдсан бөгөөд уг төслийн хүрээнд хөдөө орон нутагт хадгаламж зээлийн хоршоо байгуулах, тэдгээрийн үйлчилгээний хүрээг өргөтгөх, санхүүгийн эх үүсвэр, шаардлагатай мэдээллээр хангах ажлыг зохион байгуулж байна.

Зүүн-Өмнөд Азийн төв банкуудын холбоо (SEACEN)

Монголбанк 1999 оны 5 дугаар сард Зүүн-Өмнөд Азийн Төв банкуудын холбоонд гишүүнээр элсэж, тус холбооны гишүүн орнуудад Монгол улс, Монголбанкныг сурталчлах ажлыг зохион байгуулсан байна. 2000 оны 5 дугаар сард SEACEN-ий шинжээчдийн баг хөрөнгийн урсгалын менежментээр дамжуулан санхүүгийн зах зээлийг харилцан мэдээлэл солилцооны үндсэн дээр тогтворжуулах зорилгоор нэгдсэн мэдээллийн санг үүсгэн байгуулсан юм. Үүнтэй холбоотойгоор шинжээчдийн баг (SEACEN EXPERT GROUP) нь өндөр нууцлалтай сүлжээгээр мэдээллийн бүтэц давтамжаас хамааран тодорхой хугацаанд ЗӨАТБ-ын холбоо (SEACEN)-ий төв рүү мэдээг илгээж байхаар тохиролцсон юм.

Бусад байгууллагууд

Гол хөрш орнуудтай эдийн засаг, гадаад худалдааг хөхүүлэн дэмжих зорилгоор ОХУ-ын Төв банктай хамтын ажиллагааны гэрээг 1997 онд, БНХАУ-ын Ардын банктай 1999 онд, Вьетнамын төв банктай 2003 онд тус тус байгуулсан. Түүнээс гадна Монголбанк, Индонезийн Төв банк хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлэх, мэдээлэл солилцох тухай Харилцан ойлголцох санамж бичигт гарын үсэг зурж баталгаажуулсан. Манай улстай адил зах зээлийн системд шилжин орж буй улс орнуудтай туршлага солилцох үүднээс Румын, Унгар улсын төв банкуудтай өмнө тогтоосон уламжлалт харилцаагаа үргэжлүүлэхээр тохиролцсон. Банк хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлэх үүднээс Люксембургийн Төв банктай холбоо тогтоосон ба банкны боловсон хүчин давтан сургах тал дээр Баварын Ландесбанк, Европын сэргээн босголт хөгжлийн банк, Шведийн Олон улсын хөгжлийн агентлаг зэрэг байгууллагатай хамтран ажиллаж байна. Түүнээс гадна Ази, номхон далайн орнуудын банк, санхүүгийн байгууллагуудын 7 дугаар чуулга уулзалтад Монголбанкны төлөөлөгчид оролцсон ба Монголбанкны дэргэдэх банкны сургалтын төв уг байгууллагад 1998 онд гишүүнээр элсэн, цаашид хамтран ажиллах эхлэлийг тавьсан юм.

2001 онд Дэлхийн банкны бүлэгт багтдаг Олон улсын санхүүгийн корпораци-IFC, MIGA зэрэг байгууллагатай харилцаа тогтоож, эдгээр байгууллагад гишүүнээр элсэх, хамтын ажиллагаагаа өргөтгөх алхмуудыг хийлээ.

2002 онд гадаад үйл ажиллагаагаа идэвхтэй явуулах үүднээс санхүүгийн зах зээлийн том төвүүдийн нэг болох Лондон хотноо Монголбанкны төлөөлөгчийн газрыг нээв. Монголбанк мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг олон улсын үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон бөгөөд Монгол улс Ази номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх холбоонд ажиглагчаар элссэн байна.

Эх үүсвэр: www.mongolbank.mn

Гадаад хамтын ажиллагаа

Тайлант онд гадаадын харилцагч банкууд болон олон улсын байгууллагуудтай тогтоосон харилцаагаа үр ашигтай хөгжүүлж ирлээ.

Зүүн өмнөд Азийн Төв банкуудын гүйцэтгэх хорооны анхдугаар хуралдааныг 2003 оны 1 дүгээр сард Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулав. Мөн Зүүн Өмнөд Азийн Төв Банкуудын Холбоо (SEACEN)-ны гишүүн орнуудын хянан шалгагч нарын 4 дүгээр семинар болон хяналт шалгалтын захирлуудын 16 дахь удаагийн уулзалт хурлыг Улаанбаатар хотноо 8 дугаар сард зохион байгуулав.

Уулзалтаар бүс нутгийн гишүүн банкуудын хоорондох судалгааны ажлуудыг нэгтгэн дүгнэж, хянан шалгагч нарын туршлагын талаархи мэдээллийг харилцан солилцов.

Гадаад эдийн засгийн харилцааны төлбөр тооцоог зохион байгуулах тухай Монгол Улсын Төв банк (Монголбанк), Оросын Холбооны Улсын Төв банк хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурсан нь хоёр улсын худалдааг хөгжүүлэхэд чухал алхам боллоо.

Мөн хуучин шилжих рублийн зээлийн өрийг зохицуулах ажлын хэсэгт оролцож ажиллав.

ОУВС болон Дэлхийн банкны ээлжит жилийн хуралд оролцон гадаад хамтын ажиллагааны харилцагч байгууллагуудтай шинээр ажлын холбоо тогтоон, одоо хамтран ажиллаж буй харилцагч нартайгаа ажлын шинэ санаа, үр ашигтай хэлцэл, хамтын ажиллагааны шинэ боломжуудын талаар хэлэлцэн, зарим тохиролцоонд хүрэв. Монгол улсын банк, санхүүгийн систем, эдийн засгийн бодит байдлыг таниулах зорилгоор олон улсын хэмжээнд гардаг Банкер (The Banker), Форчун (Fortune), Евромани (Euromoney), Новая газета зэрэг хэвлэлүүдэд Монгол улсын эдийн засгийн ерөнхий байдал, хөрөнгө оруулалтын орчин, банк санхүүгийн тогтолцооны өнөөгийн байдлын талаар материал бэлтгэн гаргалаа.

Шинээр гадаад харилцаагаа өргөтгөн Сосайти женерал (Societe generale), Мицуй энд Со., Прешиус Металс. Инк (Mitsui and Co., precious Metals. Inc), Кредиттраст банк (Credittrust Bank) зэрэг байгууллагуудтай Ай Эс Ди Эй (ISDA) буюу олон улсын хэмжээнд мөрдөгддөг Мастер гэрээг байгуулав.

Тайлант онд Зүүн Өмнөд Азийн Төв банкуудын холбоо, Дэлхийн банк болон АНУ-ын Холбооны нөөцийн банктай хамтран Ази номхон далайн орнуудын ахлах хянан шалгагч нарын 4 дэх удаагийн семинарыг Монголд амжилттай зохион байгуулсан нь Төв банкны гадаад дахь нэр хүнд өсч байгаагийн нэгэн илрэл мөн.

Монгол улсад банкны байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойд зориулан гадаадын харилцагч байгууллагууд түүхт, ойн сурталчилгаанд зориулж гаргасан Монголбанкны түүхэн баримтыг харуулсан компакт дискэнд Монголбанкны гадаад харилцааны тухай материалыг англи монгол хэл дээр бэлтгэлээ.

Англи улсын Лондон хот дахь Монголбанкны төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа

Англи улсын Лондон хот дахь Монголбанкны төлөөлөгчийн газар нь Монгол улсын валютын нөөцийг өсгөн нэмэгдүүлэх, удирдахтай холбогдуулан олон улсын

банк санхүүгийн байгууллагуудтай харилцаа, холбоо тогтоон хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгийн болон мөнгөний зах зээл, түүний шинэ бүтээгдэхүүний судалгаа хийх, мэдээлэл цуглуулах үндсэн үүрэгтэй ажиллаж байна.

Уг төлөөлөгчийн газар нь 2003 онд Англи, Люксембург, Герман улсын Төв банкуудтай мэдээлэл, мэргэжилтэн солилцох, сургалт, семинар явуулах, Монгол-банкны ажилтнуудыг удаан хугацаагаар дадлага хийлгэх зэрэг асуудлаар хамтран ажиллах хэлцэл тохиролцоонд хүрч, эдгээр ажлууд амжилттай хэрэгжиж байна.

Тухайлбал, банкны захирлуудыг Лондон, Люксембург хотод айлчлуулж семинар, сургалт зохион байгуулж, дэлхийн нэр хүндтэй, томоохон банк санхүүгийн байгууллагуудтай танилцуулсан нь Монголын банкны салбарыг дэлхийн банк санхүүгийн зах зээлд танилуулахад чухал ач холбогдолтой болсон юм. Ялангуяа, энэ айлчлалын үеэр ЭСЯ-тай хамтран зохион байгуулсан уулзалт, хүлээн авалтанд ИБУИНВУ-ын Хан хүү Андрей, Европын Сэргээн Босголт, Хөгжил (ЕСБХ)-ийн банк, Английн Төв банк, Эйч Эс Би Си (HSBC), Баркли (Barclay), Жэй Пи Морган (JP Morgan), Р Би Эс (RBS) зэрэг дэлхийн нэр хүндтэй, томоохон банкуудын удирдлага, төлөөлөгчид оролцсон нь цаашдын хамтын ажиллагаанд чухал алхам боллоо.

ЕСБХ болон ЭСЯ-тай хамтран Монголын хөрөнгө оруулагчдын дугуй ширээний уулзалтыг тус банкны захирлуудын жилийн уулзалтын өмнө Лондон хотод тус банкин дээр зохион байгуулж байгаа бөгөөд уг арга хэмжээнд Монголбанк болон банкууд оролцож Монголын эдийн засаг, банк санхүүгийн салбарт хийгдэж байгаа өөрчлөлт, шинэчлэлт, ирээдүйн чиг хандлагын талаар Лондон дахь банк санхүүгийн байгууллага, олон нийгэд танилцуулах юм. Энэ нь ЕСБХ-ийн банкнаас Монгол улстай хамтран ажиллах хүрээг өргөжүүлэхэд чухал ахиц болов.

Банкны боловсон хүчинг сургах, мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх талаар боловсруулсан сургалтын төсөл, хөтөлбөрийг ЕСБХ-ийн банк хүлээн авч санхүүжүүлэхээр шийдвэрлэлээ. Үүнд Монголбанкны 20, банкуудын 30, нийт 50 хүнийг Лондон, Люксембург хотуудад сургаж, гадаадын банкны мэргэжилтнүүдээр Монголд 5 удаа семинар, сургалт зохион байгуулахад 120 хүнийг, бүгд 170 хүнийг хамарсан сургалтын 400.0 сая төгрөгийн буцалтгүй тусламжийн төсөл амжилттай хэрэгжиж байна.

Алтны хөрөнгө оруулагчдын Лондонд болсон дээд хэмжээний чуулга уулзалтанд дэлхийн Төв банкуудыг төлөөлж Монголбанкны Ерөнхийлөгч төлөөлөгчийнхээ хамт оролцсон нь Монголбанк, Монголын алтны салбарын нэр хүндийг өндөр түвшинд таниулах сайхан боломжийг бий болгосноос гадна манай алтны салбарын төлөөлөгчдийг алт санхүүжүүлэгч банк санхүүгийн байгууллагуудтай уулзуулсан нь алтны үйлдвэрлэлийг бага хүүтэй санхүүжүүлэх эх үүсвэр олох, стратегийн хөрөнгө оруулагчидтай холбоход ихээхэн ач холбогдолтой болсон юм.

Монгол улсын хөрөнгө оруулалтын зэрэглэлийг тогтоолгох, уг зэрэглэлийг нэмэгдүүлэх боломж, цаашилбал, дэлхийн үнэт цаасны зах зээлд Монгол улсын байр суурийг бий болгох, тус зах зээлээс санхүүгийн хямд эх үүсвэрийг олж авах нөхцөлийг бий болгох талаар дэлхийд нэртэй банкуудтай хамтран ажиллаж, Баркли банкны мэргэжилтнүүдээр Засгийн газрын удирдах ажилтнуудад сургалт, семинар зохион байгуулсан нь олон улсын үнэт цаасны зах зээлд гарах бэлтгэл ажлын эхлэлийг тавьлаа.

Англид ажиллаж, амьдарч байгаа Монголчуудын дунд Монголд шилжүүлж байгаа мөнгөн гуйвуулгын судалгаа явуулсан нь төлбөрийн тэнцлийг үндэслэлтэй гаргах, хөрөнгийн урсгалыг зөв тогтоох, хоёр орны хооронд хийгдэж байгаа мөнгөний урсгал хөдөлгөөн Монгол улсын эдийн засаг, валютын ханшид хэрхэн нөлөөлж байгаа, гадаадад амьдарч байгаа монгол иргэдэд банк санхүүгийн ямар үйлчилгээ үзүүлэх боломжтой талаар дүгнэлт хийх зэрэг боломжуудыг олголоо. Банкны байгууллагаас гадна СЭЗЯ, ХХААЯ, Үнэт цаасны хороо, Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн газруудыг ижил төстэй байгууллагуудтай холбож, хамтран ажиллахад мэргэжлийн туслалцаа дэмжлэг үзүүлж байна.

Түүнчлэн, европын телевизийн бизнесийн нэвтрүүлэг, Төв банкуудын хэвлэлийн газар, банк санхүүгийн нийгэмлэг, холбоогоор дамжуулан Монгол улсын эдийн засаг, банк санхүүгийн салбар, хувьчлалын талаар гадаадын байгууллагуудад танилцуулах, сурталчлах, мэдээллэх ажлыг гүйцэтгэж байна.



БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХӨГЖИЛ

6 БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН ХӨГЖИЛ

Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн Монгол Улсын хуулиар Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд Монголбанкны Ерөнхий менежерийн бүрэн эрхийг тогтоосон 28¹ дүгээр зүйлийг шинээр оруулж, хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтыг Монголбанкны Ерөнхийлөгч Монголбанкны зохион байгуулалтын бүтцийг тогтоож байхаар өөрчлөн найрууллаа.

Эрдэнэсийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн Монгол улсын хуулиар мөн эрдэнэсийн санг эрхлэх нэгжийн орон тоо, цалингийн санг Монголбанкны зардлын төсөвт багтаан тогтоож, захирлыг нь томилж, чөлөөлөх эрхийг Монголбанкны Ерөнхий менежерийн бүрэн эрхэд хамааруулж, Монголбанкны Ерөнхийлөгч эрдэнэсийн санг эрхлэх нэгжийн бүтцийг тогтоож байхаар хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг өөрчлөн найруулжээ.

Эдгээр нэмэлт, өөрчлөлт нь Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтын тухай хуулийг Монгол улс батлан мөрдөх болсонтой холбогдуулж оруулсан ба Монголбанкны Ерөнхий менежер нь Монголбанкны орон тоо, цалингийн санг тогтоох, ажилтныг ажилд томилох, чөлөөлөх, урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах эрхтэй байх юм.

Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2003 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн Монгол улсын хуулиар дараахь нэмэлт, өөрчлөлт оруулав.

Нэг. Нэмэлт орсон зүйл, заалт:

1/ 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт 5,6,7 дахь заалт

5/ Засгийн газар, банкнаас бусад хуулийн этгээд, иргэнд зээл, төлбөрийн болон банкны баталгаа гаргах;

6/ хуулийн этгээд, иргэний дотоод, гадаадаас авах зээлийг дэмжих зорилгоор алт болон нөөц активыг барьцаалах;

7/ улсын төсөвт тусгагдаж УИХ-аар батлагдсан, энэ хуулиар зөвшөөрснөөс бусад, хуулийн этгээд, иргэний эдийн засгийн буюу арилжааны үйл ажиллагааг дэмжсэн тэнцлийн болон тэнцлийн гадуурхи аливаа гүйлгээ хийх;

2/ 27¹ дүгээр зүйл

1. Монголбанкны дотоод хяналтын үйл ажиллагаа, хөндлөнгийн аудитын санал, зөвлөмжийн хэрэгжилт, хөрөнгө оруулалтын багц болон Монголбанкнаас санхүүгийн тайлангаа УИХ, олон нийтэд тайлагнаж, мэдээлж байгаа байдал, Монголбанкны Зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавих эрх бүхий орон тооны бус Хяналтын зөвлөл ажиллана. Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг УИХ тогтооно.

2. Хяналтын зөвлөл нь төрийн мөнгөний бодлоготой холбоотой асуудлаар шийдвэр гаргахад аливаа хэлбэрээр оролцохгүй.

3. Хяналтын зөвлөл нь дарга, 6 гишүүнээс бүрдэнэ. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны санал болгосноор УИХ-аас 6 жилийн хугацаатай томилж, чөлөөлнө.

4. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн нь банк, санхүү, эдийн засаг, хууль зүйн чиглэлээр мэргэшсэн, эдгээр салбарын ажлын дадлага туршлагатай, ёс зүйн хувьд төлөвшсөн, дараахь шаардлагыг хангасан хүн байна:

1. Монгол Улсын 30-аас дээш насны иргэн, ял шийтгэлгүй;
2. Банк, санхүү, эдийн засаг, хууль зүйн мэргэжлээр магистрын болон түүнээс дээш зэрэг, цолтой;

5. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнээр банк, санхүү, эдийн засгийн салбарын асуудал хариуцсан төрийн байгууллагад өмнө нь ажиллаж байсан хүнийг томилж болно.

6. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнээр УИХ-ын болон Засгийн газрын гишүүн, төрийн болон улс төрийн бусад албан тушаалтан, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, төрийн захиргааны албан тушаалтан, Монголбанкны удирдах албан тушаалтныг томилж үл болно.

7. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг үүрэгт ажлаас нь дараахь байдлаар чөлөөлж болно:

1. биеийн эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар албан үүргээ цаашид гүйцэтгэх боломжгүй гэж үзэж, уг ажлаас чөлөөлж өгөхийг хүссэн;
2. үүрэгт ажлаа хангалтгүй биелүүлсэн;
3. гэмт хэрэг үйлдсэнийг нь шүүх тогтоосон;

4. ашиг сонирхлын зөрчил үүссэн;

8. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг энэ хуулийн 27¹ дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд чөлөөлж үл болно.

9. Хяналтын зөвлөл нь энэ хуулийн 27¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийг дараахь хүрээнд хэрэгжүүлнэ:

1. Монголбанкны Зөвлөлийн үйл ажиллагааг тогтоосон журмын дагуу авч хэлэлцэх;
2. Монголбанкны дотоод аудитын газрын хянан шалгагч болон тус банкны санхүүгийн тайланд аудит хийсэн байгууллагын аудитортой харилцаж, санал солилцох;
3. шаардлагатай гэж үзвэл Монголбанкны үйл ажиллагаа, менежментийн аливаа асуудал, тодорхой гүйлгээнд шалгалт, аудит хийлгэх санал гаргах;
4. Монголбанк энэ хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу УИХ-д тайлан танилцуулга хүргүүлэх үед өөрийн үйл ажиллагааны тайланг хүргүүлж байх;

Хоёр. Өөрчлөн найруулсан зүйл, заалт:

28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт:

4. энэ хуулийн гурав, дөрөвдүгээр бүлэгт тодорхойлсон Монголбанкны үйл ажиллагааг явуулахад шаардлагатай тохиолдолд Засгийн газар буюу банкны нэрийн өмнөөс өөрийн хөрөнгийн хэмжээнд багтаан зээл, төлбөрийн болон банкны баталгаа гаргаж болно;

29 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

2. Монголбанкны албан тушаалтан, Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн нь албан үүргийнхээ дагуу олж авсан мэдээллийн нууцлалыг хуульд зааснаас бусад тохиолдолд үүрэгт ажлаасаа чөлөөлөгдснөөс хойш ч задруулж үл болно,

30 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

4. УИХ Монголбанкны үйл ажиллагаа хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, энэ хуулийн 27¹ дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн 4 дэх заалт, 30 дугаар зүйлийн 1-3 дахь хэсэгт заасан тайлан, танилцуулгатай танилцах бөгөөд ингэхдээ төрийн мөнгөний бодлого хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцохгүй.

Энэ хууль батлагдсантай холбогдуулж, УИХ-ын 2003 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн 39 дугаар тогтоолоор Монголбанкны Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг батлав. Журмаар хяналтын зөвлөлийн ажиллах нөхцөл, хэлбэрийг тодорхойллоо.

**МОНГОЛБАНКНААС 2003 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН БА
ТЕХНИКИЙН ШИНЖ ЧАНАРТАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУРААНГУЙ**

Сар, өдөр	Дугаар	Нэр	Агуулга
01.02	01	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Банкны үйл ажиллагаа, санхүүгийн байдалд газар дээр нь иж бүрэн шалгалт хийж үнэлгээ, дүгнэлт өгөх журам)	Банкны үйл ажиллагаа, санхүүгийн байдлыг хянаж, үнэлэлт, дүгнэлт өгөхдөө харгалзах чанарын хүчин зүйлсийг тодорхойлох аргачлалыг нэмлээ.
02.26	99	Үнэт металл олборлогч, арилжаа-лагчдын хүсэлтээр арилжаа хийхэд мөрдөх журам батлах тухай	Улсын экспортын чухал түүхий эд болох үнэт металл олборлогч, арилжаалагчдын бүтээгдэхүүнийг дэлхийн түүхий эдийн зах зээл дээрх үнийн уналтаас хамгаалах, улсын экспортын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанкаар дамжуулан арилжаа хийх боломжийг энэ журмаар бүрдүүлэв.
03.13	136	Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам батлах тухай	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль батлагдан гарсантай холбогдуулж, Монголбанкнаас банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журмыг тодорхой болгов.
04.22	192	Банкны дүрмийн үлгэрчилсэн загварт өөрчлөлт оруулах тухай	Иргэний хууль болон Мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулж, журмын нэр, 8 заалтын дугаарыг өөрчлөв.
04.23	195	Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2000 оны “Үлгэрчилсэн удирдамж, заавар батлах тухай” 23 тоот тушаалд “Банкны иж бүрэн шалгалт хийхэд орон нутаг дахь салбар, нэгжид баримтлах үлгэрчилсэн удирдамж” гэсэн 3 дугаар хавсралт нэмж, түүгээр шалгах ажлын хүрээ, шалгалтын дүн гаргах процессыг тодорхойлж өгөв.
05.06	229	Журам батлах тухай (Банк хоорондын төлбөр тооцооны журам, Банк хоорондын төлбөр тооцоог гүйцэтгэх ажлын гэрээ)	Банк хоорондын төлбөр тооцоог бүрэн автоматжуулж, механик ажиллагааг халснаар төлбөр тооцоог шуурхай хурдан гүйцэтгэх боломжтой болгосон бөгөөд төлбөр тооцоо гүйцэтгэсний төлөө банкуудаас авах шимтгэлийн хэмжээг төлбөр гүйцэтгэх хугацаатай уялдуулан шинээр тогтоов. Журамд орсон эдгээр өөрчлөлттэй нийцүүлж, гэрээний загварыг шинэчиллээ.
05.06	230	Журам батлах тухай (Банкны төлбөр тооцоонд залруулгын гүйлгээ хийх, түүнд хяналт тавих журам)	Банкны өдөр тутмын гүйлгээний үнэн зөв байдлыг хангах, буруу хийгдсэн гүйлгээг залруулах арга хэлбэрийг тодорхой болгох, түүнд тавих хяналтыг сайжруулах зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 1996 оны 263 тоот тушаалыг хүчингүй болгож, журмыг шинэчлэн баталлаа.
05.08	234	Банкинд олгох санхүүжилтын журам батлах тухай	Монголбанкнаас банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг богино хугацаанд хангахад санхүүжилтийн 3 хэлбэр (хямдруулалтын, репо, овернайт зээл)-ийг ашиглаж байхаар шинээр журамлав.

05.30	271	Аргачлал батлах тухай	Энэхүү аргачлалд банкны байгууллагын стратеги зорилтыг тодорхойлоход удирдлагын шат бүрт анхаарах асуудал, эрх мэдлийн хуваарилалт, зохион байгуулалтын талаархи зөвлөмжийг тусгав.
07.14	371	Банкуудаас олон нийтэд мэдээллэх үзүүлэлтийн тухай	Банкны үйл ажиллагааг олон нийтэд үнэн зөв, ил тодоор мэдээллэх боломжийг хангах зорилгоор мэдээллэх үзүүлэлт, санхүүгийн тайлангийн загварыг баталж, мөрдүүлээ.
08.13	404	Журам батлах тухай (Монголбанкны гадаад улс дахь төлөөлөгчийн үйл ажиллагааны журам)	Төв банкны үйл ажиллагааг гадаад улс оронд төлөөлж ажиллах ажилтанд тавих шаардлага, төлөөлөгчийн ажиллах нөхцөл, баталгаа, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлов.
10.30	549	Нягтлан бодох бүртгэлийн багц материал батлах тухай	Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдөх
10.31	556	Банк байгуулах зөвшөөрөл олгох тухай	Чингис хаан банкныг үүсгэн байгуулагчид банк байгуулж, банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгов.
11.12	576	Журам батлах тухай (Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тооцох журам)	Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны эрсдэлийг үнэлж, дүгнэхэд баримтлах шалгуур үзүүлэлтийг олон улсын стандартын дагуу боловсруулж батлав.
12.30	637	Журам шинэчлэн батлах тухай (Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам)	Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд өөрийн хөрөнгө нийт цэвэршүүлсэн активын зохистой харьцааг 40 хувиас багагүй, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн 10 хувиас доошгүй, холбогдох этгээдэд олгох зээл, түүнтэй адилтган тооцох активын хэмжээ өөрийн хөрөнгийн 10 хувь, нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 25 хувиас хэтрэхгүй, гадаад актив, пассивын зөрүү +/- 40 хувиас хэтрэхгүй байхаар тогтоолоо.
12.30	638	Аргачлал батлах тухай (ББСБ-ын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих аргачлал)	ББСБ-ын үйл ажиллагааны тайлан, тэнцэлд үндэслэн тэдгээрт учирч болзошгүй эрсдэлийг хянах зорилгоор зайнаас хяналт тавих журмыг баталж мөрдүүлээ.
12.30	639	Журам батлах тухай (ББСБ-ын үйл ажиллагаа, санхүүгийн байдалд газар дээр нь шалгаж, үнэлгээ, дүгнэлт өгөх журам)	ББСБ-ын үйл ажиллагаа, санхүүгийн байдлыг газар дээр нь хянан шалгаж, САМЕЛС аргачлалаар үнэлж, дүгнэж байхаар оруулав.

АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Монголбанкны Төлөөлөн Удирдах Зөвлөлд

Бид 4-39 дүгээр хуудсанд үзүүлсэн Монголбанкны 2003 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаархи санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ. Эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэх нь Банкны захирлуудын үүрэг байна. Бидний үүрэг бол хийж гүйцэтгэсэн аудитдаа үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар дүгнэлтээ гаргах явдал юм.

Дүгнэлт гаргах үндэслэл

Бид аудитаа зохих Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартууд нь санхүүгийн тайлангууд материаллаг хэмжээний алдаагүй эсэхийг нотлох хангалттай нотолгоо олж авахын тулд аудитаа төлөвлөн гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитын явцад санхүүгийн тайланд тусгагдсан дүн мэдээ, тодруулгын дагалдах нотолгоог түүврийн аргаар шалгах ажил ордог. Мөн түүнчлэн аудитын явцад санхүүгийн тайлангуудын ерөнхий танилцуулгад үнэлэлт өгөх, захирлуудын хийсэн томоохон тооцоолол, ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг үнэлэх зэрэг ажил багтдаг. Бидний гүйцэтгэсэн аудитын үр дүн нь дүгнэлт гаргахад хангалттай үндэслэл болсон гэдэгт бид итгэлтэй байна.

Улсын төсөвт шилжүүлсэн хуримтлагдсан ашиг

Банк нь 2003 оны 10 сарын 9-нд Улсын төсөвт 2002 оны 12 сарын 31-нээрх нийт хуримтлагдсан ашиг болох 6.63 тэрбум төгрөгийг шилжүүлсэн байна. Энэ нь “Монголбанкны цэвэр орлогыг дор дурдсан дарааллаар хуваарилна:-

- 40-өөс доошгүй хувийг Ерөнхий нөөцийн санд шимтгэх;
- энэ хэсгийн 1-д заасан гүйлгээг хийсний дараа үлдэх хэсгийг улсын төвлөрсөн төсөвт шилжүүлэх.” гэж заасан Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 38 дугаар зүйлтэй зөрчилдөж байна.

Ерөнхий нөөцийн санд шимтгэлгүйгээр нийт дүнг шилжүүлэх тухай Монгол-банкны Ерөнхийлөгчийн саналыг баталсан Улсын Их Хурлын Байнгын Хорооны захидал дээр үндэслэн Улсын Их Хурал уг саналыг баталсан байна.

Улсын төсөвт шилжүүлсэн хуримтлагдсан ашиг (Үргэлжлэл)

Уг шилжүүлгийг буруу хийсний улмаас Банк нь “Монголбанкны өөрийн хөрөнгийн сангуудыг байгуулах, зарцуулах, цэвэр орлогыг хуваарилах журам”-ын 6 дугаар заалтыг зөрчсөн байна. Энэ журамд Банкны ерөнхий нөөцийн сангийн хэмжээ нь дүрмийн сангийн хэмжээнээс багагүй байна гэж заасан байдаг. 2003 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ерөнхий нөөцийн сан нь 3.4 тэрбум төгрөг байгаа ба энэ нь 5 тэрбум төгрөгийн дүрмийн сантай харьцуулахад 1.6 тэрбум төгрөгөөр бага байгаа юм.

Зөвшөөрөгдөөгүй талуудад олгосон зээлүүд

Төв Банкны тухай хуулийн 23 дугаар зүйлд Монголбанк нь Засгийн газар болон банкнаас бусад хуулийн этгээд, иргэний мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалах, төлбөр тооцоо хийх, зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно гэж заасан. Санхүүгийн тайлангийн Тодруулга 18-д үзүүлснээр, 2003 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар компаниудад олгосон зээлд хугацаа дууссан санхүүгийн хэрэгслээс уул уурхайн компаниудаас авах авлагад дахин ангилагдсан 18.5 тэрбум төгрөгийн зээл багтаж байна. Бидний дүгнэлт гаргах өдөр хүртэл энэ дүн эргэн төлөгдөөгүй байсан. Иймээс Банк нь Төв Банкны тухай хуулийн 23 дугаар зүйлийг зөрчсөн гэж бид үзэж байна.

Санхүү Эдийн Засгийн Яаманд олгосон урьдчилгаа

Санхүүгийн тайлангийн Тодруулга 16-д тусгаснаар Төв Банкны тухай хуулийн Засгийн газарт олгох зээлийн хэмжээг тогтоосон 18 дугаар зүйлд зээлийн үлдэгдлийн нийт хэмжээ нь дотоодын төсөвт сүүлийн гурван жилд орсон орлогын дунджийн 10 хувиас хэтрэхгүй байна гэж заажээ. Дүгнэлт гаргах өдрийг хүртлэх байдлаар Засгийн газарт олгосон урьдчилгаа нь 10 хувиас хэтэрсэн байна. Тиймээс Банк нь Төв Банкны тухай хуулийн 18 дугаар зүйлийг зөрчсөн байна.

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр, дээрх хэсгүүдэд дурдсан асуудлуудын санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллүүдээс бусдаар уг санхүүгийн тайлангууд нь 2003 оны 12 дугаар сарын 31-ний байдлаархи Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн мөнгөн гүйлгээ, үр дүнг үнэн зөв, бодитой илэрхийлэх үүднээс зохих Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон Монголбанкнаас баталсан дүрэм журмын дагуу бэлтгэгдсэн байна.



Улаанбаатар хот
2004 оны 4 дүгээр сарын 5

МОНГОЛБАНК (ТӨВ БАНК)

ОРЛОГО, ЗАРЛАГЫН ТАЙЛАН

(2003 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн)

	Тодруулга	2003 Сая төгрөг	2002 Сая төгрөг
Хүүгийн орлого	5	6,944	7,541
Хүүгийн зардал	6	(7,483)	(5,313)
Цэвэр хүүгийн (зардал) орлого		(539)	2,228
Мөнгөжсөн алтны арилжааны цэвэр (алдагдал)/ашиг		(999)	11,507
Гадаад валютын арилжааны цэвэр ашиг		20,120	12,822
Үйл ажиллагааны бусад орлого		843	345
Хүүгийн бус цэвэр орлого		19,964	24,674
Нийт орлого		19,425	26,902
Сангууд	7	31	1
Захиргааны зардал	8	(3,330)	(2,827)
Үйл ажиллагааны бусад зардал	9	(7,027)	(2,314)
Тайлант оны ашиг		9,379	21,762

ТАЙЛАН ТЭНЦЭЛ

(2003 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар)

		2003	2002
	Тодруулга	Сая төгрөг	Сая төгрөг
АКТИВ			
Бэлэн мөнгө	10	13,234	13,771
Мөнгөжсөн алт, үнэт металл	11	15,430	63,010
Гадаадын үнэт цаасан дахь хөрөнгө оруулалт	12	77,370	51,321
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	13	220,820	253,855
Дотоодын санхүүгийн байгууллагуудад олгосон зээл, урьдчилгаа	14	12,992	8,326
Засгийн газрын үнэт цаас	15	4,000	-
Санхүү, эдийн засгийн яаманд олгосон урьдчилгаа	16	215,054	39,807
Аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл	17 & 18	18,532	165
Бусад актив	19	507	1,100
Үндсэн хөрөнгө	20	14,370	13,524
НИЙТ АКТИВ		592,309	444,879
ПАССИВ БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ			
Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө		152,827	134,643
Гаргасан үнэт цаас	21	75,734	60,810
Гадаад валютаарх пассив	22	182,753	130,704
Засгийн газрын байгууллагуудын харилцах хадгаламж	23	92,026	19,091
Дотоодын санхүүгийн байгууллагуудын харилцах хадгаламж	24	47,969	44,155
Бусад пассив	25	3,540	20,767
НИЙТ ПАССИВ		554,849	410,170
ДҮРМИЙН БОЛОН НӨӨЦИЙН САН			
Дүрмийн сан	26	5,000	5,000
Хуримтлагдсан ашиг		1,943	6,628
Нөөц	27	30,517	23,081
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		37,460	34,709
НИЙТ ПАССИВ БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		592,309	444,879
ХҮЛЭЭХ ҮҮРЭГ БА БОЛЗОШГҮЙ ЗҮЙЛС	29	64,766	3,639,539

Хавсралт тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МОНГОЛБАНК (ТӨВ БАНК)

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН (2003 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн)

	Тодотгол	Дүрмийн сан	Хуримтлагдсан ашиг	Ерөнхий ноогийн сан	Дахин үнэлгээний сан	Гадаад валютын дахин үнэлгээний сан	Нийт сая төгрөг
2002.01.01-ний байдлаар		1,000	9,954	3,404	12,239	10,425	37,022
Тухайн жилийн ашиг		-	21,762	-	-	-	21,762
Дүрмийн санд шилжүүлсэн		4,000	(4,000)	-	-	-	-
Дахин үнэлгээний нөөцөд шилжүүлсэн		-	-	-	14,194	(14,194)	-
Улсын төсөвт шилжүүлсэн	28	-	(10,954)	-	(7,423)	-	(18,377)
Нийгмийн хөгжлийн санд шилжүүлсэн		-	(3,000)	-	-	-	(3,000)
Нөөцөд шилжүүлсэн бодит бус ашиг		-	(7,134)	-	7,134	-	-
Худалдах боломжит санхүүгийн хөрөнгийн цэвэр алдагдал		-	-	-	(6,781)	-	(6,781)
Ханшийн тэгшитгэлийн зөрүү		-	-	-	-	3,769	3,769
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний цэвэр ашиг		-	-	-	314	-	314
2002.12.31-ний байдлаар		5,000	6,628	3,404	19,677	-	34,709
Тухайн жилийн ашиг		-	9,379	-	-	-	9,379
Нөөцөд шилжүүлсэн бодит бус ашиг		-	(7,436)	-	7,436	-	-
Улсын төсөвт шилжүүлсэн	28	-	(6,628)	-	-	-	(6,628)
2003.12.31-ний байдлаар		5,000	1,943	3,404	27,113	-	37,460

Хавсралт тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(2003 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн)

	2003 сая төгрөг	2002 сая төгрөг
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Тухайн жилийн ашиг	9,379	21,762
<i>Залруулга:</i>		
Нөөцөд байршуулсан худалдах боломжит санхүүгийн хөрөнгийн цэвэр бодит ашиг/ алдагдал	-	(2,698)
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бодит бус ашиг	-	(605)
Үндсэн хөрөнгийн хасалт	846	681
Үндсэн хөрөнгийн хасалтын алдагдал	25	1
Элэгдэл	527	503
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг	10,777	19,644
<i>Активын өсөлт/бууралт:</i>		
Мөнгөжсөн алт, үнэт металл	47,580	4,818
Гадаадын үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	(26,049)	(27,509)
Дотоодын санхүүгийн байгууллагуудад олгосон зээл, урьдчилгаа	(4,666)	(1,109)
Засгийн газрын үнэт цаас	(4,000)	13,570
Санхүү, эдийн засгийн яаманд олгосон урьдчилгаа	(175,247)	(1,493)
Аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл	(18,367)	-
Бусад актив	593	(984)
<i>Пассивын өсөлт/бууралт:</i>		
Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө	18,184	15,437
Гаргасан үнэт цаас	14,924	10,810
Гадаад валютаарх пассив	52,049	1,359
Засгийн газрын байгууллагуудын хадгаламж	72,935	5,785
Дотоодын санхүүгийн байгууллагуудын хадгаламж	3,814	17,574
Бусад пассив	(17,227)	13,113
Үйл ажиллагаанаас орсон/(гарсан) цэвэр мөнгөн хөрөнгө	(24,700)	71,015

МОНГОЛБАНК (ТӨВ БАНК)

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

(2003 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн)

	2003 сая төгрөг	2002 сая төгрөг
Үйл ажиллагаанаас орсон/(гарсан) цэвэр мөнгөн хөрөнгө	(24,700)	71,015
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ОРСОН МӨНГӨН ХӨРӨНГӨ		
Засгийн газарт шилжүүлсэн	(6,628)	(18,377)
Нийгмийн хөгжлийн санд хуваарилсан	-	(3,000)
Санхүүгийн үйл ажиллагаанаас орсон цэвэр мөнгөн хөрөнгө	(6,628)	(21,377)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ОРСОН МӨНГӨН ХӨРӨНГӨ		
Үндсэн хөрөнгийн борлуулалтын орлого	6	2
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	(2,250)	(1,826)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас орсон цэвэр мөнгөн хөрөнгө	(2,244)	(1,824)
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/бууралт	(33,572)	47,814
Өмнөх жилийн мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	267,626	219,812
Тайлант хугацааны мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	234,054	267,626
	2003 сая төгрөг	2002 сая төгрөг
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн бүрэлдэхүүн хэсгүүд:		
Бэлэн мөнгө	13,234	13,771
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хадгаламж, хөрөнгө	220,820	253,855
	234,054	267,626

Хавсралт тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2003 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Монголбанк, Монгол Улсын Төв Банк (цаашид "Банк" гэнэ) нь Монгол Улсын Засгийн Газрын 1924 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн тогтоолоор байгуулагдсан ба байршил нь: Монгол Улс, Улаанбаатар 46, Бага Тойруу 9.

Банк нь бүхий л үйл ажиллагаагаа Монгол улсад явуулдаг бөгөөд хилийн чанадад үйл ажиллагаа явуулдаггүй, салбар үгүй болно. Гэхдээ Банк нь Англи улсын Лондон хотод төлөөлөгчийн газартай. Тиймээс санхүүгийн тайланд бизнесийн болон газар зүйн байршлын хувьд дүн шинжилгээ хийх шаардлагагүй.

Банкны 2003 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангуудыг гаргахыг захирлуудын шийдвэрээр Захирлуудын Зөвлөлөөс зөвшөөрсөн болно.

2. ҮНДСЭН ҮҮРЭГ

Банкны хүлээх үндсэн үүргийг Төв банк (Монголбанк)-ны тухай хуулиар зохицуулна.

Банк нь үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор мөнгөний бодлогыг боловсруулан хэрэгжүүлдэг бөгөөд үнэт цаас арилжих, санхүүгийн байгууллагуудаас эх үүсвэр татан авах зэргээр хүүгийн түвшинг зохицуулж, банкны төлбөрийн чадварыг сайжруулах замаар банкны системд туслалцаа үзүүлэх арга хэмжээ авч ирсэн байна.

Банк нь Монгол улсын нэрийн өмнөөс төгрөг, гадаад валютын хоорондын харилцааг зохицуулдаг. Иймээс Банк нь улсын алт болон гадаад валютын нөөцийг эзэмшиж, зохицуулдаг. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд Банк нь бусад орны төв болон арилжааны банкуудад гадаад валютын хадгаламж байршуулж, гадаад валютаар илэрхийлэгдсэн үнэт цаас, своп болон форвардын зах зээл дээр арилжаа хийдэг.

Банк нь Монгол улсын мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах онцгой эрх эдэлнэ.

3. ТАЙЛАН ГАРГАХАД БАРИМТАЛСАН ЕРӨНХИЙ ЗАРЧИМ

Банкны санхүүгийн тайлангууд нь Банкны санхүүгийн байдал, түүний үр дүн, мөнгөн гүйлгээ, болон хүлээн зөвшөөрөгдсөн нийт ашиг, алдагдлыг дор тайлбарласан залруулгуудыг эс тооцвол төв банкинд мөрдөгдөх Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын ("СТОУС") дагуу бэлтгэгдсэн болно.

Монголбанк нь өөрийн үндсэн үүргийн дагуу мөнгөний болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэн санхүүгийн салбарт бүхэлд нь итгэл алдах байдлаас урьдчилан сэргийлэх үүднээс хүндрэлд орсон санхүүгийн байгууллагуудад "эцсийн зээлдүүлэгч"-ийн үүргийг гүйцэтгэж байна. Зарим тохиолдолд банкны системд бий болсон хямралт байдал сайжирсан нөхцөлд л Монголбанкны үзүүлсэн дэмжлэгийг танилцуулбал олон түмний банкинд итгэх итгэлийг илүү сайн хадгалж үлддэг. Тиймээс, иймэрхүү үйл ажиллагааны санхүүгийн үр дагаврыг уг үйл ажиллагаа явагдсан тухайн жилийн санхүүгийн тайланд тусгадаг боловч эдгээр санхүүгийн тайлангуудад ийм туслалцаа оршин байгааг илүү нарийн тодорхой үзүүлээгүй байж болно. Гэхдээ Төв банк нь энэхүү ажиллагааг нууцлах шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд мэдээллийг нийтэд дэлгэн үзүүлнэ.

Иймд Банкны санхүүгийн тайланд орлого, үр дүнгийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгүүд ялангуяа хүүгийн орлого, зардал болон муу, эргэлзээтэй зээлийн сан, улмаар тайлан тэнцэл, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгыг СТОУС-ын шаардлагын хэмжээнд дэлгэрэнгүйгээр үзүүлээгүй байж болно.

Гадаад валютын дахин үнэлгээний бодит ба бодит бус зөрүү, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү ба санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнийн өөрчлөлтүүдийг Төв Банкны тухай хуулийн дагуу Банкны "Дахин үнэлгээний сан"-д бүртгэдэг. Энэ нь дахин үнэлгээний бодит зөрүүг орлого, үр дүнгийн тайлан буюу хуримтлагдсан ашиг руу шилжүүлнэ гэсэн СТОУС-д нийцэхгүй байна.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ түүхэн өртгийн зарчимд үндэслэсэн ба зарим активыг дахин үнэлсэн дүнгээр тусгасан. Санхүүгийн тайланд ашигласан мөнгөн тэмдэгт нь Монгол төгрөг бөгөөд түүнийг сая төгрөгөөр илэрхийлэв.

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД**(а) Хүүгийн орлого, зардал**

Хүү авчирдаг бүхий л санхүүгийн хэрэгслүүдийн хүүгийн орлого, зардлыг худалдан авсан бодит үнэд үндэслэн үр ашигт хүүгийн аргыг ашиглан хуримтлуулж тооцох зарчмаар орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрдөг.

(б) Гадаад валют

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөжсөн актив, пассивыг тайлан тэнцэлд тухайн өдрийн ханшаар хөрвүүлж төгрөгөөр илэрхийлнэ. Банк нь гадаад валютаар илэрхийлэгдсэн актив, пассивыг өдөр бүр дахин үнэлж, эдгээр ханшийн тэгшитгэлийн зөрүүг нөөцийн сан буюу дахин үнэлгээний санд тусгах бодлого баримталдаг.

Тооцоонд ашигласан гол валютуудын ханш: -

	2003	2002
Ам. доллар	1,168.00	1,125.00
Евро	1,460.20	1,169.40
Зээлжих тусгай эрх (ЗТЭ)	1,729.00	1,519.20

ЗТЭ нь Олон Улсын Валютын Сангаас бий болгож, өөрийн гишүүдэд оруулсан хөрөнгийнх нь хувь хэмжээгээр хуваарилсан гадаад нөөцийн хөрөнгө юм.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус актив, пассив нь өртгөөрөө болон дахин үнэлсэн мөнгөн дүнгээр илэрхийлэгдсэн болно. Тухайн актив, пассив болон актив пассивыг дахин үнэлснийг тухайн үеийн ханшаар бүртгэнэ.

Орлого, зарлагын гүйлгээг тухайн өдрийн ханшаар төгрөгт хөрвүүлэн тооцсон болно. Гадаад валютын форвард хэлцлүүдийг өдөр бүр зах зээлийн ханшаар бүртгэж, ханшийн зөрүүг Дахин үнэлгээний санд шилжүүлдэг.

(в) Бэлэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Бэлэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь бэлэн мөнгө болон бэлэн мөнгөнд үнийн өөрчлөлтийн эрсдэл багатайгаар түргэн хөрвөх богино хугацаат хөрөнгө болон бусад санхүүгийн байгууллагуудад байршуулсан хадгаламж, хөрөнгө юм.

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (Үргэлжлэл)

(г) Хөрөнгө оруулалт

Бүх хөрөнгө оруулалтыг тухайн хөрөнгө оруулалттай холбогдон гарсан зардлуудыг оролцуулан гаргасан хөрөнгийн бодит үнэ болох өртгөөр нь анх бүртгэдэг.

Хөрөнгө оруулалтын үнэт цаас нь ихэвчлэн хугацааг нь дуустал эзэмшиж буй ашиг олох зорилгоор худалдан авсан үнэт цаас юм.

Засгийн газрын үнэт цаасыг өртгөөр нь бүртгэж, шаардлагатай тохиолдолд хугацааг нь дуустал урамшуулал, хөнгөлөлтийг нь элэгдүүлэн тооцдог.

Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй хөрөнгө оруулалтыг өртгөөр нь бүртгэж, шаардлагатай тохиолдолд хугацааг нь дуустал урамшуулал, хөнгөлөлтийг нь элэгдүүлэн тооцдог. Түр зуурын бус үнэлгээний бууралтанд сан байгуулдаг.

Хөрөнгө оруулалтын үнэт цаасыг борлуулахад, үнэт цаасны цэвэр орлого болон бүртгэлийн үнийн зөрүүг орлого, үр дүнгийн тайланд бүртгэдэг.

(д) Санхүүгийн хэрэгсэл

Банк нь санхүүгийн хэрэгслээр хэлцэл байгуулмагц тухайн санхүүгийн хэрэгслийг тайлан тэнцэлд бүртгэдэг. Эдгээр санхүүгийн хэрэгсэлтэй холбоотой хүлээн зөвшөөрөлт, хэмжилтийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тэдгээрийн харгалзах нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад тусгасан байна.

Хэлцэлийн мөн чанараас хамааруулан санхүүгийн хэрэгслүүдийг өр төлбөрийн, өөрийн хөрөнгийн гэж ангилдаг. Өр төлбөрийн гэж ангилагдсан санхүүгийн хэрэгсэлтэй холбоотой хүү, ногдол ашиг, ашиг, алдагдлыг зардал буюу орлогод тайлагнадаг. Өөрийн хөрөнгийн гэж ангилагдсан санхүүгийн хэрэгслийн эзэмшигчид хуваарилж буй ашгийг өөрийн хөрөнгөд тусгана. Банк нь санхүүгийн хэрэгслүүдийг хууль зүйн хүрээнд, актив пассивыг хооронд нь цэвэршүүлэн хаах буюу актив, пассивын төлбөр тооцоог нэгэн зэрэг гүйцэтгэх замаар хаадаг.

Монголбанк нь гадаад валютын арилжаа, хүүгийн своп зэрэг санхүүгийн хэрэгслүүдийг гадаад валютын ханшийн өөрчлөлт болон хүүгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор ашигладаг бөгөөд эдгээр санхүүгийн хэрэгслүүдийг бодит үнэлгээгээр нь үнэлж бүртгэдэг.

(е) Мөнгөжсөн алт ба үнэт металл

Мөнгөжсөн алтыг дахин үнэлснээр тайлан тэнцэлд тусгадаг бөгөөд дахин үнэлгээг өдөр бүр хийдэг. Дахин үнэлгээг тогтоохдоо мөнгөжсөн алтны зах зээлийн үнэ, түүний хандлага, төгрөгийн худалдан авах чадвар, төгрөгийн ханшийн өсөлт, бууралт, мөнгөжсөн алтны жигнэсэн дундаж өртөг зэргийг харгалздаг. Дахин үнэлгээний ашиг, алдагдлыг нөөцийн санд шууд тусгана. Ихэвчлэн мөнгөжөөгүй алт болон бусад үнэт металлууд жигнэсэн дундаж өртгөөрөө тайланд тусгагдсан. Алт, үнэт металлын арилжааны ашиг, алдагдлыг шууд орлогод тусгадаг.

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (Үргэлжлэл)

(ё) Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг өртгөөр нь бүртгэж, хуримтлагдсан элэгдэл болон үнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр тооцдог. Үнийн бууралтын алдагдлын хүлээн зөвшөөрөлт, хэмжилтийн бодлогыг Тодруулга 4 (и)-д тусгасан болно.

2002 онд Монголбанк нь барилга байшингаа дахин үнэлүүлж, дахин үнэлгээгээр нэмэгдсэн дүнг дахин үнэлгээний нөөцөд тусгасан байна. Дахин үнэлгээг мэргэжлийн үнэлгээний байгууллагын хийсэн үнэлгээнд үндэслэсэн.

Жилийн элэгдэл тооцох хувь хэмжээ:

Байшин, барилга	2.4% - 6.0%
Тавилга, тоног төхөөрөмж	10.0% - 12.5%
Компьютер	12.5% - 20.0%
Тээврийн хэрэгсэл	12.5% - 16.7%

Дуусаагүй капитал ажилд элэгдэл тооцдоггүй. Эдгээр активын элэгдлийг холбогдох активууд ашиглалтанд орсон үеэс тооцож эхэлдэг.

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулахдаа, бүртгэлийн үнэ болон борлуулалтын үнийн зөрүүг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрч, тухайн хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүгийн ашиглагдаагүй хэсгийг хуритлагдсан ашиг руу шууд хаадаг.

(ж) Муу болон эргэлзээтэй зээлийн сан

Ерөнхий болон тусгай хүчин зүйлсийн үндсэн дээр шаардлагатай тохиолдолд муу болон эргэлзээтэй зээлийн сан байгуулдаг. Ерөнхий зүйл нь хэдийгээр тусгайлан тогтоогдоогүй ч, туршлагаас үзэхэд банкны зээлийн багцад алдагдал оршин байдагтай холбоотой. Тухайн жилд байгуулагдсан санг (эргэн төлөгдсөн дүнгээр хорогдуулан) ашгаас хаадаг.

Тухайн зээлийн үлдэгдлийг эргэн төлөгдөх найдваргүй гэж үзсэн үед сан байгуулна. Сан нь тухайн зээлийн бүртгэлийн үнэ болон төлөгдөх боломжит цэвэр үнийн зөрүү дүн юм. Эдийн засгийн байдал, тухайн зээлийн багцын уламжлалт эрсдэл зэргийг харгалзан Ерөнхий санг тогтмол хянадаг.

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (Үргэлжлэл)

(з) Гаргасан үнэт цаас

Гаргасан үнэт цаас нь Монголбанкнаас дотоодын санхүүгийн байгууллагуудад хямдралтайгаар худалдсан үнэт цаас юм. Эдгээр үнэт цаасыг Банк нь хямдруулсан өртгөөр нь бүртгэж, хямдруулалтын хугацааг дуустал нь элэгдүүлдэг. Банк нь хугацаа дуусмагц үнэт цаас эзэмшигчдээс үнэт цаасыг буцаан худалдаж авдаг.

(и) Хөрөнгийн үнийн бууралт

Хөрөнгийн үнийн бууралтын алдагдал гарах шинж эсэхийг тодорхойлох үүднээс Банк хөрөнгийнхөө бүртгэлийн үнийг хянаж үздэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрвэл үнийн бууралтыг уг хөрөнгийн дансны үнийг нөхөн төлөгдөх дүнтэй харьцуулан хэмждэг. Нөхөн төлөгдөх дүн нь борлуулалтын цэвэр дүн ба ашиглалтын үнэлгээний аль өндөр нь байх бөгөөд үүнийг ирээдүйд буурсан мөнгөн урсгалаар хэмжинэ.

Хөрөнгийг дахин үнэлэгдсэн дүнгээр бүртгээгүй тохиолдолд үнийн бууралтын алдагдлыг гарсан даруйд нь орлого, үр дүнгийн тайланд тусгадаг. Дахин үнэлэгдсэн хөрөнгийн үнийн бууралтын алдагдлыг тухайн хөрөнгийн өмнө нь бүртгэгдсэн дахин үнэлгээний нэмэгдлээс хасч дахин үнэлгээний бууралтаар бүртгэнэ. Тухайн хөрөнгийн үнийн бууралт цаашид гарахгүй буюу буурах шинж тэмдэг илэрсэн тохиолдолд өмнөх жилүүдэд хүлээн зөвшөөрсөн үнийн бууралтын буцаалтыг бүртгэдэг.

(й) Татвар

Банк нь Монгол улсын Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын хуулийн дагуу орлогын татвараас чөлөөлөгдөнө.

(к) Ажиллагсдын нөхөн олговор

(1) Богино хугацааны нөхөн олговор

Банкны ажилтнуудын үзүүлсэн үйлчилгээнд олгож буй цалин, хөлс болон холбогдох зардлыг тухайн жилийн зардалд тусгадаг. Ажилтнуудад ээлжийн амралт зэрэг богино хугацааны чөлөө эдлэх үеийн нөхөн олговрыг ажилласан жилийг нь харгалзан, харин өвчтэй байх хугацааны нөхөн олговрыг цаг тухайд нь олгодог.

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (Үргэлжлэл)

(к) Ажиллагсдын нөхөн олговор (үргэлжлэл)

(2) Тэтгэвэр, тэтгэмж, бусад олговрууд

Монгол улсад үйлчилж буй төрийн тэтгэврийн тогтолцооноос гадуур ажилтнууддаа тэтгэвэр, тэтгэмж олгох гэрээ хэлцэл Монголбанкинд байхгүй болно. Төрийн тэтгэврийн тогтолцооны дагуу ажилтнуудад төлж буй цалин хөлсний дүнгээс тодорхой хувиар шимтгэл тооцож төлдөг ба ажилтнуудад цалин олгосон үеийн орлогын тайланд уг шимтгэлийн зардлыг тусгадаг. Түүнчлэн Монголбанкинд хуримтлуулж тооцдог бусад төрлийн тэтгэвэр, тэтгэмж байхгүй болно.

5. ХҮҮНИЙ ОРЛОГО

	2003 сая төгрөг	2002 сая төгрөг
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	3,707	3,475
Гадаадын үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	2,398	3,114
Засгийн газрын үнэт цаас	521	861
Дотоодын санхүүгийн байгууллагуудад олгосон зээл, урьдчилгаа	318	91
	6,944	7,541

6. ХҮҮГИЙН ЗАРДАЛ

	2003 сая төгрөг	2002 сая төгрөг
Гаргасан үнэт цаас	4,569	3,741
Засгийн газрын байгууллагуудын хадгаламж	2,739	1,159
Гадаад валютаарх пассив	146	234
Дотоодын санхүүгийн байгууллагуудын хадгаламж	29	179
	7,483	5,313

7. САН

	2003 сая төгрөг	2002 сая төгрөг
Аж ахуйн нэгжүүдэд олгосон зээлд байгуулсан сангийн буцаалт	(311)	(1)

8. ЗАХИРГААНЫ ЗАРДАЛ

	2003 сая төгрөг	2002 сая төгрөг
Цалин болон ажилтнуудын урамшуулал	674	614
Захирлуудын цалин болон урамшуулал	37	36
Элэгдэл	529	503
Харилцаа, холбоо	361	331
Ашиглалтын зардал	319	266
Тээврийн болон томилолтын зардал	215	179
Гишүүнчлэлийн болон аудитын зардал	194	223
Хамгаалалтын зардал	163	199
Нөхөн олговрын зардал	142	133
Бичиг хэргийн зардал	52	51
Бусад	644	292
	3,330	2,827

Тайлант хугацаанд Банкинд ажиллаж буй ажилтнуудын тоо:

	2003 Тоо	2002 Тоо
Ерөнхийлөгч болон захирлууд	21	17
Захиргааны ажилтнууд	179	169
Үйлчилгээний ажилтнууд	111	116
	311	302

9. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ЗАРДАЛ

	2003 сая төгрөг	2002 сая төгрөг
Мөнгөн тэмдэгтийн зардал	7,027	2,169
Бусад	-	145
	7,027	2,314

10. БЭЛЭН МӨНГӨ

	2003 сая төгрөг	2002 сая төгрөг
Төгрөг	55	26
Гадаад валют	13,179	13,745
	13,234	13,771

11. МӨНГӨЖСӨН АЛТ БОЛОН ҮНЭТ МЕТАЛЛ

	2003 сая төгрөг	2002 сая төгрөг
Мөнгөжсөн алт	7,769	56,019
Мөнгөжөөгүй алт	4,870	3,900
Мөнгөжөөгүй мөнгө	103	198
Зоос, түүх соёлын үнэт зүйлс	2,688	2,893
	15,430	63,010

12. ГАДААДЫН ҮНЭТ ЦААСАН ДАХЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

	2003 сая төгрөг	2002 сая төгрөг
Өрийн бичиг	37,775	51,321
Буцаан худалдан авах гэрээ	39,595	-
	77,370	51,321

Өрийн бичиг нь 8-10 сарын хугацаатай богино хугацааны өрийн бичиг бөгөөд хямдруулалтын хувь хэмжээ нь жилийн 2.76% - 2.84%-ийн хүүтэй (2002: 6.04% -10.00%). Буцаан худалдан авах гэрээ 2004 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр хугацаа дууссан бөгөөд жилийн 0.85 хувийн хүүтэй байсан.

13. ГАДААДЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД БАЙРШУУЛСАН ХӨРӨНГӨ, ХАДГАЛАМЖ

	2003 сая төгрөг	2002 сая төгрөг
Богино хугацааны хугацаат хадгаламж	135,683	179,035
Олон улсын валютын санд ноогдох ЗТЭ	79,921	71,406
Харилцах данс	3,880	1,956
Дэлхийн Банк	1,326	1,448
Бусад	10	10
	220,820	253,855

Богино хугацаатай хадгаламж

Богино хугацаатай хадгаламж нь ам.доллараар илэрхийлэгдсэн ба 30 хүртэлх хоногийн хугацаатай бөгөөд жилийн 1.25% - 4.00% хүүтэй (2002: 1.58% -6.00%).

Олон улсын валютын санд ноогдох ЗТЭ

Банкинд байршуулсан Зээлжих тусгай эрх нь ОУВС-д нийлүүлсэн хувь хөрөнгө болох 51.1 сая ЗТЭ буюу 79.8 тэрбум төгрөг болно (2002: 51.1 сая ЗТЭ буюу 71.4 тэрбум төгрөг). Энэ дүнгээр холбогдох пассив талд тусгасан (Тодруулга 22-г үзнэ үү) ба түүнд хүү тооцдоггүй.

Харилцах данс

Энэ үлдэгдэл нь гадаадын төв банкууд болон бусад санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах данс бөгөөд түүнд хүү тооцдоггүй.

Дэлхийн Банк

Энэ үлдэгдэл нь Дэлхийн банкинд байршуулсан хадгаламж болон оруулсан хувь хөрөнгийн хэсэг юм. Энэ дүнгээр холбогдох пассив талд тусгасан (Тодруулга 22-г үзнэ үү) ба түүнд хүү тооцдоггүй.

14. ДОТООДЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ, УРЬДЧИЛГАА

	2003 сая төгрөг	2002 сая төгрөг
Валютын зээл	7,822	4,277
Төгрөгийн зээл	4,736	3,631
Санхүүгийн байгууллагуудаас авах авлага	3,502	3,486
Дахин санхүүжилтийн зээл	130	130
Нийт зээл, урьдчилгаа	16,190	11,524
Хасах нь: Болзошгүй алдагдлын нөөцийн сан	(3,198)	(3,198)
	12,992	8,326

Валютын зээл

Гадаад валютын зээлийг дотоодын арилжааны хоёр банкаар дамжуулан Монголын аж ахуйн нэгжүүдэд олгосон байна. Санхүүжилт нь хоёр тусдаа хөтөлбөрийн хүрээнд Герман Улсын Засгийн газраас жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд зориулан олгосон зээл юм. (Тодруулга 22-г үзнэ үү). Хоёр хөтөлбөрийн хүрээнд олгогдож байгаа зээл нь жилийн 1.75% (2002: 1.75%)-ийн хүүтэй бөгөөд ямар нэгэн барьцаагаар баталгаажуулаагүй болно. Хоёр хөтөлбөрийн хүрээнд олгогдож буй зээл нь тухайн хоёр банкны харилцагчдын хэрэгцээний хэрээр янз бүрийн хэмжээтэй олгогдож байна. Тиймээс, олгогдсон зээлүүдийн төлөгдөх хугацаа нь анх олгосон өдрөөс хамааран янз бүр байна.

Төгрөгийн зээл - Мөн чанар, хүүгийн хувь, барьцаа ба эргэн төлөгдөх хугацаа

Төгрөгийн зээлийг дотоодын арилжааны банкуудаар дамжуулан Монголын аж ахуйн нэгжүүдэд олгосон байна. Санхүүжилт нь хоёр тусдаа хөтөлбөрийн хүрээнд Азийн Хөгжлийн Банкнаас эдийн засгийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн салбарын хөгжүүлэхэд зориулан олгосон зээл юм. Нэг дэх хөтөлбөрийн хүрээнд олгогдож байгаа зээл нь жилийн 10% (2002: 10%)-ийн хүүтэй бөгөөд зээлүүдийн төлөгдөх хугацаа нь анх олгосон өдрөөс хамааран янз бүр байна. Хоёр дахь хөтөлбөрийн хүрээнд олгогдож байгаа зээл нь жилийн 5.5% (2002: 5.5%)-ийн хүүтэй, нэг жилийн хугацаатай.

Санхүүгийн байгууллагуудаас авах авлага

Эдгээр авлага нь төлбөрийн чадваргүй дотоодын банкуудын нэрийн өмнөөс Банкны төлсөн 3.2 сая ам. долларын баталгааны төлбөртэй холбоотой юм. Банк нь энэ дүнд 2,8 сая ам.долларын болзошгүй алдагдлын санг байгуулсан байна. Банк нь үлдэгдэл дүнд болзошгүй алдагдлын санг нэмж байгуулах шаардлагагүй гэж үзсэн байна.

Дахин санхүүжилтийн зээл

Энэ зээл нь 1996 онд банкинд олгосон зээл бөгөөд тухайн банк татан буугдсан байна. Тухайн зээлд бүрэн хэмжээгээр сан байгуулсан болно.

15. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС

	2003 сая төгрөг	2002 сая төгрөг
Засгийн газрын үнэт цаас	4,000	-

Засгийн газрын эдгээр үнэт цаас нь СЭЗЯ-аас гаргасан бонд бөгөөд Банк нь тус яамтай байгуулсан гэрээний дагуу дотоодын төрийн өмчит санхүүгийн байгууллагуудаас худалдаж авсан байна. Энэхүү гэрээний дагуу СЭЗЯ нь Банкинд 2003 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар байршиж буй үнэт цаасны төлбөрийг 2 хуваан 2004 оны 6 сарын 15, 2004 оны 12 сарын 31-ний өдрүүдэд тус тус хийнэ. Засгийн газрын үнэт цаас жилийн 12.62% -16.64% (2002 : Тэг)-ийн хүүтэй.

16. САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ЯАМАНД ОЛГОСОН УРЬДЧИЛГАА

	2003 сая төгрөг	2002 сая төгрөг
Засгийн газарт олгосон урьдчилгаа	160,216	-
Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөрийн зээл	54,838	39,807
	215,054	39,807

Засгийн газарт олгосон урьдчилгаа

Энэхүү урьдчилгааг Орос Улсын Засгийн Газарт төлөх хөнгөлөлттэй зээлийн төлбөрийг бүрэн барагдуулах зорилгоор Банкнаас Засгийн газарт олгосон байна. Эдгээр хүүгүй урьдчилгааг 37 сая ам.доллар болон 117 тэрбум төгрөгөөр тус тус 2 хэсэгчлэн олгосон байна. Банк ба СЭЗЯ-ны хооронд байгуулсан гэрээний дагуу нэг дэх хэсгийг 2004 оны 1 дүгээр улиралд төлөх бөгөөд 2 дахь хэсгийг 10 хувааж буюу 2004 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн жил бүр 11.7 тэрбум төгрөг төлөх бөгөөд хамгийн сүүлчийн төлбөрийг 2013 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хийнэ.

Төв Банкны тухай хуулийн 18 дугаар зүйлд Засгийн газарт олгох зээлийн хязгаарлалтуудыг зааж өгсөн байдаг ба үүнд нийт зээлийн үлдэгдэл нь өмнөх 3 жилд хуримтлагдсан дотоодын төсвийн орлогын 10 хувиас хэтрэх ёсгүй гэж заасан байдаг. Үлдэгдлийн тэнцлийн өдрийн байдлаар Засгийн газарт өгсөн урьдчилгааны хэмжээ нь дээрх 10 хувийн хязгаараас хэтэрсэн байна.

Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөрийн зээл

Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөрийн (ЯБӨХХ, хуучин нэрээр Бүтцийн өөрчлөлтийг дэмжих хөтөлбөр) хүрээнд нийт олгосон зээлийн СЭЗЯ-ны хариуцах хэсгийг оны эцсийн байдлаар харуулсан болно. Мөн энэ зээл нь Гадаад валютын пассив нэрээр тэнцлийн пассивт бүртгэгдсэн болно (Годруулга 22-г үзнэ үү). Зээл нь 10 жилийн хугацаатай, жилийн 0.5% (2002: 0.5%)-ийн хүүтэй.

17. АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ

	2003 сая төгрөг	2002 сая төгрөг
Дотоодын аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл	556	867
Бусад зээл	18,532	165
	19,088	1,032
Хасах нь: Болзошгүй алдагдлын сан	(556)	(867)
	18,532	165

Болзошгүй алдагдлын сангийн хөдөлгөөнийг дор үзүүлэв:

	2003 сая төгрөг	2002 сая төгрөг
1 дүгээр сарын 1-ний өдрийн үлдэгдэл	867	868
Тухайн жилийн буцаалт	(311)	(1)
12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл	556	867

18. АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ

Дотоодын аж ахуйн нэгжүүдэд олгосон 0.6 тэрбум төгрөгийн (2002 онд 0.9 тэрбум төгрөг байсан) зээл нь санхүүгийн бус байгууллагуудад зээл олгохыг хориглосон журам гарахаас өмнөх зээлд хамааралтай юм. Банк нь эдийн засгийг сайжруулах зорилгоор дотоодын ахуйн нэгжүүдэд энэ зээлийг олгосон. Эдгээр зээлүүд нь эргэж төлөгдөөгүй бөгөөд эдгээр зээлд болзошгүй алдагдлын санг бүрэн байгуулжээ.

2003 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар аж ахуйн нэгжүүдэд олгосон зээлийн дүнд хугацаа дууссан санхүүгийн хөрөнгөөс уул уурхайн компаниудаас авах авлагад дахин ангилагдсан 18.5 тэрбум төгрөгийн дүн багтаж байгаа юм. Үлдэгдлийн тэнцлийн өдрийн байдлаар эдгээр дүнгүүд нь төлөгдөөгүй хэвээр байсан ба энэ нь Төв Банкны тухай хуулийн 23 дугаар заалтыг зөрчиж байна.

19. БУСАД АКТИВ

	2003 сая төгрөг	2002 сая төгрөг
Үүсмэл санхүүгийн хэрэгслүүд	-	922
Бусад	507	178
	507	1,100

Бусад актив нь ажилтнуудад олгосон урьдчилгаа, материал болон бичиг хэргийн хэрэгслээс бүрдэж байна.

Банк нь 1999 онд гадаадын санхүүгийн байгууллагатай своп гэрээ хийсэн ба гэрээний хугацаа нь 2004 онд дуусна. Энэ гэрээний дагуу Банк нь 32,000 унц мөнгөжсөн алтыг 8.2 сая ам.доллараар арилжсан бөгөөд гэрээнд заасан хугацаа дуусах үед энэ алтыг гэрээний үнээр буцаан худалдан авах үүрэг хүлээсэн. Банк нь харилцагч этгээддээ ханшийн зөрүүг нөхөх зорилгоор алтны унцаар илэрхийлэгдсэн хүүг жил тутам төлдөг болно. Банкны зүгээс энэ гэрээг хүчингүй болгох эрхгүй. Банкны энэхүү гэрээнээс хүлээх ашиг, алдагдал нь ам. доллар болон алтны хүүгийн ханшийн зөрүүнээс шалтгаална. Банк нь энэ арилжаанаас материаллаг алдагдал хүлээнэ гэж үзэхгүй байна.

20. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Өртөг/үнэлгээ	Байшин барилга сая төгрөг	Тавилга тоног төхөөрөмж сая төгрөг	Компьютер сая төгрөг	Тээврийн хэрэгсэл сая төгрөг	Дуусаагүй барилга сая төгрөг	Нийт сая төгрөг
Оны эхний үлдэгдэл	10,784	537	798	554	2,165	14,838
Нэмэгдсэн	163	108	211	127	1,641	2,250
Борлогдсон	(19)	(5)	(61)	(20)	-	(105)
Хасагдсан	(53)	(7)	(46)	(24)	(795)	(925)
Оны эцсийн үлдэгдэл	10,875	633	902	637	3,011	16,058
Үүнээс:						
Өртгөөр	4,604	633	902	637	3,011	9,787
Үнэлгээгээр	6,271	-	-	-	-	6,271
	10,875	633	902	637	3,011	16,058
Хуримтлагдсан элэгдэл						
Оны эхний үлдэгдэл	513	190	383	228	-	1,314
Тухайн жилийн элэгдэл	283	53	148	43	-	527
Борлогдсон	(1)	(2)	(58)	(13)	-	(74)
Хасагдсан	(8)	(6)	(43)	(22)	-	(79)
Оны эцсийн үлдэгдэл	787	235	430	236	-	1,688

20. ҮНДСЭН ХӨРӨНГӨ (Үргэлжлэл)

Бүртгэлийн цэвэр үнэ

2003.12.31-ний байдлаар

Өртгөөр	Байшин барилга сая төгрөг	Тавилга тоног төхөөрөмж сая төгрөг	Компьютер сая төгрөг	Тээврийн хэрэгсэл сая төгрөг	Дуусаагүй барилга сая төгрөг	Нийт сая төгрөг
Үнэлгээгээр	4,179	398	472	401	3,011	8,461
	5,909	-	-	-	-	5,909
	10,088	398	472	401	3,011	14,370

2002.12.31-ний байдлаар

Өртөг	4,210	347	415	326	2,165	7,463
Үнэлгээ	6,061	-	-	-	-	6,061
	10,271	347	415	326	2,165	13,524

2002 оны элэгдэл

	250	48	142	63	-	503
--	-----	----	-----	----	---	-----

Барилгыг мэргэжлийн үнэлгээний байгууллагаар үнэлүүлсэн нь 2003 оны 12 дугаар сарын 31-нээр дараах байдалтай байна. Үүнд:

Үнэлгээ хийгдсэн өдөр	Хөрөнгийн төрөл	Үнэлгээний дүн сая төгрөг	Үнэлгээний үндэслэл
2002 оны 5 сарын 27	Барилга	6,325	Зах зээлийн үнэ

Хэрвээ дахин үнэлсэн барилгыг өртгөөр нь бүртгэсэн бол 2003 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайланд барилгын бүртгэлийн цэвэр дүнг 5,394 (2002 : MNT5,527) төгрөгөөр тусгах байсан болно.

21. ГАРГАСАН ҮНЭТ ЦААС

Энэ нь Банкнаас дотоодын санхүүгийн байгууллагуудад гаргасан үнэт цаас болно. Үнэт цаасны хугацаа нь нэг долоо хоногоос гурван сар бөгөөд жилийн хүү нь 9.9% - 14.0% (2002: 12% - 14.5%) байна.

22. ГАДААД ВАЛЮТААРХ ПАССИВ

	2003 сая төгрөг	2002 сая төгрөг
Олон улсын валютын сан (ОУВС)		
- ЯБӨХХ-ийн зээл	57,674	47,609
- ОУВС-д оруулсан хувь хөрөнгө	79,775	71,401
Швейцар дахь Олон улсын төлбөр тооцооны банкнаас байршуулсан хугацаат хадгаламж	29,204	-
Герман Улсын Засгийн Газраас авсан зээл	9,618	5,432
Азийн Хөгжлийн Банкнаас (АХБ) авсан зээл	4,547	3,539
Дэлхийн Банк, АХБ ба ОУХ		
Агентлагт оруулсан хувь хөрөнгө	1,784	1,841
Европын холбооноос авсан зээл	-	731
Нэгдсэн Үндэсний Хөгжлийн Хөтөлбөрт оруулсан хувь хөрөнгө	151	151
	182,753	130,704

Олон улсын валютын сан (ОУВС)

Ядуурлыг бууруулах өсөлтийг хангах хөтөлбөрийн (ЯБӨХХ, хуучин нэрээр Бүтцийн өөрчлөлтийг дэмжих хөтөлбөр) хүрээнд ОУВС-аас олгосон зээл нь 10 жилийн хугацаатай, жилийн 0.5% (2002: 0.5%)-ийн хүүтэй. Гүйцэтгэлийн шалгуур болон хөтөлбөрийн гүйцэтгэлийг хянаж үзсэний үндсэн дээр эдгээр зээл нь гурван жилийн хугацаатайгаар олгож байна. Зээл болон түүний эргэн төлөлт нь ЗТЭ-ээр хийгдэнэ.

ОУВС-ийн данс нь гурван данснаас бүрддэг. Үүнд: ОУВС-ийн 1 дүгээр данс, ОУВС-ийн 2 дугаар данс, мөн ОУВС-ийн Үнэт цаасны данс. ОУВС-ийн нэг дугаартай данс нь ОУВС-ийн үйл ажиллагааны төлбөр тооцоо, ОУВС-ийн 2 дугаартай данс нь Монгол Улс болон ОУВС-ийн хоорондын төлбөр тооцоо хийхэд ашиглагддаг данс юм. Үнэт цаасанд хүү тооцдоггүй бөгөөд ОУВС нь шаардлагатай тохиолдолд мөнгөжүүлдэг. Оруулсан хувь хөрөнгө нь ЗТЭ-ээр илэрхийлэгдсэн болно.

Швейцарын Олон улсын төлбөр тооцооны банкны хугацаат хадгаламж

Энэхүү 20 сая еврогийн хугацаат хадгаламжийн хугацаа нь 2004 оны 3 дугаар сарын 10-ны өдөр дуусах бөгөөд жилийн 2.19%-ийн хүүтэй.

22. ГАДААД ВАЛЮТААРХ ПАССИВ (Үргэлжлэл)

Герман Улсын Засгийн Газраас авсан зээл

Хоёр тусдаа хөтөлбөрийн хүрээнд олгогдож буй энэхүү зээл нь Германы Засгийн Газраас жижиг, дунд аж ахуйн нэгжийг дэмжих зорилготой. Хоёр хөтөлбөрийн хүрээнд еврогоор олгогдож буй зээл нь 40 жилийн хугацаатай. 1 дэх хөтөлбөрийн зээл нь 1995 онд олгогдож эхэлсэн, жилийн 1%-ийн хүүтэй. Энэ зээлийг еврогоор олгосон бөгөөд үндсэн зээлийн эргэн төлөлт нь 2005 оноос эхэлнэ. 2 дахь хөтөлбөрийн зээл нь 2002 онд олгогдож эхэлсэн, жилийн 0.75%-ийн хүүтэй. Энэ зээлийг төгрөгөөр олгож болох бөгөөд үндсэн зээлийн эргэн төлөлт нь 2012 оноос эхэлнэ.

Азийн Хөгжлийн Банкнаас ("АХБ") авсан зээл

АХБ-ны зээл нь Монгол Улсад ядуурлыг бууруулах, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг дэмжих, хөгжүүлэх мөн Засгийн Газар, төрийн бус байгууллагууд, дотоодын арилжааны банкуудад сургалтын болон зөвлөх үйлчилгээ үзүүлэх, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх үндсэн зорилготой. Зээл нь жилийн 1%-1,5%-ийн хүүтэй, 25-30 жилийн хугацаатай.

Дэлхийн Банк, АХБ ба ОУХАгентлагт оруулсан хувь хөрөнгө

Энэ үлдэгдэл нь Банкнаас эдгээр байгууллагуудад оруулсан хувь хөрөнгө юм. Эдгээр хувь хөрөнгөд хүү тооцдоггүй бөгөөд эргэн төлөгдөх тодорхой нөхцөлгүй.

Нэгдсэн Үндэсний Хөгжлийн Хөтөлбөрт оруулсан хувь хөрөнгө

Олон улсын байгууллагуудын хувь хөрөнгө нь банк бус санхүүгийн байгууллагуудыг хөгжүүлэх зорилгоор Нэгдсэн Үндэсний Хөгжлийн Хөтөлбөрийн хүрээнд олгосон туслалцаа юм. Энэхүү эх үүсвэрийг жижиг зээлээр дамжуулан орлого багатай хүмүүст олгож байна. Энэ хувь хөрөнгөд хүү тооцдоггүй бөгөөд эргэн төлөгдөх тогтсон нөхцөлгүй.

23. ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ХАДГАЛАМЖ

	2003	2002
	сая төгрөг	сая төгрөг
Улсын төсвийн болон засгийн газрын бусад дансд	73,102	15,344
СЭЗЯ-ны данс	18,924	3,747
	92,026	19,091

Улсын төсвийн болон засгийн газрын бусад дансд

Улсын төсвийн дансд нь Банкинд байршуулсан Засгийн Газрын байгууллагуудын төгрөгийн харилцах дансд юм. 2002 оны 11 дүгээр сараас эдгээр дансдыг Банкинд төвлөрүүлсэн. Өмнө нь эдгээр дансдыг Банкинд болон бусад дотоодын арилжааны банкуудад байршуулж байжээ. Эдгээр харилцах дансд нь жилийн 2,3%-4,7% (2002: 4.0%-13,0%)-ийн хүүтэй.

СЭЗЯ-ны дансд

СЭЗЯ-ны дансд нь СЭЗЯ-наас банкинд байршуулсан валютын харилцах дансууд юм. Эдгээр дансуудад хүү тооцдоггүй.

24. ДОТООДЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХАДГАЛАМЖ

Эдгээр хадгаламжууд нь дотоодын санхүүгийн байгууллагуудаас байршуулсан, хүүгүй хадгаламжийн дансанд хамаарагдаж, Банкинд байршуулсан банкуудын заавал байлгах нөөцөд орно. Банкуудын татан төвлөрүүлсэн хөрөнгийн тодорхой хувиар тооцож заавал байлгах нөөцийг тогтоодог.

25. БУСАД ПАССИВ

	2003	2002
	сая төгрөг	сая төгрөг
Нийгмийн хөгжлийн сан	2,423	5,383
Даатгалын сан	302	14,490
Бусад өглөг	815	894
	3,540	20,767

Нийгмийн хөгжлийн сан нь ажилтнуудын нийгмийн хангамжинд зориулагдсан болно.

Даатгалын сан нь Засгийн газрын байгууллагуудаас ажилтнуудынхаа нийгмийн хангамжид зориулж Банкинд байршуулсан төрөл бүрийн даатгалын сан юм. Эдгээр хадгаламжид хүү тооцдоггүй.

26. ДҮРМИЙН САН

	2003 сая төгрөг	2002 сая төгрөг
Дүрмийн сан	5,000	5,000

Монголбанк нь 100 хувийн Төрийн өмч болно. Дүрмийн сан нь Банкны өөрийн хөрөнгө юм.

27. НӨӨЦИЙН САНГУУД

Нөөцийн сангууд нь Ерөнхий Нөөцийн Сан, Дахин Үнэлгээний Сан болон Гадаад Валютын Дахин Үнэлгээний Сангуудаас бүрдэнэ.

Монгол Улсын Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн дагуу Төв банкны жилийн цэвэр ашгийн 40-өөс доошгүй хувийг ерөнхий нөөцийн санд хуваарилж, үлдэх хэсгийг Улсын төсөвт шилжүүлдэг. Харин 2003 онд Засгийн газар нь 6,63 тэрбум төгрөгийг Улсын Төсөвт шилжүүлэх шийдвэр гаргаснаас Монголбанк Ерөнхий нөөцийн санд хөрөнгө хуваарилаагүй байна (Тодруулга 28-г үзнэ үү).

Дахин үнэлгээний санд санхүүгийн хөрөнгө болон үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүг бүртгэдэг. Гадаад валютын дахин үнэлгээний санг дахин үнэлгээний санд нэгтгэснээр цаашид хэрэглэхээ больсон байна.

28. УЛСЫН ТӨСӨВТ ШИЛЖҮҮЛСЭН

2003 оны 10 дугаар сарын 9-ний өдөр Банк нь 2002 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хуримтлагдсан бүх ашиг буюу 6,63 тэрбум төгрөгийг Улсын Төсөвт шилжүүлсэн байна. Монголбанкны:

- цэвэр орлогын 40-өөс доошгүй хувийг ерөнхий нөөцийн санд;
- дээрх хувийг хасаад цэвэр орлогын үлдэх хэсгийг Улсын Төсөвт гэсэн дарааллаар хуваарилна гэж заасан Төв Банкны тухай хуулийн 38 дугаар заалтыг зөрчсөн байна.

Ерөнхий нөөцийн санд шимтгэлгүйгээр нийт дүнг шилжүүлэх тухай Монголбанкны Ерөнхийлөгчийн саналыг баталсан Улсын Их Хурлын Байнгын Хорооны захидлыг үндэслэн Улсын Их Хурал уг саналыг баталсан байна.

29. САНХҮҮГИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ БОЛОН БОЛЗОШГҮЙ ЗҮЙЛС

а) Аккредитив

	2003 сая төгрөг	2002 сая төгрөг
Аккредитив	64,586	3,638,459

2003 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны бүх аккредитив нь СЭЗЯ болон Засгийн Газрын байгууллагуудад барьцаагүйгээр нээгдсэн аккредитив байна. Гэхдээ СЭЗЯ болон Засгийн Газрын эдгээр байгууллагууд нь Банкинд валютын болон төгрөгийн хадгаламжаа байршуулсан байна.

б) Хууль зүй

Бизнесийн ердийн үйл ажиллагааны явцад Банкны эсрэг өдүүлсэн зарга нэхэмжлэл гарч болох боловч түүний үр дүнд хүлээж болзошгүй үүрэг нь Банкны хувьд материаллаг бус гэж Банкны Захирлуудын Зөвлөл үзэж байна.

в) Түрээсийн үүрэг

2003 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монголбанкинд түрээсийн гэрээгээр хүлээсэн үүрэг байхгүй болно. (2002: Тэг)

г) Хөрөнгийн үүрэг

Банкны Захирлуудын Зөвлөл нь төв байрны дэргэд шинээр барилга барихад зориулж ойролцоогоор 2.4 тэрбум төгрөгийг зарцуулахаар 2001 оны 7 дугаар сарын 20-ны өдөр шийдвэрлэсэн. Энэ дүнг жилийн эцсээр 2,88 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлсэн байна (2002: 2.88 тэрбум). Тайлан гаргах өдрийн байдлаар энэ хөрөнгийн 95% (2002: 60%) буюу ойролцоогоор 2,7 тэрбум (2002: 1,8 тэрбум) төгрөгийг зарцуулаад байна.

30. ХОЛБОГДОХ ЭТГЭЭДИЙН ТОДРУУЛГА

Нэг этгээд нөгөө этгээдийнхээ санхүүгийн буюу үйл ажиллагааны шийдвэрт мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх чадвартай бол холбогдох этгээд гэж үздэг. Банк нь 100 хувийн Монгол Улсын Засгийн газрын өмч.

Банкны Ерөнхийлөгч болон Захирлуудын Зөвлөлийн гишүүдэд олгосон 37,0 сая (2002: 36,4 сая) төгрөгийн цалингаас өөр холбогдох этгээдийн ажил гүйлгээ тухайн жилд гараагүй байна.

31. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО

Банк нь үйл ажиллагаагаа зөв зохистой явуулахын тулд Захирлуудын Зөвлөлөөс гаргасан журам, заавар, шийдвэрийн дагуу хүүний, зээлийн, үйл ажиллагааны болон нэр хүндийн эрсдэлийг удирдаж байна.

Гадаад валютын улсын нөөцийг удирдахад тулгардаг зах зээлийн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын, үйл ажиллагааны эрсдэлүүдэд түлхүү анхаарч, эдгээр эрсдэлийг зохицуулах, хянах, удирдах, бууруулахад чиглэгдсэн арга хэмжээнүүдийг "Гадаад валютын нөөцийн удирдлагын журам"-д тусгасан байна. Үүнд:

а) Зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор:

- Нөөцийг хамгийн эрсдэл багатай, найдвартай активт байршуулах талаар ихээхэн анхаарсан. Тухайлбал, нөөцийг АНУ, Япон, ХБНГУ, Англи, Швейцари улсын Төв банк дахь харилцах данс, ААА болон АА зэрэглэлтэй арилжааны банкууд дахь хадгаламж, эдгээр орнуудын Засгийн газрын үнэт цаас, олон улсын болон бүс нутгийн санхүүгийн байгууллагын үнэт цаас зэрэгт байршуулахаар заасан.
- Нөөцийн зарим хэсгийг уламжлалт харилцаатай арай доод зэрэглэлийн улс орон, банкинд байршуулж байна. Ийм нөхцөлд тухайн тохиолдол бүрийг тусгайлан авч үзэж, холбогдох тооцоо судалгаа хийн асуудлыг Монголбанкны Ерөнхийлөгчид танилцуулж шийдвэрлүүлж байна.
- Мөн нөөцийн активыг байршуулах гадаад орны банк, санхүүгийн байгууллагуудын жагсаалт, тэдгээрт олгох хязгаарыг улирал бүр батлуулж байна.

б) Зах зээлийн эрсдэлийг тодорхой түвшинд байлгаж, хянан зохицуулж байх үүднээс:

- Нөөцийн активын ерөнхий бүтцийг жилээр,
- Алт болон гадаад валютын нийт нээлттэй позицийн хязгаарыг улирлаар,
- Санхүүгийн хэрэгсэл тус бүрээр нээлттэй позицийн хязгаарыг улирлаар,
- Диллер тус бүрийн стоп-лосс хязгаарыг улирлаар тус тус батлуулан мөрдөж байна.

31. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО (Үргэлжлэл)

в) Гадаад нөөцийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийг удирдах зорилгоор:

- харилцах дансны үлдэгдэл, касс дахь бэлэн валютын доод хэмжээ,
- тодорхой хугацаагаар байршуулах активын доод, дээд хэмжээг тус тус тогтоосон,
- активын тодорхой хэсгийг долоо хоног тутам эргэлтэд оруулж байхаар зааж үйл ажиллагаандаа баримталж байна.

г) Гадаад нөөцийн үйл ажиллагааны эрсдэлийг удирдах зорилгоор:

- арилжааны хэсэг, арын албыг салган өөр өөр газарт харъяалуулан ажиллуулдаг,
- гадаад арилжаанд оролцогч бүх этгээд, хэсэг тус бүрийн хийж гүйцэтгэх ажил үүргийг тодорхой зааж, зааварт тусган мөрдүүлсэн,
- нээлттэй позицийн хязгаар, стоп-лосс хязгаарыг диллер тус бүрт валют, хэрэгсэл тус бүрээр улирал бүр хуваарилан баталдаг.

Монголбанкны зорилго нь банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад чиглэгдэж байгаа бөгөөд энэхүү үүргээ банк, банк бус санхүүгийн байгууллагуудад зайнаас болон газар дээрх хяналт шалгалтаар болон эдгээр байгууллагуудын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, журам зааврыг боловсронгуй болгох, аргачлал, зөвлөмж гаргах байдлаар хэрэгжүүлж байна.

Эрсдэлийн удирдлагын чиглэлээр зөвхөн хяналт шалгалт явуулж буй банк, банк бус санхүүгийн үйл ажиллагаатай бодлого явуулаад зогсохгүй хяналт шалгалтын ажилтнуудад учирч болзошгүй эрсдэлийг бууруулах талаар анхаарах шаардлагатай байдаг. Хяналт шалгалтын эрсдэлээс ажилтнуудыг сэргийлэх, хамгаалахад анхаарч Байгууллагын нууцын тухай хууль, Монголбанкны нууцын заавар, Монголбанкны улсын байцаагчийн эрх зүйн байдлын тухай журмыг хянан шалгагч нарт мөрдүүлж байна.

Хяналт шалгалтын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах үүднээс хяналт шалгалт явуулахтай холбоотой дараах эрх зүйн баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллаж байна. Үүнд:

1. Банкны үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих аргачлал.
2. Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих аргачлал.
3. Банкны үйл ажиллагаа, санхүүгийн байдалд газар дээр нь хийсэн шалгалтын акт материал бичих заавар
4. Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн байдалд газар дээр нь шалгалт хийн үнэлгээ, дүгнэлт өгөх журам.
5. Зээлийн мэдээллийн сангийн журам.
6. Банкны хувийн хэрэг хөтлөх заавар.

Түүнчлэн 2003 онд Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих аргачлал, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журмыг шинээр боловсруулснаас гадна банк, банк бус санхүүгийн үйл ажиллагаа, эрсдэлийг удирдахтай холбоотой ихэнх журам, зааварт нэмэлт өөрчлөлт оруулсан.

Монголбанк нь банкуудад болон Засгийн газарт төгрөгөөр зээл олгох Засгийн газрын үнэт цаасыг худалдан авах, мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах, гүйлгээнээс татах үйл ажиллагааг эрсдэлийн удирдлагын бодлогын дагуу хэрэгжүүлдэг.

31. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО (Үргэлжлэл)

Зээл, авлагын эрсдэлийн удирдлагын талаар:

Монголбанкнаас олгосон төгрөгийн зээл болон Монголбанкны төгрөгийн авлагын эрсдэлийг "Монголбанкны активын ангилал, болзошгүй алдагдлын нөөцийн сан байгуулах, зарцуулах журам"-ын дагуу удирдаж байна. Засгийн газар болон банкуудад олгосон зээл, гаргасан батлан даалт, худалдан авсан Засгийн газрын үнэт цаасны чанар, эргэж төлөгдөх магадлалыг нь харгалзан эрсдэлээр нь ангилсны үндсэн дээр болзошгүй алдагдлын нөөцийн сан байгуулан ажиллаж байна. Тухайлбал, олгосон зээлийг хэвийн зээл, хугацаа хэтэрсэн зээл, хэвийн бус зээл, эргэлзээтэй зээл, муу зээл гэсэн 5 ангилалд хуваан үздэг.

Түүнчлэн Засгийн газрын цэвэр зээлийн талаар СЭЗЯ-тай мэдээлэл солилцох ажилд ахиц гарч долоо хоног бүрийн баасан гаригт төрийн сангийн нэгдсэн дансны орлого, зарлагын мэдээг авдаг боллоо. Ингэснээр Засгийн газрын санхүүгийн талаар тогтмол мэдээлэлтэй байх боломж бүрдсэн.

Мөнгөн тэмдэгтийн эрсдэлийн удирдлагын талаар:

Мөнгөн тэмдэгтийн үйл ажиллагаатай холбоотой дараах эрсдэлийн удирдлагын бодлогыг баримталлаа. Үүнд:

1. Аймгуудад зузаатгалаар хүргүүлж байгаа мөнгөн тэмдэгтийг Монгол Даатгал компаниар даатгуулсан,
2. Монголбанкны кассын ажиллагааны журам, "Монголбанкны мөнгө тоолох, хянах ажиллагааны журам"-ыг 2002 оны 12 дугаар сараас шинэчлэн мөрдөж түүнд оруулсан мөнгөн тэмдэгтийг хамгаалах, хянах, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон заалтуудыг хэрэгжүүлж ирлээ.

Монголбанк нь аудитын эрсдэлийн гурван төрөл болох уламжлалт, хяналтын болон илрүүлэлтийн эрсдлүүдийг удирдаж байна.

- Уламжлалт болон хяналтын эрсдэлийг бууруулахын тулд Монголбанкны нэгжүүдийн эрсдэлийн түвшинг харгалзан хяналт шалгалтыг явуулж, тэдгээрийн дотоод хяналтын системд тухай бүр үнэлэлт өгч, зөрчил, дутагдлыг илрүүлэн ажлыг нь сайжруулах чиглэлээр санал зөвлөмж өгч, шаардлагатай тохиолдолд удирдлагын шийдвэр гаргуулан ажиллаж байна,
- Илрүүлэлтийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор Монголбанкны Дотоод аудитын дүрэмд тусгагдсаны дагуу хянан шалгагчдад тавих шаардлагыг өндөржүүлэн тэдгээрийн ур чадвар, мэргэжлийн хянамгай байдлыг нь дээшлүүлэх болон мэдлэг, мэргэшлийг нь сайжруулах чиглэлээр сургалт, семинарт хамруулахад анхаарч, газрын удирдлагаас шалгалт хийх тухай бүрт холбогдох заавар, зөвлөмж өгч байна.

Дээрх зорилгоор эрсдэлд үндэслэсэн аудитын урт хугацааны хөтөлбөр болон жил, улирлын төлөвлөгөө боловсруулан мөрдөн ажиллаж байгаа болно.

31. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО (Үргэлжлэл)

АУДИТОРЫН
ТАЙЛАН

Монголбанк нь 2003 онд Банкны үйл ажиллагаанд үүсч болзошгүй эрх зүйн эрсдэлээс урьдчилан сэргийлэх бодлого баримтлан ажиллаж, Төв банкны үйл ажиллагааны зохицуулалтад зарим өөрчлөлт, шинэчлэлт хийх хуулийн төслийг боловсруулж, УИХ-аар батлууллаа. Үүнд:

Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн Монгол Улсын хуулиар Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд Монголбанкны Ерөнхий менежерийн бүрэн эрхийг тогтоосон 28 дугаар зүйлийг шинээр оруулж, хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтыг Монголбанкны Ерөнхийлөгч Монголбанкны зохион байгуулалтын бүтцийг тогтоож байхаар өөрчлөн найрууллаа.

Эрдэнэсийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн Монгол улсын хуулиар мөн эрдэнэсийн санг эрхлэх нэгжийн орон тоо, цалингийн санг Монголбанкны зардлын төсөвт багтаан тогтоож, захирлыг нь томилж, чөлөөлөх эрхийг Монголбанкны Ерөнхий менежерийн бүрэн эрхэд хамааруулж, Монголбанкны Ерөнхийлөгч эрдэнэсийн санг эрхлэх нэгжийн бүтцийг тогтоож байхаар хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг өөрчлөн найруулжээ.

Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2003 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн Монгол улсын хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулав. Үүнд:

- а) 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт 5, 6, 7 дахь заалт 5) Засгийн газар, банкнаас бусад хуулийн этгээд, иргэнд зээл, төлбөрийн болон банкны баталгаа гаргах; 6) хуулийн этгээд, иргэний дотоод, гадаадаас авах зээлийг дэмжих зорилгоор алт болон нөөц активыг барьцаалах; 7) улсын төсөвт тусгагдаж Улсын Их Хурлаар батлагдсан, энэ хуулиар зөвшөөрснөөс бусад, хуулийн этгээд, иргэний эдийн засгийн буюу арилжааны үйл ажиллагааг дэмжсэн тэнцлийн болон тэнцлийн гадуурх аливаа гүйлгээ хийх.
- б) Монголбанкны дотоод хяналтын үйл ажиллагаа, хөндлөнгийн аудитын санал, зөвлөмжийн хэрэгжилт, хөрөнгө оруулалтын багц болон Монголбанкнаас санхүүгийн тайлангаа Улсын Их Хурал, олон нийтэд тайлагнаж, мэдээлж байгаа байдал, Монголбанкны Зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавих эрх бүхий орон тооны бус Хяналтын зөвлөл ажиллана. Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг Улсын Их Хурал тогтооно.

Улсын Их Хурлын 2003 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн 39 дүгээр Тогтоолоор Монголбанкны Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг батлав. Журмаар хяналтын зөвлөлийн ажиллах нөхцөл, хэлбэрийг тодорхойллоо.

Цаг хугацааны болон төлбөр тооцооны эрсдэл

2003 онд Банк хоорондын төлбөр тооцооны журмыг шинэчлэн баталж, салбар хоорондын төлбөр тооцоо дамжуулах цагийг сунгасан.

32. АКТИВ, ПАССИВЫН ГАЗАР ЗҮЙН БАЙРШЛААРХ АНГИЛАЛ

Актив, пассивын газар зүйн байршил. Үүнд:

	2003 (сая төгрөг)		
	Монгол улс	Бусад улс	Нийт
Актив			
Бэлэн мөнгө	13,234	-	13,234
Мөнгөжсөн алт, үнэт металл	7,662	7,768	15,430
Гадаадын үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	-	77,370	77,370
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хадгаламж, хөрөнгө	-	220,820	220,820
Дотоодын санхүүгийн байгууллагуудад олгосон зээл, урьдчилгаа	12,992	-	12,992
Засгийн газрын үнэт цаас	4,000	-	4,000
Санхүү, эдийн засгийн яаманд олгосон урьдчилгаа	215,054	-	215,054
Аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл	18,532	-	18,532
Бусад актив	507	-	507
Үндсэн хөрөнгө	14,370	-	14,370
	286,351	305,958	592,309
Пассив			
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	152,827	-	152,827
Гаргасан үнэт цаас	75,734	-	75,734
Гадаад валютаарх пассив	182,753	-	182,753
Засгийн Газрын байгууллагуудын хадгаламж	92,026	-	92,026
Дотоодын санхүүгийн байгууллагуудын хадгаламж	47,969	-	47,969
Бусад пассив	3,540	-	3,540
	554,849	-	554,849
Цэвэр позици	(268,498)	305,958	37,460

32. АКТИВ, ПАССИВЫН ГАЗАР ЗҮЙН БАЙРШЛААРХ АНГИЛАЛ (Үргэлжлэл)

Актив, пассивыг газар зүйн байршлаар нь ангилбал:-

	2002 (сая төгрөг)		Нийт
	Монгол улс	Бусад улс	
Актив			
Бэлэн мөнгө	13,771	-	13,771
Мөнгөжсөн алт, үнэт металл	6,991	56,019	63,010
Гадаадын үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	-	51,321	51,321
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хадгаламж, хөрөнгө	-	253,855	253,855
Дотоодын санхүүгийн байгууллагуудад олгосон зээл, урьдчилгаа	8,326	-	8,326
Санхүү, эдийн засгийн яаманд олгосон урьдчилгаа	39,807	-	39,807
Аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл	165	-	165
Бусад актив	178	922	1,100
Үндсэн хөрөнгө	13,524	-	13,524
	82,762	362,117	444,879
Пассив			
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	134,643	-	134,643
Гаргасан үнэт цаас	60,810	-	60,810
Гадаад валютаарх пассив	130,704	-	130,704
Засгийн Газрын байгууллагуудын хадгаламж	19,091	-	19,091
Дотоодын санхүүгийн байгууллагуудын хадгаламж	44,155	-	44,155
Бусад пассив	20,767	-	20,767
	410,170	-	410,170
Цэвэр позици	(327,408)	362,117	34,709

33. АКТИВ ПАССИВЫН ВАЛЮТААР ХИЙСЭН АНГИЛАЛ

Банкны санхүүгийн байдал болон мөнгөн хөрөнгийн урсгалд гадаад валютын ханшийн өөрчлөлт нөлөөлдөг. Банкны удирдлага нь гадаад валютын (голчлон ам.доллар) ханшийн эрсдэлд лимит тогтоодог. Банкны гадаад валютын ханшийн эрсдэл:

		2003 (сая төгрөг)				
	Төгрөг	Ам. доллар	ЗТЭ	Бусад валют	Нийт	
Актив						
Бэлэн мөнгө	55	11,102	-	2,077	13,234	
Мөнгөжсөн алт, үнэт металл	7,662	-	-	7,768	15,430	
Гадаадын үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	-	77,370	-	-	77,370	
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хадгаламж, хөрөнгө	81,131	135,860	171	3,658	220,820	
Дотоодын санхүүгийн байгууллагуудад олгосон зээл, урьдчилгаа	12,987	-	-	5	12,992	
Засгийн газрын үнэт цаас	4,000	-	-	-	4,000	
СЭЗЯ-нд олгосон урьдчилгаа	160,216	-	-	54,838	215,054	
Аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл	-	18,532	-	-	18,532	
Бусад актив	507	-	-	-	507	
Үндсэн хөрөнгө	14,370	-	-	-	14,370	
Нийт актив	280,928	242,864	171	68,346	592,309	
Пассив						
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	152,827	-	-	-	152,827	
Гаргасан үнэт цаас	75,734	-	-	-	75,734	
Гадаад валютаарх пассив	81,709	4,547	57,674	38,823	182,753	
Засгийн газрын байгуул- лагуудын хадгаламж	73,102	18,878	46	-	92,026	
Дотоодын санхүүгийн бай- гууллагуудын хадгаламж	27,961	16,619	-	3,389	47,969	
Бусад пассив	3,540	-	-	-	3,540	
Нийт пассив	414,873	40,044	57,720	42,212	554,849	
Дүрмийн сан	5,000	-	-	-	5,000	
Нөөцийн сан	32,460	-	-	-	32,460	
Нийт өөрийн хөрөнгө	37,460	-	-	-	37,460	
Нийт пассив болон өөрийн хөрөнгө	452,333	40,044	57,720	42,212	592,309	

33. АКТИВ ПАССИВЫН ВАЛЮТААР ХИЙСЭН АНГИЛАЛ (Үргэлжлэл)

АУДИТОРЫН
ТАЙЛАН

	Төгрөг	2002 (сая төгрөг) Ам. доллар	ЗТЭ	Бусад валют	Нийт
Актив					
Бэлэн мөнгө	26	5,961	-	7,784	13,771
Мөнгөжсөн алт, үнэт металл	6,991	-	-	56,019	63,010
Гадаадын үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	-	51,321	-	-	51,321
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуул- сан хадгаламж, хөрөнгө	1,463	250,555	39	1,798	253,855
Дотоодын санхүүгийн байгууллагуудад олгосон зээл, урьдчилгаа	8,324	-	-	2	8,326
СЭЗЯ-нд олгосон урьдчилгаа	-	-	39,807	-	39,807
Аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл	165	-	-	-	165
Бусад актив	178	922	-	-	1,100
Үндсэн хөрөнгө	13,524	-	-	-	13,524
Нийт актив	30,671	308,759	39,846	65,603	444,879
Пассив					
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	134,643	-	-	-	134,643
Гаргасан үнэт цаас	60,810	-	-	-	60,810
Гадаад валютаарх пассив	73,392	4,270	47,609	5,433	130,704
Засгийн газрын бай- гууллагуудын хадгаламж	15,344	3,707	40	-	19,091
Дотоодын санхүүгийн байгууллагуудын хадгаламж	28,351	14,772	-	1,032	44,155
Бусад пассив	20,767	-	-	-	20,767
Нийт пассив	333,307	22,749	47,649	6,465	410,170
Дүрмийн сан	5,000	-	-	-	5,000
Нөөцийн сан	29,709	-	-	-	29,709
Нийт өөрийн хөрөнгө	34,709	-	-	-	34,709
Нийт пассив болон өөрийн хөрөнгө	368,016	22,749	47,649	6,465	444,879

34. АКТИВ ПАССИВЫН ХУГАЦААГААРХ АНГИЛАЛ

2003 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Банкны актив, пассивын хугацаагаарх ангилал:

(сая төгрөг)	3 сараас доош	3-6 сар	6 сараас 1 жил	1 жилээс дээш	Хугацаа- гүй	Нийт
Актив						
Бэлэн мөнгө	-	-	-	-	13,234	13,234
Мөнгөжсөн алт, үнэт металл	-	-	-	-	15,430	15,430
Гадаадын үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	5,840	-	31,935	-	39,595	77,370
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хадгаламж, хөрөнгө	132,161	-	-	-	88,659	220,820
Дотоодын санхүүгийн байгууллагуудад олгосон зээл, урьдчилгаа	-	-	4,736	8,256	-	12,992
Засгийн газрын үнэт цаас	-	-	4,000	-	-	4,000
СЗЗЯ-нд олгосон урьдчилгаа	-	-	43,216	117,000	54,838	215,054
Аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл	18,532	-	-	-	-	18,532
Бусад актив	507	-	-	-	-	507
Үндсэн хөрөнгө	-	-	-	-	14,370	14,370
Пассив						
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	-	-	-	-	(152,827)	(152,827)
Гаргасан үнэт цаас	(75,734)	-	-	-	-	(75,734)
Гадаад валютаарх пассив	-	(29,231)	-	(71,813)	(81,709)	(182,753)
Засгийн газрын байгууллагуудын хадгаламж	-	-	-	(4,091)	(87,935)	(92,026)
Дотоодын санхүүгийн байгууллагуудын хадгаламж	-	-	-	-	(47,969)	(47,969)
Бусад пассив	-	-	-	-	(3,540)	(3,540)
Цэвэр позици	81,306	(29,231)	83,887	49,352	(147,854)	37,460
Зөрүү (өссөн дүнгээр)	81,306	52,075	135,962	185,314		37,460

34. АКТИВ ПАССИВЫН ХУГАЦААГААРХ АНГИЛАЛ (Үргэлжлэл)

2002 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Банкны актив, пассивын хугацаагаарх ангилал:

(сая төгрөг)	3 сараас доош	3-6 сар	6 сараас 1 жил	1 жилээс дээш	Хугацаа- гүй	Нийт
Актив						
Бэлэн мөнгө	-	-	-	-	13,771	13,771
Мөнгөжсөн алт, үнэт металл	-	-	-	-	63,010	63,010
Гадаадын үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	208	-	31,763	5,625	13,725	51,321
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хадгаламж, хөрөнгө	178,743	2,250	-	-	72,862	253,855
Дотоодын санхүүгийн байгууллагуудад олгосон зээл, урьдчилгаа	-	-	3,631	4,695	-	8,326
СЭЗЯ-нд олгосон урьдчилгаа	-	-	-	-	39,807	39,807
Аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл	-	-	-	-	165	165
Бусад актив	124	-	-	-	976	1,100
Үндсэн хөрөнгө	-	-	-	-	13,524	13,524
Пассив						
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	-	-	-	-	(134,643)	(134,643)
Гаргасан үнэт цаас	(60,810)	-	-	-	-	(60,810)
Гадаад валотаарх пассив	-	-	-	(57,312)	(73,392)	(130,704)
Засгийн газрын байгууллагуудын хадгаламж	-	-	-	(1,451)	(17,640)	(19,091)
Дотоодын санхүүгийн байгууллагуудын хадгаламж	-	-	-	-	(44,155)	(44,155)
Бусад пассив	(84)	-	(57)	(584)	(20,042)	(20,767)
Цэвэр позици	118,181	2,250	35,337	(49,027)	(72,032)	34,709
Зөрүү (өссөн дүнгээр)	118,181	120,431	155,768	106,741		34,709

35. САНХҮҮГИЙН ХЭРЭГСЛИЙН БОДИТ ҮНЭ

Санхүүгийн хэрэгсэл нь санхүүгийн актив, санхүүгийн пассиваас бүрдэнэ. Санхүүгийн хэрэгслийн бодит үнэ гэдэг нь тухайн санхүүгийн хэрэгслийг мэдлэгтэй, холбоотой бус талуудын хооронд солилцох дүн юм.

2003 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх бараг бүх санхүүгийн хэрэгсэл нь богино буюу нэг жилээс доош хугацаатай байна. Эдгээр санхүүгийн актив, пассивын тайлан тэнцлийн өдрөөр тооцоолсон бодит үнэ нь тэнцэлд тусгагдсан бүртгэлийн дүнтэй ойролцоо байна.

35. МОНГОЛ ОРЧУУЛГЫН ТАЛААР

Энэхүү санхүүгийн тайлан нь мөн монгол хэл дээр бэлтгэгдсэн бөгөөд монгол болон англи хувиудын хооронд ялгаа, зөрүү гарсан тохиолдолд англи хувийг баримтална.

ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
	1999	2000	2001	2002	2003 ¹
ДНБ-ний бодит өсөлт	3.2	1.1	1.0	4.0	5.5
ДНБ оны үнээр, тэрбум төгрөг	925.3	1018.9	1115.6	1240.8	1362.5
Инфляци	10.0	8.1	8.0	1.6	4.7
Ажилгүйдлийн түвшин	4.7	4.6	4.6	3.4	3.5
Мөнгөний тойм (тэрбум төгрөг)					
M2	220.2	258.8	331.1	470.1	703.3
Гадаад цэвэр актив	167.5	201.7	220.2	308.5	256.3
Дотоод цэвэр актив	116.6	84.8	129.3	200.0	514.6
M2/ДНБ (%)	23.8	25.4	29.7	37.9	51.6
Зээл/ДНБ (%)	8.4	6.6	12.1	18.7	32.5
Хадгаламж/ДНБ (%)	13.7	15.5	19.9	28.2	42.0
Банкуудын зээл	77.5	66.8	135.1	231.4	442.1
Чанаргүй зээл	42.1	15.9	10.9	16.6	36.7
Банкуудын зээлийн хүү	37.7	30.3	31.8	26.6	25.6
Банкуудын хадгаламжийн хүү	19.8	13.8	13.2	14.0	14.0
ТБҮЦ-ны жигнэсэн дундаж хүү	11.4	8.6	8.6	9.9	11.5
Төлбөрийн тэнцэл (сая ам. доллар)					
Экспорт ф.о.б	454.2	535.8	523.2	523.9	627.3
Импорт с.и.ф	-567.1	-675.9	-693.1	-752.8	-826.9
Урсгал тэнцэл	-57.8	-69.9	-61.7	-105.1	-98.7
Урсгал тэнцэлийн ДНБ-д эзлэх хувь	-6.4	-7.2	-6.1	-9.4	-8.3
Нийт гадаад нөөц	155.9	190.9	206.8	268.2	203.4
Импортын долоо хоногоор	14.3	14.7	15.6	18.6	12.8
Ам. доллартай харьцах төгрөгийн ханш (хугацааны эцэст)	1072.4	1097.0	1102.0	1125.0	1168.0
Улсын нэгдсэн төсөв (тэрбум төгрөг)					
Нийт орлого ба тусламж	254.7	351.0	439.3	477.0	553.9
Урсгал орлого	247.9	346.2	430.0	469.8	545.3
Нийт зарлага ба цэвэр зээл	364.7	429.6	489.9	550.5	615.8
Урсгал зардал	251.0	314.1	366.8	415.3	434.8
Төсвийн тэнцэл	-109.9	-78.6	-50.6	-73.4	-61.9
Төсвийн тэнцэлийн ДНБ-д эзлэх хувь	-11.9	-7.7	-4.5	-6.0	-4.5
Санхүүжилт					
Гадаад эх үүсвэр, цэвэр	93.7	66.6	72.5	81.8	-158.2
Дотоод эх үүсвэр, цэвэр	16.2	12.0	21.9	-8.3	220.1

¹ Урьдчилсан байдлаар

ХАВСРАЛТ 2

СТАТИСТИКИЙН
ХАВСРАЛТУУД

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ							сая төгрөг		
Хугацааны эцэст	Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө		Үүнээс			Мөнгө (M1)		Үүнээс	
	дүн	сарын өөрчлөлт %	Касст байгаа мөнгө	Банкнаас гадуурхи мөнгө		дүн	сарын өөрчлөлт %	Аж ахуйн нэгж, бай- гууллагын харилцах (МБ)	Төгрөгийн харилцах (Банкууд)
				дүн	сарын өөрчлөлт %				
1990 12	742.7		5.7	737.0		4,749.9		3,915.9	97.0
1991 12	2,003.0		308.7	1,694.3		7,313.7		27.3	5,592.1
1992 12	2,896.4		1,057.2	1,839.2		7,640.2		11.2	5,789.8
1993 12	10,786.1	13.2	2,035.5	8,750.6	12.0	18,548.4	-8.8	40.6	9,757.2
1994 12	21,804.8	3.1	3,037.6	18,767.2	5.7	32,871.2	-0.4		14,104.0
1995 12	29,755.7	0.8	4,164.5	25,591.2	2.6	42,636.5	-0.4		17,045.3
1996 12	46,095.8	11.8	4,391.4	41,704.4	14.4	64,301.6	14.7		22,597.2
1997 12	56,816.5	3.1	7,048.2	49,768.3	4.1	76,108.9	4.0		26,340.6
1998 03	47,551.7	-7.0	6,050.8	41,500.9	-9.3	63,773.2	-9.5		22,272.3
06	61,565.7	2.5	6,170.9	55,394.8	0.0	78,699.1	-1.2		23,304.3
09	59,996.1	-2.8	5,997.4	53,998.7	-2.3	79,175.0	-1.1		25,176.3
12	61,754.2	5.7	5,308.4	56,445.8	9.2	82,582.0	9.4		26,136.2
1999 03	52,625.8	-7.2	4,558.4	48,067.4	-9.0	66,289.8	-7.3		18,222.4
06	78,453.6	9.3	4,645.8	73,807.8	8.1	92,599.9	5.7		18,792.1
09	82,990.7	-2.1	6,630.0	76,360.7	-4.5	100,454.2	-1.5		24,093.5
12	91,567.5	13.8	4,286.2	87,281.3	15.2	114,825.7	14.9		27,544.4
2000 03	102,316.4	30.1	7,282.1	95,034.2	30.4	116,237.0	22.4		21,202.8
06	125,507.4	-2.1	6,618.0	118,889.4	1.2	143,684.2	2.7		24,794.8
09	120,879.8	-1.1	6,405.4	114,474.4	-0.4	143,562.4	2.5		29,088.0
12	107,394.4	7.8	6,461.0	100,933.4	7.3	130,775.0	8.9		29,841.6
2001 03	99,711.6	-2.4	6,000.6	93,711.0	-1.4	123,586.3	3.0		29,875.3
06	133,397.4	6.6	7,933.6	125,463.8	6.7	155,099.6	2.8		29,635.9
09	124,288.6	-1.2	7,980.1	116,308.5	-0.7	151,808.6	1.0		35,500.2
12	119,205.8	5.7	10,045.1	109,160.7	8.2	156,155.3	6.9		46,994.6
2002 01	109,607.2	-8.1	12,220.9	97,386.4	-10.8	141,027.6	-9.7		43,641.3
02	108,997.7	-0.6	13,693.8	95,303.8	-2.1	138,758.8	-1.6		43,455.0
03	110,822.1	1.7	9,538.3	101,283.8	6.3	146,932.2	5.9		45,648.4
04	129,199.1	16.6	13,321.1	115,878.0	14.4	164,200.9	11.8		48,322.9
05	139,543.7	8.0	12,847.1	126,696.6	9.3	178,267.6	8.6		51,571.0
06	145,888.0	4.5	14,093.3	131,794.6	4.0	187,708.4	5.3		55,913.8
07	148,605.2	1.9	12,891.0	135,714.2	3.0	185,360.3	-1.3		49,646.1
08	152,233.7	2.4	12,276.1	139,957.6	3.1	189,423.1	2.2		49,465.5
09	144,851.7	-4.8	14,176.1	130,675.6	-6.6	181,084.7	-4.4		50,409.0
10	136,641.6	-5.7	12,643.8	123,997.7	-5.1	177,714.5	-1.9		53,716.8
11	133,987.7	-1.9	14,590.4	119,397.2	-3.7	175,576.6	-1.2		56,179.4
12	134,642.8	0.5	13,859.2	120,783.6	1.2	187,727.8	6.9		66,944.1
2003 01	138,836.5	3.1	18,556.1	120,280.4	-0.4	196,577.6	4.7		76,297.2
02	120,935.7	-12.9	14,635.7	106,300.1	-11.6	176,951.1	-10.0		70,651.0
03	131,235.3	8.5	16,228.6	115,006.7	8.2	180,109.6	1.8		65,102.9
04	145,422.1	10.8	18,198.2	127,224.0	10.6	193,596.3	7.5		66,372.4
05	152,903.4	5.1	17,645.1	135,258.3	6.3	200,968.7	3.8		65,710.4
06	160,481.3	5.0	19,423.2	141,058.1	4.3	208,987.9	4.0		67,929.8
07	162,537.0	1.3	17,115.5	145,421.5	3.1	204,711.3	-2.0		59,289.9
08	168,875.6	3.9	18,414.8	150,460.8	3.5	217,316.7	6.2		66,855.9
09	166,532.4	-1.4	18,150.1	148,382.3	-1.4	214,417.5	-1.3		66,035.2
10	156,175.3	-6.2	14,614.6	141,560.7	-4.6	213,157.5	-0.6		71,596.8
11	151,140.6	-3.2	16,869.1	134,271.5	-5.1	203,784.6	-4.4		69,513.1
12	152,826.6	1.1	21,329.9	131,496.7	-2.1	212,833.4	4.4		81,336.7

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ							сая төгрөг	
Хугацааны эцэст	Бараг мөнгө		Үүнээс				Мөнгө (M2)	
	дүн	сарын өөрчлөлт %	Төгрөгийн хадгаламж	Үүнээс		Гадаад валютын хадгаламж	дүн	сарын өөрчлөлт %
				Иргэдийн	Байгуул- лагын			
1990 12	883.2		726.3	726.3	-	157.0	5,633.1	
1991 12	2,601.1		1,996.9	1,553.3	443.6	604.2	9,914.8	
1992 12	5,412.1		4,430.2	2,985.7	1,444.5	981.9	13,052.3	
1993 12	24,215.8	10.6	10,103.1	7,969.6	2,133.5	14,112.7	42,764.2	1.2
1994 12	43,905.8	-2.6	28,937.5	25,287.3	3,650.2	14,968.3	76,777.0	-1.7
1995 12	59,408.1	-4.7	38,529.1	36,602.7	1,926.4	20,879.0	102,044.6	-2.9
1996 12	64,093.7	-4.0	35,164.2	33,819.1	1,345.1	28,929.5	128,395.3	4.5
1997 12	93,956.6	13.0	44,673.8	42,892.7	1,781.1	49,282.8	170,065.5	8.8
1998 03	89,854.6	-1.8	49,870.4	43,718.6	6,151.8	39,984.2	153,627.8	-5.1
06	81,527.3	-6.1	43,492.4	40,643.1	2,849.3	38,034.9	160,226.4	-3.8
09	86,818.2	2.0	42,212.1	39,674.0	2,538.1	44,606.1	165,993.2	0.5
12	84,667.6	-0.5	44,840.1	42,044.5	2,795.6	39,827.5	167,249.6	4.2
1999 03	87,392.9	-3.3	42,874.2	40,646.1	2,228.1	44,518.7	153,682.7	-5.1
06	92,035.4	4.7	41,158.2	38,447.7	2,710.5	50,877.2	184,635.3	5.2
09	98,485.8	3.8	44,071.8	41,877.7	2,194.1	54,414.0	198,940.0	1.1
12	105,341.3	-1.6	45,052.3	43,257.9	1,794.4	60,289.1	220,167.0	6.3
2000 03	106,197.0	-5.7	47,447.8	46,009.3	1,438.5	58,749.3	222,434.0	7.2
06	111,573.9	8.3	49,036.2	46,967.5	2,068.8	62,537.7	255,258.1	5.0
09	120,927.8	3.5	54,046.5	51,485.1	2,561.4	66,881.3	264,490.2	3.0
12	128,067.7	2.1	59,004.3	54,125.9	4,878.4	69,063.4	258,842.6	5.4
2001 03	146,954.5	6.4	66,993.0	61,110.6	5,882.4	79,961.5	270,540.8	4.8
06	158,846.5	6.6	72,344.0	63,382.0	8,962.1	86,502.5	313,946.1	4.7
09	165,619.9	-3.0	81,629.0	70,893.8	10,735.3	83,990.8	317,428.5	-1.1
12	174,908.9	3.0	87,590.4	79,321.6	8,268.7	87,318.6	331,064.3	4.8
2002 01	183,708.4	5.0	93,203.5	82,549.2	10,654.3	90,504.9	324,736.0	-1.9
02	193,578.4	5.4	101,346.6	87,704.9	13,641.7	92,231.8	332,337.3	2.3
03	198,939.7	2.8	102,964.3	92,059.3	10,905.0	95,975.4	345,871.9	4.1
04	205,133.8	3.1	108,110.1	85,884.7	22,225.4	97,023.7	369,334.7	6.8
05	209,979.4	2.4	111,538.6	100,046.1	11,492.4	98,440.9	388,247.1	5.1
06	213,270.1	1.6	113,054.1	103,517.4	9,536.7	100,216.0	400,978.5	3.3
07	236,247.4	10.8	124,332.7	111,429.5	12,903.1	111,914.7	421,607.7	5.1
08	241,304.5	2.1	126,626.7	113,075.9	13,550.7	114,677.8	430,727.6	2.2
09	256,280.1	6.2	134,245.4	121,098.3	13,147.1	122,034.7	437,364.8	1.5
10	261,900.5	2.2	137,123.2	127,012.9	10,110.4	124,777.2	439,615.0	0.5
11	271,982.8	3.8	141,912.7	131,679.9	10,232.7	130,070.1	447,559.4	1.8
12	282,397.8	3.8	147,211.7	137,182.7	10,029.0	135,186.1	470,125.6	5.0
2003 01	291,039.3	3.1	154,137.4	146,258.1	7,879.3	136,902.0	487,616.9	3.7
02	313,492.5	7.7	167,210.0	159,061.9	8,148.0	146,282.5	490,443.6	0.6
03	324,137.7	3.4	176,134.3	163,836.2	12,298.1	148,003.4	504,247.3	2.8
04	336,930.3	3.9	181,237.5	168,090.5	13,147.0	155,692.8	530,526.7	5.2
05	341,454.2	1.3	186,132.1	173,389.7	12,742.4	155,322.1	542,422.9	2.2
06	348,727.8	2.1	193,137.5	180,771.4	12,366.1	155,590.3	557,715.7	2.8
07	377,666.1	8.3	203,725.4	191,044.6	12,680.8	173,940.8	582,377.4	4.4
08	371,170.3	-1.7	203,603.9	193,425.6	10,178.3	167,566.4	588,487.0	1.0
09	394,923.6	6.4	210,986.9	200,585.6	10,401.3	183,936.8	609,341.1	3.5
10	410,229.7	3.9	220,221.5	210,127.9	10,093.6	190,008.2	623,387.2	2.3
11	423,716.6	3.3	223,024.3	212,120.7	10,903.6	200,692.3	627,501.2	0.7
12	490,499.0	15.8	240,280.1	228,133.5	12,146.6	250,218.9	703,332.4	12.1

ХАВСРАЛТ 3

СТАТИСТИКИЙН
ХАВСРАЛТУУД

ХЭРЭГЛЭЭНИЙ БАРААНЫ ҮНИЙН ИНДЕКС								хувиар
Хугацааны эцэст	Хүнсний бүтээгдэхүүн	Үүнээс						
		Мах, махан бүтээгдэхүүн	Сүү, сүүн бүтээгдэхүүн	Үр тарианы бүтээгдэхүүн	Сахар, чихэр, цай, жимс	Төмс, хүнсний ногоо	Хүнсний бусад бүтээгдэхүүн	Ундаа, тамхины зүйл
1991 01 16	100.0	100.0	100.0	100.0			100.0	100.0
1991 12	134.4	136.4	156.3	124.0			131.4	126.9
1992 12	755.4	468.3	884.2	978.4			828.9	800.1
1993 12	2,247.0	1,744.3	2,153.2	2,906.7			2,736.5	1,424.5
1994 12	3,565.3	2,723.1	3,658.8	4,147.5			4,681.4	1,855.4
1995.12=100*								
1995 12	58.7	18.4	5.1	17.2			4.9	4.5
1996 12	78.2	19.5	7.1	27.0			7.5	6.3
1997 12	87.0	21.2	9.6	28.1			8.7	7.8
1998 12	87.7	22.0	10.0	27.6			10.1	7.7
1999 12	95.5	25.0	10.0	28.8			10.6	8.5
2000 12	46.6	12.4	5.2	12.9	4.9	4.1	3.5	3.7
2000.12=100**								
2001 01	50.4	14.7	6.0	12.9	4.9	4.3	3.5	4.1
03	55.5	18.6	6.5	13.1	4.9	4.8	3.5	4.1
06	56.0	21.3	4.1	13.0	5.0	4.9	3.5	4.2
09	47.4	13.9	4.1	13.2	4.9	3.6	3.5	4.2
12	50.7	14.8	5.5	13.3	4.9	4.3	3.6	4.3
2002 01	51.1	14.9	5.6	13.3	4.9	4.4	3.6	4.3
02	52.4	16.0	5.6	13.3	4.9	4.6	3.6	4.4
03	51.6	15.9	5.5	12.9	4.9	4.4	3.6	4.4
04	53.0	17.6	5.2	12.8	5.0	4.5	3.5	4.4
05	54.1	19.0	4.8	12.7	4.9	4.9	3.5	4.3
06	53.5	18.8	3.8	12.5	5.1	5.7	3.5	4.2
07	51.7	17.8	3.6	12.2	4.9	5.5	3.6	4.2
08	49.2	15.9	3.5	12.1	4.8	5.0	3.6	4.2
09	47.9	15.0	3.8	12.1	4.7	4.5	3.6	4.2
10	47.9	14.2	4.6	12.2	4.7	4.5	3.6	4.3
11	48.6	14.1	5.1	12.2	4.7	4.7	3.6	4.3
12	49.9	14.8	5.6	12.2	4.7	4.8	3.6	4.3
2003 01	51.3	15.9	5.5	12.0	4.7	5.3	3.6	4.3
02	52.5	17.3	5.6	11.7	4.7	5.5	3.6	4.2
03	54.9	19.5	5.6	11.7	4.7	5.7	3.6	4.2
04	57.8	22.3	5.6	11.8	4.6	5.7	3.6	4.2
05	61.3	26.4	5.0	11.9	4.7	5.4	3.7	4.2
06	59.0	25.3	4.1	11.9	5.0	5.0	3.6	4.2
07	57.7	23.4	3.9	12.6	5.0	5.1	3.6	4.2
08	52.2	18.9	3.6	12.5	4.7	4.8	3.6	4.1
09	50.8	17.8	3.9	13.0	4.5	3.9	3.6	4.1
10	50.7	16.0	4.3	14.5	4.6	3.5	3.7	4.1
11	52.0	16.7	5.1	14.3	4.8	3.3	3.7	4.2
12	53.8	18.3	5.3	14.2	4.8	3.5	3.7	4.2

ХЭРЭГЛЭЭНИЙ БАРААНЫ ҮНИЙН ИНДЕКС								хувиар
Хугацааны эцэст	Хувцас, гутал	Үүнээс						Орон сууц, түлш, цахилгаан
		Хөвөн, бөс бараа	Эр.хүний костюм, хувцас	Эм.хүний бэлэн хувцас	Том хүний дотуур хувцас	Хүүхдийн хувцас	Гутал, ботинк	
1991 01 16	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
1991 12	192.4	148.4	174.5	229.3	173.5	100.0	236.1	115.5
1992 12	679.1	676.3	347.3	541.2	397.1	440.9	965.4	245.8
1993 12	1,304.3	1,161.6	650.4	896.4	743.6	1,404.4	1,782.9	1,068.3
1994 12	2,363.1	1,957.5	1,259.4	2,110.3	972.1	2,126.9	3,377.3	1,595.7
1995.12=100*								
1995 12	10.3	0.4	1.5	3.4		1.0	4.0	10.4
1996 12	15.4	0.6	2.3	4.5		1.8	6.2	17.9
1997 12	20.6	0.7	2.9	6.5		2.3	8.2	27.0
1998 12	22.8	0.6	3.2	6.9		2.4	9.4	29.5
1999 12	23.9	0.6	3.1	7.1		2.4	10.2	32.1
2000 12	13.5	0.3	3.5	4.6		0.5	4.6	14.1
2000.12=100**								
2001 01	13.4	0.3	3.5	4.6		0.5	4.5	15.1
03	13.3	0.2	3.5	4.6		0.5	4.5	14.7
06	13.4	0.2	3.5	4.6		0.5	4.5	14.6
09	13.9	0.2	3.8	4.7		0.6	4.6	14.9
12	14.1	0.2	3.9	4.7		0.6	4.6	17.2
2002 01	14.1	0.2	3.9	4.7		0.6	4.7	17.2
02	14.1	0.2	3.9	4.7		0.6	4.6	16.7
03	13.7	0.3	3.9	4.6		0.5	4.5	16.4
04	13.6	0.3	3.8	4.6		0.5	4.5	16.4
05	13.6	0.3	3.8	4.6		0.5	4.5	16.4
06	13.6	0.3	3.8	4.6		0.5	4.5	16.3
07	13.6	0.3	3.8	4.5		0.6	4.5	17.0
08	13.5	0.3	3.7	4.5		0.5	4.5	17.5
09	13.6	0.3	3.8	4.5		0.6	4.5	17.5
10	13.8	0.3	4.0	4.5		0.6	4.5	17.9
11	14.5	0.3	4.0	4.8		0.6	4.9	18.0
12	14.9	0.3	4.0	4.8		0.6	5.2	18.0
2003 01	14.9	0.3	4.0	4.9		0.6	5.2	17.2
02	15.1	0.3	4.0	4.9		0.6	5.2	16.8
03	14.2	0.3	3.9	4.5		0.6	4.9	16.7
04	14.0	0.3	3.8	4.5		0.6	4.8	16.7
05	13.8	0.3	3.8	4.4		0.6	4.7	16.7
06	13.7	0.3	3.7	4.4		0.6	4.6	16.7
07	13.7	0.3	3.8	4.4		0.6	4.6	16.6
08	14.0	0.3	3.7	4.6		0.6	4.8	16.6
09	14.1	0.3	3.9	4.6		0.6	4.7	17.8
10	14.6	0.3	3.9	4.7		0.7	5.0	18.4
11	14.9	0.3	4.0	4.7		0.7	5.1	18.1
12	14.9	0.3	4.0	4.7		0.7	5.1	17.7

ХАВСРАЛТ 3 (үргэлжлэл)

СТАТИСТИКИЙН
ХАВСРАЛТУУД

ХЭРЭГЛЭЭНИЙ БАРААНЫ ҮНИЙН ИНДЕКС										хувиар
Хугацааны эцэст	Гэр ахуйн бараа	Эм, тариа	Тээвэр, холбоо	Соёл боловс- рол	Бусад бараа	Ерөнхий индекс	Сарын өөрчлөлт %	Оны эхнээс %	Жилийн өөрчлөлт	
1991 01 16	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0				
1991 12	209.6	100.0	137.3	277.3	152.3	152.7	5.1	52.7		
1992 12	795.8	196.7	535.3	581.0	430.2	649.8	11.0	325.5		
1993 12	2,087.2	1,933.9	1,673.3	2,154.8	1,483.8	1,838.7	2.5	183.0		
1994 12	3,247.2	1,933.9	3,221.1	4,427.9	2,904.7	3,057.8	2.1	66.3		
1995.12=100*										
1995 12	3.9	2.1	7.6	3.6	3.5	100.0	2.1	53.1	53.1	
1996 12	5.4	3.0	13.6	5.7	5.3	144.6	3.2	44.6	44.6	
1997 12	6.6	3.8	15.0	8.2	6.4	174.2	0.9	20.5	20.5	
1998 12	6.1	3.9	17.8	9.8	7.4	184.7	2.1	6.0	6.0	
1999 12	6.5	4.6	23.3	11.3	7.9	203.2	1.7	10.0	10.0	
2000 12	3.2	1.4	10.1	7.4	3.7	100.0	2.1	8.1	8.1	
2000.12=100**										
2001 01	3.2	1.4	10.2	7.4	3.7	104.9	4.9	4.9	10.4	
03	3.3	1.4	10.2	7.4	3.7	109.5	2.7	9.5	13.2	
06	3.3	1.4	10.0	7.3	3.7	109.8	-3.7	9.8	4.5	
09	3.2	1.4	10.1	7.3	3.8	102.0	-2.0	2.0	5.8	
12	3.3	1.4	10.2	7.3	3.8	107.9	2.1	7.9	8.0	
2002 01	3.3	1.4	10.4	7.2	3.8	108.5	0.5	0.5	3.5	
02	3.3	1.4	10.4	7.2	3.8	109.3	0.7	1.2	2.5	
03	3.3	1.4	10.3	7.2	3.8	107.8	-1.4	-0.1	-1.6	
04	3.3	1.4	10.3	7.2	3.8	109.0	1.2	1.0	-2.1	
05	3.3	1.5	10.3	7.2	3.8	110.1	1.0	2.0	-3.4	
06	3.3	1.5	10.3	7.2	3.8	109.5	-0.5	1.5	-0.2	
07	3.3	1.5	10.3	7.2	3.8	108.5	-0.9	0.5	0.9	
08	3.3	1.5	10.3	7.2	3.8	106.3	-2.0	-1.5	2.1	
09	3.3	1.5	10.3	7.5	3.8	105.4	-0.9	-2.3	3.4	
10	3.3	1.5	10.4	7.5	3.9	106.3	0.9	-1.5	2.9	
11	3.4	1.5	10.5	7.6	3.9	108.0	1.6	0.1	2.2	
12	3.4	1.5	10.5	7.6	3.9	109.8	1.6	1.6	1.6	
2003 01	3.3	1.5	10.5	7.6	4.0	110.3	0.5	0.5	1.7	
02	3.3	1.5	10.5	7.5	4.1	111.4	1.0	1.5	1.9	
03	3.3	1.6	10.5	7.5	4.3	113.0	1.5	3.0	4.9	
04	3.3	1.6	10.4	7.9	4.3	116.0	2.6	5.7	6.4	
05	3.2	1.6	10.4	7.9	4.3	119.2	2.7	8.5	8.2	
06	3.2	1.6	10.4	7.8	4.3	116.7	-2.0	6.3	6.6	
07	3.2	1.6	10.5	7.8	4.3	115.5	-1.1	5.2	6.5	
08	3.3	1.6	10.6	8.4	4.3	111.0	-3.9	1.1	4.5	
09	3.3	1.6	10.7	8.4	4.4	111.1	0.1	1.2	5.4	
10	3.3	1.6	10.8	8.5	4.4	112.3	1.0	2.3	5.6	
11	3.2	1.6	10.8	8.5	4.5	113.6	1.2	3.5	5.2	
12	3.3	1.6	10.8	8.4	4.5	114.9	1.1	4.7	4.7	

* 1995 оны 12 сараас хэрэглээний сагсан дахь 123 нэр төрлийн бүтээгдэхүүнийг 205 болгож өргөтгөв

** 2000 оны 12 сараас хэрэглээний сагсан дахь 205 нэр төрлийн бүтээгдэхүүнийг 239 болгож өргөтгөв

МӨНГӨНИЙ ТОЙМ										сая төгрөг
Хугацааны эцэст	Гадаад цэвэр актив	Дотоодын зээл (цэвэр)	Үүнээс							Нийт актив
			Төв Засгийн Газар	Улсын сектор	Хувийн сектор	Хугацаа хэтэрсэн зээл	Хэвийн бус, эргэлзээтэй, найдваргүй	Банкны бус санхүүгийн байгууллага	Хувьцаа, вексель	
1991 12	495.4	10,971.2	-1,883.7	9,779.6	3,075.3		0.0	0.0	0.0	11,466.6
1992 12	-27.0	16,078.2	-3,051.7	12,204.2	6,925.7		0.0	0.0	0.0	16,051.2
1993 12	23,395.7	24,460.3	-7,143.4	21,744.4	9,859.3		0.0	0.0	0.0	47,856.0
1994 12	29,699.3	49,190.3	-3,773.1	12,193.3	40,638.0		0.0	7.8	124.3	78,889.6
1995 12	51,709.7	45,494.7	-17,227.8	10,883.3	51,653.5		0.0	61.4	124.3	97,204.4
1996 12	73,733.6	90,240.4	19,920.3	14,520.3	22,851.9	8,057.8	24,890.1	0.0	0.0	163,974.0
1997 12	135,437.2	67,635.4	13,352.1	11,713.0	28,112.6	4,553.9	9,903.8	0.0	0.0	203,072.6
1998 12	96,557.5	136,062.0	41,460.0	18,295.6	43,667.5	6,051.9	26,587.0	0.0	0.0	232,619.5
1999 12	167,541.5	116,635.6	34,555.7	8,564.5	31,408.6	2,925.7	39,181.0	0.0	0.0	284,177.1
2000 12	201,696.9	84,831.1	17,171.2	6,281.5	45,482.9	1,281.8	14,613.8	0.0	0.0	286,528.0
2001 01	187,939.5	96,095.0	21,698.0	6,201.3	51,727.3	1,845.7	14,622.7	0.0	0.0	284,034.5
03	199,864.8	107,671.8	26,210.3	5,201.4	60,415.9	1,704.0	13,989.9	150.3	0.0	307,536.6
06	222,366.1	107,107.5	9,575.3	8,765.3	76,509.5	1,420.0	10,687.1	150.3	0.0	329,473.6
09	222,664.5	116,362.0	14,208.5	8,708.7	81,368.3	1,738.6	10,187.7	150.3	0.0	339,026.5
12	220,165.7	129,259.5	-6,829.1	10,402.0	114,670.4	1,798.3	9,067.6	150.3	0.0	349,425.2
2002 01	202,909.8	142,387.8	-275.5	9,513.5	122,402.5	1,849.3	8,747.6	150.3	0.0	345,297.6
02	211,910.0	148,558.8	1,683.3	11,174.9	124,274.7	2,786.3	8,489.3	150.3	0.0	360,468.8
03	219,898.3	150,435.6	-1,724.8	10,486.9	127,431.4	3,526.4	10,565.4	150.3	0.0	370,333.9
04	220,753.8	166,629.7	1,563.0	10,181.7	141,496.3	2,748.1	10,490.3	150.3	0.0	387,383.6
05	224,544.0	179,416.9	1,543.2	11,195.4	152,716.7	3,461.9	10,349.5	150.3	0.0	403,960.9
06	223,696.2	195,587.4	3,529.6	12,675.9	163,173.1	5,437.4	10,621.1	150.3	0.0	419,283.7
07	247,989.9	191,091.1	-2,410.0	13,277.4	163,957.3	5,472.3	10,643.8	150.3	0.0	439,081.0
08	242,746.7	195,909.8	-2,753.9	13,164.6	169,146.4	4,832.1	11,370.4	150.3	0.0	438,656.5
09	276,385.3	177,337.3	-20,282.6	13,509.2	168,246.7	4,263.0	11,450.7	150.3	0.0	453,722.6
10	281,081.3	179,515.3	-22,689.6	13,910.4	171,416.5	4,293.7	12,434.0	150.3	0.0	460,596.6
11	286,248.8	193,978.2	-18,567.5	12,291.3	183,806.6	4,294.5	12,003.1	150.3	0.0	480,227.0
12	308,507.4	200,027.4	-32,439.3	12,184.9	203,567.2	4,819.4	11,744.9	150.3	0.0	508,534.8
2003 01	317,455.0	210,552.0	-33,345.3	12,045.1	214,002.3	5,710.5	11,989.1	150.3	0.0	528,007.0
02	302,249.3	231,186.8	-29,411.5	11,835.5	228,615.8	7,823.7	12,173.0	150.3	0.0	533,436.2
03	307,375.0	245,360.2	-35,418.6	11,194.3	239,107.3	11,582.1	18,744.9	150.3	0.0	552,735.2
04	310,190.3	264,074.7	-39,663.1	10,991.2	261,760.0	11,646.2	19,190.0	150.3	0.0	574,265.0
05	320,070.6	274,327.1	-43,096.0	9,448.7	273,808.6	13,515.8	20,499.8	150.3	0.0	594,397.6
06	321,357.8	284,502.7	-44,157.8	12,582.5	282,641.1	13,310.1	19,976.6	150.3	0.0	605,860.5
07	347,071.9	287,451.5	-54,417.2	14,395.1	293,791.3	12,941.0	20,591.1	150.3	0.0	634,523.5
08	352,808.3	288,619.0	-61,361.0	16,062.7	299,330.8	13,774.9	20,661.3	150.3	0.0	641,427.2
09	381,705.0	272,149.6	-81,605.8	15,712.7	304,676.9	11,538.9	21,676.5	150.3	0.0	653,854.6
10	391,665.3	277,991.6	-93,016.8	17,585.4	317,005.3	14,834.1	21,433.2	150.3	0.0	669,656.9
11	377,107.6	323,133.9	-106,829.7	17,207.2	376,970.8	14,428.2	21,207.1	150.3	0.0	700,241.4
12	256,341.5	514,615.2	96,687.3	16,203.6	365,024.4	15,549.7	21,150.3	0.0	0.0	770,956.7

ХАВСРАЛТ 4 (үргэлжлэл)

СТАТИСТИКИЙН
ХАВСРАЛТУУД

МӨНГӨНИЙ ТОЙМ						сая төгрөг
Хугацааны эцэст	Мөнгө (M1)	Бараг мөнгө	Урт хугацаатай гадаад пассив	Бусад зүйл	Нийт пассив	
1991 12	7,313.7	2,601.2	1,981.7	-430.0	11,466.6	
1992 12	7,640.2	5,412.1	3,809.5	-810.6	16,051.2	
1993 12	18,548.4	24,215.8	9,094.4	-4,002.6	47,856.0	
1994 12	32,871.2	43,905.8	7,452.1	-5,339.5	78,889.6	
1995 12	42,636.5	59,408.2	14,176.2	-19,016.5	97,204.4	
1996 12	64,301.6	64,093.7	11,121.4	24,457.3	163,974.0	
1997 12	76,108.9	93,956.6	3,659.2	29,347.9	203,072.6	
1998 12	82,582.0	84,667.6	12,800.4	52,569.5	232,619.5	
1999 12	114,825.7	105,341.3	5,682.5	58,327.5	284,177.1	
2000 12	130,775.0	128,067.7	4,173.2	23,512.1	286,528.0	
2001 01	116,271.4	133,729.3	4,331.2	29,702.6	284,034.5	
03	123,586.3	146,954.5	4,226.3	32,769.5	307,536.6	
06	155,099.6	158,846.5	5,370.7	10,156.8	329,473.6	
09	151,808.6	165,619.9	5,756.8	15,841.2	339,026.5	
12	156,155.3	174,908.9	6,603.8	11,757.2	349,425.2	
2002 01	141,027.6	183,708.4	7,493.7	13,067.9	345,297.6	
02	144,738.8	193,578.4	8,036.7	14,114.9	360,468.8	
03	146,932.2	198,939.7	8,345.9	16,116.1	370,333.9	
04	164,200.9	205,133.8	8,471.5	9,577.4	387,383.6	
05	178,267.6	209,979.4	8,685.9	7,027.9	403,960.9	
06	187,708.4	213,270.1	8,890.5	9,414.7	419,283.7	
07	185,360.3	236,247.4	9,621.9	7,851.4	439,081.0	
08	189,423.1	241,304.5	9,957.3	-2,028.4	438,656.5	
09	181,084.7	256,280.2	10,606.0	5,751.7	453,722.6	
10	177,714.5	261,900.5	10,100.0	10,881.6	460,596.6	
11	175,576.6	271,982.8	11,343.1	21,324.5	480,227.0	
12	187,727.8	282,397.8	11,718.8	26,690.4	508,534.8	
2003 01	196,577.6	291,039.3	12,235.5	28,154.5	528,007.0	
02	176,951.1	313,492.5	11,964.7	31,027.9	533,436.2	
03	180,109.6	324,137.7	11,177.2	37,310.7	552,735.2	
04	193,596.3	336,930.3	11,552.4	32,185.9	574,265.0	
05	200,968.7	341,454.2	12,405.7	39,569.1	594,397.6	
06	208,987.9	348,727.8	12,475.9	35,668.9	605,860.5	
07	204,711.3	377,666.1	13,215.4	38,930.6	634,523.5	
08	217,316.7	371,170.3	15,502.3	37,437.9	641,427.2	
09	214,417.5	394,923.6	15,867.6	28,645.9	653,854.6	
10	213,157.5	410,229.7	16,541.6	29,728.1	669,656.9	
11	203,784.6	423,716.6	42,580.0	30,160.2	700,241.4	
12	212,833.4	490,499.0	44,100.0	23,524.2	770,956.7	

ХАДГАЛАМЖИЙН ХҮҮНИЙ ХУВЬ

Хугацааны эцэст	Хадгаламжийн хүү		Хугацаагүй хадгаламж	Хугацаатай хадгаламж		
	Харилцах данс			Төгрөгийн		Валютын
	Төгрөгийн	Валютын				
				0-1 жил	1-3 жил	1-3 жил
1993 12	2.0		24-100	70-153	125-151.8	10-72
1994 12	2.0		10-63.8	50-101.2		6-72
1995 12	2.0		12.0-42.6	12.5-101.2		6.0-42.6
1996 12	2.0		12.0-34.5	12.7-60.1	26.8	3.6-42.6
1997 12	2.0		3.6-34.5	6.2-69.6	36.0-42.6	2.4-42.6
1998 12	0.8-6.0	1.0-3.6	3.6-19.6	6.0-42.58	24.0-30.0	1.2-24.0
1999 12	3.0-6.0	1.0-3.6	3.0-13.2	9.6-30.0		3.6-14.4
2000 01	3.0-6.0	1.0-3.6	3.6-13.2	9.6-30.0		3.6-14.4
02	3.0-6.0	1.0-3.6	3.6-13.2	9.6-30.0		3.6-14.4
03	3.0-6.0	1.0-3.6	3.6-13.2	9.6-30.0		3.6-14.4
04	3.0-6.0	1.0-3.6	1.2-13.2	3.6-30.0		2.4-14.4
05	3.0-6.0	1.0-3.6	1.2-13.2	3.6-30.0		2.4-14.4
06	3.0-6.0	1.0-3.6	1.2-13.2	3.6-30.0		2.4-14.4
07	3.0-6.0	1.0-3.6	1.2-13.2	3.6-30.0		2.4-14.4
08	3.0-6.0	1.0-3.6	1.2-13.2	3.6-30.0		1.2-14.4
09	3.0-6.0	1.0-3.6	1.2-13.2	3.6-30.0		1.2-12.0
10	3.0-6.0	1.0-3.6	1.2-13.2	3.6-24.0		1.2-12.0
11	2.4-6.0	1.0-3.6	1.2-13.2	3.6-24.0		1.2-12.0
12	2.4-6.0	1.0-3.6	1.2-13.2	3.6-24.0		1.2-12.0
2001 01	2.4-6.0	1.0-3.6	1.2-9.6	2.4-24.0		1.2-12.0
02	2.4-6.0	1.0-3.6	1.2-9.6	2.4-24.0		1.0-12.0
03	2.4-6.0	1.0-3.6	1.2-9.6	2.4-24.0		1.0-12.0
04	2.4-4.8	1.0-3.6	1.2-9.6	2.4-24.0		1.0-12.0
05	2.4-4.8	1.0-3.6	1.2-9.6	2.4-24.0		1.0-12.0
06	2.4-4.8	1.0-3.6	1.2-9.6	2.4-25.2		1.0-18.0
07	2.4-4.8	1.0-3.6	1.2-9.6	2.4-24.0		1.0-12.0
08	2.4-4.8	1.0-3.6	1.2-9.6	2.4-25.2		1.0-18.0
09	0.3-4.8	0.3-3.6	1.2-9.6	2.4-24.0		1.0-14.4
10	0.3-4.8	0.3-3.6	1.2-9.6	2.4-36.0		1.0-12.0
11	0.0-4.8	0.3-3.6	1.2-9.6	2.4-36.0		1.0-12.0
12	0.0-5.1	0.3-4.2	1.2-9.6	2.4-24.0		1.0-13.2
2002 01	0.0-5.1	0.3-4.2	1.2-9.6	2.4-24.0		1.0-13.2
02	0.0-5.1	0.3-4.2	1.2-9.6	2.4-24.0		1.0-13.2
03	0.0-5.1	0.3-4.2	1.2-9.6	2.4-24.0		1.0-13.2
04	0.0-5.1	0.3-4.2	1.2-9.6	2.4-24.0		1.0-13.2
05	0.0-6.0	0.3-3.6	1.2-9.6	2.4-24.0		1.0-13.2
06	0.0-6.0	0.3-3.6	2.4-9.6	2.4-22.0		1.0-13.2
07	0.0-4.8	0.3-3.6	2.4-10.0	2.4-22.0		1.0-13.2
08	0.0-4.8	0.3-3.6	2.4-10.0	2.4-22.0		1.0-13.2
09	0.0-4.8	0.3-3.6	2.4-10.2	6.0-22.0		1.2-13.2
10	0.0-4.8	0.3-3.6	2.4-10.2	6.0-22.0		1.2-13.2
11	0.0-4.8	0.3-3.6	2.4-10.2	6.0-22.0		1.2-12.0
12	0.0-6.0	0.3-3.0	2.4-10.2	6.0-22.0		1.2-12.0
2003 01	0.0-6.0	0.3-3.0	2.4-10.2	6.0-22.0		1.2-12.0
02	0.0-6.0	0.3-3.0	2.4-10.2	6.0-22.0		1.2-12.0
03	0.0-6.0	0.3-3.0	2.4-10.2	6.0-22.0		1.2-12.0
04	0.0-6.0	0.3-3.0	2.4-10.2	6.0-22.0		1.2-12.0
05	0.0-6.0	0.3-3.0	2.4-10.2	6.0-22.0		1.2-22.1
06	0.0-6.0	0.3-3.0	6.0-10.2	6.0-22.0		1.81-12.0
07	0.0-6.0	0.3-3.0	6.0-10.2	6.0-22.0		1.81-12.0
08	0.0-6.0	0.3-3.0	6.0-10.2	6.0-22.2		1.81-12.0
09	0.0-6.0	0.3-3.0	3.6-10.2	6.0-22.2		2.4-12.0
10	0.0-6.0	0.3-3.0	2.4-10.0	6.0-22.0		2.4-12.0
11	0.0-6.0	0.3-3.0	2.4-10.0	6.0-22.0		2.4-12.0
12	0.0-6.0	0.3-3.0	1.8-10.0	6.0-22.0		2.4-12.0

ХАВСРАЛТ 6

СТАТИСТИКИЙН
ХАВСРАЛТУУД

ЗЭЭЛИЙН ХҮҮНИЙ ХУВЬ

Хугацааны эцэст	Зээлийн хүү					
	Монголбанк	Банкуудын зээлийн хүү				
		Богино хугацааны		Дунд ба урт хугацааны		
		Төгрөгийн	Валютын	1-3 жил	3-5 жил	5 -аас дээш
1993 12	120-300					
1994 12	72-264					
1995 12	72-150					
1996 12	72-109					
1997 12	45.0-50.0					
1998 12	23.3	45.8	34.2			
1999 12	11.4	38.8	36.5			
2000 01	12.3	33.4	33.1			
02	11.3	45.0	26.5			
03	11.2	36.5	31.7			
04	12.8	37.0	29.7			
05	16.1	37.3	26.7			
06	15.6	38.9	27.1			
07	15.6	32.2	30.9			
08	14.6	35.3	23.5			
09	10.9	42.7	29.3			
10	11.1	37.7	31.6			
11	6.9	32.7	26.6			
12	8.6	34.7	25.8			
2001 01	4.8	38.8	23.7			
02	11.2	40.1	27.2			
03	11.2	38.0	21.5			
04	11.7	37.9	21.6			
05	12.5	37.6	24.2			
06	12.5	34.5	22.8			
07	11.1	33.9	20.7			
08	10.2	35.0	23.5			
09	9.9	37.4	21.4			
10	6.7	36.2	25.5			
11	6.5	37.4	23.3			
12	8.6	41.4	22.2			
2002 01	9.3	39.0	24.2			
02	11.6	34.2	21.4			
03	11.4	39.3	21.1			
04	11.4	37.8	22.3			
05	10.9	35.5	19.6			
06	11.5	33.4	22.3			
07	12.6	33.2	19.9			
08	13.3	35.0	20.4			
09	13.0	35.0	23.6			
10	8.9	35.1	19.9			
11	9.9	35.3	20.4			
12	9.9	33.4	19.8			
2003 01	4.9	30.7	20.7			
02	4.9	31.4	21.3			
03	3.9	32.6	20.8			
04	10.8	31.0	20.2			
05	14.3	32.0	16.6			
06	15.5	32.4	20.9			
07	14.1	32.8	19.9			
08	14.0	33.2	23.5			
09	11.3	32.2	22.6			
10	12.2	29.9	20.8			
11	12.6	33.2	21.7			
12	11.5	31.5	19.6			

ГАДААД ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ХАНШ											төгрөгөөр		
Хугацааны эцэст	USD		EUR	SEK	BGN	HUF	CZK	EGP	ECU	JPY	CHF	GBP	HKD
	Хуга- цааны эцэст	сарын дун- даж											
1993 12	396.51	395.03							349.19	3.55	275.01	592.70	51.32
1994 12	414.09	413.00							498.77	4.12	310.99	639.77	53.51
1995 12	473.62	473.48							604.81	4.63	409.53	731.27	61.23
1996 12	693.51	692.76							860.82	5.98	514.28	1172.48	89.64
1997 12	813.16	811.95							904.88	6.28	565.93	1358.14	104.93
1998 12	902.00	891.86							1052.86	7.71	656.72	1508.05	116.45
1999 01	950.00	916.45	1099.96							8.30	687.16	1572.96	122.67
03	1041.24	1019.63	1120.58							8.67	703.30	1689.93	134.37
06	1014.73	1008.06	1056.64							8.36	660.33	1608.35	130.81
09	1058.62	1052.28	1104.51							10.04	689.30	1737.09	136.29
12	1072.37	1070.43	1086.85							10.42	676.15	1734.56	137.99
2000 01	1087.61	1080.76	1065.97							10.17	661.87	1765.63	139.79
03	1090.00	1091.83	1065.15							10.20	670.60	1736.04	140.01
06	1065.00	1053.57	997.59							10.18	643.00	1598.62	136.69
09	1085.62	1084.14	957.25							10.05	628.98	1583.43	139.21
12	1097.00	1097.00	1006.61							9.74	659.53	1615.11	140.66
2001 01	1099.00	1097.77	1020.31							9.40	668.53	1611.46	140.91
02	1098.00	1098.99	993.42							9.43	648.28	1588.75	140.78
03	1097.00	1098.00	977.04							8.93	623.40	1563.83	140.66
04	1091.00	1092.95	985.34							8.80	640.71	1573.33	139.88
05	1095.00	1092.67	943.18							9.10	617.67	1548.06	140.39
06	1097.00	1096.00	936.51							8.82	616.15	1551.05	140.65
07	1098.00	1096.67	964.37							8.87	638.78	1567.23	140.77
08	1099.00	1098.43	1006.46							9.18	662.47	1591.08	140.90
09	1099.00	1099.50	1013.20							9.40	689.70	1607.60	140.90
10	1100.00	1099.57	982.90							9.00	666.80	1574.80	141.00
11	1100.00	1100.00	966.20							8.87	661.40	1545.60	141.00
12	1102.00	1101.29	973.60							8.39	657.30	1598.60	141.30
2002 01	1102.00	1102.00	964.50	104.50	494.20	3.90	30.20	238.10		8.18	675.00	1567.50	141.30
02	1104.00	1103.40	957.50	105.00	492.60	3.90	30.20	239.30		8.23	648.80	1572.90	141.60
03	1104.00	1104.00	971.70	108.00	498.10	4.00	31.30	238.30		8.34	664.70	1574.30	141.50
04	1104.00	1104.00	992.60	107.60	509.30	4.10	32.60	238.30		8.60	678.30	1606.20	141.50
05	1103.00	1103.35	1014.20	111.30	519.40	4.20	33.00	239.30		8.82	696.60	1603.00	141.40
06	1105.00	1104.00	1067.40	117.80	548.20	4.30	35.10	239.70		8.96	725.90	1657.30	141.70
07	1110.00	1108.38	1110.70	117.80	570.10	4.50	36.30	239.60		9.44	768.30	1753.00	142.30
08	1116.00	1113.23	1095.10	119.80	562.50	4.50	35.80	242.40		9.42	746.80	1711.40	143.10
09	1117.00	1116.05	1092.90	119.80	561.40	4.50	36.00	242.80		9.12	747.10	1738.00	143.30
10	1121.00	1119.00	1096.20	120.00	563.10	4.50	35.20	245.00		9.05	747.10	1742.60	143.70
11	1123.00	1122.22	1126.20	125.40	576.60	4.80	36.60	242.40		9.22	765.80	1777.30	144.00
12	1125.00	1124.09	1169.40	128.00	599.30	5.00	37.30	242.80		9.38	804.00	1804.00	144.30
2003 01	1132.00	1129.50	1224.70	133.20	626.20	5.00	39.00	210.40		9.54	833.50	1862.90	145.10
02	1138.00	1134.05	1228.50	135.10	628.50	5.00	38.70	204.30		9.72	840.10	1804.50	145.90
03	1140.00	1139.74	1219.30	132.10	625.30	4.90	38.30	198.40		9.48	824.50	1783.70	146.20
04	1134.00	1136.18	1243.70	136.10	638.90	5.10	39.50	193.00		9.45	826.00	1805.40	145.40
05	1130.00	1130.00	1328.80	145.30	682.80	5.40	42.40	189.40		9.51	871.00	1850.50	144.90
06	1139.00	1133.67	1302.20	142.20	669.20	4.90	41.30	188.90		9.53	844.60	1891.40	146.10
07	1153.00	1146.59	1318.50	143.50	677.40	5.00	41.30	188.20		9.62	852.00	1872.20	147.80
08	1154.00	1152.19	1255.20	136.30	644.80	4.90	38.70	187.60		9.86	816.20	1820.10	148.00
09	1159.00	1156.64	1321.80	147.90	678.60	5.20	41.80	188.50		10.40	857.80	1914.20	149.60
10	1165.00	1161.39	1306.30	151.10	698.50	5.30	42.40	189.60		10.78	876.00	1979.50	150.10
11	1171.00	1168.26	1397.60	154.90	716.30	5.20	43.60	190.00		10.72	903.10	2010.00	150.80
12	1168.00	1170.30	1460.20	160.60	746.50	5.60	44.90	188.80		10.92	935.70	2073.40	150.50

ХАВСРАЛТ 7 (үргэлжлэл)

СТАТИСТИКИЙН
ХАВСРАЛТУУД

ГАДААД ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ХАНШ												төгрөгөөр
Хугацааны эцэст	RUB	CNY	KRW	CAD	AUD	THB	IDR	MYR	SGD	XAU	XAG	SDR
1993 12				298.28								549.62
1994 12	0.12	48.60		295.08								602.19
1995 12	0.10	56.94		347.61								708.53
1996 12	0.12	83.57	0.82	506.86								999.35
1997 12	0.14	98.21	0.49	567.27								1095.06
1998 12	42.65	108.96	0.74	582.16	547.97	24.73	0.11	237.68	543.18	257,761.60	4446.86	1271.24
1999 01	40.77	100.00	0.80	625.45	601.40	25.57	0.10	250.33	563.55	272,032.50	4849.75	1331.50
03	39.74	125.75	0.85	688.15	660.30	27.63	0.12	274.02	599.97	291,859.57	5692.56	1417.69
06	41.50	122.59	0.88	692.34	671.19	27.66	0.15	267.39	596.27	263,119.49	5346.59	1361.01
09	41.73	127.89	0.87	719.73	691.33	25.98	0.13	278.95	620.35	290,591.19	5853.91	1469.60
12	39.95	129.53	0.95	730.75	691.09	28.52	0.15	282.20	642.41	308,574.47	5651.60	1473.72
2000 01	38.01	131.38	0.97	753.01	694.17	28.92	0.15	286.21	636.36	307,521.73	5601.65	1482.71
03	38.44	131.66	0.98	745.20	666.37	28.89	0.15	287.62	635.05	310,541.00	5442.91	1459.80
06	37.81	128.67	0.95	717.95	632.34	27.26	0.12	281.02	614.86	301,288.50	5261.10	1417.14
09	39.01	131.13	0.96	729.56	594.97	25.46	0.12	285.69	621.78	295,994.29	5319.54	1407.44
12	39.18	132.52	0.89	720.81	608.56	26.10	0.12	288.68	634.84	300,358.60	5062.66	1426.96
2001 01	38.74	132.75	0.86	730.48	599.12	25.67	0.12	289.21	629.15	291,235.00	5297.18	1415.57
02	38.25	132.66	0.88	713.50	573.65	25.48	0.11	288.95	629.05	283,942.80	4864.14	1411.76
03	38.12	132.53	0.84	700.29	542.41	24.80	0.11	288.68	615.15	287,797.95	4771.95	1388.36
04	37.71	131.81	0.82	707.18	558.32	23.88	0.09	287.77	599.88	288,624.05	4800.40	1388.05
05	37.60	132.29	0.85	709.50	570.99	24.08	0.10	288.16	607.05	305,778.75	5026.05	1377.52
06	37.66	132.54	0.84	719.79	566.55	24.23	0.10	288.68	602.38	298,877.65	4760.98	1370.43
07	37.50	132.66	0.84	716.15	557.29	24.04	0.11	288.95	609.83	292,562.10	4677.48	1385.18
08	37.42	132.78	0.86	713.66	587.69	24.72	0.13	289.21	627.57	302,609.65	4654.27	1408.25
09	37.30	132.80	0.85	701.70	539.00	24.90	0.12	289.20	631.90	318,847.40	4951.00	1423.20
10	37.10	132.90	0.85	698.70	551.90	24.50	0.11	289.50	601.80	304,865.00	4647.50	1394.00
11	36.70	132.90	0.86	687.20	570.00	24.80	0.10	289.50	599.10	300,685.00	4477.00	1388.80
12	36.20	133.10	0.83	691.00	559.70	24.90	0.11	290.00	595.90	306,080.50	4937.00	1382.40
2002 01	36.00	133.10	0.83	687.30	572.40	25.00	0.11	290.00	600.10	307,733.50	4738.60	1373.50
02	35.70	133.40	0.84	693.20	567.60	25.20	0.11	290.50	602.30	324,410.40	4890.70	1374.80
03	35.40	133.40	0.84	699.60	585.90	25.40	0.11	290.50	603.50	324,024.00	4979.00	1384.40
04	35.40	133.40	0.85	705.60	601.40	25.50	0.12	290.50	610.80	339,866.40	5111.50	1397.30
05	35.20	133.30	0.88	716.60	612.10	25.70	0.12	290.30	612.90	353,621.80	5382.60	1414.30
06	35.10	133.50	0.91	723.10	634.20	26.30	0.13	290.80	623.20	358,075.30	5425.60	1438.70
07	35.20	134.10	0.94	706.70	599.10	26.70	0.12	292.10	631.40	343,656.00	5383.50	1484.90
08	35.30	134.80	0.93	718.50	618.20	26.40	0.13	293.70	638.00	348,192.00	5033.20	1473.70
09	35.20	134.90	0.91	708.90	609.40	25.70	0.12	294.30	628.30	357,998.50	5048.80	1474.50
10	35.30	135.40	0.91	715.90	622.30	25.80	0.14	295.40	631.40	350,312.50	4921.20	1471.70
11	35.30	135.70	0.93	712.10	632.10	25.90	0.12	295.50	634.70	357,619.40	5031.00	1493.90
12	35.40	135.90	0.94	720.60	634.90	26.00	0.13	296.10	647.60	393,187.50	5298.80	1519.20
2003 01	35.60	136.70	0.97	744.30	666.70	26.50	0.13	297.90	653.50	415,302.50	5433.60	1561.60
02	36.00	137.50	0.96	762.70	690.30	26.70	0.13	299.50	656.60	403,534.80	5325.80	1558.00
03	36.30	137.70	0.91	777.90	683.80	26.60	0.13	300.00	644.30	376,542.00	4993.20	1554.90
04	36.50	137.00	0.94	782.40	702.30	26.40	0.13	298.40	639.00	376,488.00	5182.40	1564.00
05	36.90	136.50	0.94	814.40	731.80	27.00	0.14	297.40	651.40	409,851.00	5231.90	1598.90
06	37.60	137.60	0.95	840.70	758.50	27.30	0.14	299.70	649.40	391,986.90	5159.70	1601.50
07	38.10	139.30	0.98	826.00	762.50	27.50	0.13	303.40	656.80	415,714.20	5903.40	1616.10
08	37.80	139.40	0.98	824.60	738.60	28.00	0.13	303.70	656.70	426,547.30	5908.50	1582.20
09	37.80	140.00	1.01	876.00	798.30	29.70	0.14	305.30	674.40	432,390.00	5684.00	1666.80
10	39.00	140.80	0.99	888.50	822.00	29.20	0.14	306.60	672.20	450,592.90	5999.80	1675.20
11	39.10	141.50	0.97	897.60	847.20	29.30	0.14	308.20	679.00	464,008.80	6253.10	1685.70
12	39.90	141.10	0.98	892.60	872.10	29.50	0.14	307.40	686.40	485,537.60	6926.20	1729.00

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ	сая ам. доллар								
	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003 ¹
Урсгал данс	38.9	-36.9	68.0	-75.6	-57.8	-69.9	-61.7	-105.1	-98.7
Худалдааны тэнцэл	-22.0	-87.4	30.2	-120.1	-112.9	-140.1	-169.9	-228.9	-199.6
Экспорт F.O.B	451.0	423.4	568.5	462.3	454.2	535.8	523.2	523.9	627.3
Үүнээс: Зэсийн баяжмал	257.6	174.5	211.4	124.8	119.2	160.3	148.0	140.2	161.7
Мөнгөжөөгүй алт	-	52.4	117.0	117.2	95.9	69.7	74.7	117.6	157.3
Бусад	193.4	196.5	240.1	220.3	239.1	305.8	300.6	266.1	308.3
Импорт C.I.F	-473.0	-510.8	-538.3	-582.4	-567.1	-675.9	-693.1	-752.8	-826.9
Үйлчилгээний тэнцэл	9.2	-6.0	-2.1	-11.6	-14.2	-17.6	-22.2	-9.3	-49.1
Орлого	57.3	55.7	52.7	77.9	71.0	77.5	113.5	184.5	207.9
Зарлага	-48.1	-61.7	-54.8	-89.5	-85.2	-95.1	-135.7	-193.9	-257.1
Орлого, цэвэр	-25.4	-13.3	-12.0	0.4	0.1	-6.5	-2.0	-4.5	-11.5
Хүүгийн төлбөр	0.0	-9.3	-9.4	-9.2	-6.2	-9.1	-8.8	-10.8	-11.9
Шилжүүлэг, цэвэр	77.1	69.8	51.9	55.7	74.5	94.3	132.4	137.6	161.5
Хувийн гуйвуулга	0.0	6.2	4.2	2.5	7.4	-4.3	25.0	64.4	74.3
Албан ёсны буцалтгүй шилжүүлэг	77.1	63.6	47.7	53.2	61.8	98.6	107.4	73.2	87.2
Хөрөнгө ба Санхүүгийн данс	-16.9	41.3	27.0	128.6	67.8	89.8	117.7	157.4	4.9
Дунд, урт хугацааны хөрөнгө	32.3	72.0	104.3	124.1	122.4	136.4	131.6	180.1	29.4
Шууд хөрөнгө оруулалт	9.8	15.9	25.0	18.9	30.4	53.7	63.0	77.8	131.5
Санхүүгийн хөрөнгө оруулалт	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	50.0
Зээл	22.5	56.1	79.3	105.2	92.0	82.7	68.6	102.3	-152.1
Үүнээс: Ашигласан	83.0	93.4	116.2	122.4	112.3	156.6	167.1	185.3	190.5
Үндсэн өрийн төлбөр	-60.5	-37.3	-36.9	-17.2	-20.3	-73.9	-98.5	-83.0	-342.6
Богино хугацаат хөрөнгө (цэвэр)	-49.2	-30.7	-77.3	4.5	-54.7	-46.6	-13.9	-22.7	-24.5
Арилжааны банк	-15.3	-9.3	-18.1	40.0	-17.7	-13.0	1.4	-8.7	-21.0
Банк бус	-33.9	-21.4	-59.2	-35.5	-37.0	-33.6	-15.3	-14.0	-3.5
Залруулга	11.4	-26.9	-40.2	-51.4	30.9	-19.0	-41.3	14.2	-3.1
Нийт төлбөрийн тэнцэл	33.4	-22.5	54.8	1.6	40.9	1.0	14.7	66.5	-96.9
Санхүүжилт	-33.4	22.5	-54.8	-1.6	-40.9	-1.0	-14.7	-66.5	96.9
Валютын цэвэр албан нөөцийн өөрчлөлт	-33.4	16.6	-55.0	-5.6	-36.1	-1.0	-19.5	-66.5	96.8
ОУВС-ийн зээл	-10.7	-3.1	6.2	0.8	4.3	1.6	-1.7	-7.8	7.1
Зээлийн өрийн үлдэгдэл	0.0	5.9	0.2	4.0	-4.8	0.0	4.8	-1.9	0.0
Хугацаа хойшлуулсан өр	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Эх үүсвэрийн дутагдал	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Санамж:									
Урсгал дансны ДНБ-д эзлэх хувь	5.2	-4.0	6.2	-7.8	-6.4	-7.2	-6.1	-9.4	-8.3
Нийт гадаад нөөц	115.2	98.2	157.1	123.2	155.9	190.9	206.7	268.2	203.4
импортын 7 хоногоор	12.7	10.0	15.2	11.0	14.3	14.7	15.6	18.6	12.8

¹ Урьдчилсан байдлаар

Монголбанк
Бага тойруу 9
Улаанбаатар 46
Монгол Улс
Утас: 976-11-322166
Факс: 976-11-311471
Телекс: BOMCB MH 79333
<http://www.mongolbank.mn>